

Монгол улсын сургуулийн өмнөх боловсрол

Үйлчилгээний Хүртээмж, Чанар ба Хүүхдийн Хөгжлийн Үр дүн

2016 оны 11 сар

Хоёр дахь хэвлэл

Тайлан № 113752

ГАРЧИГ

Талархал.....	5
Товчилсон үгийн тайлбар	7
Нэр томъёоны тайлбар	8
Хураангуй	9
Бүлэг 1. Монгол улсын сургуулийн өмнөх боловсролын ерөнхий байдал: Үйл ажиллагаа ба санхүүжилт	15
1.1 Яагаад СӨБ-д хөрөнгө оруулах хэрэгтэй вэ?	15
1.2 Монгол улсын сургуулийн өмнөх боловсрол ба үйл ажиллагааны хэв шинж	18
1.3 Монгол улсын СӨБ-ын үйлчилгээний хүртээмж	22
1.4 СӨБ-ын төсвийн зарцуулалт	26
1.5 СӨБ-ын санхүүжилтийн тогтолцоо	30
1.6 Хоол хүнс, сургалтын хэрэглэгдэхүүний хангамжийг нягтлан харах нь	32
1.7 Дүгнэлтүүд	33
Бүлэг 2 Монгол улсын цэцэрлэгүүдийн үйлчилгээний чанар	36
2.1 Монгол улсын цэцэрлэгийн үйлчилгээний чанарыг баталгаажуулах нь	37
2.2 Монгол улсын цэцэрлэгийн чанарыг хэмжих нь: Дэлхийн банкны СӨБ-ын чанарын судалгаа-2015.....	39
2.2.1 Түүвэрт хамрагдсан цэцэрлэгүүдийн бүтцийн шинж чанар.....	43
2.2.2 Чанарыг цэцэрлэгийн төрөл ба байршлаар харсан нь	47
2.2.3 ЕСЕMI аргачлалаар тооцсон чанарын дэд хэмжүүр тус бүрийн гүйцэтгэлийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл	49
2.3 Дүгнэлт	55
Бүлэг 3 Монголын СӨБ-д хамрагдаж байгаа 5 настай хүүхдүүдийн сургуульд бэлтгэгдсэн байдал.....	60
3.1 Дэлхийн банкны СӨБ-ын чанарын үнэлгээний судалгаа 2015: Мэдээлэл цуглуулалт, түүврийн шинж чанар ба БНХБ-ын үр дүнгүүд	62
3.1.1 Судалгааны түүвэр ба мэдээлэл цуглуулалт.....	62
3.1.2 Цэцэрлэгт хамрагдсан 5 настай хүүхдүүдийн ар гэрийн нөхцөл байдал	65
3.1.3 Хүүхдийн гэр бүл ба эцэг эхчүүдийн оролцоо	70
3.1.4 Цэцэрлэгт хамрагдсан таван настай хүүхдүүдийн БНХБ-ын үр дүн	73
3.2 Монгол улсад хэрэгжүүлсэн гэр бүлд суурилсан сургуульд бэлтгэх хөтөлбөрийн БНХБ-ын үр дүн	80
3.3 ОУБТС-д хамрагдсан хүүхдүүдийн БНХБ-ын үр дүн	86
3.4 Дүгнэлт	89
Бүлэг 4 Цаашид авах голлох арга хэмжээ	93
Арга хэмжээ 1: Олон нийт болон гэр бүлийн орчинд суурилсан БНХБ-ын шалгарсан аргуудаар дамжуулан хөдөө орон нутагт БНХБ-ын хүртээмжийг нэмэгдүүлэх.....	94

Арга хэмжээ 2: Хот суурин газруудад хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлснээр СӨБ-ын хүртээмжийг нэмэгдүүлэх	97
Арга хэмжээ 3: Хөдөө орон нутаг руу чиглэсэн хөрөнгө оруулалтаар дамжуулан төрийн өмчийн ердийн цэцэрлэгийн чанарыг сайжруулах	98
Арга хэмжээ 4: БНХБ-ын санхүүжилтын нормуудыг эргэн харж, хүүхдийн хөгжлийн үр дүнд нөлөөлж буй хүйсийн болон бусад төрлийн ялгааг арилгахын тулд гүнзгийрүүлэн судлах	100
Номзүй	102
Хавсралтууд	106
Хавсралт 1 Монгол улсын СӨБ ба хувилбарт сургалтын түүх	106
Хавсралт 2 Монгол улсын СӨБ-ын хамрагдалтанд нөлөөлөх хүчин зүйлс: Регрессийн үр дүнгийн хүснэгт	108
Хавсралт 3 Монгол улсын СӨБ-д хамрагдсан малчдын хүүхдүүд	109
Хавсралт 4 Цэцэрлэгийн хүүхдийн эцэг эхээс нэг хичээлийн жилд бэлтгүүлэх сургалтын хэрэглэгдхүүн, ариун цэврийн хэрэгслийн жагсаалт	110
Хавсралт 5 Монгол улсын цэцэрлэгт хамрагдаж байгаа 5 настай хүүхдүүд, 2015 оны байдлаар	112
Хавсралт 6 Дэлхийн банкны СӨБ-ын чанарын судалгаанд зориулж өрхийн аж я байдлын индексийг боловсруулсан нь	113
Хавсралт 7 ДБ-ны 2015 оны судалгааны түүврийг 2010 ОУБТС-ныхтай харьцуулсан нь	115
Улсын болон хувийн цэцэрлэгүүдэд хамрагдсан хүүхдүүдийн түүвэр	116
Гэр цэцэрлэгт хамрагдсан хүүхдүүдийн түүвэр	118
Хавсралт 8 Монгол улсын цэцэрлэгт хамрагдсан 5 настай хүүхдүүдийн MELQO аргачлалаар үнэлэгдсэн хүүхэд хөгжлийн үр дүнгүүдийн дундаж онооны тархалт, 2015	120
Хавсралт 9 Өрхийн, хувь хүний ба цэцэрлэгийн түвшний шинж чанарууд MELQO шууд үнэлгээний аргачлалын дундаж оноонуудад нөлөөлөх хүчин зүйлс: Регрессийн үр дүнгийн хүснэгт	121
Танин мэдэхүйн хөгжил ба хэл яриа	122
Гүйцэтгэх ур чадвар/өөрийгөө удирдах	125
Жижиг булчингийн хөгжил	126
Хавсралт 10 Эхийн боловсрол болон бусад нийгэм эдийн засгийн шинж чанарууд MELQO үнэлгээний аргачлалын оноонд нөлөөлөх нь	127

Талархал

Энэхүү тайланг Рабия Али (Төслийн багийн ахлагч, GED02), Муким Темуров (GED05), Такико Игараши (GED02) нарын Дэлхийн банкны мэргэжилтнүүдээс бүрдсэн баг боловсруулсан юм. Дэлхийн банкны захиалгаар Судалгаа, зөвлөх үйлчилгээний Mongolia Marketing Consulting Group (MMCG) ХХК нь СӨБ-ын чанарын судалгаа-2015-ыг хийсэн. Мөн Дэлхийн банкны ажилтан Г. Пагма (GHN02) судалгааны ажилд дэмжлэг үзүүлж, БСШУСЯ, Сангийн яам болон бусад олон улсын хөгжлийн түншүүдтэй харилцах үйл явцыг зохицуулж судалгааны ажлыг дэмжиж ажилласан. Монгол улс дахь Японы хүүхдийг ивээх сан нь өөрийн байгууллагын хэрэгжүүлсэн сургуульд бэлтгэх хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүдийг СӨБ-ын чанарын үнэлгээнд хамруулсан. Мөн Г.Пагма, Ч.Тунгалаг (GSP02) болон Т.Цэндсүрэн (өмнө нь НҮБ-ын Хүүхдийн санд БНХБ хариуцсан мэргэжилтэн байсан) нар тус тайлангийн монгол, англи хувилбаруудыг хянан тохиолдуулах, засварлахад дэмжлэг үзүүлж ажилласан юм.

Хураангуй болон дэлгэрэнгүй тайланг бичих, хянан сайжруулахад Аманда Деверчелли, Назмул Шодхэри ба Софи Наду зэрэг хамтран ажиллагсад маань тусалсан. Энэхүү тайланг Харри Патринос (менежер, GED02), Луи Бенвенистэ (өмнө нь Зүүн Азийн боловсролын асуудлыг хариуцсан менежер байсан), Жеймс Андерсон (Монгол улсыг хариуцсан менежер) нарын зааварчилгаа, удирдамж дор бичиж боловсруулсан юм.

Төслийн үндсэн ойлголтоос эхлээд энэхүү дэлгэрэнгүй тайланг бичиж боловсруулах бүхий л үе шатанд зөвлөн тусалж, хамтран ажилласан Дэлхийн банкны ажилтнууд болон бусад байгууллагын төлөөлөл, мэргэжилтнүүдэд төслийн багийн өмнөөс талархал илэрхийлж байна. Тухайлбал, MELQO аргачлалын баг буюу Аманда Деверчелли (Дэлхийн банк), Абби Райкес (НҮБ-ын Хүүхдийн сан), Ивелина Борисова (Хүүхдийг ивээх сан) нар; мөн тайланг бэлтгэх ажилд тусалсан Линда Платас ба Т. Цэндсүрэн (НҮБ-ын Хүүхдийн сан), болон Монгол улсын нөхцөл байдалд тохирсон судалгааны асуулт бэлдэх, тайлангийн сэдвүүдийг боловсруулахад ихээхэн хүчин чармайлт гарган хамтран ажилласан Г.Монголхатан (Боловсролын хүрээлэн) нарт гүн талархал илэрхийлж байна. Мөн тайлангийн төслийг боловсруулахад Дэлхийн банкны ажилтан Елена Глинская, Луи Бенвенистэ, Амер Хасан, Шиаоян Лиян нарын өгсөн мэдээлэл, зөвлөмж ихээхэн хувь нэмэр оруулсан. Түүнчлэн сургуулийн өмнөх боловсролын төсвийн зарцуулалтын талаарх мэдээлэл цуглуулахад дэмжлэг үзүүлсэн БСШУСЯ-ны мэргэжилтэн А.Мөнх-Оргил, Б.Дэнсмаа болон СЯ-ны мэргэжилтэн М.Санжаадорж нарт талархаж байна.

Дээр дурьдсан судалгааны арга хэрэгслийг нутагшуулан нэвтрүүлэх сургалтыг Ц.Гэрэлтуяа, Сувддэлгэр нарын оролцоотойгоор удирдан зохион байгуулсан Ивелина Борисова (Хүүхдийг ивээх сан), Б.Мягмар (МУБИС), Мөнхзаяа (Нийслэлийн боловсролын газар), Г.Амирда, Н.Норжхорлоо (БСШУСЯ) нар, сургалтад оролцож, судалгааны асуултыг боловсруулах талаар зөвлөн тусалсан, судалгааны бэлтгэл хангах, судалгааны мэдээлэл цуглуулах үйл явцад дэмжлэг үзүүлсэн О.Сумъяа, С.Дуламсүрэн (Эм Эм Си Жи ХХК) нарт төслийн баг онцгой талархаж байна. Төслийн баг Д.Бум-Эрдэнэ, Ч.Даваасүрэн нарын удирдлага дор ажилласан Эм Эм Си Жи компанийн ажилтнуудад мэдээлэл цуглуулах үйл явцыг удирдан чиглүүлж, судалгааны хамрах хүрээнд үүссэн аливаа асуудлуудыг цаг тухайд нь оновчтой шийдвэрлэж, судалгааны хэрэгцээнд нийцүүлэн уян хатан

ажилласанд маш их талархаж байна. Мөн Баян-Өлгий аймгийн Боловсролын газар, тэр дундаа мэргэжилтэн Сергульд алслагдсан орон нутаг, хөдөөд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг хэрхэн зохион байгуулах талаар төслийн багт маань мэдээлэл өгч, зааж чиглүүлсэнд талархалтай байна. Мэдээллийн дүн шинжилгээ хийх явцад Абби Райкес, Натали Козиол (Небраска мужийн Линкольны их сургууль), Суэхила Мессауд-Галуси (Дэлхийн банкны ажилтан байсан) нарын мэргэжилтнүүд нэн чухал зөвлөмжөөр хангаж, тусалсныг цохон тэмдэглэж байна.

Тайлангийн бэлтгэл шатанд төслийн багийг дэмжин, сургалт зохион байгуулах, төрийн байгууллагууд болон бусад холбогдох талуудтай харилцах, хамтран ажиллахад тусалсан Э.Өлзиймаа, Я.Отгонбаяр, Анна Коронадо нарын Дэлхийн банкны ажилтнуудад талархал илэрхийлье.

Товчилсон үгийн тайлбар

БНХХ	Бага насны хүүхдийн хөгжил
БНХБ	Бага насны хүүхдийн боловсрол
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
ДБ	Дэлхийн банк
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
ОУБТС	Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа
УБ	Улаанбаатар
СЯ	Сангийн яам
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ЯХИС	Японы хүүхдийг ивээх сан

Нэр томъёоны тайлбар

Аймаг: Засаг захиргааны нэгж. Монгол улс 21 аймагтай.

Дүүрэг: Тус тайланд нийслэл хотын засаг захиргааны нэгж болох дүүргийн талаар дурдах болно. Дүүрэг нь сумаас ялгаатай төдийгүй нийслэл хотын хоёр дахь шатны засаг захиргааны нэгж юм. Монгол улсын нийслэл хот Улаанбаатар нь 9 дүүрэгтэй, тэдгээрийн 6 нь хотын төвийн бүсэд байрладаг.

Гэр: Уламжлалт сууц. Гэр нь эвхэгдэх модон хана, унь, тооно зэргээс гадна эсгий, даавуун бүрээс зэргээс бүрдэнэ. Гэрийн халаалтын уламжлалт эх хувилбар нь энгийн галлагаа бүхий зуух (пийшин) юм.

Сум: Хөдөө орон нутаг дахь аймгийн дараах засаг захиргааны нэгж. Аймаг нь сумдад хуваагдана. Монгол улс 331 сумтай.


Хураангуй

БНХБ-ын чанартай үйлчилгээнд хөрөнгө оруулах нь өндөр өртөгтэй стратеги боловч жилд 10 хүртэлх хувийн эргэх ашгийг авчирдаг байна.

Монгол улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030–д бага насны хүүхдийн боловсролыг (БНХБ) “мэдлэгт суурилсан нийгэм ба ур чадвар бүхий Монгол хүн”-ийг бий болгох зорилгын тэргүүн эгнээнд тавьсан байна. Тус үзэл баримтлалын зорилгод хүүхэд бүрийг стандартын шаардлага хангасан сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулж, монгол хэл, сэтгэлгээний үндсийг эзэмшүүлнэ гэж заасан байна.

Энэхүү зорилго нь БНХБ-ын хөрөнгө оруулалтын үр өгөөж алсдаа маш их байдгийг дэлхийн дахины туршлагаар нотолсон улс орнуудын туршлагад суурилж байгаа юм. Танин мэдэхүйн болон нийгэмшихүйн хөгжлийн хүрээнд анхаарал төвлөрүүлэх чадвар, тэсвэр хатуужил, сэтгэл хөдлөлөө барих чадвар ба нийгэм-сэтгэлийн хөдөлгөөний чадварууд нь хойшдын боловсрол болон суралцахуйн, амьдралын амжилтыг хөтлөгч гол түлхүүр болж өгдөг. Тиймээс хүүхдийн эхийн хэвлийд байх үед болон төрсний дараах удамшлын, эцэг эхийн болон орчин тойрны хязгаарлагдмал байдлаас үүдэлтэй туршлага болон суралцахуйн тэгш бус байдал нь эдгээр ур чадварын хөгжилд саад болж, улмаар хүүхдийг насанд хүрэх үед ур чадвар, ололт амжилт, эрүүл мэндийн зэрэг ялгаатай байдлыг бий болгодогт гайхах зүйлгүй юм. Үүнээс гадна бага насны хүүхдийн өсөн торниж буй орчин хор хөнөөлтэй байх нь хүүхдийн хөгжилд муугаар нөлөөлж, ирээдүйн эргэх ашгийг бууруулж, нийгмийн халамжийн өртгийг өсгөдөг тул иргэдийн санхүүгийн ачааллыг ч улам нэмэгдүүлдэг. Гэвч эдгээр хязгаарлалтуудаас үүсэх сөрөг нөлөөг БНХБ-ын чанартай үйлчилгээнд хөрөнгө оруулснаар шийдвэрлэж болох бөгөөд чанартай үйлчилгээ нь бүтээмжийг сайжруулахад шаардагдах хүүхдийн олон талт хөгжлийг дэмжих нөөц боломжийг хүүхэд болон эцэг эхчүүдэд олгодог. Энэхүү арга хэмжээнд шаардагдах зардал нь өндөр хэдий ч

тусгай боловсрол ба давтан сургахад шаардагдах төсвийн бууралт, эрүүл мэндийн нөхцөл байдлын сайжралт, халамжийн үйлчилгээний хэрэгцээ, зардал болон гэмт хэргийн зардлын бууралт, түүнчлэн гэр бүлүүдийн бие даах чадвар болон хөдөлмөрийн бүтээмж сайжрах зэрэг богино болон урт хугацааны олон эерэг үр дүн бүхий эргэх ашгаар бүрэн нөхөгддөг юм. Мөн энэхүү хөрөнгө оруулалтыг эрт хийх тусам үр өгөөж, эргэх ашиг нь нэмэгддэг байна (зураг 1). Бүтээмжийг хөгжүүлэх хамгийн чухал үе нь тав хүртэлх нас бөгөөд энэ үед хүүхдийн тархины хөгжил нэн хурдацтай байдаг.



СӨБ-ын хамран сургалт харьцангуй нэмэгдсэн боловч БНХБ-д хамрагдах нэн хэрэгцээтэй байгаа хүүхдүүд үйлчилгээний гадна байсаар байна.

Төрөөс БНХБ-д зарцуулж байгаа төсвийн хэмжээ нь тус салбар Монгол улсын хувьд чухал хэвээр байгааг илтгэж, боловсролын салбарын нийт зарцуулалтын 20 хувийг эзэлж байгаа нь хөгжлийн хувьд адил төстэй бусад орнуудтай харьцуулахад төдийгүй дэлхийн хэмжээнд нэлээд өндөр үзүүлэлт юм. БНХБ-ын үйлчилгээ сүүлийн хорин жил асар хурдацтай өсч, 3-5 насны нийт хүүхдийн 70 гаруй хувь нь СӨБ-ын албан ёсны үйлчилгээ буюу цэцэрлэгт, 9 хувь нь СӨБ-ын хувилбарт сургалтад хамрагдаж байна. СӨБ-ын хамран сургалтын тухайд жэндэрийн ялгаатай байдал байхгүй боловч салбарын хэмжээнд хэд хэдэн асуудал нэн тулгамдаж байна. Үүнд:

- Газарзүйн байршил болон яс үндсээс хамааралтай ялгаа байсаар байна (зураг 2). Хөдөө орон нутагт СӨБ-ын хамрагдалт хот суурин газруудынхаас нэлээд хоцорч, нийт 36-59 сартай хүүхдүүдийн дөнгөж 46 хувь нь бага насны боловсролын үйлчилгээнд хамрагдаж байна (НҮБ-ын Хүүхдийн сан, 2015). Улаанбаатар хотод амьдарч буй хүүхдүүдийн СӨБ-ын хамрагдалт аймаг болон сумын төвүүдийнхээс хоцрогдолтой буюу 10 пунктээр доогуур байна.

Хүн амын олонх болох халхчуудтай харьцуулахад казах өрхийн хүүхдүүдийн СӨБ-ын хамрагдалт 24 пунктээр доогуур байна.

- Өрхийн аж байдлын түвшин СӨБ-ын хамрагдалтын гол хүчин зүйл болж байгаа бөгөөд баялгийн хамгийн доод квинтилд багтаж байгаа өрхийн хүүхдүүдийн хувьд чинээлэг амьдралтай бүлгийн өрхүүдийн хүүхдүүдтэй харьцуулахад СӨБ-д хамрагдах магадлал нь 40 пунктээр доогуур байна.
- Малчдын хүүхдүүдийн хувьд тэдний нийт улсын хүн амд эзлэх хувьтай харьцуулахад хамрагдалт бага байна.
- Нийгэм, эдийн засгийн түвшин доогуур, амьдралын боломж багатай өрхүүдийн хүүхдүүдийн хувьд БНХБ-д хамрагдах нь хамгийн бага байгаа учир БНХБ-д үзүүлэх төрийн дэмжлэгийн ихэнх хувь чинээлэгдүү амьдралтай өрхийн хүүхдүүдэд зориулагдаж байна.




Цэцэрлэгт хамрагдсан хүүхдүүдийн дунд хийсэн бага насны хөгжлийн үр дүнгийн судалгаанаас харахад хүүхдүүдийн сургуульд бэлтгэгдсэн байдал нийгэм-эдийн засгийн байдлын түвшингээс хамааран хол зөрүүтэй байна.

Хөдөө орон нутгийн төрийн өмчийн цэцэрлэгийн хүүхдүүд танин мэдэхүй болон танин мэдэхүйн бус нэлээд хэдэн ур чадварын хувьд хотын хүүхдүүдээс хоцорч байна (зураг 3). Хүүхдийн өрхийн нийгэм-эдийн засгийн байдал нь хамрагдаж буй цэцэрлэгийн чанар болон хамрагдсан хугацаа зэрэг хүчин зүйлсийг хянаж үзсэний дараа ч гэсэн хөгжлийн үр дүнд чухал нөлөөтэй хэвээр байна. Цэцэрлэгийн чанараас гадна, хүүхдийн ээж дээд боловсролтой байх нь өрхийн, хувь хүний ба цэцэрлэгийн түвшний хүчин зүйлсийг

хянасны дараа ч гэсэн, үнэлсэн бүх таван айн хувьд өндөр оноотой байхад нөлөөлөх цорын ганц хүчин зүйл болж байна. Эрэгтэй, үндэсний цөөнх, тусгай хэрэгцээтэй байх зэрэг нь хүүхдийн хөгжлийн үр дүнд нөлөөлж, бага буюу доогуур оноотой байх нөхцөл болж байна.

Зураг 3 Төрийн өмчийн ердийн цэцэрлэгт хамрагдсан 5 настай хүүхдүүдийн үнэлгээний дундаж оноо, байршлаар, Монгол улс, 2015



СӨБ-ын хувилбарт сургалт нь алслагдсан орон нутгийн хүүхдүүдийн сургуульд бэлтгэгдсэн байдлын зөрүүг арилгахад хангалтгүй байна. Эдгээрээс нүүдлийн гэр цэцэрлэг нь нь малчин хүн ам, өрхөд чиглэсэн хамгийн түгээмэл хэлбэр юм. Нүүдлийн гэр цэцэрлэгт хамрагдсан хүүхдийн танин мэдэхүй болон танин мэдэхүйн бус ур чадварууд, гурваас дөрвөн долоо хоног үргэлжлэх тус цэцэрлэгийн сургалт тал дундаа орчихоод байхад хүртэл ердийн цэцэрлэгийн хүүхдүүдээс нэлээд ихээр хоцорч байна. Тийм учраас хэдий гэр цэцэрлэгүүдийг эцэг эхчүүд баяртайгаар хүлээн авч, гэр цэцэрлэг нь малчин өрхийн хүүхдүүдийн СӨБ-д хамрагдалтыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр болж байгаа ч гэлээ хүүхдийн хөгжлийн үр дүнгийн

үзүүлэлтээр ердийн цэцэрлэгт хамрагдсан хүүхдүүдтэй харьцуулах боломжгүй байна.

Цаашид авах гол арга хэмжээ

Гол арга хэмжээ 1: Малчин өрхүүд зэрэг алслагдсан орон нутгийн хүн амд зориулсан олон нийт болон гэр бүлд суурилсан БНХБ-ын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлснээр хөдөө орон нутагт БНХБ-ын хүртээмжийг сайжруулах

Энэхүү тайланд хүүхдийн гэр бүлийн гишүүд гэртээ байхдаа хүүхдүүдтэйгээ ном унших, дуу дуулах, хамтдаа тоглох зэрэг үйл ажиллагааг хамтран хийснээр хүүхдийн тоо болон хэл ярианы хөгжилд ихээхэн нөлөөлдөг болохыг тодруулсан. Энэ нь алслагдсан орон нутгийн хүүхдүүдийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг сайжруулахад гэр бүлд суурилсан БНХБ-ын сургалтын хөтөлбөр чухал нөлөөтэй байж болохыг харуулж байна. Монгол улсад Японы хүүхдийг ивээх сангаас (ЯХИС) 2012 – 2017 онд ийм нэг үйл ажиллагааг хэрэгжүүлсэн нь гэр бүлд суурилсан хүүхдийг сургуульд бэлтгэх хөтөлбөрөөр дамжуулан эцэг эх, багш нарын чадавхыг бэхжүүлж, тэдэнд техникийн дэмжлэг туслалцаа үзүүлэн, олон нийтийн оролцоог хангаснаар сургуульд бэлтгэгдсэн байдлыг сайжруулах зорилготой байв. Тус хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүдийн нийгэм, эдийн засгийн байдал болон хувийн зан чанарыг хянасны дараа ч гэсэн БНХБ-ын үр дүн нь гэр цэцэрлэгт хамрагдсан хүүхдүүдээс харьцангуй өндөр байжээ. Тиймээс энэ хөтөлбөр нь зорилтот бүлгийн хүүхдүүдийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг сайжруулахад одоогоор хэрэгжиж буй бусад хувилбаруудаас хамгийн сайн үр дүнтэй байв.

Гол арга хэмжээ 2: Хот суурин газруудад хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлснээр цэцэрлэгийн хүртээмжийг сайжруулах ба нэг бүлэгт байх хүүхдийн тоог хэвийн хэмжээнд барих боломжтой .

Хот суурин газруудад төрийн өмчийн шинэ цэцэрлэгүүдийг барьснаар ердийн цэцэрлэгийн үйлчилгээний цар хүрээг өргөжүүлэх боломжтой. Хувийн хэвшлийн оролцоо маш ихээр нэмэгдэж байгаа тул хувийн цэцэрлэгүүдийг төрөөс санхүүжүүлэх нь ялангуяа Улаанбаатар хотод зохистой арга байж болох юм. БНХБ-ын үйлчилгээг ийнхүү өргөжүүлэх нь нэн шаардлагатай болохыг орон зайн үнэлгээний үзүүлэлтүүд харуулж байна. Тухайлбал, гурван цэцэрлэг тутмын нэг нь бүлгийн өрөөний зай талбай нь хүүхэд чөлөөтэй тоглоход хангалтгүй төдийгүй үнэлгээнд хамрагдсан цэцэрлэгийн дөнгөж тал нь том булчин хөгжүүлэх тоног төхөөрөмжтэй байна. Цэцэрлэгийн нэг бүлэгт байх хүүхдийн тоо нормоос хэтэрч байгаа нь улсын хэмжээнд нийтлэг, нэг бүлэг дунджаар хөдөө орон нутагт 42 хүүхэд, хот суурин газруудад 50 хүүхэд байна. Харин урт хугацааны өндөр эргэх ашигтай болох нь батлагдсан АНУ-ын зорилтот бүлгийн хүүхдүүдэд чиглэсэн БНХБ-ын хөтөлбөрүүдэд багш-суралцагчийн харьцаа 1:6 буюу нэг багшид 6 хүүхэд ногдож байна.

Хоёрдугаарт, цэцэрлэгийн үйлчилгээг өргөжүүлэхийн тулд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэхдээ зөвхөн хамрагдалтыг нэмэгдүүлэх бус, чанарт анхаарсан урамшууллын системийг бий болгох хэрэгтэй. Энэхүү тайланд Улаанбаатар хотын гэр хорооллын бус хэсгийн чинээлэг өрхүүдэд үйлчилж байгаа хувийн цэцэрлэгүүдийн үйлчилгээ нь гэр хорооллын цэцэрлэгүүдээс илүү чанартай үйлчилгээ үзүүлж байгааг тодруулсан. Тиймээс чанартай үйлчилгээг үзүүлэх, чанарын зөрүүг арилгахын тулд оновчтой урамшууллыг бий болгох, зохих хяналт ба техникийн туслалцаа үзүүлэхэд анхаарах хэрэгтэй байна.

Гол арга хэмжээ 3: Хөдөө орон нутаг руу чиглэсэн хөрөнгө оруулалтаар дамжуулан төрийн өмчийн ердийн цэцэрлэгийн чанарыг сайжруулах

Төрийн өмчийн болон хувийн хэвшлийн цэцэрлэгүүдийн чанарын норматив, хэм хэмжээ (стандарт шаардлага)-ний хэрэгжилт, мөрдөлтийг тогтмол хянах, чанарыг үнэлэх баталгаажуулалтын механизм хэрэгтэй байна. Норматив, хэм хэмжээг мөрдөж буй байдал болон чанарын үнэлгээг тогтмол хийхгүй бол сайжруулах хэрэгтэй зүйлсээ зөв тодорхойлж, хөрөнгө оруулалтаа оновчтой чиглүүлэх боломжгүй болно. Хяналтыг хэрэгжүүлж болох нэг арга бол цэцэрлэгийн түвшинд ашиглаж болох чанарын онооны картыг боловсруулах юм. Онооны картаар дамжуулан цуглуулсан мэдээллийг аймгийн эсвэл тухайн орон нутгийн боловсролын газар, хэлтэст цуглуулж, БСШУСЯ-д нэгтгэж болох юм. Ингэхдээ жил бүрийн боловсролын салбарын статистикийн мэдээллийн эмхэтгэлийг гаргахад ашигладаг мэдээлэл солилцооны журмыг баримталж болно.

БНХБ-ын хөрөнгө оруулалтын тэгш байдал, үр нөлөөг сайжруулахын тулд чанарыг сайжруулах аливаа үйл ажиллагааг хөдөө орон нутаг руу чиглүүлэх ёстой. Энэхүү тайланд цэцэрлэгийн чанар нь цэцэрлэгт хамрагдсан хүүхдүүдийн сургуульд бэлтгэгдсэн байдлын түвшинг тодорхойлогч цорын ганц чухал хүчин зүйл бөгөөд хүүхдүүдийг цэцэрлэгт удаан хамруулах, эсвэл бүр бага наснаас нь хамрууллаа гээд цэцэрлэгийн чанар одоогийн түвшинд байвал бэлтгэл сайн хангагдахгүй гэдгийг харуулж байна. Ялангуяа хөдөө орон нутгийн цэцэрлэгүүд чанарын бүх үзүүлэлтээр хоцорч байна. Хүүхдийн хөгжлийн хот ба хөдөөгийн ялгаа, зөрүүг арилгахад сургалтын хэрэглэгдэхүүний төрөл, тэдгээрт зарцуулах санхүүжилтийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны төрлийг олшруулах нь нэн тэргүүний зорилт байх ёстой. Нийт цэцэрлэгүүдийн гуравны нэгд өөрчлөлт, сайжруулалт хэрэгтэй байна. Мөн цаашлаад чанарыг сайжруулахдаа тоо болон математикийн орчныг сайжруулах тал дээр анхаарах нь зүйтэй. Учир нь энэ дэд хэмжүүрээр улсын хэмжээний бараг бүх цэцэрлэгүүд хамгийн доогуур оноог авсан. Гэвч хүүхдүүдийг тоогоор шахахгүй байх,

хүчээр цээжлүүлэхгүй байх, хэт их дарамттай орчныг үүсгэхгүй байх тал дээр анхаарах ёстой.

Гол арга хэмжээ 4: Тулгамдсан асуудлуудыг гүнзгийрүүлэн судлах

БНХБ-ын санхүүжилтийн норм, эцэг эхийн оруулах хувь нэмрийг тооцоолохдоо нийт боловсролын салбарын санхүүжилтэд хэрхэн нөлөөлөх талаар бодолцож үзэн, тэгш байдлыг сайжруулах тал дээр анхаарах ёстой. Одоогоор мөрдөж байгаа байршлаас болон цэцэрлэгийн төрлөөс хамаарч олгодог норм, нормативууд нь чанарын ялгааг арилгахад үр нөлөөтэй байж чадахгүй байна. БНХБ-д эцэг эхийн халааснаас оруулах хувь нэмэр нь алслагдсан орон нутгийн өрхүүд, малчид болон бусад амьжиргааны түвшин доогуур өрхүүдэд санхүүгийн дарамт үүсгэж болзошгүй байна. Цаашид энэ талаар судалгаа хийж, үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудад (төрийн өмчийн болон хувийн) үйл ажиллагаагаа явуулах болон эцэг эхчүүдэд хүүхдээ хамруулахад нь төрөөс дэмжлэг үзүүлэх боломжуудыг эрэлхийлж, тухайн зорилтот бүлгээсээ хамааран янз бүрийн түвшний дэмжлэг үзүүлж болох юм. Нөхцөлт мөнгөн дэмжлэг, эрхийн бичиг зэрэг эрэлт хэрэгцээний талын шийдлүүд бас байж болно. Одоогийн нийгмийн халамжийн хөтөлбөр, тухайлбал Хүүхдийн мөнгө зэрэг хөтөлбөртэй ч холбон хэрэгжүүлж болох юм. Тус хөтөлбөрүүдийг зорилтот бүлгийн өрхүүдэд чиглүүлэх, тэдний эрх ашгийг хамгаалах эсвэл аж байдлын тестээр дамжуулан хэрэгжүүлж болно. Авч болох арга хэмжээнд төрийн өмчийн БНХБ-ын үйлчилгээнд хамрагдахад өрхийн орлогын түвшнээс хамааран хамрагдах эрхийг олгох, мөн хамтран санхүүжүүлэх хэм хэмжээг тогтоох зэрэг аргууд багтаж болно. Зорилтот хүн амын дундах боловсролын үр дүнг сайжруулахын тулд боловсролын байгууллагуудад нэг суралцагчид ногдох нэмэлт санхүүжилтийг ч олгож болох юм.

Хүснэгт 1 Монгол улсад БНХБ-ын үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулахад чиглэсэн гол арга хэмжээнүүдийн хураангуй

Гол арга хэмжээ	Хэрэгжүүлэх арга зам	Хүсч буй үр дүн, үр нөлөө
1. Хөдөө орон нутгийн БНХБ-ын хүртээмжийг сайжруулах	Гэр бүлийн орчинд олон нийт-гэр бүлд- суурилсан хөтөлбөр	Малчид гм хүрч үйлчлэхэд хүндрэлтэй өрхийн хүүхдүүдийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг сайжруулах
	Гэр цэцэрлэгийн давуу, сул талуудыг бусад БНХБ-ын хөтөлбөрүүдтэй харьцуулах	БНХБ-д зарцуулж байгаа төсвийн зарцуулалтын үр нөлөөг сайжруулах; малчин өрхийн хүүхдүүдийн БНХБ-ын үйлчилгээний хүртээмжийг сайжруулах
2. Хот суурин газруудад цэцэрлэгийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, ингэхдээ хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх	Төрийн өмчийн болон хувийн хэвшлийн цэцэрлэгийн үйлчилгээг нэмэгдүүлэхэд хөрөнгө оруулалт хийх	БНХБ-ын хүртээмж сайжрах; нэг бүлэгт байх хүүхдийн тоо хэт олон байгааг багасгах.
	Хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэхдээ чанарыг сайжруулах урамшууллын системийг бий болгох	Хувийн хэвшлийн цэцэрлэгүүдийн хоорондох чанарын ялгааг арилгах
3. Хөдөө орон нутаг руу чиглэсэн хөрөнгө оруулалтаар дамжуулан	Чанарын баталгаажилтын	Чанарын хэм хэмжээ, нормыг хэрэгжүүлэх, мөрдөх үйл явцыг хянаж, чанарын үнэлгээг

төрийн өмчийн ердийн цэцэрлэгүүдийн чанарыг сайжруулах	механизмыг бий болгох	тогтмол хийх
	Чанарыг сайжруулахдаа хөдөө орон нутаг руу чиглэх	Одоо байгаа төрийн хөрөнгө оруулалтын эрх тэгш байдал, үр нөлөөг сайжруулах
	Математик, тооны орчныг сайжруулах	Танин мэдэхүйн үр дүнг сайжруулах
	Одоогоор ангиудад байгаа хүүхдийн суралцах буланг ашиглан тоо, үсэг таниулах боломжийг нэмэгдүүлэх	Танин мэдэхүй, хэл ярианы үр чадварын үр дүнд ажиглагдаж байгаа нийгэм-эдийн засгийн түвшний ялгааг арилгах
4. Чухал асуудлуудыг хөндөж байгаа хэсгүүдийг илүү гүн судлах	БНХБ-ын санхүүжилтийн норм ба эцэг эхийн халааснаас гарах мөнгө	Төрийн хөрөнгө оруулалтын тэгш байдлыг сайжруулах зорилтот арга хэмжээг оновчтой зохион байгуулахад шаардагдах мэдээллээр хангах
	Бага насны боловсрол дахь хөвгүүдийн хоцрогдол	
	Үндэсний цөөнх байх болон хөгжлийн бэршээлтэй холбоотой тусгай хэрэгцээ	

Бүлэг 1. Монгол улсын сургуулийн өмнөх боловсрол: Үйл ажиллагаа ба санхүүжилт

Монгол улс боловсролын салбарын төсвийн 24 хувь буюу ДНБ-ний ойролцоогоор 1.0 хувийг бага насны хүүхдийн боловсролд зарцуулж байгаа нь тус улсыг сургуулийн өмнөх боловсрол дахь төсвийн өндөр зарцуулалттай улс болохыг харуулж байна. Түүхээс харахад Монгол улс суурь боловсролд хөрөнгө оруулахыг чухалчилж ирсэн төдийгүй сургуулийн өмнөх боловсролыг суурь боловсролын бүрэлдэхүүн хэсэг, сургуульд элсэн орох үндсэн тулгуур, бэлтгэл шат хэмээн үзэж иржээ. Энэхүү бүлэгт Монгол улс БНХБ-ын хүртээмжийг нэмэгдүүлэхэд ихээхэн ахиц дэвшлийг гаргасан хэдий ч саад бэрхшээлүүд байсаар байгааг тодруулж харуулна. Бага насны хүүхдийн боловсролын хамран сургалтын ялгаатай байдал нь газарзүйн байршил, үндэстний цөөнх эсэхээс ихээхэн хамааралтай төдийгүй өрхийн аж байдлын түвшин, сургуулийн өмнөх боловсролын хамрагдалт зэрэг нь голлох хүчин зүйл болж байна. Харин малчдын хүүхдүүдийн СӨБ-ын хамрагдалтыг улсын нийт хүн амд эзлэх хувьтай дүйцүүлэн шинжлэн харваас харьцангуй бага буюу цөөн хувийг эзэлж байна.

Төсвийн хуваарилалт, зарцуулалтын хэв маягийг шинжлэн ажиглавал хэд хэдэн сул тал байна. Төсвийн ихэнх хувийг цалин хөлс, хүүхдийн хоол унд, халаалт, цахилгаан зэрэгт хуваарилан зарцуулж, хичээл сургалтын хэрэглэхүүн, хүүхдийн хөгжлийг дэмжих бусад үйл ажиллагаанд маш бага буюу бараг зарцуулагдахгүй байна. Тиймээс цэцэрлэгүүд сургалтын материал болон бусад шаардлагатай хичээл, сургалтын хэрэглэгдэхүүнийг эцэг эхчүүдээс мөнгө цуглуулах, сан үүсгэх эсвэл орон нутгийн захиргаанаас нэхэмжлэх зэрэг аргуудаар хөрөнгө босгож хангадаг байна. Орон нутгийн нөөц бүрдүүлэх, мөнгөн хуримтлал сан үүсгэх боломж, чадавхиас хамааран төрийн өмчийн цэцэрлэгүүдийн сургалтын орчны чанар харилцан адилгүй, ялгаатай байхад хүргэж байна. Мөн нийгмийн эмзэг буюу зорилтот бүлгийн өрхийн хүүхдүүдийн бага насны боловсролын үйлчилгээнд хамрагдах нь цөөн, хамгийн бага хувийг эзэлж байгаа учраас бага насны хүүхдийн боловсролд үзүүлэх төрийн дэмжлэгийн ихэнх хувийг дундаж буюу дундажаас дээгүүр түвшний орлоготой, боломжийн амьдралтай өрхүүдийн хүүхдүүдэд зарцуулдаг гэсэн дүр зураг харагдаж байна.

Энэхүү бүлэг нь дараах бүтэцтэй, үүнд эхний хэсэгт бага насны хүүхдийн боловсролд төрийн хөрөнгө оруулалт нэн шаардлагатай болох тухай дэлхийн улс орнуудын туршлага, баримт нотолгоо багтаж байна. 2 дахь хэсэгт Монгол улсын бага насны хүүхдийн боловсролын үйлчилгээний тухай өгүүлэх бол, 3 дахь хэсэгт энэхүү үйлчилгээг хэн хүртэж байгааг тодруулах болно. 4 ба 5 дахь хэсгүүдэд төсвийн зарцуулалтын чиглэл, хандлагыг танилцуулж, Монгол улсын бага насны хүүхдийн боловсролын санхүүжилтийн гол шинж чанаруудыг тусган харуулна. 6 дахь хэсэгт хүүхдийн хоол хүнс, сургалтын материал, хэрэглэгдэхүүнийг нарийвчлан авч үзэж, эдгээр нь цэцэрлэгийн чанарыг тодорхойлоход чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг харуулсан. Сүүлийн буюу 7 дахь хэсэгт гол асуудлуудыг дүгнэж бичсэн.

1.1 Яагаад СӨБ-д хөрөнгө оруулах хэрэгтэй вэ?

Бага насны хөгжил нь хүүхдийн хожим насанд хүрсэн хойноо хүрэх амжилтын чухал урьдал, үндэс суурь болдог учраас бага насны боловсрол, хөгжилд хөрөнгө оруулах нь жилд 10 хүртэлх хувийн үр өгөөжтэй байж чадна. Бага насны хүүхдийн хөгжил нь тэдний хожмын, ирээдүйн амьдралыг тодорхойлдог (Cunha and Heckman, 2007;

төстэй байна.³ Хүүхдүүд бага ангид орох үед танин мэдэхүйн хөгжлийн зөрүү илт харагдаж эхэлдэг бөгөөд нийгэм эдийн засгийн түвшний хувьд доогуур байгаа хүүхдүүд чинээлэг өрхийн хүүхдүүдээс ихээхэн хоцордог байна. Анх сургуульд ороход илэрч байсан эдгээр зөрүү нь нас ахих тусам улам гүнзгийрсээр байдаг (Paxson & Schady, 2007; Grantham-McGregor et al, 2007). Тиймээс бодлого боловсруулагчид нь хүүхдийн бага насандаа хөгжих орчныг сайжруулснаар хүүхдүүдийн хоорондын хөгжлийн зөрүүг арилгаж чадна (Heckman, 2006).

СӨБ-ын үйлчилгээний чанарыг тооцолгүй зөвхөн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалт нь бага насны хүүхдийн хөгжлийн үр дүнг сайжруулах биш, улам бүр дордуулах аюултай байна. Хүүхдийн сайн сайхныг хамгаалж, цаашдын хөгжил, суралцах үйл явцад бэлтгэхэд хяналт –шинжилгээ болон чанарын баталгаажуулалт нэн чухал юм. Тиймээс чанарыг орхигдуулан зөвхөн хүртээмжийг нэмэгдүүлснээр сургуулийн өмнөх боловсролд ахиц дэвшил авчирна хэмээн найдаж байсан бодлого боловсруулагчдын зорилтыг хойш татаж болох юм. Гвиней, Кэйп Вердэ, Бангладеш зэрэг нийгэм-эдийн засгийн хөгжлийн хувьд хоорондоо багагүй ялгаатай улс орнуудын сургуулийн өмнөх боловсролын үнэлгээнээс харахад боловсролын үйлчилгээний чанараас танин мэдэхүйн хөгжлийн үр дүн хамаардаг болохыг харуулж байна (Jaramillo & Tietjen, 2002; Aboud, 2006 ба 2007). Хэрвээ боловсролын үйлчилгээний чанар муу байх нь хүүхдийн хөгжилд үр өгөөж багатай, магадгүй сөргөөр нөлөөлж болох талтай (Bernal, 2008 ба 2010; Naudeau et al, 2011). Монгол улс СӨБ-д ихээхэн хэмжээний санхүүжилтийг зориулдаг хэдий ч боловсролын үйлчилгээний чанарын талаар системтэй мэдээлэл хомс байна. Монгол улсын сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний чанарын талаарх мэдээллийг энэхүү тайлангийн дараагийн бүлгүүдэд оруулсан.

Ерөнхийлэн дүгнэвэл, энэ бүлэгт бага насны хүүхдийн хөгжилд хийх хөрөнгө оруулалтын хожмын, урт хугацааны нийгэм-эдийн засгийн үр ашгийг тооцсон дэлхийн туршлагад үндэслэн Монгол улсын сургуулийн өмнөх боловсролын хөрөнгө оруулалтыг тодруулж байна. Түүхээс харахад Монгол улс суурь боловсролд хөрөнгө оруулахыг ямагт чухалчилж ирсэн бөгөөд, боловсролын тогтолцооны хэсэг болохын хувьд сургуулийн өмнөх боловсролыг сургуульд бэлтгэх нэн чухал тулгуур хэмээн тодорхойлж иржээ. Монгол улсын сургуулийн өмнөх боловсролын хууль эрх зүйн болон бодлогын баримт бичгүүд нь салбарын хөрөнгө оруулалтын эх суурь болдог (Баримт 1.1). Эдгээрээс хоёр хуулийг онцлон тэмдэглэж байна. Тухайлбал, нэгдүгээрт

³Латин Америкийн таван орныг харьцуулсан судалгаанд (Schady et al, 2014) эдгээр улс орны судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн квартилуудад хэл ярианы хөгжлийн томоохон ялгаа байгааг илрүүлж, тухайлбал Колумб улсын хот суурин ба Эквадор улсын хөдөө орон нутгуудад нэг стандарт хазайлтаас илүү байж, мөн таван улсын хот суурин ба хөдөө орон нутгийн хувьд 0.75 стандарт хазайлтаас илүү байжээ. Эквадорын хөдөө орон нутгийн ядуу хүүхдүүдийн хувьд гэвэл нийгэм-эдийн засгийн түвшний хувьд арай дээгүүр ба доогуур байгаа хүүхдүүдийн танин мэдэхүйн хөгжлийн ялгаа бага насанд нь нэлээд их байсан бөгөөд үүнд үгийн баялаг, ой тогтоолт ба дүрслэн бодох чадварууд багтаж байна. Үгийн баялгийн хувьд нийгэм-эдийн засгийн градиентууд 3 - 5 насны хооронд нэмэгдсээр байв (Schady, 2011, энэ нь Paxson and Schady, 2007-д суурилсан юм). Индонез, Мадагаскар, Камбож болон Мозамбик улсад хийсэн судалгаанаас нь харахад бага насны хүүхдийн танин мэдэхүйн чадварын хувьд нийгэм-эдийн засгийн том ялгаа байгааг харуулж, энэхүү танин мэдэхүйн хөгжлийн үзүүлэлтүүдийн ялгаа нь бүх хүүхдийн хувьд биш ч гэлээ зарим хүүхдүүдийн хувьд нас ахих тусам улам нэмэгдсээр байдаг ажээ (Indonesia: Jung and Hasan, 2014; Madagascar: Fernald et al., 2011; Камбож ба Мозамбик: Naudeau et al., 2011. Halpern et al., 1996; Ghuman et al., 2005; Grantham-McGregor et al., 2007; Bouguen et al., 2013-г бас харна уу).

Бага, дунд боловсролын тухай хууль, хоёрдугаарт Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль юм.

Баримт 1.1 Монгол улсын сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ: Эрх зүйн зохицуулалт

Сургуулийн өмнөх боловсролын хууль эрх зүйн болон бодлогын баримт бичгүүд нь төрөөс сургуулийн өмнөх боловсролд хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө хуваарилах үндэслэл болдог. Энэ дотроос хоёр хуулийг онцлон тэмдэглэж байна. Бага, дунд боловсролын тухай хуульд сургуулийн өмнөх боловсролын зорилгыг тодорхойлохдоо хүүхдийн авьяас чадвар болон насан туршийн ур чадварыг хөгжүүлэх орчныг бүрдүүлснээр тэдний оюун санаа, бие махбод болон хувь хүнийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх юм гэж тодорхойлжээ. Монгол улсын Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд улсын цэцэрлэгт явж байгаа хүүхдүүдийн ном, сургалтын материал, тоглоом, нормативт хувьсах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ хэмээн заасан байна. Саяхан хуульд орсон өөрчлөлтийн дагуу хоолны зардлыг үе шаттайгаар эцэг эхчүүд төлөх болсон. Үүний зэрэгцээ сургуульд орох нас 7 байсныг 6 болгосон нь хүүхдүүдийн сургуульд орох бэлтгэлийг сайтар хангахын үүднээс СӨБ-д хамруулах сонирхлыг нэмэгдүүлсэн юм.

Мөн эцэст нь, “Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих цогц бодлого” (2005)-ыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Эрүүл мэндийн яам болон Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам хамтран баталсан байна. Тус бодлого нь эх хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээл, нийгмийн халамж ба хамгаалал, боловсролын асуудлыг хариуцаж байгаа төрийн захиргааны бүхий л шатны байгууллагууд болон түншлэгчдийн үйл ажиллагааг зохицуулж байгаа юм. Түүнчлэн уг бодлого нь бага насны хүүхдийн хөгжлийн чанартай үйлчилгээ үзүүлэхийн тулд нэгдмэл, цогц байдлаар ажиллахыг дэмжихийн зэрэгцээ хувийн хэвшил болон бусад оролцогч талуудын оролцоог нэмэгдүүлэх замаар үйлчилгээний олон хувилбарыг хөгжүүлэхийг дэмжиж байна. Ингэхдээ алслагдмал орон нутгийн болон хөгжлийн бэрхшээлтэй зэрэг зорилтот бүлгийн хүүхдүүдийг онцгойлон анхаарах юм (ЮНЕСКО, 2008)⁴.

1.2 Монгол улсын сургуулийн өмнөх боловсрол ба үйл ажиллагааны хэв шинж

Монгол улсад боловсролын чанартай үйлчилгээг үзүүлэх, улмаар боловсролын үйлчилгээний үр дүнг сайн байлгахын тулд хэд хэдэн онцлог зүйлсийг бодолцон үзэх ёстой. Нэгдүгээрт, Монгол улс харьцангуй цөөн хүн амтай, өргөн уудам нутагт тархан суудаг учраас төрийн үйлчилгээг зохион байгуулахад өртөг өндөртэй байдаг нь

⁴Тус бодлогын хүрээнд 2–5 насны хүүхдүүдэд зориулсан цэцэрлэгүүдийг шинээр барьж байгуулахын зэрэгцээ, Монгол улсын СӨБ-ын нийт багш нарыг ажиллах хугацаанд нь сургах, гэр бүл, эхчүүд ба эмэгтэйчүүдэд гэрээр нь очин хүүхдийн эмчийн болон сэтгэлзүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх, албан бус сургалтын үйлчилгээ, утсаар болон интернэтээр зөвлөх үйлчилгээ, радио, зурагт, сонин ба бусад хэвлэмэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан ухуулах болох мэдээлэл өгөх кампанит ажил зохион байгуулж байгаа юм. Эдгээр арга хэмжээнд хүүхдийн хоол тэжээл, ариун цэвэр, дархлаажуулалт, эрүүл мэндийн халамж асаргаа болон хүүхдийн нийгэмшихүй ба танин мэдэхүйн хөгжлийг дэмжих аргуудын талаар эцэг эхчүүдэд зааж өгөх зөвлөгөө, мэдээлэл багтаж байна.

асуудал болж байна. Нэг квадрат километр 1.7 хүн ногддог Монгол улс дэлхийн хамгийн бага хүн амын нягтаршилтай улсад тооцогддог. 3 сая гаруй хүн амын ойролцоогоор дөрөвний нэг нь гэр хэмээн нэрлэгдэх уламжлалт сууцанд амьдардаг, өөр хоорондоо 5-15 км зайтай байршин амьдрах нүүдэлчин малчид эзэлж байна. Тэдний амьдарч буй газар нутгийн цаг уур эрс тэс, зундаа +40С°-с өвөлдөө -50С° хүртэл хэлбэлздэг. Эдгээр хүчин зүйлс нь нийгмийн салбарын үйлчилгээний зохион байгуулалтад бэрхшээл учруулах төдийгүй үйлчилгээний өртөг зардал өндөр байх голлох хүчин зүйлс болдог ажээ.

Монгол улсын СӨБ-ын үйлчилгээний голлох буюу үндсэн төрөл бол төрийн өмчийн ердийн цэцэрлэгүүд юм. Тус улсын СӨБ-ын байгууллагын 90 орчим хувийг эзлэх төрийн өмчийн ердийн цэцэрлэгүүд нь өдөрт найман цагаар, долоо хоногийн таван өдөрт, 9-р сараас 6-р сар хүртэл ажилладаг. Цэцэрлэгүүд нь хүүхдийн бие бялдар, оюун ухаан танин мэдэхүй, нийгэм-сэтгэлийн хөдөлгөөний хөгжлийг дэмжих хөгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулдаг. Түүнчлэн цэцэрлэгийн өдөр тутмын үйл ажиллагааны төлөвлөлтийн дагуу аялал зугаалга зэрэг эрүүл мэнд, бие бялдрын хөгжлийг дэмжих арга хэмжээ, үйл ажиллагааг зохион байгуулдаг. Ердийн үйл ажиллагаатай цэцэрлэгээс гадна цөөн тооны сувиллын болон тусгай цэцэрлэгүүд бий. Эдгээр нь хүүхдүүдийг тодорхой хугацаанд цэцэрлэг дээр байрлуулан эрүүл мэнд болон хөгжлийн хэрэгцээнд нийцүүлэн асран сувилах, хөгжүүлэх зэргээр үйлчилгээ үзүүлдэг.

СӨБ олгох хувилбарт сургалтууд байх ба эдгээрээс хамгийн түгээмэл хэлбэр нь гэр цэцэрлэг юм. Монгол улс өргөн удам нутагтай, хүн ам нь тархай байрладаг учраас ердийн цэцэрлэгээс гадна СӨБ-ын хувилбарт сургалтын хөтөлбөрийг бий болгоход хүргэжээ. Үүнд нөлөөлсөн бас нэг хүчин зүйл бол Монгол улсын нийт хүн амын бараг дөрөвний нэг нь уламжлалт мал аж ахуй эрхлэж нүүдэллэн амьдардаг учраас СӨБ-ын үйлчилгээг малчдын хүүхдүүдэд хүргэхэд зарим талаар хүндрэлтэй байдаг. Энэхүү хүндрэлийг даван туулахын тулд СӨБ-ын тухай хуулинд сургуулийн өмнөх боловсролыг хувилбарт хэлбэрүүдээр олгож болох тухай зааж хууль, эрх зүйн орчныг бүрдүүлснээр төрийн өмчийн ихэнх цэцэрлэгүүд хувилбарт сургалтыг зохион байгуулж байна (Баримт 1.2). Сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалтыг гурван хэлбэрээр зохион байгуулж байна. Үүнд: явуулын багшийн сургалт; нүүдлийн гэр цэцэрлэг буюу нүүдлийн бүлэг; ээлжийн бүлэг зэрэг багтаж байна (Баримт 1.1). Эдгээр төрлүүдээс хамгийн түгээмэл нь гэр цэцэрлэгүүд бөгөөд эдгээрийг төрин өмчийн ердийн цэцэрлэгийг түшиглэн салбар бүлэг хэлбэрээр зохион байгуулж байна.

Хүснэгт 1.1 Монгол улсын СӨБ-ын хувилбарт сургалтын хэлбэрүүд

СӨБ-ын хувилбарт сургалтын хэлбэрүүд	Явуулын багшийн сургалт	Өрх, гэрээр нь очиж хүүхэд болон эцэг эхэд боловсролын үйлчилгээ үзүүлэх
	Гэр цэцэрлэгийн сургалт	Уламжлалт сууц гэрийг цэцэрлэгийн бүлгийн зориулалтаар ашиглан боловсролын үйлчилгээг хүргэх
	Ээлжийн бүлгийн сургалт	Цэцэрлэгт хамрагдаагүй боловч цэцэрлэгийн ойролцоо амьдардаг хүүхдүүдийг өдөрт богино цагаар цэцэрлэг дээр авчран хөгжүүлэх үйл ажиллагаанд хамруулах замаар СӨБ олгох

Эх сурвалж: Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, НҮБ-ын Хүүхдийн сан

Баримт 1.2 Гэр цэцэрлэг: Нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг өрхийн хүүхдүүдэд СӨБ-ын үйлчилгээг хүргэх шинэлэг арга хэлбэр

Гэр цэцэрлэг нь ердийн цэцэрлэгийн үйл ажиллагааг Монгол орны онцлог, өвөрмөц нөхцөл байдалд нийцүүлсэн шинэлэг арга хэлбэр тул дэлгэрэнгүй өгүүлэх нь зүйтэй (хавсралт 1-д гэр цэцэрлэгийн тухай ойлголт хэрхэн гарч ирсэн талаар өгүүлсэн). Гэр цэцэрлэг нь Монгол орны нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг өрх, хүн амын нийгэм-эдийн засаг, соёл, зан заншилд нийцүүлсэн СӨБ-ын үйлчилгээний хэлбэр юм. Ихэнх гэр цэцэрлэгүүд нь монголын ард түмний уламжлалт сууц болох 2 гэрт үйл ажиллагаа явуулна. Эхний гэрт нь хөгжүүлэх үйл ажиллагаа, сургалтыг зохион байгуулах ба нөгөө гэрийг хөгжүүлэх үйл ажиллагаанд бэлдэх, хоол цай хийх, амрах зэрэгт ашигладаг. Гэрийн насжилт нь түүнийг хийсэн материал, үйлдвэрлэлийн чанар зэргээс шалтгаалан 10-20 жил ашиглагдах боломжтой. Гэр дотор бага насны хүүхдийн хөгжлийн хэрэгцээнд нийцсэн тавилга, тухайлбал ширээ, сандал, тавиур, тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүн, амрах дэвсгэр зэрэг байна. Нэг гэр цэцэрлэг 2-5 насны 20-25 хүүхдийг хүлээн авах боломжтой байдаг.

Нүүдлийн гэр цэцэрлэгүүд нь зөвхөн зун ажилладаг төдийгүй малчин өрхүүд ойролцоо олноороо нутаглаж буй газар нутагт хүрч үйлчлэхэд чиглэдэг. Нүүдлийн гэр цэцэрлэгүүд нь нэг газраас нөгөө рүү нүүхдээ гэрийг ачааны машин дээр ачиж, зуны саруудад ойролцоо амьдарч буй 10-15 өрхийн нутаглах газарт байрлан нүүж тэдгээрийн бага насны хүүхдүүдэд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг үзүүлдэг.

Гэр хэмээх монголын ард түмний уламжлалт сууц нь барьж угсрахад амар хялбар төдийгүй ойролцоогоо гэрийг барих эсвэл буулган хураахад 1-2 цаг зарцуулна.

Гэр цэцэрлэгүүд нь сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг нүүдэллэн амьдардаг малчин өрхийн хүүхдүүдэд хүргэх боловсролын үйлчилгээний хэлбэр болж байна. Гэр цэцэрлэгүүд нь ердийн цэцэрлэгийн үйл ажиллагаа завсарлах үеэр зохион байгуулагдаж байгаа тул ердийн цэцэрлэгт ажиллаж буй мэргэжлийн багш нар зуны улиралд малчдын хүүхдүүдэд боловсролын үйлчилгээг мэргэжлийн түвшинд үзүүлэх нөхцөл болдог. Малчин өрхүүд төв суурин газраас алс хол амьдардаг тул гэр цэцэрлэг нь бага насны хүүхдүүдэд зөвхөн сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг хүргээд зогсохгүй тэдний өөр хоорондоо, үе тэнгийнхэнтэйгээ харилцах, нийгэмших орчин болдог.


Гэр цэцэрлэг нь өдөрт 8 цагийн хугацаатай ажилладаг хэдий ч малчдын амьдрал ахуйн онцлогоос шалтгаалан зөвхөн зундаа буюу 6-8-р саруудад үргэлжлэх боломжтой байдаг. Эцэг эх, хамаатан садан нь хүүхдийг өглөө цэцэрлэгт авчирч, орой авдаг бол заримдаа цэцэрлэг дээр багштай нь хонуулах нь ч бий. Гэр цэцэрлэг нь гурваас зургаан долоо хоногийн хугацаанд нэг байршилдаа байгаад малчдын нүүдлийг даган дараагийн байршил рүү нүүдэг. Гэр цэцэрлэгийн үйлчилгээг зунаас бусад улиралд бараг зохион байгуулахгүй.

Гэр цэцэрлэгүүдийг тэднийг харьяалж буй төрийн өмчийн ердийн цэцэрлэгүүд удирддаг. Гэр цэцэрлэгийн багшийн цалин, урсгал зардал болон бусад шаардлагатай төсвийг төрөөс хуваарилан олгож байна. Орон нутагт зарим тохиолдолд сумын захиргаанаас гэр цэцэрлэгүүд ажиллуулах, гэр цэцэрлэгийн төсөвт нэмэр болох арга хэмжээний нэмэлт эх үүсвэрийг хангаж өгөх нь бий. Бараг бүхий л тохиолдлыг ажиглахад гэр цэцэрлэгийн зориулалттай гэр, тавилга, тоног төхөөрөмж, тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүн зэргийг олон улсын хөгжлийн болон тусламжийн байгууллагууд, хандивлагчдын санхүүгийн дэмжлэгтэйгээр худалдан авч бүрдүүлж байна.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын тоо нэмэгдэж байгаа нь хувийн цэцэрлэгүүд олшрох болсонтой холбоотой юм. СӨБ-ын хамран сургалт байнгын өсөлттэй байна. 2004-2005 оны хичээлийн жилд улсын хэмжээнд 687 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байсан бол 2014-2015 онд 1288 -д хүрч 87%-иар өссөн үзүүлэлттэй байна (зураг 1.2). 2014 онд 675 нүүдлийн гэр цэцэрлэгийн бүлэг, 200 ээлжийн бүлэг болон 8 явуулын багшийн бүлэг байжээ. СӨБ-ын үйлчилгээ үзүүлж буй нэгжийн тоо өссөн явдал нь хувийн сектороос үүдэлтэй бөгөөд СӨБ дахь хувийн цэцэрлэгийн эзлэх хувийн жин 7 хувиас 35 хувь болон өсчээ. Хувийн цэцэрлэгүүдийн 78 хувь нь нийслэл Улаанбаатар хотноо байрладаг. Харин хувилбарт сургалтыг зөвхөн төрийн өмчийн цэцэрлэгүүд зохион байгуулж, үйл ажиллагааны зардлыг улсаас хангаж байна. Хувийн цэцэрлэгүүдийн тоо өсч байгаа ч гэсэн сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний гол ханган нийлүүлэгч улс хэвээрээ байгаа бөгөөд, улсын цэцэрлэгүүдэд СӨБ-д хамрагдсан хүүхдүүдийн 90 хувь бүртгэлтэй байна.

Цэцэрлэгийн хамт олон нь эрхлэгч, багш, туслах багш, арга зүйч ба бусад ажилчдаас бүрддэг. Улсын болон хувийн цэцэрлэгүүд нь одоогоор 24179 хүнийг ажиллуулж байгаа бөгөөд үүнд 6833 багш, 6133 туслах багш, 1204 эрхлэгч, 510 арга зүйч болон 9499 туслах ажилтнууд байна. Цэцэрлэгийн нормативийн дагуу нэг бүлгийг нэг багш, туслах багшийн дэмжлэгтэйгээр удирдах ёстой боловч бодит байдал дээр үндсэн багш нарт ногдож байгаа туслах багш нэгээс бага зэрэг бага байна. 2010-2015 хичээлийн жилийн мэдээллээс харахад цэцэрлэгт ажиллаж байгаа багш нарын тоо (багш, туслах багш, дуу хөгжмийн багш) өссөөр байгаа бөгөөд ялангуяа хувийн цэцэрлэгүүдэд ажиллаж байгаа багш нарын тоо өсч байна. Харин нөгөө талаас ердийн цэцэрлэгт хамрагдаж байгаа хүүхдүүдийн тоо нэмэгдэж байгаатай холбоотойгоор СӨБ-ын хувилбарт сургалтын багшийн тоо буурч байна.

Зураг 1.2 Монгол дахь улсын болон хувийн цэцэрлэгүүдийн чиг хандлага, 2004-14



Эх сурвалж: БСШУЯ (2014)

Хүснэгт 1.2 Монгол улсын СӨБ-ын ажилтнуудын тоо, 2015

	Эрхлэгч	Арга зүйч	Багш	Туслах багш	Бусад ажилтан	Нийт
Улсын	798	449	5542	4971	8244	20004
Хувийн	406	61	1291	1162	1255	4175
Нийт	1204	510	6833	6133	9499	24179

Эх сурвалж: БСШУЯ (2016)

Хүснэгт 1.3: Монгол улсын СӨБ-ын багш нарын бүтэц, 2015

Хичээлийн жил	Багш	Үүнээс:				Туслах багш
		Бүлгийн	Дуу хөгжмийн	Ээлжийн бүлгийн	Нүүдлийн гэр цэцэрлэгийн	
2011-2012	4907	4241	479	94	93	4326
2012-2013	5332	4632	516	88	96	4769
2013-2014	5895	5177	530	96	92	5249
2014-2015	6158	5446	568	72	72	5589

2015-2016	6833	6052	639	65	77	6133
Эх сурвалж: БСШУЯ (2016)						

1.3 Монгол улсын сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний хүртээмж


Сүүлийн арван жилд СӨБ-ын хамран сургалт тогтвортой өссөөр ирсэн. 2005 - 2016 оны хугацаанд СӨБ-д хамрагдсан хүүхдийн тоо маш хурдацтай буюу 84 хувиар өсч, СӨБ-д хамрагдсан хүүхдийн тоо 122536-гаас 225388 болж өссөний дотор 201834 хүүхэд цэцэрлэгт, 23554 хүүхэд СӨБ-ын хувилбарт сургалтад хамрагдаж байна (хүснэгт 1.4). СӨБ-ын хамран сургалт өссөн хэдий ч 2-оос доош насны хүүхдүүдийн дунд өсөлт маш хурдацтай байжээ. Харин сургуульд элсэх нас 6 болсонтой холбоотойгоор энэ насны хүүхдийн СӨБ-д эзлэх хувийн жин буурчээ.

Хүснэгт 1.4 СӨБ-д хамрагдсан хүүхдийн тоо

Хичээлийн жил	Тоо	Насны ангилал			
		2 нас хүртэл	2 нас	3-5 нас	6 нас
2011-2012	164263	5383	30937	124442	3501
2012-2013	180969	5920	30673	142125	2251
2013-2014	193672	6560	35587	149932	1593
2014-2015	206636	8085	41453	155478	1620
2015-2016	225388	8213	46799	168723	1653
Эх сурвалж: БСШУЯ (2016)					

СӨБ-ын хувилбарт сургалтанд хамрагдаж буй хүүхдүүдийн тоо нэлээд урт хугацааны туршид тогтмол хэмжээнд байснаа сүүлийн хэдэн жил бага зэрэг буурч байна. Зураг 1.3а-д ердийн цэцэрлэг болон хувилбарт сургалтанд хамрагдсан хүүхдийн тооны өөрчлөлтийг харуулсан байна. Тус улсын сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт ерөнхийдөө нэмэгдэж байгаа ч хувилбарт сургалтанд хамрагдсан хүүхдийн тоо 2010 оноос хойш бага зэрэг буурчээ. Энэхүү бууралтанд олон хүчин зүйлс, тухайлбал ердийн цэцэрлэгийн хүртээмж нэмэгдсэн, шилжин суурьшилт хөдөөнөөс хот руу чиглэсэн, хувилбарт сургалтын санхүүжилт буурсан болон хувилбарт сургалтын чанар хангалтгүй зэрэг нөлөөлсөн байж болох юм.


Зураг 1.3а Монгол улсын СӨБ-д хамрагдсан хүүхдүүдийн тооны өсөлтийн чиг хандлага, 2005-2015



Эх сурвалж: БСШУЯ (2015)

Сүүлийн хорин жилд Монгол улсын СӨБ-ын хамран сургалт хурдацтай өсч, өөрийн адил эдийн засгийн дундаж өсөлттэй орнуудтай харьцуулахад өндөр хөгжилтэй орнуудынхтай дөхөж очсон байна. Дээр дурьдсанчлан СӨБ-ын үйлчилгээний төрлийг өргөжүүлснээр Монгол улсад СӨБ-ын хамран сургалт⁵ нэмэгдэж, 1991 онд нийт 2–5 насны хүүхдийн 40-өөс доош хувь нь СӨБ-д хамрагдаж байсан бол 2014-2015 онд 80 хувь болон өсчээ. Гэвч энэхүү албан ёсны тоонд цэцэрлэг болон хувилбарт сургалтын хоёулангийнх нь тоог оруулсан юм. 2014-2015 он хүртэлх хичээлийн жилд цэцэрлэгийн хамран сургалт

Зураг 1.36 Монгол улсын СӨБ-д хамрагдсан 36-59 сартай хүүхдүүдийн эзлэх хувийн жин, 2013 оны байдлаар




71.3 хувьтай байж, үлдсэн 9.2 хувь нь хувилбарт сургалтанд хамрагдсан хүүхдүүд эзэлж байв. НҮБ-ын Хүүхдийн сангийн Нийгмийн олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаанд (MICS-2013), албан буюу ердийн цэцэрлэгийн хамрагдалтын хувийг тусгасан байх бөгөөд энэ нь сая дурьдсан албан ёсны тоотой бараг адилхан байгаа юм. 2013 онд хийсэн судалгаагаар сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 36-59 сартай хүүхдүүдийн дунд 68 хувьтай байж, 2010 онд 58 хувьтай байсан нь гурван жилийн дотор мэдэгдэхүйц хэмжээгээр нэмэгдсэнийг харуулж байна. Энэхүү өсөлтийг нэг суралцагчид ногдох хэмжээгээр авч үзвэл, Монгол улсын СӨБ-ын хамран сургалт нь бусад дундаж хөгжилтэй орнуудынхтай харьцуулахад өндөр хөгжилтэй орнуудынхтай тун дөхөж байна.

СӨБ-ын хамран сургалт нэмэгдэж байгаа ч, газарзүйн байршил болон үндэсний цөөнхийн хувьд хамран сургалтын зөрүү байсаар байна. Хөдөөд СӨБ-ын хамран сургалт доогуур буюу 36-59 сартай хүүхдүүдийн дөнгөж 46 хувь нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байна (зураг 1.36). Мөн нийслэл Улаанбаатар хотын хамран сургалт аймгийн болон сумын төвүүдийн үзүүлэлтээс 10 пунктээр доогуур байна. Хөдөө орон нутгийн хамран сургалт доогуур байгаа нь асуудал хэдий боловч нийслэл хотод ч бас зарим хүүхдүүд СӨБ-д хамрагдахад хүндрэлтэй байна.

Үүнээс гадна үндэсний цөөнхийн хувьд хамран сургалтын ялгаа байна. Үндэсний цөөнх болох казах өрхүүдийн хүүхдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдах нь бусдаас харьцангуй бага буюу 24 пунктээр доогуур байна.

⁵ Хамран сургалт нь цэцэрлэгт хамрагдаж байгаа хүүхдүүдийн тоог 2-5 настай нийт хүүхдүүдийн тоонд харьцуулсан үзүүлэлт юм.

Зураг 1.4 Монгол улс болон Зүүн Европ, Ази, Латин Америкийн орнуудын СӨБ-ын нийт хамран сургалтын хувь




Эх сурвалж: Дэлхийн банкны үзүүлэлтүүд

Төрийн өмчийн ердийн цэцэрлэгийн хамран сургалт Улаанбаатар хот, зүүн ба төвийн бүсийн нутгаар хамгийн өндөр байгаа бол хувилбарт сургалтын тухайд баруун болон хангайн бүсийн нутгаар өндөр байна. Ердийн цэцэрлэгийн хамран сургалтын үзүүлэлт аймгуудын хооронд нэлээд зөрүүтэй⁶ (зураг 1.5), тухайлбал СӨБ-ын хамран сургалт Баян-Өлгий, Өвөрхангай аймгуудад 55 хувьтай байхад Говьсүмбэр аймагт 93 хувьтай байна. Харин Улаанбаатар хотод 74 хувьтай байна. Гэр цэцэрлэг зэрэг хувилбарт сургалтын үйлчилгээ нь нүүдэлчин малчин ахуй, байршилтай холбоотой байдаг тул нийт хамран сургалтын 20 орчим хувийг хувилбарт сургалт эзэлж байгаа баруун ба хангайн бүсэд ердийн цэцэрлэгийн хамран сургалт доогуур байгаа юм⁷. Эдгээр бүс нутагт оршин суудаг СӨБ-д хамрагдаж байгаа хүүхдүүдийн гуравны нэгээс дөрөвний нэг хэсэг нь хувилбарт сургалтанд хамрагдаж байгаа юм. Ерөнхийдөө хамран сургалт нь Дархан-Уул аймагт 1.5 хувь байхад Баянхонгор аймагт 27 хувь байгаа зэргээр аймгуудын үзүүлэлтүүд зөрүүтэй байна.

⁶ Монгол улс нь захиргааны нэгжийн хувьд Улаанбаатар хот (нийслэл хот), 21 аймагт хуваагддаг. Аймгууд нь сумдад хуваагдаж, сум нь багуудад хуваагддаг. Улаанбаатар хот нь есөн дүүрэг ба хороодод хуваагддаг.

⁷ Энэ хоёр бүс нутаг нь ОУБТС-д хамгийн бага тооны СӨБ-ын хамрагдалттай байдаг.

Зураг 1.5 Монгол улсын 2-5 хүртэлх насны хүүхдийн СӨБ-ын хамран сургалт, аймаг тус бүрээр, 2014-2015



Эх сурвалж: БСШУЯ (2015)

Өрхийн амьжиргааны түвшин нь СӨБ-ын хамрагдалтад нөлөөлөх гол хүчин зүйл болдог бөгөөд өрхийн шинж байдлыг судлан үзэхэд үндэсний цөөнх болох Казах өрхийн хүүхдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдах нь асуудалтай хэвээр байна. Өрхийн түвшний хүчин зүйлсээс өрхийн амьжиргааны түвшин нь хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдах эсэхийг тодорхойлдог гол хүчин зүйл болдог байна (хавсралт 2). ОУБТС (2010)-ны өрхийн түвшний хүчин зүйлсийг нийтэд нь шинжлэн дүгнэж үзэхэд аж байдлын индексийн хувьсагчдын коэффициентууд нэлээд зөрүүтэй байна (зураг 1.6). Өрхийн аж байдлын хамгийн доод түвшинд буй өрхийн хүүхдүүд илүү боломжтой өрхүүдийн хүүхдүүдтэй харьцуулахад СӨБ-д хамрагдах магадлал нь 40 пунктээр бага байна. Эдийн засгийн бүх хувьсагч үзүүлэлтүүдийг дүгнэж үзэхэд Казах хүүхдүүдийн хоцрогдол статистик тооны хувьд их биш боловч коэффициентийн хэмжээ нь зөрүү ихтэй хэвээр буюу 14 хувь пунктын зөрүүтэй байна. Харин хүйсийн ялгаа байхгүй байна.


Малчдын хүүхдийн СӨБ-д хамрагдах нь нэмэгдэж байгаа ч, тэдний СӨБ-ын хамран сургалтад эзлэх хувийн жин хангалтгүй хэвээр байна. Сүүлийн арван жилд, малчин өрхийн хүүхдүүдийн СӨБ-ын хамран сургалтын үзүүлэлт тав дахин өсчээ. Малчдын хүүхдүүдийн СӨБ-ын хамрагдалт 2000 оны эхэн үеэр тун ахицтай өссөн боловч сүүлийн жилүүдэд зогсонги байдалтай болсон байна (хавсралт 3). 2014-2015 онд СӨБ-д хамрагдаж байгаа хүүхдийн 14 хувь нь малчдын хүүхдүүд байжээ. Гэвч Монгол улсын нийт хүн амын дөрөвний нэгийг малчид эзэлж байгаа атал тэдний хүүхдүүдийн СӨБ-д хамрагдалт доогуур үзүүлэлттэй байна.

1.4 СӨБ-ын төсвийн зарцуулалт

Улсын төсөвт боловсролын салбарын эзлэх хувийн жин сүүлийн арван жилд хэлбэлзсээр байна⁹. Монгол улс боловсролыг чухалчилсаар ирсэн бөгөөд боловсролын төсөв улсын хөрөнгө нөөцийн ихээхэн “том” хэсгийг бүрдүүлдэг. ДНБ-ээс буюу төрөөс боловсролын салбарт зарцуулах төсөв нь 2001 онд 8.5 хувь буюу оргилдоо хүрсэн боловч тэр цагаас хойш хэлбэлзсээр байгаа төдийгүй сүүлийн жилүүдэд буурч, 2014 онд ойролцоогоор 4.1 хувьтай болжээ. Энэхүү хэлбэлзэл нь Монгол улсын макро-эдийн засгийн тогтворгүй орчны улмаас ДНБ-д өөрчлөлт гарсантай холбоотой байна.


Боловсролын зардал нь инфляцийг эс тооцвол ерөнхийдөө тогтвортой байсаар ирсэн. Боловсролын салбарын зардал 2010 онд 30 хувиас дээш гарч, дотоодын орлогын ихээхэн хэсгийг авч байсан бол, энэ үзүүлэлт нь 2014 онд 16 хувь болж улмаар буурах хандлагатай болжээ.

Зураг 1.6 Монгол улсын 36-59 сартай хүүхдүүдийн СӨБ-д хамрагдах магадлал ба өрхийн амьжиргааны түвшний харилцан хамаарал, 2010 оны байдлаар⁸




Эх сурвалж: ОУБТС-г ашиглан гаргасан зохиогчийн тооцоо (2010)

Зураг 1.7 Монгол улсын боловсролын салбарын төсвийн зарцуулалт, 2000-14 он



Эх сурвалж: БСШУЯ (2015)

Зураг 1.8 Монгол улсын боловсролын салбарын төсвийн зарцуулалт-боловсролын түвшингээр, 2008-12 он




⁸Багануудын өндөр нь аж байдлын аль нэг түвшинд хамаарах өрхүүдийн СӨБ-д хамрагдаж байгаа хүүхдүүдийн эзлэх хувийн хоорондын зөрүүг харуулж, ядуу хэсэгт багтаж байгаа хүүхдүүдийн эзлэх хувийг ч бас харуулж байна (энэ хэсгийг хассан). Бүх зөрүүг 1 хувийн түвшин дотор авч үзвэл хоорондоо нэлээд зөрүүтэй харагдаж байна. Предиктор буюу бие даасан хувьсагчид эхийн боловсролын түвшин, хүүхдийн хүйс, орон нутгийн байршил ба бүс, өрхийн тэргүүний яс үндэс ба итгэл үнэмшил, амьдарч буй орчин зэрэг орсон байна.

⁹Энэ хэсгийг ихэвчлэн Дэлхийн Банкны 2008 онд хийсэн Төсвийн зарцуулалтын тойм судалгаанд (ТЗТС) үндэслэсэн юм. Үүнтэй холбоотой шинэ мэдээлэл 2017 оны 9 сард хийгдэж дуусах ТЗТС-гаар гарах бөгөөд урьдчилсан дүн шинжилгээгээр 2008 оноос хойшхи зарцуулалтын хэм хэмжээ тогтвортой байсан байна.

Боловсролын салбарын зардал бага, дунд боловсролын хувьд нэлээд өндөр байсан боловч сүүлийн үеийн мэдээллээс харахад сургуулийн өмнөх боловсролд зарцуулах хөрөнгө нэмэгдэх чиг хандлагатай. Монгол улсын боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй нийт оюутан, суралцагчдын 70 орчим хувийг ерөнхий боловсролын сургуулийн сурагчид эзэлж, төрөөс ихэд чухалчилдаг ерөнхий боловсролын зардал нь нийт боловсролын салбарын зардлын талаас илүү хувийг эзэлдэг. Дээд боловсролын салбарт зарцуулж байгаа санхүүжилтийн хувь сүүлийн жилүүдэд буурчээ. Учир нь Засгийн газар тус дэд салбарыг хувийн санхүүжилтээр (сургалтын төлбөрөөр) санхүүжүүлж болно хэмээн үзэж байгаа учраас улсын дэмжлэг буурсан юм. Харин төрөөс буюу засгийн газраас сургуулийн өмнөх боловсролд зарцуулах санхүүжилт харьцангуй тогтвортой байв. Засгийн газар хүүхдүүдийг зургаан настайд нь 1-р ангид цаг алдалгүй хамруулахыг эрмэлзэж байгаа учраас энэ дэд салбар боловсролын нийт зардлын 22-24 хувийг эзэлж байна. Сүүлийн жилүүдэд хандивлагчид ч тус дэд салбарт нэлээд хөрөнгө хуваарилж байна.


Зураг 1.9а СӨБ-д зарцуулах төсвийн зарцуулалт - номинал дүнгээр **Зураг 1.9б СӨБ-д зарцуулах төсвийн зарцуулалт - бодит дүнгээр**



Эх сурвалж: БСШУЯ (2015)

Монгол улсад СӨБ үнэ төлбөргүй бөгөөд ихэнх орнуудтай харьцуулахад СӨБ-ын санхүүжилт илүү байна. Монгол улсын СӨБ-ын зарцуулалтын ДНБ-д эзлэх хувь (1.0%) болон боловсролын салбарын нийт төсвийн зарцуулалтанд эзлэх хувийн жин (24%-г авч үзвэл бусад дундаж орлоготой орнууд болон ЭЗХАХБ-ын өндөр хөгжилтэй орнуудаас ч илүүг зарцуулдаг байна.


Зураг 1.10 Боловсролын салбарын нийт төсвийн зарцуулалтанд эзлэх хувийг Монгол улс ба бусад дундаж орлоготой орнуудтай харьцуулсан нь



СӨБ-ын байгууллагуудын урсгал зардлын дийлэнх хэсгийг ажилтнуудын цалин эзэлдэг бөгөөд дараа нь хүүхдийн хоол, аж ахуй үйлчилгээний төлбөр, хувийн хэвшилд үзүүлэх дэмжлэг орж байна. Өмнө нь төрийн санхүүжилтийн нэлээд хэсгийг хөрөнгийн зардал эзэлж, үүнд СӨБ хамаардаг байсан бол, энэхүү бүлгийн төгсгөлд өгүүлсэнчлэн 2012 оны Нэгдсэн төсвийн тухай хуулийн (НТТХ) дагуу хөрөнгө оруулалтын зориулалттай төсвийн зарцуулалт хийх эрх, хариуцлагыг орон нутгийн захиргаанд шилжүүлсэн тул одоогоор улсын төсвөөс боловсролын салбарт зориулан зарцуулж байгаа зарцуулалт нь зөвхөн урсгал зардлыг хамарч байна. СӨБ-ын хувьд урсгал зардлын хамгийн их хэсгийг эзлэх ангилалд цалин хөлс, нийгмийн даатгалаас олгож буй төлбөрүүд (65%), үүний дараа хоол хүнс (18%), нийтийн аж ахуй үйлчилгээний төлбөр (10%), мөн хувийн хэвшилд олгох дэмжлэг багтаж байна (7%)¹⁰. Монгол орон өргөн дэлгэр газар нутагтай, хүйтэн хахир өвөлтэй учир дулааны зардал нь тус улсын боловсролын салбарын бүхий л байгууллагуудад тулгардаг нийтийн аж ахуйн үйлчилгээний ихээхэн хэмжээний урсгал зардал юм. Үүний зэрэгцээ Монголын төр төсвийнхөө багагүй хэсгийг СӨБ-д хамрагдсан хүүхдүүдийн хоол хүнсэнд зарцуулдаг. Тиймээс хичээл, сургалтын хэрэглэгдэхүүн, материалыг "бусад" гэсэн зардлын ангилалд багтааж, эдгээр зардлыг ихэвчлэн тухайн цэцэрлэгийн эцэг эхчүүд санхүүжүүлдэг болохыг дараагийн бүлгүүдэд дэлгэрүүлэн өгүүлэх болно.

¹⁰Одоо тогтолцооны дагуу улсын төсвөөс хувийн цэцэрлэгүүдэд олгох дэмжлэг нь зөвхөн хувьсах зардалд чиглэж байгаа бөгөөд үүнийг төрийн өмчийн цэцэрлэгийнхтэй адил байдлаар тооцож гаргадаг. Энэ тухай тус хэсгийн төгсгөлд өгүүлнэ.

Зураг 1.11 Монгол улсын СӨБ-ын зарлагын бүтэц



Эх сурвалж: БСШУЯ (2016)

Төрийн өмчийн ердийн цэцэрлэгүүд сургуулийн өмнөх боловсролын төсвийн зарцуулалтын дийлэнх хэсгийг эзэлж түүний дараа гэр цэцэрлэгүүд орж байна. СӨБ-ын төсвийн урсгал зардлын 88 хувь нь ердийн цэцэрлэгийн үйл ажиллагаанд зарцуулагдаж байна. Үүний дараа СӨБ-ын хувилбарт сургалтын нэн түгээмэл хэлбэр болох гэр цэцэрлэгүүд 6 хувийг эзэлж, үүний дараа 24 цагийн цэцэрлэг (2 хувь), ээлжийн бүлэг (2 хувь), явуулын багшийн сургалт (< 1 хувь) тус тус орж байгаа юм.

СӨБ-ын үйлчилгээний нэг хүүхдэд ногдох зардал тухайн байгууллагын төрлөөс хамааран өөр өөр байгаа боловч, хамгийн өндөр нь 24 цагийн ажиллагаатай цэцэрлэгүүдийнх, хамгийн бага нь ээлжийн бүлгийнх байна. 2015 оны төсвийн зарцуулалтын мэдээллээс харахад СӨБ-ын үйлчилгээг хүргэхэд нэг сурагчид ногдох жилийн дундаж зардал нь 24 цагийн цэцэрлэгийн хувьд хамгийн өндөр, удаах нь ердийн цэцэрлэгүүд, нүүдлийн цэцэрлэгүүд, ээлжийн бүлгүүд ба явуулын багшийн үйлчилгээнд тус тус ногдож байна. 24 цагийн цэцэрлэгийн өндөр өртөг нь хүүхдүүдийг цэцэрлэгт байрлуулж олон төрлийн үйлчилгээ (унтах өрөө, хоол унд, аж ахуй үйлчилгээний зардал гэх мэт) үзүүлдэгтэй холбоотой бол, СӨБ-ын хувилбарт сургалт нь харьцангуй өртөг багатай байна. Үүнд ээлжийн бүлэг, явуулын багшийн сургалт хамаарах ба зөвхөн зуны цагаар ажилладаг нүүдлийн цэцэрлэгийн хувьд дулааны зардал гарахгүй байх жишээтэй.

Хүснэгт 1.5 Төсвийн зарцуулалтыг СӨБ-ын байгууллагын хэв шинжээр харуулсан нь, Монгол улс, 2015

	Хүүхдийн тоо	Жилийн нийт зарцуулалт	Нийт зарцуулалтанд эзлэх %	Нэг ноогдох дундаж зардал	хүүхдэд жилийн зардал
	Жилийн дундаж	(мян.төг)		(мян.төг)	
24 цагийн цэцэрлэг	3094	3,944,581	2.19	1,275	
Ээлжийн бүлэг	6563	3,716,323	2.06	566	
Нүүдлийн гэр цэцэрлэг	17696	11,649,373	6.46	658	
Явуулын багшийн сургалт	2554	1,500,216	0.83	587	
Ердийн цэцэрлэг	154788	159,414,866	88.45	1,030	
Нийт	184695	180,225,359	100.00	976	

Эх сурвалж: БСШУЯ (2015)

1.5 СӨБ-ын санхүүжилтийн тогтолцоо¹¹

Монгол улсын Нэгдсэн төсвийн тухай хуулийн дагуу сургуулийн өмнөх ба ерөнхий боловсролын үйлчилгээг хангаж өгөх үүрэг хариуцлагыг хоёрдахь шатны захиргааны байгууллагуудад хуваарилан, улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх болсон. Тус хуульд заасны дагуу БСШУСЯ нь хоёрдахь шатны захиргааны байгууллага ба бусад холбогдох байгууллагуудтай хамтран Боловсролын хөгжлийн богино болон урт хугацааны төлөвлөгөөг боловсруулах үүрэгтэй. Яамны энэнхүү төлөвлөгөө нь Засгийн газраас тогтоосон норм, нормативын хамтаар *аймаг, сумд* ба *дүүргүүдийн* боловсролын хөгжлийн богино ба урт хугацааны төлөвлөгөөг боловсруулах үндэс суурь болж өгдөг. Орон нутгийн боловсролын хөгжлийн төлөвлөгөөг тухайн бүс нутгийн холбогдох хурлаар баталсны дараа БСШУСЯ тусгай зориулалтын шилжүүлгийг засгийн газраас баталсан төсвийн хэмжээнд багтаан хянан засварлаж, *аймгуудын* боловсролын газар руу илгээдэг.

Засгийн газраас тусгай зориулалтын шилжүүлэгт хуваарилсан хөрөнгө орон нутгийн түвшинд үйл ажиллагаа явуулж байгаа боловсролын байгууллагуудын орлогын гол эх үүсвэр болдог ба үүнд СӨБ-ын байгууллагууд орж байна. 2011 оны ТТХ-иар орон нутгийн засаг захиргаа боловсролын байгууллагуудын засвар үйлчилгээг хариуцах болсон. Учир нь эдгээр барилга байгууламж нь орон нутгийн өмч билээ. Тиймээс СӨБ-ын байгууллагыг оролцуулан боловсролын байгууллагууд нь Орон нутгийн хөгжлийн сангаас (ОНХС) санхүүжилт авах эрхтэй юм.

Төсвийн хуваарилалт

СӨБ-ын төсвийн хуваарилалт нь нэг хүүхдэд ногдох зардлыг нийт хүүхдийн тоонд үржүүлэх зарчмаар тооцогдог. Боловсролын төсөвт хувьсах ба тогтмол гэсэн хоёр төрлийн зардал байдаг. Тогтмол зардалд халаалт, цахилгаан, цэвэр болон бохир ус зэрэг ордог бөгөөд эдгээр нь өмнөх үеийн зарцуулалтанд үндэслэсэн байдаг. Хувьсах зардалд цалин, бусад урсгал зардал (багшийн сургалт, ном, шуудан, харилцаа холбооны зардал гэх мэт) багтана. Нэг хүүхдэд ногдох байдлаар тооцсон хувьсах зардалд зөвхөн хичээл заах багшийн цалинг оруулдаг бол СӨБ-ын байгууллагуудын нэн чухал ажилтнууд болох

¹¹Энэ хэсгийн мэдээллийг ихэвчлэн “Монгол улс: Төвлөрлийг сааруулсан орчинд үйлчилгээг хүргэх нь” (Дэлхийн банк, 2015) ба “Монгол улсын төрийн санхүүгийн менежментийн гүйцэтгэлийн тайлан” (Дэлхийн банк, 2015)-д сууриллаа.

туслах ажилтнуудын цалинг тогтмол зардалд багтаадаг ажээ. СӨБ-ын байгууллагын багш нарын цалин боловсролын салбарын бусад ажилчдынхтай ерөнхийдөө ойролцоо боловч тэдний нийт цалин урамшуулал бусадтай харьцуулахад харьцангуй бага юм. Учир нь тэд сургуулийн багш нарын адил гэрийн даалгавар шалгасан, илүү цагаар хичээл заасан зэрэг нэмэлт цалин хөлс авдаггүй юм.

Хувьсах зардлыг тухайн боловсролын байгууллагын байршил, төрлөөс хамааран тооцдог. Монгол улсын Засгийн газраас саяхан хийсэн өөрчлөлтийн дагуу төрийн өмчийн болон хувийн хэвшлийн цэцэрлэгүүдийн нэг хүүхдэд ногдох дундаж зардал нь Монгол улсын засаг захиргааны нэгжийн гурван түвшнээс хамааран олгогдох ажээ (Улаанбаатар хот, аймгийн төв, аймгийн төвөөс бусад). Хөдөө орон нутагт ажиллаж байгаа боловсролын салбарын ажилтнуудыг тогтвортой ажиллуулах үүднээс аймаг болон түүнээс доошхи нэгжид олгох хувьсах зардлыг Улаанбаатар хотынхоос илүү өндөр жишгээр тогтоож ирсэн. Цэцэрлэгийн норматив хэм хэмжээг нэгэнт засгийн газраас баталсан бол эдгээр нь бусад төрлийн СӨБ-ын хувьсах зардлыг тооцох үндэс суурь болж өгдөг байна (жишээ нь 24 цагийн цэцэрлэг ба СӨБ-ын хувилбарт сургалт). Ингэхдээ СӨБ-ын хувилбарт сургалтын онцлог шинж чанаруудыг бодолцож үзэхийн үүднээс өсгөх коэффициентийг ашигладаг байна. Засгийн газраас 2012 онд баталсан нэг хүүхдэд ногдох дундаж зардал ба өсгөх коэффициентийг (өөрчлөх коэффициент/нэмэлт итгэлцүүр) доорх хүснэгтэнд харуулсан болно.

Хүснэгт 1.6: Цэцэрлэгийн нэг хүүхдэд ногдох дундаж хувьсах зардал ('000 төг)

Байршил	Цалингийн зардал	Нийгмийн даатгал	Бусад хувьсах зардал	Нийт хувьсах зардал
Аймгийн төвөөс бусад	760.1	83.6	27.9	871.6
Аймгийн төв	616.7	67.8	25.1	709.6
Нийслэл	615.0	67.7	22.8	705.5

Эх сурвалж: БСШУЯ (2015)

Хүснэгт 1.7: Нэг хүүхдэд ногдох дундаж хувьсах зардлыг өсгөх коэффициентууд

Суралцагчийн төрөл	Цалингийн хувьсах зардлын коэффициент	Бусад төрлийн хувьсах зардлын коэффициент
24 цагийн цэцэрлэгийн хүүхэд	1.5	1.04
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд	1.3	1.07
Ээлжийн бүлгийн хүүхэд	0.6	0.5
Нүүдлийн гэр цэцэрлэгийн хүүхэд	0.7	0.5

Эх сурвалж: БСШУЯ (2015)

Монгол улсын боловсролын салбарт ашигладаг нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын тооцоолол нь ашиглахад харьцангуй энгийн, ил тод бөгөөд тооцооллыг хэт хүндрүүлэх олон тооны итгэлцүүргүй юм. Нэг хүүхдэд ногдох зардлаар олгох санхүүжилтийн томъёолол энгийн байх тусам ил тод байдаг болохыг олон улсын туршлага харуулж байна. Тиймээс ил тод тооцооллын арга нь бодлого боловсруулагч нарт ойлгоход амар байдаг, мэдээлэл цуглуулах ба дүн шинжилгээний зардлыг багасгадаг ба шилжүүлэх дүн нь тодорхой учраас орон нутгийн түвшинд хариуцлага тооцоход илүү амар байдгаараа ашиг тустай юм. Гэвч энгийн тооцоолол нь эрх тэгш байдал, үр нөлөөтэй зарцуулалт зэрэг зарим талын асуудлуудад сөрөг нөлөө үзүүлж, энэ нь илүү их итгэлцүүрийг бий болгоход хүргэж болох боловч сая дурьдсан давуу талуудыг мартахгүй байх нь зүйтэй юм.

1.6 Хоол хүнс, сургалтын хэрэглэгдэхүүний хангамжийг нягтлан харах нь

Хоол хүнсний хангамж нь СӨБ-д зарцуулах төсөв хөрөнгийн багагүй хувийг эзэлдэг боловч хүүхдүүдэд өгч байгаа хоолны чанар хангалтгүй байна. Өмнө дурьдсанчлан төрийн өмчийн цэцэрлэгүүдийн хоол хүнсийг улс бүрэн даадаг ба сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын хамгийн өндөр зарцуулалтын ангилалд хоол хүнсний хангамж багтдаг юм. СӨБ-ын байгууллагуудын хүүхдүүдийн хоолны санхүүжилтийн өнөөгийн норм, хэм хэмжээг бага сургуульд суралцаж байгаа суралцагчдын норм, ерөнхий болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн дотуур байрны нормын хамтаар Засгийн газрын 2012 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн тогтоолоор баталсан байдаг. Тус тогтоолын дагуу өдөрт нэг хүүхдэд ногдох хоолны зардал төрийн өмчийн ердийн цэцэрлэгийн хувьд 1650 төг (0.82 ам.доллар), 24 цагийн цэцэрлэгт 2400 төг (1.20 ам.доллар) байна. Засгийн газар энэхүү нормыг инфляцийн түвшингээс хамааран жил бүр өөрчлөх төлөвлөгөөтэй байсан боловч тус улсад нүүрлээд байгаа эдийн засгийн хямралаас шалтгаалан өнөөдрийг хүртэл өөрчлөлт хийгээгүй байна.

Хоол хүнсэнд зарцуулах хөрөнгийг нэмэгдүүлэхийн тулд СӨБ-ын тухай хуульд саяхан орсон өөрчлөлтийн дагуу эцэг эхчүүд цэцэрлэгийн хүүхдийнхээ хоолны зардалд хувь нэмэр оруулах болоод байна. Улсаас нэг хүүхдэд олгож байгаа хоолны зардал харьцангуй бага байгаа тул цэцэрлэгийн хүүхдүүдэд шим тэжээлтэй, олон төрлийн хоол хүнсийг өгөх боломж хязгаарлагдмал байдаг. Нэг өдөрт ногдох хоолны зардал нь СӨБ-ын журамд заасны дагуу гурван удаагийн халуун хоол, хоёр удаа цай өгөхөд хангалтгүй учраас тус хомсдлыг арилгахын тулд эцэг эхчүүдээс албан бус хандив оруулахыг хүсч байжээ. Харин энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд засгийн газар СӨБ-ын тухай хуульд өөрчлөлт оруулж, эцэг эхчүүдээс цэцэрлэгийн хүүхдийнхээ хоолны төлбөрт албан ёсоор нэмэр хандив оруулдаг болгож байна. Тус өөрчлөлтийн дагуу эцэг эхчүүд одоогоор улсаас цэцэрлэгийн хүүхдийн нэг өдрийн хоолонд зориулан өгч буй дүнтэй тэнцэх мөнгийг (1650 төг)-ийг төлөх болсноор нэг хүүхдэд ногдох хоолны мөнгө хоёр дахин нэмэгдэх юм.

Хичээлийн хэрэгсэл, сургалтын материал нь ихэвчлэн эцэг эхчүүдийн халааснаас санхүүжиж байна. Төрөөс багш нарын цалин хөлс, хүүхдийн хоол унд, цахилгаан, дулаан зэрэг гол зардлуудыг дааж байгаа учраас сургалтын хэрэглэгдэхүүн, материал хэрэгсэл, хичээлээс гадуурх үйл ажиллагаа ба бусад сургалтын арга хэмжээнд зориулах санхүүжилт бараг үлддэггүй байна. Төсвийн санхүүжилт хангалтгүй учраас боловсролын яамнаас гаргасан жагсаалтын дагуу эцэг эхчүүд хичээлийн болон ариун цэврийн хэрэгслийг хангадаг (хавсралт 4). Хичээлийн хэрэглэгдэхүүний энэхүү жагсаалтанд харандаа, дэвтэр, фломастер, самбарын үзэг, хайч, цавуу ба бусад хэрэгсэл ордог бол ариун цэврийн хэрэгслийн жагсаалтанд саван, 00-н цаас, шүдний оо, сойз болон бусад шаардлагатай хэрэгслүүд багтаж байна. Хэрэгслийн тоо хэмжээ хүүхдийн насны ангилал, цэцэрлэгийн төрлөөс хамааран янз бүр, үүний дотор ердийн болон 24 цагийн үйл ажиллагаатай цэцэрлэгийнх ч бас ялгаатай байх юм. Тиймээс хичээлийн хэрэгсэл худалдан авах, хичээлээс гадуурх үйл ажиллагаа зохион байгуулах, анги танхимд бага зэргийн засвар хийхэд хүртэл эцэг эхчүүдийн хандиваар хийдэг байна. Эцэг эхчүүд цэцэрлэгийн хүүхдийнхээ хоол хүнсний төлбөрийн зарим хэсгийг төлөх тухай СӨБ-ын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт нь олон эерэг үр дүнг авчрах төлөвтэй байгаа хэдий ч эцэг эхчүүдийн халааснаас гарах мөнгийг ойрын ирээдүйд нэмэгдүүлэх хандлагатай байна.

1.7 Дүгнэлт

СӨБ-ын үйлчилгээг хөдөө орон нутаг, зорилтот бүлгийн хүүхдүүд рүү илүү оновчтой байдлаар чиглүүлснээр СӨБ-д зарцуулж байгаа төсвийн зарцуулалтын¹² эрх тэгш байдлыг сайжруулах боломжтой байна. Улсын хэмжээнд амьжиргааны түвшин доогуур бөгөөд нийгэм, эдийн засгийн тааламжгүй нөхцөлд байгаа өрхүүдийн хүүхдүүдийн СӨБ-ын хамрагдалт хамгийн бага байгааг судалгаагаар тогтоосон бөгөөд эдгээр хүмүүс нь ихэвчлэн хөдөө орон нутагт оршин сууж байна. Тиймээс СӨБ-д төрөөс үзүүлж байгаа дэмжлэгийн ихээхэн хэсэг нь боломжийн амьдралтай айлуудын хүүхдүүдэд очиж байгаа нь харагдаж байна. Хөдөө орон нутгийн хүрч очиход хүндрэлтэй өрхийн хүүхдүүдийг СӨБ-д хамруулах нөхцөл байдлыг сайжруулах нь Монгол улсын СӨБ-ын хөрөнгө оруулалтын тэгш байдлыг хангах гол түлхүүр болно хэмээн үзэж байна. Алслагдсан орон нутгийн хүн амд СӨБ-ын үйлчилгээг хүргэхэд өндөр өртөгтэй байдаг учраас одоогоор хэрэгжиж буй СӨБ-ын үйлчилгээний хувилбарт сургалтуудыг сайтар нягтлан дүгнэж, илүү сайжруулах замаар ашиглаж болох юм. Үүнийг хэрхэн хэрэгжүүлэх талаар тус тайлангийн дараагийн бүлгүүдэд тусгасан.

Эрх тэгш байдлыг илүү сайн хангахын тулд СӨБ-ын санхүүжилтийн механизм, хуваарилалтын дүрэм журмыг нарийвчлан дүгнэж үзэх хэрэгтэй. Цэцэрлэгүүдийн хувьсах зардлыг санхүүжүүлэх одоогийн нормативууд нь цэцэрлэгийн байршлаас хамаараад цалин хөлс, нийгмийн даатгал болон бусад хувьсах зардлыг тохируулдаг ба хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллаж байгаа багш нарын цалинг нэмэгдүүлж боддог байна. Гэвч тус нормативууд бүс нутаг хоорондын чанарын ялгааг арилгаж чадахгүй байгааг 2-р бүлэгт тодруулсан. Үүнээс гадна эцэг эхчүүдэд ирэх санхүүгийн дарамт, ялангуяа алслагдмал орон нутгийн малчид болон амьжиргааны түвшин доогуур өрхүүдийн ачааллыг багасгах нөхцөл байхгүй байна. Харин ч үүний эсрэгээр, цэцэрлэгийн хүүхдүүдтэй боломжтой ч тэр, боломж муутай ч тэр бүх айлууд цэцэрлэгт ашиглагдах сургалтын материалуудыг яг адилхан нөхцөлтэйгээр ханган өгч байгаа ба ойрын ирээдүйд хоолны мөнгийг бас адилхан өгөх ёстой болох нь ээ. Тиймээс санхүүжилтийн системийн шударга, эрх тэгш байдлыг сайжруулахын тулд эцэг эхчүүдийн халааснаас гарах мөнгө, хандивын нормыг эргэцүүлэн тунгааж, нийт боловсролын салбарын санхүүжилтийн арга тооцоолол нь иргэдийн ахуй амьжиргаанд хэрхэн нөлөөлөх талаар бодож үзэх ёстой.

Улсын төсөв хүрэлцээгүйн улмаас сургалтын хэрэглэгдэхүүн, материалын хангамж муу байгаа нь цэцэрлэгүүдийн үйлчилгээний чанарт нөлөөлж болох юм. СӨБ-д зарцуулж байгаа төсвийн зарцуулалтын сүүлийн үеийн байдлаас харахад сургуулийн өмнөх боловсрол нь Монгол улсын хувьд чухал асуудал хэвээр байгааг харуулж байна. Монгол улс нь өөртэйгээ ижил төстэй болон дэлхийн бусад орнуудтай харьцуулахад боловсролын салбарын төсвийнхээ харьцангуй их хэсгийг СӨБ-д зарцуулж байна. Гэвч зарцуулалтын бүтцийг судлаад үзэхээр төсөв тун хязгаарлагдмал байгаа нь илт харагдаж эхэлнэ. СӨБ-ын байгууллагуудын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай болох багш

¹²Энэ нь СӨБ-д зарцуулж байгаа төсвийн зарцуулалтын үр нөлөөтэй байдлын тухай асуудал бөгөөд энэ асуудлын хариуг зөвхөн тус тайланд оруулсан мэдээллээр олох боломжгүй юм. Энэхүү бүлгийн эхний хэсэгт өгүүлсэн газарзүйн байршил, хүн амын нягтаршил зэрэг хүчин зүйлс нь Монгол улсад нийгмийн үйлчилгээг хүргэх ажлыг өндөр өртөгтэй болгодог гэдэгтэй бүгд санал нийлнэ. Гэвч байгаа хөрөнгө нөөцөө тус дэд салбар *дотоо* хэрхэн оновчтойгоор хуваарилж болох талаар асуудал хөндөгдөхгүй байна. Энэ асуудал нь тус тайлангийн хүрээнээс хол давсан цогц судалгааг шаардах ба, үүнд ирээдүйд хийхээр төлөвлөж буй нийт боловсролын салбарын зарцуулалтын үнэлгээ орох юм.

нарын цалин хөлс болон бусад урсгал зардалд төсвийг зарцуулсны дараа сургалтын материал, хэрэглэгдэхүүнд тун бага төсөв, мөнгө үлдэж байна. Тийм учраас цэцэрлэгүүд нь сургалтын материалын хэрэгцээгээ өөрсдөө зохицуулж, эцэг эхчүүдээс цуглуулах, сан үүсгэх эсвэл орон нутгаасаа дэмжлэг авах зэрэг байдлаар хангаж байна. Ийнхүү өөрсдийн орон нутаг эсвэл хамт олноос материал цуглуулах боломж бололцоо нь тухайн цэцэрлэг хаана байрлаж байгаагаас ихээхэн шалтгаалдаг бөгөөд байршлаас хамаараад цэцэрлэгийн суралцах орчин, тухайлбал сургалтын материалын хүртээмж ба чанар, төрөл зүйл, хөгжүүлэх үйл ажиллагаануудын төрөл зэрэг нь ихээхэн ялгаатай байдаг юм. Үүнд хөдөө орон нутгийн цэцэрлэгүүд хамгийн ихээр өртөж болох юм. 2-р бүлэгт энэ нь бодит байдал дээр үнэн эсэхийг дэлгэрэнгүй өгүүлсэн байгаа.

БНХБ-ын санхүүжилтын норм, нормативуудыг шинэчлэхдээ эрэлтийн талаас хэр боломжтойг бодолцож үзэн, боловсролын салбарын нийт санхүүжилтэнд үзүүлэх нөлөө, тэгш байдлыг сайжруулах тал дээр анхаарч хийх ёстой. Одоогоор эцэг эхчүүдийн хандиваар сургалтын хэрэглэгдэхүүн, материалыг авч байгаа бол ирээдүйд хоолны зардлын зарим хэсгийг бас санхүүжүүлэх төлөвлөөгөөтэй байна. Гэвч эцэг эхчүүдийн халааснаас гарч байгаа зардлууд нь тэдний амьдралын боломжинд хэрхэн нөлөөлж байгааг сайтар хянаж үзэх хэрэгтэй. Одоогоор хүүхдүүд нь цэцэрлэгт хамрагдаагүй байгаа айл өрхүүд нь эдийн засгийн боломжийн хувьд хамгийн доод түвшний өрхүүд байх магадлалтай учраас эцэг эхийн халааснаас гарах хувь нэмрийг бага орлоготой өрхийн хүүхдүүдэд СӨБ-д хамрагдахад саад болохоор өндөр байлгахгүй байх тал дээр анхаарах ёстой. Тиймээс эцэг эхчүүдийн төлөх төлбөр, оруулах хувь нэмрийг зохицуулах төрийн тодорхой зохицуулалт байх хэрэгтэй байна. Гэвч үүний зэрэгцээ нэн ядуу бүлгүүдийн дунд хүртээмжийг сайжруулах, эцэг эхийн халааснаас гарах мөнгөнөөс үүдэх санхүүгийн дарамтнаас чөлөөлөхийн тулд болзолт бэлэн мөнгөний шилжүүлэг, эрхийн бичиг зэрэг эрэлтийн талын шийдлүүдийг бас ашиглаж болох юм. Мөн одоогоор хэрэгжиж байгаа нийгмийн халамжийн хөтөлбөр, тухайлбал Хүүхдийн мөнгө хөтөлбөртэй ч уялдуулж болно. Хөтөлбөрүүдийг эмзэг бүлгийн өрхүүд рүү чиглүүлж, тэдний эрх ашгийг хамгаалах, аж байдлын түвшнийг харгалзах зэргээр хэрэгжүүлэх боломжтой. Цаашид эрэлтийн талыг санхүүжүүлэх боломжийн талаар судалж үзэх хэрэгтэй.

СӨБ-ын байгууллагуудын барилга байгууламж, дэд бүтэц, засвар үйлчилгээний хэрэгцээ хангагдахгүй орхигдсоор байгаа тул бага насны хүүхдийн боловсролд орон нутгийн зүгээс хийх үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтын мэдээллийг төв системд нэгтгэн оруулж, БСШУСЯ-наас хянах боломжтой болгох хэрэгтэй байна. Төсвийн хязгаарлалтын асуудал нөлөөлж байгаа бас нэг хэсэг бол цэцэрлэгийн засвар, дэд бүтцийн асуудал юм. Энэхүү бүлэгт гарч буй зарцуулалтын дүн шинжилгээнээс харахад энэ талын зардалд маш бага төсөв хуваарилагддаг аж. Энэхүү тайланг бичихээс өмнө хийсэн ярилцлагуудад нийслэл Улаанбаатар хот болон бусад нэлээд хэдэн газрын цэцэрлэг засвар үйлчилгээний төсөв мөнгөний хүсэлт илгээдэг боловч хариу ирдэггүй учраас 1960-1970-аад оны үед баригдсан олон цэцэрлэгийн барилгууд нь нурж унахад ойрхон байгааг тэмдэглэж байсан. Хөрөнгө зардлын талаарх төсвийн шийдвэр гаргах эрх мэдлийг орон нутагт шилжүүлсэн нь ирэх жилүүдэд хэрхэн өөрчлөгдөх нь тодорхойгүй байна. Орон нутгаас СӨБ-д (мөн боловсролын бусад дэд салбарт ч бас) хийж буй хөрөнгө оруулалтыг хянах нь засгийн газрын байгууллагуудын чухал үүрэг байх ёстой. Гэвч БСШУСЯ-д энэхүү хөрөнгийн зарцуулалтын талаар мэдээлэл байхгүй байгаа учраас энэ хяналт хэрэгжихгүй байгаа нь тодорхой байна.

БНХБ-ын үйлчилгээг хувийн хэвшлээр дамжуулан хангах боломжийг нэмэгдүүлэх талаар судлах хэрэгтэй байна. Хот суурин газруудад, ялангуяа Улаанбаатар хотод сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг өргөжүүлэхэд хувийн хэвшил чухал үүргийг гүйцэтгэсэн. Харин одоогоор засгийн газарт тулгамдаад байгаа эдийн засгийн хямралын энэ цаг хугацаанд оновчтой урамшууллын багцаар дамжуулан тус салбарын үйлчилгээ үзүүлэгчдийн тоог нэмэгдүүлэх боломж байгаа эсэхийг судлах нь зүйтэй байж болох юм. Хувийн хэвшлийн өсөлт нь олон боломжуудыг нээхийн зэрэгцээ, саад бэрхшээлийг ч бас дагуулдаг. Хувийн хэвшлийн цэцэрлэгүүд нь одоогоор хүн амын аль хэсэгт үйлчилж байгаа, тухайлбал зөвхөн чинээлэг эсвэл холимог бүлгийн хүн амд үйлчилж байгаа эсэхийг тодорхойлох, мөн хувийн цэцэрлэгийн чанар төрийн өмчийн цэцэрлэгүүдийнхээс хэр ялгаатай байгааг харах нь нэн чухал эхний алхам юм. Эдгээр асуултуудад 2 болон 3 дугаар бүлгүүдэд хариулсан.

СӨБ-ын хувилбарт сургалтын үйлчилгээ нь малчид болон алслагдсан орон нутгийн хүүхдүүдэд хүрэхэд тохиромжтой арга боловч эдийн засгийн хувьд үр ашигтай байх тал дээр анхаарч, энэ талаар судлах хэрэгтэй байна. СӨБ-ын хувилбарт сургалт, түүний хамгийн түгээмэл хэлбэр болох нүүдлийн гэр цэцэрлэгийн үйлчилгээний зардлыг нэг хүүхдэд ногдох зардлын хувьд авч үзвэл ердийн цэцэрлэгээс харьцангуй хямд байдаг. Гэвч гэр цэцэрлэгүүд нь дунджаар буюу дээд тал нь дөрвөн долоо хоног, зөвхөн зуны улиралд, богино хугацаагаар ажилладаг болохыг мартаж болохгүй. Сургалтын хугацаа богино байгаа нь СӨБ-ын чанарт тодорхой хэмжээгээр нөлөөлж байх талтай. Гэвч нөгөө талаас, суралцах хугацааг уртасгах нь тус сургалтыг илүү өндөр өртөгтэй болгох бөгөөд үүнийг хэрэгжүүлэх нөөц бололцоо байхгүй байж болох юм. 2 ба 3 дугаар бүлэгт эдгээр асуудлын талаар дэлгэрэнгүй өгүүлж, гэр бүлийн орчныг цэцэрлэгийг орлож болохуйц газар болгох буюу олон нийт ба гэр бүлд түшиглэсэн үйл ажиллагааны хэлбэрүүдийг санал болгох юм.

Бүлэг 2. Монгол улсын цэцэрлэгүүдийн үйлчилгээний чанар

1-р бүлэгт, Засгийн газраас СӨБ-д зарцуулах хөрөнгийн сүүлийн үеийн чиг хандлага, тус дэд салбар Монгол улсын хувьд чухал хэвээр байгааг илтгэж байгаа боловч төсөв хангалтгүйн улмаас сургалтын хэрэглэгдэхүүн, материалыг ихэвчлэн цэцэрлэг өөрсдөө эсвэл эцэг эхчүүдээр хангуулдаг болохыг өгүүлсэн. Цэцэрлэгүүд хүүхдийн хөгжлийг дэмжих материаллаг орчныг бий болгохдоо эцэг эхчүүдээс мөнгө цуглуулах, хуримтлал, сан үүсгэх эсвэл орон нутгийн засаг захиргаанаас хүсэмжлэх зэрэг аргуудыг хэрэглэдэг ба энэхүү орчныг бий болгох боломж бололцоо олон газар янз бүр байдаг. Тиймээс энэ нөхцөл байдалтай холбоотойгоор цэцэрлэгийн үйлчилгээний чанар нь бүтцийн хувьд ч тэр (цэцэрлэгийн дэд бүтэц ба сургалтын материаллаг орчин), үйлчилгээний үйл явцын хувьд ч тэр (танин мэдэхүйн болон хүүхдийн олон талт хөгжлийг дэмжих харилцааны орчныг бүрдүүлэх, бий болгох) цэцэрлэг нэг бүрийн хувьд янз бүр байдаг. Энэхүү ялгаатай байдал нь бага насны хүүхдийн боловсролын үр дүнгийн ялгаанд хүргэж болох юм. Сургалтын хэрэглэгдэхүүний хүртээмж ба чанарын ялгаа, тэдний төрөл зүйл, бүлэгт явагдаж буй үйл ажиллагааны төрөл гэх мэт зүйлс нь хөдөө орон нутаг болон бусад ядуурал ихтэй төвлөрсөн газрууд, тухайлбал Улаанбаатар хотын гэр хороолол зэрэг газруудын цэцэрлэгийн үйлчилгээний чанар тааруу байх, бусдаас хоцрогдоход хүргэж байж болох талтай.

Монгол улсын сургуулийн өмнөх боловсрол хэмээх дэд салбар нь хүүхдийн тоо хэтэрсэн, дэд бүтэц муу, сургалтын хэрэглэгдэхүүн, материалын хүрэлцээ хангалтгүй, мөн тухайн цэцэрлэг өөрөө төсвөө зөв тооцоолоогүй зэрэг асуудлуудын улмаас хүндрэл, бэрхшээлтэй тулгарч байгааг түүврийн судалгааны баримт, нотолгооноос харж болно. Өнөөдрийг хүртэл цэцэрлэг тус бүрийг стандарт шалгуурт үндэслэн хооронд нь харьцуулж үнэлэх, цэцэрлэгийн түвшинд хийх үнэлгээний системтэй аргачлал байхгүй байна. Мөн цаашлаад цэцэрлэгийн барилга байгууламж, дэд бүтэц ба бүтцийн шинж чанартай хувь нэмрийг багш хүүхдийн харилцаа, хөгжүүлэх үйл ажиллагаа зэрэг үйл явцын чанартай харьцуулсан мэдээлэл маш бага байна. Эцэст нь хэлэхэд хувийн хэвшлийн цэцэрлэгүүдийн талаар ямар ч мэдээлэл алга байна.

Харин энэхүү бүлэг нь тус мэдээллийн хомсдлыг арилгахыг зорьж байгаа бөгөөд 2015 онд Дэлхийн банкны санхүүжилттэйгээр хийсэн төрийн өмчийн болон хувийн цэцэрлэгүүдийн чанарын судалгааны үр дүнд суурилж байгаа юм. Тус судалгааны хүрээнд мэдээллийг хоёр удаа цуглуулсан. Эхний удаагийн мэдээллийг Монгол улсын хот суурин ба хөдөө орон нутгийн төрийн өмчийн ердийн цэцэрлэгүүдээс цуглуулсан бол хоёр дахь удаагийн мэдээлэл цуглуулах ажлыг СӨБ-ын хувилбарт сургалтуудыг оролцуулан хийсэн.

Ерөнхийдөө тус улсын цэцэрлэгүүд нь хөгжүүлэх үйл ажиллагааны явц дахь багш-суралцагчийн харилцаагаар хамгийн дээд оноог авч, харин тооны ур чадварт сургах орчны хувьд хамгийн бага оноог авчээ. Төрийн өмчийн цэцэрлэгүүдийн бүлгүүдийн тоо олон байгаа нь ажиглагдаж байсан бол хөдөө орон нутгийн цэцэрлэгүүдийн чанар бүх талаар ихээхэн хоцрогдолтой байна. Ихэнх цэцэрлэгүүд тоо тоолол, хэл яриаг хөгжүүлэх, хүүхдийн хөгжлийг дэмжих сургалтын болон тоглоом, хэрэглэгдэхүүний үндсэн багцтай боловч тэдгээрийн төрөл цөөн, чанар муу байгаагийн улмаас судалгаанд ашигласан үнэлгээний стандарт үзүүлэлтэд бүрэн хүрч чадаагүй байна.

Гэр цэцэрлэгүүд нь багш-суралцагчийн харилцаагаар ердийн цэцэрлэгүүдтай харьцуулбал харьцангуй өндөр оноо авсан боловч чанарын бусад үзүүлэлтийн хувьд бүгд

доогуур байв. Гэвч тус цэцэрлэгүүдийн боломж тааруу, үйлчилгээг хүргэх орчин хэцүү байдаг учраас энэ үр дүнд гайхах зүйлгүй юм. Хувийн цэцэрлэгүүд төрийн өмчийн цэцэрлэгүүдтэй тун дөхүү оноо авч, багш-суралцагчийн харилцаагаар арай илүү, бусад үзүүлэлтийн хувьд үл ялиг доогуур байна. Улаанбаатар хотын гэр хороололд байрлалтай хувийн цэцэрлэгүүд нь гэр хорооллын бус хувийн цэцэрлэгүүдээс доогуур үзүүлэлттэй гарсан боловч тус ялгаа нь төрийн өмчийн хот ба хөдөөгийн цэцэрлэгүүдийн хоорондох ялгаанаас бага байсан юм.

Энэхүү бүлэг нь дараах бүтэцтэй. 1 дэх хэсэгт Монгол улсад одоогоор ашиглаж байгаа чанарын баталгаажуулалтын тогтолцооны тухай ярих юм. 2 дахь хэсэгт цэцэрлэгийн чанарын болон үйл явцын элементүүдийг энэхүү тайлангийн хүрээнд тодорхойлж, Дэлхийн банкнаас хийсэн цэцэрлэгийн чанарын судалгааны мэдээлэл цуглуулах үйл явц, үр дүнг танилцуулж, цэцэрлэгийн төрлөөр нь ангилан харуулсан (төрийн өмчийн ердийн цэцэрлэгүүд, хувийн цэцэрлэгүүд болон гэр цэцэрлэгүүдээр). Түүнчлэн энэ хэсэгт чанарын хэмжилт бүрийн гүйцэтгэлийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг оруулсан. 3 дахь хэсэгт тус судалгаанаас үүдэн гарсан чухал асуудлуудын талаар дүгнэлт хийсэн.

2.1 Монгол улсын цэцэрлэгийн үйлчилгээний чанарыг баталгаажуулах нь

Хүүхдийн сайн сайхныг хамгаалах, тэдний хөгжил ба суралцахуйг дэмжихэд хяналт-шинжилгээ, үйлчилгээний чанарын баталгаажуулалт нэн чухал юм. Улс төрийн болон төсвийн дарамт шахалт нэмэгдэн тулгамдах үед бодлого боловсруулагчид бага насны боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд ихэд анхаарч эхэлдэг. Хүртээмжийг нэмэгдүүлэх нь нэн чухал боловч чанарыг хангах тал дээр ч эн тэнцүү анхаарах ёстой. Зөвхөн хүртээмжид анхаарах нь, тэр дундаа хүртээмжийг нэмэгдүүлэхдээ чанарыг орхигдуулах нь бодлого боловсруулагчид СӨБ ба бусад БНХХ-ийн арга хэмжээгээр дамжуулан бий болгоно хэмээн найдаж байсан үр ашгийг багасгах аюултай юм. Гвиней, Кэйп Вердэ, Бангладеш зэрэг хоорондоо нэлээд ялгаатай улсуудын сургуулийн өмнөх боловсролын үнэлгээнээс харахад хөгжүүлэх үйл ажиллагааны чанараас танин мэдэхүйн үр чадварын үр дүн хамаардаг болох нь харагдаж байна (Jaramillo & Tietjen, 2002; Aboud, 2006 ба 2007). Харин үүний эсрэгээр, сургалт буюу хөгжүүлэх үйл ажиллагаа чанар муутай байвал хүүхдийн хөгжилд үр өгөөж багатай эсвэл бүр хор уршигтай ч байх тал ажиглагдсан байна (Bernal, 2008 ба 2010; Naudeau et al, 2011). Дэлхийн банкны “Боловсролын үр дүнг сайжруулах системт аргачлал”-ын (Systems Approach for Better Education Results-SABER) БНХХ-ийн оношлогооны хэрэгсэлд суурилсан дүн шинжилгээний хүрээ нь Монгол улсын БНХБ-ын чанарын баталгаажуулалтын үйл ажиллагааг дүгнэж үзэхэд тохиромжтой арга юм¹³. БНХХ-ийн үр нөлөөтэй тогтолцооны бодлогын гурван гол зорилтын нэг нь чанарын баталгаажуулалт гэж заасан байдаг ба үүнд гурван төрлийн бодлогын тулгуур арга хэмжээ багтдаг: (i) мэдээллийн олдоц; (ii) чанарын стандартууд; ба (iii) стандартын мөрдөлт. Харин энэхүү бодлогын тулгуур арга хэмжээнүүд нь Монгол улсад ямар хэмжээнд байгааг дараах байдлаар тодруулж байна.

Монгол улс БНХБ-ын үйлчилгээний хүртээмж ба БНХХ-ийн зарим нэг үр дүнгийн талаарх судалгаа, захиргааны мэдээллийг тогтмол цуглуулж, мэдээлж байна. БНХБ-

¹³SABER-ECD аргачлалыг бүрэн утгаар нь хэрэгжүүлэх явдал энэхүү тайлангийн зорилгоос давсан зүйл байсан юм. Тиймээс тус үнэлгээний хүрээ ба түүний элементүүдийг зөвхөн Монгол улсын цэцэрлэгүүдийн чанарын баталгаажилтын тогтолцоог харуулахын тулд ашигласан юм.

ын үйлчилгээний хүртээмжийн талаар захиргааны мэдээллийг цуглуулдаг бөгөөд үүнд цэцэрлэгийн бэлтгэл бүлэгт элсэн орсон хүүхдийн тоо (аймаг, хөдөө орон нутаг ба хот суурин газруудаар ангилсан байдлаар), нэг багшид ногдох хүүхдийн дундаж тоо, БНХБ-д зориулсан санхүүжилтийн хэмжээний тухай мэдээлэл ордог байна. Монгол улс нь НҮБ-ын Хүүхдийн сангийн нийгмийн олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаанд оролцдог тул энэхүү судалгааны 2010 ба 2013 оны тайланд багтсан бага насны хүүхдийн хөгжлийн үр дүнгийн талаарх мэдээллийг ашиглах боломжтой байгаа юм¹⁴.

БНХБ-ын үйлчилгээний чанарын стандартууд нэлээд нарийн дэлгэрэнгүй байна. Улсын хэмжээнд одоогоор мөрдөж буй сургалтын стандартууд нь СӨБ-ын цөм хөтөлбөрт туссан байх ба суралцах чадваруудад биеийн хөдөлгөөн, нийгэм- сэтгэлийн хөдөлгөөн, хэл яриа ба математикийн ур чадварын зэрэгцээ байгал орчинтой таницах, соёл урлаг, дуу хөгжим зэрэг багтаж байна. Бүх цэцэрлэгүүд тус хөтөлбөрийг дагах үүрэгтэй байдаг. Багш нар хүүхдийн хөгжлийг ажиглаж, чадвар тус бүрийн хувьд хүүхдэд гарч буй ахицын талаар хичээлийн жилийн туршид тэмдэглэл хөтөлдөг. Гүйцэтгэлийг хэмжих тоон үнэлгээ гэж байхгүй. Харин зэрэг зан байдлыг төлөвшүүлэх, хүүхдийн зан үйлийг удирдан чиглүүлэх ба бие махбодийн шийтгэл үзүүлэхийг хориглох зэрэг багш-хүүхдийн харилцааг зохицуулсан удирдамжууд байдаг. Биет, гаднах орчны шаардлагуудад цэцэрлэгийн байр, тоног төхөөрөмж, гадаа тоглох талбай ба унтаж амрах өрөө тусдаа байх зэрэг стандартууд багтдаг. Эрүүл мэнд, аюулгүй байдал, хоол тэжээл/хоол хүнсний үйлчилгээний шаардлагууд ч бас бий¹⁵. Олон нийтийн оролцооны талаарх стандартууд байхгүй боловч үндэсний цөм хөтөлбөрт гэр бүл, олон нийтийн оролцоог маш ихээр дэмжсэн байдаг. Цэцэрлэгүүд хүүхдийн авьяас чадварыг харуулсан концерт, арга хэмжээг тогтмол зохион байгуулж, үүнийг хүүхдүүдийн эцэг эх, гэр бүлийнхэн, орон нутгийн мэргэжлийн байгууллагын төлөөлөл ирж үздэг байна.

СӨБ-ын багш бэлтгэх сургуульд 4 жил суралцан бакалаврын диплом авсан тохиолдолд цэцэрлэгийн багш болох боломжтой. Цэцэрлэгийн багш нар нь Монгол улсад байгаа СӨБ-ын багш бэлтгэх хувийн болон улсын арван хоёр их, дээд сургуулийн төгсөгчид байдаг. Цэцэрлэгийн багш болох хүсэлтэй сурагчид 12 жилийн дунд сургуулийг төгссөний дараа элсэлтийн шалгалт өгч багш бэлтгэх сургуульд ордог. Багш бэлтгэх бүх их, дээд сургуулийн оюутнууд дөрвөн жилийн сургалтын хөтөлбөрийг дүүргэж, бакалаврын зэргийг авдаг. Монгол улсын боловсролын их сургууль өөр мэргэжлээр дээд боловсролын зэрэг авсан (жишээ нь инженерийн) боловч цэцэрлэгийн багш болохыг хүсч байгаа оюутнуудад зориулж цэцэрлэгийн багшийн хоёр жилийн “хөрвөх” хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

¹⁴Энэхүү тайланг бичих үед 2013 оны ОУБТС-ны тайлан бэлэн болсон байсан боловч судалгааны мэдээлэл нь дангаараа байхгүй байсан юм.

¹⁵Сүүлийн жилүүдэд НҮБ-ын Хүүхдийн сан Монгол улсын зорилтот орон нутгийн сургууль, цэцэрлэгүүдэд ихээхэн хэмжээний дэмжлэгийг үзүүлж, тэдэнд орон нутгийн онцгой байдлын газруудтай хамтран гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөг гаргахад тусалсан юм (НҮБ-ын Хүүхдийн сан, 2014 ба 2015 оныхыг харна уу). Мөн хөдөөний ихэнх цэцэрлэг дотор ариун цэврийн өрөө байдаггүй, гадаа хүйтэн байдаг учир хүүхдүүд гадаа жорлон ашигладаг бөгөөд энэ нь эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж байна. Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд НҮБ-ын Хүүхдийн сан 2015 онд БСШУЯ-наас баталсан "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны ус, ариун цэвэр, эрүүл ахуйд тавигдах норм, шаардлага" хэмээх үндэсний бодлогын бичиг баримтыг боловсруулахад дэмжлэг үзүүлсэн юм.

Стандартыг хэрхэн мөрдөж байгааг төвлөрсөн байдлаар хянах албан ёсны механизм байхгүй, ялангуяа анги танхим доторх хүүхдийн ур чадварын хөгжилд нөлөөлөх орцуудын стандартын мөрдөлтийг тогтмол шалгаж үнэлэхгүй байна. БСШУСЯ нь улсын хэмжээний СӨБ-ын бүх байгууллагыг хянадаг. Төрийн өмчийн болон хувийн хэвшлийн цэцэрлэгүүдийг жил бүр барилга байгууламж, дэд бүтэц, аюулгүй байдлын хувьд шаардлага хангаж байгаа эсэхийг шалгадаг боловч энэ нь тухайн цэцэрлэг хүлээж авсан санхүүжилтээ батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулсан эсэхийг л баталгаажуулах аудит хэлбэрээр явагддаг. Харин хөгжүүлэх орчны хэрэгцээ, тухайлбал хөгжүүлэх үйл ажиллагаанд ашиглах хэвлэмэл материал, дүрслэх урлаг ба тоглоомын материал зэргийн хэрэгцээ хангагдсан эсэх, мөн багшлах арга барил нь зохих чанарын шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалгах тогтмол хяналт байхгүй байна.¹⁶ Багшийн ур чадварыг дүгнэхийн хувьд гэвэл ихэвчлэн цэцэрлэгийн захирал, арга зүйч нар өөрийн байгууллагын доторх багш нартаа зөвлөх байдлаар явж байна. Цэцэрлэгийн захиргаанаас албан ёсоор өөрийн үнэлгээ хийх, чанартай үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөө гаргахыг шаарддаггүй байна. Тиймээс БСШУСЯ-д цэцэрлэгүүдийн хөгжүүлэх орчны хэрэгцээ, хөгжүүлэх үйл ажиллагааны чанарын түвшинг тодорхойлох механизм ерөнхийдөө байхгүй байна.

Цэцэрлэгийн хүрэлцээнээс шалтгаалан нэг бүлэгт байх хүүхдийн тооны хязгаар, норм мөрдөгдөхгүй байна. Цэцэрлэгийн нэг бүлэгт 25 хүүхэд байна гэж зөвхөн цаасан дээр л заасан байна. Харин бодит байдал дээр нэг бүлэгт байх хүүхдийн тоо үүнээс хоёр дахин илүү байгааг тус тайланд хожим тодруулах болно. Энэхүү тайланг бичихийн өмнөх ярилцлагуудын үеэр цэцэрлэгийн хэрэгцээ маш их байгаа тул эцэг эхчүүд цэцэрлэг эхлэхээс өмнө хэдэн цаг, өдрийн турш урт дараалалд зогсдог гэж эрхлэгч нар ярьсан. Бидний очсон цэцэрлэгүүдийн эрхлэгч нар хүүхдийн орон тоо гарах юм бол холбогдож болох эцэг эхчүүдийн жагсаалтыг үзүүлж байсан юм. Өөрөөр хэлбэл хүлээх жагсаалтад олон хүүхэд бүртгэгдэж цэцэрлэгт орон тоо гарахыг хүлээж байгаа ажээ. Нөхцөл байдал ийм байгаа учраас цэцэрлэгүүд стандарт хязгаараас хол давсан тооны хүүхдийг нэг бүлэгт байлгахгаас өөр аргагүй байдалд ордог аж.

2.2 Монголын цэцэрлэгүүдийн чанарыг хэмжих нь: Дэлхийн банкны 2015 оны СӨБ-ын чанарын судалгаа

Чанарын бүтэц ба үйл явцтай холбоотой талуудын ялгааг харах нь чухал юм. Чанарын бүтэцтэй холбоотой талуудад хөгжүүлэх орчинд өрнөх хоорондын харилцааг дэмжих нөөц, материалын хангамж байгаа (эсвэл байхгүй) эсэх орох юм (Berlinski and Schady, 2015). Эдгээрт дэд бүтэцтэй холбоотой талууд (орон зай, гэрэлтүүлэг, тавилга, тоног төхөөрөмж), эрүүл мэнд, ариун цэвэр ба аюулгүй байдалтай холбоотой хэсгүүд (эрүүл мэндийн шаардлагууд, онцгой байдлын дүрэм, журмууд), багш нар болон туслах багш, ажилтнуудын шинж чанарууд (боловсрол, ажилласан жилүүдийн хөгжил дэвшил, туршлага, цалин), мөн тэдний хариуцаж байгаа бүлгийн хүүхдүүдийн шинж чанарууд (хүүхдийн тоо, насны ангилал, багш, туслах багшид ногдох хүүхдийн тоо гэх мэт). Харин чанарын үйл явцтай холбоотой талуудад хүүхдийн өдөр тутам цэцэрлэгээс авч байгаа мэдрэмж, тэдний суралцах ба хөгжих үйл явцад шууд нөлөөлж байгаа элементүүд орох

¹⁶Зарчмын хувьд авч үзвэл хөдөө орон нутгийн болон нийслэлийн боловсролын газар, хэлтсүүд тус мониторингийг тогтмол хийх үүрэгтэй байдаг. Гэвч эдгээр хяналт шинжилгээний үр дүнг албан ёсоор мэдээлэх, зөвлөмж гаргах, эсвэл төв захиргааны түвшинд бодлого боловсруулахад ашиглах зорилгоор нэгтгэхгүй байна.

юм. Эдгээр талууд нь сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэнд (хэрэв хөтөлбөр байгаа бол) анхаардаг бөгөөд хүүхдүүд ба багш нарын хоорондын, хүүхдүүд хоорондын, багш ба эцэг эхчүүд хоорондын харилцааны давтамж, төрөл, чанарт голчлон анхаардаг юм.

Дэлхийн банкны судалгаагаар цэцэрлэгийн чанарыг үнэлэхдээ Хүүхдийг ивээх сангаас (Save the Children) боловсруулсан Бага насны хүүхдийн суралцах орчны мониторингийн аргачлалыг (Early Childhood Environment Monitoring Instrument/ECEMI) ашигласан юм. Энэхүү судалгаанд ашигласан Бага насны хүүхдийн орчныг үнэлэх хэмжүүрийн (ECERS) Монгол орны нөхцөлд тохируулсан хувилбарыг Хүүхдийг ивээх сангаас боловсруулсан бөгөөд үүнийг цаашид Бага насны хүүхдийн суралцах орчны мониторингийн хэрэгсэл (ECEMI)¹⁷ гэж нэрлэсэн байгаа. ECEMI хэрэгсэл нь ECERS хэмжүүрийн адил бага насны хүүхдийн төв буюу цэцэрлэгүүдийн суралцах, хөгжих орчныг ажиглалт дээр суурилан үнэлэх арга бөгөөд ECERS аргачлалын орон зай ба тавилга, тоноглол (барилгын доторх болон гаднах орон зайны зохицуулалт), үйл ажиллагаа (хүүхдүүдийн хичээлд ашиглаж байгаа материал, оролцуулж байгаа үйл ажиллагаа), сургалтын зохион байгуулалт (тухайн өдрийн хуваарь, үүнд өдөр тутмын үйл ажиллагаа) ба харилцаа (багш ангийг удирдан хянах, хүүхдүүдтэй харилцах, үүнд хэл яриагаар дамжуулан харилцах) (ECERS-R, Harms, Clifford, & Cryer, 1998)¹⁸, ба ECERS аргачлалын Бичиг үсэг ба математикийн (ECERS-E Sylva, Siraj-Blatchford, Taggart, 2003) дэд хэмжүүрүүдийг багтаах юм. Судалгаанд сая дурьдсан зургаан дэд хэмжүүрийг онцлон авчээ. Учир нь СӨБ-ын сургалтын хөтөлбөрийн үндсэн хэсэг эдгээрээс бүрдэх ба эдгээр нь хүүхдийг сургуульд бэлтгэх суурь болж өгдөг юм.

ECEMI аргачлалын зургаан дэд хэмжүүрийн дор нийтдээ 28 зүйл багтаж байна (хүснэгт 2.1). Зүйл тус бүрийн хувьд юуг нь үнэлэхийг заасан байгаа бөгөөд 1 онооноос эхлээд (хангалтгүй), 3 (наад захын), болон 5 (сайн) оноогоор үнэлэх боломжтой байна. Зүйл тус бүрийн эцсийн оноог нэлээд хэдэн дүрмийн дагуу тооцоолж гаргах юм¹⁹. Чанарын дэд хэмжүүр тус бүрийн дундаж оноог тухайн дэд хэмжүүр дотор байгаа зүйл тус бүрийн онооны дунджийг гаргаснаар олно. Үүний дараа долоон дэд хэмжүүрийн оноонуудын дунджийг гаргаснаар ECEMI аргачлалын нийт дундаж утгыг (mean) гаргах юм.

ECEMI аргачлал нь чанарын бүтэц ба үйл явцтай холбоотой талуудыг хоёуланг нь хэмждэг боловч дэд хэмжүүрүүд нь энэ хоёр талын ялгааг тод харуулж чадахгүй. Орон зай ба тавилга, тоноглолын дэд хэмжүүр нь цэцэрлэгийн зай багтаамж, гэрэлтүүлэг, тавилга, тоноглол төхөөрөмж зэрэг дэд бүтэцтэй холбоотой талуудыг үнэлэх ба эдгээр нь

¹⁷Тус аргачлалыг Хүүхдийг ивээх сангаас зургаагаас дээш оронд ашиглаж, үр нөлөө нь баталгаажсан боловч Монгол улсад анх энэ удаа (2015 онд) ашиглаж байна. ECEMI аргачлалыг нэвтрүүлэх сургалтыг Хүүхдийг ивээх сангаас БСШУСЯ, НҮБ-ын Хүүхдийн сан болон бусад орон нутгийн БНХХ-ийн мэргэжилтнүүдтэй хамтран зохион байгуулсан юм. Судалгааны талбарт очиж ажиглалт хийхээс өмнө бүх үнэлээчдийг ECEMI аргачлалыг хэрхэн ашиглах тал дээр сургасан юм. Энэ сургалтын үеэр үнэлээчдээр судалгаанд хамрагдах цэцэрлэгүүдтэй адил төстэй орчинд ажиглалтын дадлага хийлгүүлж, дараа нь ажиглалтын үр дүнг нь хянан шалгасан юм.

¹⁸ECERS-R аргачлалын бүтэн хувилбарт хувийн дадал хэвшил, хэл яриа, тоо тоолол, гүйцэтгэх чадвар, эцэг эх ба ажилтнуудын дэд хэмжүүрүүд багтдаг юм.

¹⁹Үнэлээчид нь эхлээд 1 онооны шаардлагууд хангагдсан эсэхийг үнэлж, тийм бол дараа нь 3 онооны үзүүлэлтүүд хангагдсан эсэхийг шалгаад, дараагийн оноо руу шилжих байдлаар үнэлсэн юм. Ингэхдээ 'stop-scoring' буюу "оноог зогсоох" аргыг ашигласан. Stop-scoring гэдэг нь аль нэг онооны бүх үзүүлэлтүүдийг хангаагүй тохиолдолд үнэлгээг зогсоож, илүү оноо авсан бусад үзүүлэлтүүд байсан ч гэсэн тухайн онооны хувьд үнэлгээг зогсоон оноо өгдөггүй байна.

чанарын бүтэцтэй холбоотой талууд юм. Харилцаа болон сургалтын зохион байгуулалт зэрэг дэд хэмжүүрүүд нь сургалтын үйл явцын чанарыг хэмждэг. Харин үйл ажиллагаа, хэл яриа, бичиг үсэг ба математикийн орчны дэд хэмжүүрүүд нь чанарын хоёр талыг хоёуланг нь хэмждэг юм. Жишээ нь Үйл ажиллагааны дэд хэмжүүр нь ангид тодорхой хэмжээний хөгжмийн зэмсэг байгаа эсэхийг үнэлээд зогсохгүй мөн тэдгээр нь хичээлд өдөр тутам ашиглагдаж байгаа эсэхийг үнэлдэг. Математикийн орчны дэд хэмжүүр нь зохих хэвлэмэл материал байгаа эсэхийг үнэлэхийн зэрэгцээ багш тоо болон тоо сургах аргуудыг өдөр тутмын үйл ажиллагаандаа оруулдаг эсэхийг үнэлдэг юм. Хүүхдүүдтэй холбоотой чанарын бүтцийн асуудлууд, тухайлбал тэдний насны ангилал, багш-хүүхдийн харилцаа, цэцэрлэгийн хэмжээ, бүлгийн насны бүтэц, багш-хүүхдийн харилцах хугацаа зэргийг ECEMI аргачлалаар бус, тусад нь хэмжсэн юм.

Хүснэгт 2.1 Бага насны хүүхдийн хөгжих, суралцах орчныг үнэлэх аргачлал (ECEMI): Чанарын дэд хэмжүүрүүд ба тэдгээрт хамаарах зүйлс

Бүтцийн чанар		Үйл явцын чанар		Бүтэц болон үйл явцын чанарын хоршил	
Дэд хэмжүүр	Зүйл	Дэд хэмжүүр	Зүйл	Дэд хэмжүүр	Зүйл
1. Орон зай ба тавилга	Доторх орон зай	2. Сургалт зохион байгуулалт	Цагийн хуваарь	4. Үйл ажиллагаа	Жижиг булчин хөгжүүлэх материал ашиглах
	Тавилга, тоноглол		Чөлөөт цаг		Зураг, урлалын материал ба тэдгээрийн ашиглалт
	Тоглоход зориулсан орчны зохион байгуулалт		Бүлгийн цаг		Хөгжмийн материал ба тэдгээрийн ашиглалт
	Том булчинг хөгжүүлэх тоглоом	3. Харилцаа	Эерэг зан үйлийг дэмжих арга хэмжээ		Өрж байгуулах тоглоом, материалууд
	Багш-хүүхдийн харилцаа		Жүжиг/төсөөллийг хөгжүүлэх тоглоомын материалууд		
	Хүүхдүүдийн өөр хоорондын харилцаа		Байгаль орчин/шинжлэх ухаан/эрүүл мэндийн материал		
			5. Хэл яриа, бичиг үсгийн чадвар хөгжүүлэх орчин	Хэвлэмэл материал	
				Ном, бичих дасгал	
				Багш хүүхдүүдтэйгээ хамт унших	
				Шүлэг	
			6. Математик ба тооны орчин	Бичиж сурах	
				Ярих/сонсох	
				Тоо ба тоолох	
				Тоог унших ба илэрхийлэх	
				Тоог ашиглаж сурах	
				Ялгах/харьцуулах/шинжлэн дүгнэх	
				Шинжлэх ухаан/туршилт	

Цэцэрлэгийн үйлчилгээний чанарын тухай мэдээллийг төрийн өмчийн цэцэрлэгүүдийн 171 бүлэг (101 цэцэрлэгийн), мөн хувийн хэвшлийн цэцэрлэгүүдийн 5 бүлгийн (50 цэцэрлэгийн) түүврээс цуглуулсан юм. Мэдээлэл цуглуулах ажлыг 2015 оны 10 дугаар сард хийж, Монгол улсын таван бүс нутгийн цэцэрлэгүүдийг түүвэрт хамруулсан юм (хүснэгт 2.2). Түүвэрт хамрагдсан төрийн өмчийн цэцэрлэгт Улаанбаатар хотын 35 цэцэрлэг, мөн найман аймгийн 66 цэцэрлэг хамрагдсан. Улаанбаатар хотын

хувьд гэр хороолол ба гэр хорооллын бус цэцэрлэгүүдийг аль алиныг нь оруулсан юм. Сүүлийн жилүүдэд Улаанбаатар хотын хүн ам хурдацтай нэмэгдсэн нь гэр хорооллын өсөлттэй холбоотой бөгөөд гэр хорооллуудад нэн ядуу өрхүүд амьдарч, сүлжээ холбооны үйлчилгээ төдийлөн сайн нэвтрээгүй, байгалийн гамшигт нэрвэгдэх боломж өндөр байдаг. Эдгээр хороололд амьдардаг бага орлоготой иргэд өөрсдөө гэрээ барьж амьдардаг боловч тэдэнд хатуу хучилттай зам, гудамжны гэрэлтүүлэг, ногоон цэцэрлэг, цэвэр, бохир усны холболт зэрэг үндсэн үйлчилгээ, дэд бүтцийн хангамж байхгүй юм²⁰. Байршил тус бүрийн цэцэрлэгийг төрийн болон хувийн хэвшлийн цэцэрлэгийн бүртгэлээс санамсаргүйгээр түүвэрчилж авсан болно. Улаанбаатар хотоос гадна аймгуудын цэцэрлэгүүдийг аймгийн төвүүд болон сумдаас санамсаргүйгээр түүвэрлэн сонгосон²¹.

Цэцэрлэгүүдийн үйлчилгээний чанарын талаарх мэдээллийг мөн 101 гэр цэцэрлэгийн түүврээс цуглуулжээ. Гэр цэцэрлэг нь Монгол улсад хэрэгжиж байгаа СӨБ-ын сургалтын хамгийн түгээмэл хэлбэр юм. Эдгээр нь зөвхөн зуны улиралд богино хугацаанд ажилладаг учраас мэдээлэл цуглуулалтын ажлыг 2015 оны 6-7 дугаар сарын хугацаанд хийсэн. Мөн эдгээр цэцэрлэгүүд нь цэцэрлэгийн хамран сургалт харьцангуй доогуур байдаг газруудад төвлөрсөн байдаг билээ. Энэ шалтгааны улмаас гэр цэцэрлэгүүдийн түүвэрт хамрагдах байршил бусдаас арай өөр байсан.

Хүснэгт 2.2 Дэлхийн банкны СӨБ-ын чанарын судалгааны түүвэрт багтсан цэцэрлэгийн бүлгүүдийн тоо

Бүс нутаг	Аймаг	Гэр цэцэрлэг	Төрийн өмчийн цэцэрлэг	Хувийн хэвшлийн цэцэрлэг
Зүүн	Хэнтий	20	20	
Төв	Төв	10	4	
	Сэлэнгэ		3	
	Дорноговь	9	14	1
	Дархан-Уул	2	16	2
Хангайн	Өвөрхангай	18	11	1
	Хөвсгөл	24	11	
Баруун	Баян-Өлгий	15	18	
Улаанбаатар			74	51
Нийт		101	171	55

Энэ хэсэгт гарч буй судалгааны үр дүн нь Монгол улсын 5 настай хүүхдүүдийн цэцэрлэгт явдаг түгээмэл учир шалтгаануудыг харуулж байгаа боловч цэцэрлэгт хамрагдсан бүх хүүхдүүдийг төлөөлж чадахгүй юм. Энэ хэсэгт гарч байгаа судалгааны үр дүнг тайлбарлахдаа анхаарах ёстой хоёр зүйл байна. Нэгдүгээрт ЕСЕMI аргачлалыг цэцэрлэгийн түвшинд бус бүлгийн түвшинд ашигласан юм. Тиймээс зарим цэцэрлэгүүдэд нэгээс дээш бүлгийг ажиглаж, тус цэцэрлэгийн ЕСЕMI аргачлалаар шалгуулсан чанарын ажиглалт нь нэлээд хэдэн багц болж байгаа юм. Хоёрдугаарт тус судалгааны ерөнхий зорилго бол цэцэрлэгт хамрагдаж байгаа 5 настай хүүхдүүдийн хөгжлийн үр дүнг үнэлэх ба үүний зэрэгцээ эдгээр хүүхдүүдийн хамрагдаж байгаа цэцэрлэгийн үйлчилгээний чанарыг харах байсан юм. Тиймээс аль нэг цэцэрлэгт ажиглалтанд хамрагдах бүлгийн тоо тухайн цэцэрлэгийн 5 настай хүүхдийн бүлгийн тооноос хамаарч байв. Жишээ нь цэцэрлэгт 5 настай хүүхдийн бүлэг хоёр байвал хоёр

²⁰Дэлхийн банк (2015)

²¹Хувийн цэцэрлэгүүд зөвхөн хот суурин газруудад байдаг ба ихэнх нь Улаанбаатар хотод төвлөрсөн байна. Тиймээс сумдын хувийн цэцэрлэгийн түүвэр гэж байхгүй.

бүлгийг хоёуланг нь ажиглан, судалгаанд хамруулсан. Хүүхдүүдийг хэрхэн түүвэрчилсэн тухай мэдээллийг 3-р бүлгээс харна уу. Ерөнхийд нь дүгнэж хэлэхэд энэхүү хэсэгт гарч байгаа мэдээлэл нь Монгол улсад 5 настай хүүхдүүд ер нь яагаад цэцэрлэгт хамрагддаг болохыг харуулах мэдээлэл гэдгийг ойлгож, энэ нь цэцэрлэгт хамрагдсан бүх хүүхдийг төлөөлж чадахгүй гэдгийг анхаарна уу.

2.2.1 Түүвэрт хамрагдсан цэцэрлэгүүдийн бүтцийн шинж чанарууд

Төрийн өмчийн цэцэрлэгүүд, ялангуяа хот суурин газарт цэцэрлэгүүдийн нэг бүлэгт байх хүүхдийн тоо хэт олон байхад хувийн хэвшлийн цэцэрлэгүүдийнх харьцангуй цөөн байна.

Цэцэрлэгийн бүлгийн хэмжээ нь улсын хэмжээнд янз бүр, мөн цэцэрлэгийн төрлөөс хамааран янз бүр байна (хүснэгт 2.2). Төрийн өмчийн цэцэрлэгүүдийн нэг бүлэгт дунджаар 42²² хүүхэд байв. Нэг бүлэг дэх хүүхдийн тоо нь бүс нутгаас хамааран нэн ялгаатай байх ба Улаанбаатар хотын гэр хороолол ба гэр хорооллоос бусад газруудад 50 –иас бага зэрэг хэтэрч, аймгийн төвүүдэд 37, сумдад 34 байна. Улаанбаатар хотын цэцэрлэгүүдийн нэг бүлэгт байх хүүхдийн тоо хэт олон байгаа нь нэн тулгамдсан асуудлын нэг болж байгаа хэдий ч бусад орон нутгийн цэцэрлэгүүдэд ч мөн адил хүүхдийн тоо олон байна.

Гэр цэцэрлэгийн тухайд, сумын гэр цэцэрлэгийн нэг бүлэгт 22 хүүхэд, аймгийн төвийн гэр цэцэрлэгт 27 хүүхэд хамрагдаж байна. Эндээс дүгнэвэл, гэр цэцэрлэгүүд ч зөвшөөрсөн тоо болох 20-иос хэтэрсэн тооны хүүхэдтэй байна. Судалгааны түүвэрт хамрагдсан 100 гэр цэцэрлэгийн зөвхөн нэг нь л 10 -аас доош тооны хүүхэдтэй байсан.

Хувийн цэцэрлэгүүдийн нэг бүлэгт байх хүүхдийн тоо цөөн, Улаанбаатар хотын гэр хорооллын бус байршил болон аймгийн төвүүдэд нэг бүлэгт ойролцоогоор 20 хүүхэд, Улаанбаатар хотын гэр хорооллуудаар харьцангуй олон буюу нэг бүлэгт 25 хүүхэд хамрагдаж байна.

Хүснэгт 2.3 Монгол улсын цэцэрлэгүүдийн ерөнхий шинж байдал, Дэлхийн банкны СӨБ-ын чанарын судалгаа, 2015

	Төрийн өмчийн гэр цэцэрлэг		Төрийн өмчийн цэцэрлэг		Хувийн цэцэрлэг	
Цэцэрлэгийн байршил						
УБ хотын гэр хорооллын бус байршил	0		31.6		56.4	
УБ хотын гэр хороолол	0		11.7		36.4	
Аймгийн төв	7.1		28.7		7.3	
Сум	92.9		28.1		0	
Нийт	100		100		100	
Цэцэрлэгт ажиллаж байгаа ажилчдын тоо	Дундаж	Голч	Дундаж	Голч	Дундаж	Голч
УБ хотын гэр хорооллын бус			32.5	28	10.8	9
УБ хотын гэр хороолол			31.5	32	10.6	9
Аймгийн төв	25.7	27	28	27.5	10.7	7
Сум	2.6	2	18.8	19		
Нийт	4.2	2	26.3	25	10.7	9
Цэцэрлэгийн бүлгийн хэмжээ	Дундаж	СХ	Дундаж	СХ	Дундаж	СХ
УБ-ын гэр хорооллын бус			51.481	9.31	19.839	6.357

²²Төрийн өмчийн ердийн болон гэр цэцэрлэгүүдийн бүлэг тус бүрт нэг багш, нэг туслах багш ногддог.

УБ-ын гэр хорооллын			52	9.947	25.15	8.261
Аймгийн төв	27.714	4.889	36.51	7.433	20.5	3.317
Сум	22.308	5.385	34.021	8.091		
Нийт	22.694	5.508	42.351	11.775	21.818	7.318
Өнөөдөр байгаа хүүхдийн хувь	Дундаж	СХ	Дундаж	СХ	Дундаж	СХ
УБ хотын гэр хорооллын бус			81.912	9.212	79.697	15.195
УБ хотын гэр хороолол			78.37	13.604	75.747	17.401
Аймгийн төв	76.268	16.712	86.79	8.096	76.368	10.656
Сум	69.897	15.814	79.477	9.841		
Нийт	70.352	15.875	82.212	10.117	78.019	15.648

Эх сурвалж: Дэлхийн банкны СӨБ-ын чанарын судалгааны (2015) мэдээлэлд үндэслэв.

Төрийн өмчийн цэцэрлэгийн хүчин чадал хот суурин газруудад их, хөдөө орон нутагт бага байдаг бол, хувийн цэцэрлэгийнх эдгээртэй харьцуулахад харьцангуй бага байна.

Цэцэрлэгийн хэмжээ, хүчин чадал нь ажилтны тоонд суурилах ба улсын аль хэсэгт оршиж байгаагаас шалтгаалж байгаа юм. Улаанбаатар хотоос бусад газрын СӨБ-ын байгууллагуудын хэмжээ харьцангуй жижиг байдаг. Төрийн өмчийн нэг цэцэрлэгт ногдох ажилчдын дундаж тоо 26, сумын төвд 19, Улаанбаатар хотод 30-аас дөнгөж даваад байна. Хувийн цэцэрлэгүүдийн хэмжээ үүний талтай тэнцэх ба, нэг цэцэрлэгт ногдох ажилтнуудын тоо дунджаар 11 байгаа бөгөөд Улаанбаатар хотын гэр хороолол ба гэр хорооллын бус газруудын хооронд ялгаа бараг байхгүй байна. Сумын гэр цэцэрлэгүүд тус бүрдээ 2-3 ажилтныг ажиллуулж байгаа нь гэр цэцэрлэгийн үйл ажиллагаанд тун тохирч байгаа юм (1-р бүлгийг харна уу). Аймгийн төвүүдийн гэр цэцэрлэгүүд илүү олон тооны (дунджаар 27) ажилтантай гэсэн мэдээллийг өгсөн, яагаад гэвэл тэдгээр нь ердийн цэцэрлэгтэй хоршин ажилладаг бөгөөд ердийн цэцэрлэгийн багш, ажилтнууд гэр цэцэрлэгт бас ажилладаг байна.

Төрийн өмчийн цэцэрлэгт 5 настнууд тусдаа бүлэгт байдаг бол хувийн болон гэр цэцэрлэгүүдэд бусад насныхантай хамт холимог бүлэгт суралцаж байна.

Төрийн өмчийн цэцэрлэгүүдээс судалгааны ажиглалтанд хамрагдсан бүлгүүдэд холимог бүлэг байгаагүй (хүснэгт 2.4). Судалгааны түүвэрт хамрагдсан бүлгүүдийн нэг бүлэгт ногдох 5 настнуудын хувь дунджаар 83 хувь, 3-4 настнууд 16 хувь, харин 6 настнууд зөвхөн 1 хувь байжээ. Дундаж тоо нь байршлаас хамаараад нэлээд хол зөрүүтэй байна. Бусад газруудтай харьцуулахад цэцэрлэгийн бүлгүүд нь 5-аас доош насны хүүхдийн тоогоор нэлээд их байгаа газар зөвхөн сумд байсан. Сумдад нэг бүлэгт ногдох 5-аас доош насныхан дунджаар 23 хувьтай байсан бол Улаанбаатар хотын гэр хороололоос бусад газруудад 15 хувьтай байсан.

Хүснэгт 2.4 Монгол улсын цэцэрлэгүүдийн бүлгүүд насны бүтцээр, 2015

	Улсын гэр цэцэрлэг			Улсын ердийн цэцэрлэг			Хувийн цэцэрлэг		
	3-4 наст-нууд	5-наст-нууд	6-наст-нууд	3-4 наст-нууд	5-наст-нууд	6-наст-нууд	3-4 наст-нууд	5-наст-нууд	6-наст-нууд
УБ хотын гэр хорооллын бус				15	84.5	0.6	44.1	54.3	1.7
УБ хотын гэр хороолол				14.7	85.3	0	51.8	47.8	0.4
Аймгийн төв	83.2	14	2.9	11.5	87.7	0.8	30.5	67.5	2
Сум	61.1	24.5	14.3	23.4	74.5	2.1			
Нийт	62.7	23.8	13.5	16.3	82.7	1	45.9	52.9	1.2

Эх сурвалж: Дэлхийн банкны СӨБ-ын чанарын судалгааны (2015) мэдээлэлд үндэслэв.

Хувийн цэцэрлэгүүдийн бүлгүүд нь насны хувьд холимог байх нь нийтлэг байна. Дунджаар нэг бүлгийн 53 хувь нь 5 настнууд, 46 хувь нь 5 хүртэлх настнууд, 1,2 хувь нь 6 настнуудаас бүрдэж байв. 5 настнуудын эзлэх дундаж хувь Улаанбаатар хотын гэр хороололд 48 хувиас эхлэн хэлбэлзэж байсан бол гэр хорооллын бус газруудад 54 хувьтай байсан. Монгол улсын СӨБ-ын багш нарыг бага насны бүх ангиллын хүүхдүүдтэй ажиллахаар бэлтгэдэг ч гэлээ цэцэрлэгийн нэг бүлэгт холимог насны хүүхдүүдтэй хэрхэн ажиллах тал дээр бэлтгэдэггүй байна. Энэ нь хувийн цэцэрлэгүүдийн багш нар тухайн насны ангиллын хүүхдийн тусгай хэрэгцээг хангаж чадахгүй байхад хүргэх талтай.

Харин гэр цэцэрлэгүүдийн хувьд төрийн өмчийн болон хувийн цэцэрлэгүүдтэй харьцуулахад 5 настнуудын эзлэх хувь маш бага, 5 хүртэлх насныхан ихэнх хувийг эзэлж байна. Нэг бүлэгт дунджаар 5 настнууд 24 хувь, 3-4 настнууд 63 хувь, 6 настнууд 14 хувь байв. Холимог бүлэгтэй багш нар хүүхэд нэг бүрийн насны онцлог, хэрэгцээг хангахуйц үйл ажиллагааг зохион байгуулах тал дээр бэрхшээлтэй байгаад зогсохгүй хүүхдийн хөгжлийн хэрэгцээг хангаж чадахгүй байх эрсдэлтэй юм.

Төрийн өмчийн цэцэрлэгийн хүүхдүүд хувийн цэцэрлэгүүдийнхтэй харьцуулахад одоогоор хамрагдаж байгаа цэцэрлэгтэй илүү удаан хугацааны турш явжээ. Харин гэр цэцэрлэгүүдийн хүүхдүүд өмнө нь СӨБ-д хамрагдаагүй байх нь нийтлэг байна.

Судалгаанд хамрагдсан хүүхэд бүрийн СӨБ-д хамрагдсан хугацааны талаарх мэдээллийг цуглуулсан. Судалгаанд хамрагдсан төрийн өмчийн цэцэрлэгүүдийн 5 настай хүүхдүүд судалгаа авах үеэр СӨБ-д дунджаар 27,2 сарын турш (голч утга 25 сар) хамрагдсан байна (хавсралт 5-г харна уу). Хамрагдсан жилийн дундаж утга нь Улаанбаатар хотын гэр хороололоос бусад газрууд, аймгийн төвүүдэд сумдынхаас илүү их байсан бөгөөд зөрүү нь дунджаар 3 сар байв.

Хувийн цэцэрлэгүүдийн хүүхдүүд СӨБ-д харьцангуй бага хугацааны турш буюу дунджаар 22,6 сарын турш хамрагдаж (голч утга 25 сар), Улаанбаатар хотын гэр хорооллуудад 20 сараас эхлээд Улаанбаатар хотын гэр хороололоос бусад газруудад 24 сар хүртэл хэлбэлзэж байна. Хувийн цэцэрлэгүүдийн хүүхдүүд одоогоор явж байгаа цэцэрлэгтэй улсын цэцэрлэгт хамрагдаж байгаа хүүхдүүдтэй харьцуулахад харьцангуй бага хугацааны турш хамрагдаж байгаа нь сонирхол татаж байв (улсын цэцэрлэгийн 25,2 сартай харьцуулахад 15,3 сар). Мөн хувийн цэцэрлэгүүдийн дунд одоогоор явж байгаа цэцэрлэгтэй хамрагдсан хугацаа нь хоорондоо нэлээд зөрүүтэй, тухайлбал Улаанбаатар хотын гэр хороололд 12,8 сар байсан бол гэр хороололоос бусад газруудад 17,4 сар байна. Өөрөөр хэлбэл хувийн цэцэрлэгт хамрагдаж байгаа хүүхдүүдийн СӨБ-д хамрагдсан нийт хугацаа төрийн өмчийн цэцэрлэгт явж буй хүүхдүүдийн үзүүлэлтээс бага байхаас гадна тэд цэцэрлэгээ солих магадлал өндөртэй байна. Энэ тоо баримт нь хүүхдүүд төрийн өмчийн цэцэрлэгт нэгэнт орсон бол тэр газартаа үлддэг, харин хувийн цэцэрлэгүүдийн хувьд тийм биш байна гэдгийг харуулж байна.

Гэр цэцэрлэгийн хүүхдүүд урьд өмнө нь бараг СӨБ-д хамрагдаагүй байдаг. Хүүхдүүдийн 41 хувийн хувьд одоогоор хамрагдсан цэцэрлэг нь тэдний орсон анхны цэцэрлэг байв. Гэхдээ хүүхдүүдийн багагүй хувь (59) нь урьд нь ямар нэг хэв шинжийн СӨБ-ын үйлчилгээнд хамрагдаж байжээ. Эдгээрээс 50 хувь нь өмнө нь өөр цэцэрлэгт 5 сар буюу түүнээс доош хугацаагаар хамрагдаж байсан байна. Гэхдээ өмнө нь СӨБ-д хамрагдаж байсан хүүхэд цэцэрлэгт дунджаар 10 сар хамрагджээ.

Хувийн цэцэрлэгүүдийн багш хүүхдийн хамтдаа байсан хугацаа төрийн өмчийн цэцэрлэгүүдийнхтэй харьцуулахад богино байх бөгөөд энэ нь хувийн цэцэрлэгүүдийн хамран сургалт тогтворгүй байгааг илтгэж байна.

Судалгаа авах үед төрийн өмчийн цэцэрлэгийн 5 настай хүүхэд одоогийн багштайгаа дунджаар 1,3 жил хамт байжээ (хавсралт 5). Сумдын дундаж нь 1,1 жил байхад, аймгийн төвүүдийнх хамгийн өндөр буюу 1,5 жил байжээ. Тиймээс голч дүн нь дундаж дүнтэйгээ тун ойр байна.

Харин хувийн цэцэрлэгүүдийн багш хүүхдийн хамтдаа байх хугацаа харьцангуй тогтвор муутай байна. Хувийн цэцэрлэгийн хүүхдүүд одоогийн багштайгаа дунджаар 0,6 жил буюу төрийн өмчийн цэцэрлэгийнхээс бараг тал хувиар богино хугацаанд хамт байгаад зогсохгүй, нийт хүүхдийн 50 хувь нь одоогийн багштайгаа хамгийн дээд тал нь 0,1 жил хамт байгаа ажээ. Тэгэхээр хувийн цэцэрлэгүүдийн ихэнх хүүхдүүд одоо явж байгаа цэцэрлэгтээ дор хаяж 15 сарын турш хамрагдсан гэж үзэхэд хувийн цэцэрлэгүүдийн багш нар төрийн өмчийн цэцэрлэгүүдийнхээс илүү олон солигдож байна.

Төрийн өмчийн болон хувийн цэцэрлэгүүдийн ирц бараг адилхан, хүүхдийн цэцэрлэгтээ өнгөрөөсөн цаг хугацаа долоо хоногт 4 өдрөөс доош бараг буухгүй байна. Гэр цэцэрлэгийн ирц үүнээс нэлээд бага байсан.

Цэцэрлэгийн бүлэг тус бүрийн багш судалгаа авсан өдрийн хүүхдийнхээ ирцийг бидэнд мэдээлсэн. Төрийн өмчийн цэцэрлэгүүдэд хамрагдсан хүүхдүүдийн дунджаар 80 хувь ангидаа ирсэн байсан бөгөөд Улаанбаатар хот болон Улаанбаатар хотоос бусад газруудын хоорондын зөрүү байхгүй байв. Хувийн цэцэрлэгүүдийн ирц үүнтэй тун дөхүү (хамрагдсан хүүхдийн 78 хувь) байсан боловч, Улаанбаатар хотын гэр хороололд арай цөөн байсан (75 хувь). Гэр цэцэрлэгүүдэд хамрагдсан хүүхдүүдийн ирц хамгийн бага, дунджаар 70 хувьтай байсан. Гэвч алслагдсан хөдөө орон нутагт зорилтот бүлгийн хүүхдүүдийн СӨБ-ын хүртээмжийн асуудлыг бодолцон үзэхэд энэ нь байж болох зүйл юм.

Судалгаанд хамрагдсан бүх хүүхдийн хувьд өнгөрсөн долоо хоногийнх нь ирцийг бас бүртгэжээ. Судалгаа авах өдөр төрийн өмчийн цэцэрлэгт ирсэн хүүхэд өмнөх долоо хоногт дунджаар 41 цаг цэцэрлэгтээ явж, хөдөө орон нутаг ба хот суурин газруудын дундаж үзүүлэлтийн зөрүү байсангүй. Улаанбаатар хот ба аймгийн төвүүдэд, судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 95 хувь нь өнгөрсөн долоо хоногт цэцэрлэгтээ наад зах нь 32 цаг цаг явсан бол сумдад хамгийн багадаа 24 цаг явжээ.

Гэр цэцэрлэгүүдэд өнгөрсөн долоо хоногт явсан цагийн дундаж хэмжээ 58 цаг байв. Энэ тоо маш өндөр боловч олон гэр цэцэрлэгүүд долоо хоногийн бүх өдрүүдэд буюу 7 өдөр ажилласан гэсэн мэдээллийг өгсөн юм. Мөн ирцийн хэлбэлзэл гэр цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд ердийн цэцэрлэгүүдийнхээс илүү өндөр байсан. Хүүхдүүдийн 10 хувь нь өмнөх долоо хоногт цэцэрлэгтээ 16 цаг буюу түүнээс доош цаг явж, 25 хувь нь дээд тал нь 32 цаг явсан байна. Гэхдээ энд хөдөө орон нутгийн хүн амын амьдралын хэв шинж, ахуйг харгалзан үзэх хэрэгтэй.

Хувийн цэцэрлэгүүдийн сүүлийн 7 хоногийн ирц төрийн өмчийн цэцэрлэгүүдийнхтэй адил, дундаж нь хот суурин, хөдөө орон нутагт ялгаа байсангүй. Улаанбаатар хотын гэр хорооллын хувийн цэцэрлэгийн хүүхдүүдийн ирц цөөвөр буюу 5-р персентилын хувьд улсын ердийн цэцэрлэгүүдийнхээс 8 цагаар бага байжээ.

2.2.2 Чанарыг цэцэрлэгийн төрөл ба байршлаар харсан нь

Төрийн өмчийн цэцэрлэгүүд харилцаан дээр хамгийн өндөр оноо авч, математик ба тооны орчин дээр хамгийн бага оноог авсан байна. ЕСЕМІ аргачлалаар үнэлэхэд төрийн өмчийн цэцэрлэгүүд чанарын индексийн хувьд нэлээд сайн гүйцэтгэлтэй гарсан ба нийт дундаж оноо нь 5 байхаас 4.1 оноотой байна (хүснэгт 2.5). Энэ нь нийт гүйцэтгэлийг “наад захын” (3) ба “сайн” (5)-ы хооронд байсныг харуулж байна. Гүйцэтгэлийг тусдаа дэд хэмжүүрүүдээр үнэлсэн нь аль хэсгийг сайжруулах вэ гэдгийг тодруулж, анхаарах ёстой хэсгийг харуулж байна. Ингээд харилцааны дэд хэмжүүрээр хамгийн өндөр (4.5) оноо авсан бол орон зай ба тавилга/тоноглол (4.3), сургалтын зохион байгуулалт (4.2) зэргээр дараалалтай байв. Үйл ажиллагаагаар 4.17 оноо авсан нь хэл яриа, бичиг үсгийн орчны 4.16 оноотой дөхүү байна. Харин математикийн орчны хэмжигдэхүүн дээр хамгийн бага оноо авчээ (3.63).

Хүснэгт 2.5 Монгол улсын цэцэрлэгүүдийг ЕСЕМІ аргачлалаар үнэлсэн чанарын дэд хэмжүүрүүдийн дундаж оноо, 2015

		Гэр		Улсын ердийн		Хувийн	
		Дундаж	СХ	Дундаж	СХ	Дундаж	СХ
Бүтцийн чанар	<i>Орон зай ба тавилга</i>	3.75	1.199	4.259	0.871	4.127	0.938
Явцын чанар	<i>Харилцаа</i>	4.74	0.63	4.548	0.778	4.642	0.669
	<i>Сургалтын зохион байгуулалт</i>	3.71	1.201	4.201	0.959	4.188	0.931
Бүтэц ба явцын чанар	<i>Үйл ажиллагаа</i>	2.798	0.988	4.171	0.871	3.918	0.929
	<i>Бичиг үсэг</i>	3.815	1.057	4.164	0.755	4.052	0.823
	<i>Математик</i>	3.118	1.126	3.633	0.99	3.506	1.008
ЕСЕМІ аргачлалын чанарын нийт дундаж оноо		3.655	0.805	4.162	0.731	4.072	0.707

Эх сурвалж: : Дэлхийн банкны СӨБ-ын чанарын судалгааны (2015) мэдээлэлд үндэслэв.

Харилцаанаас бусад дэд хэмжүүрийн хувьд хувийн цэцэрлэгүүд бүтэц ба явцын чанарын тал дээр төрийн өмчийн цэцэрлэгүүдийнхтэй тун ойролцоо оноог авсан байна. Хувийн цэцэрлэгүүд төрийн өмчийн цэцэрлэгүүдтэй маш ойр оноог авч, чанарын нийт дундаж оноо нь 4.07 байсан нь улсын цэцэрлэгүүдийнхээс дөнгөж 0.09 оноогоор л бага байгаа юм. Хувийн цэцэрлэгүүд нь төрийн өмчийн цэцэрлэгүүдтэй харьцуулахад таван дэд хэмжүүрийн дөрөвт нь арай бага оноо авсан боловч ялгаа тун бага байсан юм (сургалтын зохион байгуулалт 0.013 онооны зөрүүтэй бол, үйл ажиллагааны оноо 0.25-аар ялгаатай). Эдгээр үр дүнгээс ганцхан харилцаан дээр авсан оноо өөр байсан ба тус дэд хэмжүүрийн хувьд хувийн цэцэрлэгүүд 0.11-ээр илүү оноо авчээ.

Гэр цэцэрлэгүүд харилцааны тал дээр ердийн цэцэрлэгүүдээс илүү оноог авсан боловч чанарын бүтцийн болон үйл явцын бусад бүх хэмжигдэхүүний хувьд нэлээд доогуур оноо авсан. Гэр цэцэрлэгүүд хүнд нөхцөлд үйл ажиллагаа явуулдаг учир чанарын үнэлгээнд ердийн цэцэрлэгүүдийнхээс бага оноо авна гэсэн хүлээлттэй байв. Энэ таамаглал ерөнхийдөө батлагдсан. Гэр цэцэрлэгүүдийн ЕСЕМІ онооны нийт дундаж нь цэцэрлэгүүдээс хагас оноогоор доогуур байна. Ердийн цэцэрлэгүүдтэй харьцуулахад гэр цэцэрлэгүүдийн орон зай, тавилга хагас оноогоор доогуур байв. Уншиж бичихэд бэлтгэхийн хувьд ялгаа нь бага, гуравны нэг онооны зөрүүтэй, харин математикийн хувьд бага зэрэг илүү буюу 0.50 онооны зөрүүтэй байв. Хамгийн их ялгаа үйл ажиллагааны үнэлгээний оноон дээр гарч, гэр цэцэрлэгүүд бүхэл бүтэн 1.35 оноогоор доогуур байсан. Харин харилцааны оноо нь ердийн цэцэрлэгүүдийнхээс 0.23 оноогоор илүү байсан нь гайхмаар сайн үр дүн байв. Гэр цэцэрлэгүүд бусдаас нэлээд хоцордог ч гэлээ хүнд хэцүү

нөхцөлд үйлчилгээг хүргэдэг, цэцэрлэгийн багш нар нь тав тух муутай нөхцөлд ажилладаг зэрэг саад бэрхшээлээс үл хамааран нийт 3.6 оноо авч, “наад захын” буюу 3-аас илүү оноотой байгаа нь үнэхээр сайшаалтай хэрэг юм. Дэд хэмжүүр бүрийн оноо (үйл ажиллагаанаас бусад) “наад захын” ба “сайн” үнэлгээний хооронд хэлбэлзэж байв. Багш нар бүлгийн өрөөний багтаамж тааруу, сургалтын материал ба нөөц боломж хязгаарлагдмал ч гэлээ нөөц бололцоогоо сайн ашиглаж, хүүхдийг хөгжүүлэх, суралцахад таатай орчныг бүрдүүлсэн нь ажиглагдсан. Мэдээж сайжруулах зүйлс байгаа ч гэсэн тэдний хүрсэн ололт амжилт чамлахааргүй сайн байна.

Төрийн өмчийн цэцэрлэгүүдээс хөдөө орон нутгийн цэцэрлэгүүд дэд хэмжүүрээр нэлээд хоцрогдолтой байна. Дэд хэмжүүр бүрийн дундаж оноон дотор тухайн цэцэрлэгийн байршлаас хамааралтай ялгаа байна (зураг 2.1). Улаанбаатар хотын гэр хорооллын ба гэр хорооллоос бусад газрын төрийн өмчийн цэцэрлэгүүд ерөнхийдөө ижил оноотой байна. Аймгийн төвийн цэцэрлэгүүд онооны хувьд нэлээд хоцорч байгаа бол сумын цэцэрлэгүүд хамгийн доогуур оноог авсан. Сумын цэцэрлэгийн хоцрогдол маш их, орон зай, хөгжүүлэх үйл ажиллагаа буюу сургалтын зохион байгуулалт, математикийн дэд хэмжүүрүүдийн хувьд хагас оноогоор дутуу, бичиг үсгийн хувьд гуравны нэг оноогоор доогуур байна. Харин үйл ажиллагааны хувьд сумын цэцэрлэгүүд Улаанбаатар хотын цэцэрлэгүүдээс бүхэл бүтэн нэг оноогоор хоцорч байна.

Аймгийн төвийн гэр цэцэрлэгүүд сумын төвийн гэр цэцэрлэгүүдээс илүү оноог авсан байна. Аймгийн төвд байрлалтай гэр цэцэрлэгүүд сумын төвүүдийнхээс бараг бүх дэд хэмжүүрээр илүү байсан ба, орон зай ба үйл ажиллагааны ангилалд хамгийн их зөрүү ажиглагдаж байв (0.9 хувь). Бусад дэд хэмжүүрийн зөрүү гуравны нэг ба гуравны хоёр онооны ялгаатай байгаа бөгөөд зөвхөн харилцааны хувьд ялгаа бараг байхгүй байна. Энэ үр дүн нь аймгийн төвийн гэр цэцэрлэгүүдийг харьяалдаг төрийн өмчийн цэцэрлэг нь сумын цэцэрлэгүүдээс илүү их санхүүгийн үүсвэртэй байдагтай холбоотой байж болох юм.



Улаанбаатар хотын гэр хорооллын хувийн цэцэрлэгүүд гэр хорооллын бус цэцэрлэгүүдээс бага зэрэг хоцорч байгаа боловч энэ ялгаа нь төрийн өмчийн хот ба хөдөөгийн цэцэрлэгүүдийн чанарын ялгаатай харьцуулахад харьцангуй бага байна.

Улаанбаатар хотын гэр хороолол ба гэр хорооллын бус газарт байдаг ердийн үйл ажиллагаатай хувийн цэцэрлэгүүдээс судалгаа авахдаа бага орлоготой иргэд амьдардаг газруудынх чанараар тааруу байх болов уу гэсэн хүлээлттэй байв. Үнэхээр ч түүвэрт орсон гэр хороололд байрлах хувийн цэцэрлэгүүд гэр хорооллын бус газруудынхаас хоцорч байгаа нь харагдсан юм (зураг 2.2). Гэвч энэхүү ялгаа нь төрийн өмчийн хот ба хөдөөгийн цэцэрлэгүүдийн ялгаанаас бага байгаа юм (зураг 2.1). Эндээс харвал, хувийн цэцэрлэгүүдийн чанарыг төрийн өмчийн цэцэрлэгүүдийнхтэй харьцуулж болохуйц хэмжээнд байна. Харин төрийн өмчийн цэцэрлэгүүд байршлаасаа шалтгаалсан чанарын ялгаа их байна.

2.2.3 ECEMI аргачлалаар тооцсон чанарын дэд хэмжүүр тус бүрийн гүйцэтгэлийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл

Зөвхөн бүтцийн чанарыг үнэлсэн ECEMI аргачлалын дэд хэмжүүрүүд

Орон зай ба тавилгын оноо ихэвчлэн "наад захын шаардлага хангасан" ба "сайн" үнэлгээний хооронд хэлбэлзэж, төрийн өмчийн цэцэрлэгүүдийн бараг гуравны нэгд нь сайжруулах зүйлс байгааг тодруулсан. Тус ангиллын оноонууд нь нэг бүлэгт байх хүүхдийн тоо олон байгааг харуулж байна.

Төрийн өмчийн ердийн цэцэрлэгүүдийн хоёрдахь хамгийн өндөр оноо авсан ангилал бол орон зай ба тавилгын ангилал юм. Цэцэрлэгийн нэг бүлэгт байх хүүхдийн тоо нормоос хэтэрсэн, хэт бөөгнөрөл үүссэн асуудлууд энэ ангилал дээр нэн тод харагдаж байна. Цэцэрлэгүүд ерөнхийдөө тавилга тоног төхөөрөмж хүүхдийн хэрэгцээнд зохицсон эсэх, ерөөний доторх агааржуулалт ба гэрэлтүүлэг, хүүхдийн хөгжийг дэмжих булангууд байгаа эсэх зэрэг үзүүлэлтээр хангалттай оноо авч байв (нийт цэцэрлэгүүдийн 83-88%). Гэхдээ цэцэрлэгүүдийн цөөн хувь нь бүлгийн өрөөнд тоглох, хөгжүүлэх үйл ажиллагаа зохион байгуулах, хүүхдийн хөгжлийг дэмжих булангуудыг зохистой байршуулах хангалттай зайтай байв (73-78%). Зөвхөн 66 хувьд нь бүлгийн өрөөнд нэгэн зэрэг олон төрлийн тоглоом тоглуулахад тохиромжтой зай, 54 хувьд нь том булчинг хөгжүүлэхэд тохирсон хангалттай хэмжээний хэрэгсэл байсан, гэхдээ зөвхөн 60 хувь нь л энэхүү хэрэгслийг ашиглаж байна. Төрийн өмчийн ердийн цэцэрлэгүүдийн 37 хувь энэхүү хэмжигдэхүүнээр төгс 5 оноо буюу "сайн" үнэлгээ авч, өөр нэг 37 хувь нь 4-тэй тэнцүү буюу дээш боловч 5-аас бага оноо авсан.

Ердийн цагаар ажилладаг хувийн цэцэрлэгүүд төрийн өмчийн цэцэрлэгүүдээс багахан зөрүүтэй байгаа боловч гол ялгаа нь бүлгийн өрөөнд дэх хүүхдийн хөгжлийг дэмжих булангууд (19 пунктээр бага байх магадлалтай), мөн эдгээр булангуудыг зохистой байршуулсан эсэх (14 пунктээр доогуур) дээр харагдаж байв. Хувийн цэцэрлэгүүд нэлээд өндөр оноо авсан ганц үзүүлэлт бол том булчинг хөгжүүлэх хэрэгсэл хангалттай байсан явдал юм (8 пунктээр илүү байх магадлалтай). Энэ хэмжигдэхүүнээр нийт хувийн цэцэрлэгүүдийн 35 хувь нь 5 буюу "сайн" үнэлгээг авсан.

Гэр цэцэрлэгийн тухайд дэд бүтцийн асуудал нэн тулгамдаж байдаг атал чанарыг тодорхойлох орон зайн зарим нэг үнэлгээн дээр ердийн цэцэрлэгүүдтэй адил оноо авсан

нь сонирхол татаж байв. Ердийн цэцэрлэгүүдтэй бараг ижил тооны гэр цэцэрлэгүүдэд дасгал хөдөлгөөн хийх, хөгжүүлэх үйл ажиллагаа зохион байгуулахад хангалттай орон зай байв. Гэхдээ орон зайн хүрэлцээ гэр цэцэрлэгт явж буй хүүхдийн тооноос хамаарч байна. Зарим ердийн цэцэрлэгүүд нормоос хэт дэвсан тооны хүүхэдтэй байдаг тухай бид өмнө өгүүлсэн. Тийм учраас ердийн цэцэрлэгийн бүлгийн өрөөний орон зай нь 60 хүүхдэд хүрэлцэхгүй байхад, гэр цэцэрлэгийн жижиг орон зай нь 15 хүүхдэд тохирсон байж болох юм. Гэхдээ гэр цэцэрлэгүүд нь бусад дэд хэмжүүрийн тухайд нэлээд хоцрогдолтой байгаад гайхах зүйлгүй болов уу. Гэр цэцэрлэгүүдийн 11-ээс цөөн хувьд нь шаардлага хангасан агааржуулалт, гэрэлтүүлэг, хүүхдэд тохирсон сандал ширээ байна. Ойролцоогоор 60 хувьд нь хүүхдийн хөгжлийг дэмжих булангууд байсан ба 40 орчим хувь нь том булчин хөгжүүлэх тоноглол хэрэгсэлтэй, тэдгээрийг ашиглаж байна. Гэр цэцэрлэгүүдийн зөвхөн 25 хувь нь энэ дэд хэмжүүрээр төгс 5 оноо буюу "сайн" үнэлгээг авч, 31 хувь нь 5-аас доош, гэхдээ 4-өөс их буюу тэнцүү оноог авсан байна.

Зөвхөн үйл явцын чанарыг үнэлэх ECEMI аргачлалын дэд хэмжүүрүүд

Харилцааны дэд хэмжүүр дээр ихэнх цэцэрлэгүүд "сайн" үнэлгээ авч энэ нь хамгийн өндөр оноо бүхий ангилал болсон. Гэр цэцэрлэгүүд энэ дэд хэмжүүрт төрийн өмчийн цэцэрлэгүүдээс илүү өндөр оноог авсан.

Төрийн өмчийн, хувийн болон гэр цэцэрлэгүүдийн дунд хамгийн өндөр оноо авсан дэд хэмжүүр нь харилцаа байв. Төрийн өмчийн ердийн ажиллагаатай цэцэрлэгүүдийн багш нарын 80-87 хувь нь хүүхдэд бие махбодын шийтгэл үзүүлдэггүй, шийтгэлийн бус аргаар хүүхдийг хүмүүжүүлэх, хүүхэдтэй элэгсэг дулаан, хүндэтгэлтэй харилцаж, хүүхдийнхээ сэтгэл тавгүйтсэн үед нь тайтгаруулж, харилцааны сайн ур чадварыг үлгэрлэхээс гадна үе тэнгийнхэнтэйгээ хэрхэн зөв, зохистой харилцаж сурахад дэмжлэг үзүүлж байсан. Харин цэцэрлэгүүдийн үүнээс арай цөөн (70 хувь) хувь нь зөрчил маргаанаас зайлсхийлсэн, хамгаалсан харилцааны зохион байгуулалттай байв. Үүнд нэг ижил тоглоомын тоо хангалтгүй, хүүхэд дуртай тоглоомоороо тоглох орчин хангалтгүй зэрэг шалтгаанууд нөлөөлсөн юм. Тус дэд хэмжүүрээр төрийн өмчийн ердийн ажиллагаатай цэцэрлэгийн 63 хувь нь 5 оноо буюу "сайн" үнэлгээг авсан.

Хувийн цэцэрлэгүүд энэхүү дэд хэмжүүрийн тухайд төрийн өмчийн ердийн ажиллагаатай цэцэрлэгүүдээс маш багаар илүү байсан бол хамгийн өндөр оноо (10-14 пунктийн ялгаатай)-г гэр цэцэрлэгүүд авсан. Хувийн цэцэрлэгүүд төрийн өмчийн ердийн ажиллагаатай цэцэрлэгүүдээс тун багахан оноогоор илүү байсан. Харин ихээхэн ялгаатай бас нэг хэсэг бол зөрчилдөөн үүсэхээс зайлсхийсэн, хамгаалсан зохион байгуулалттай гэсэн дэд хэмжүүрээр хувийн цэцэрлэгүүд илүү байсан (80 хувь). Энэхүү дэд хэмжүүрээр хувийн цэцэрлэгүүдийн 66 хувь, гэр цэцэрлэгүүдийн 67 хувь нь тус тус 5 оноо буюу "сайн" үнэлгээг авчээ.

Хөгжүүлэх үйл ажиллагаа буюу сургалтын зохион байгуулалтын оноо "наад захын шаардлага хангасан" ба "сайн" хоёрын хооронд хэлбэлзэж, төрийн өмчийн цэцэрлэгүүдийн гуравны нэгд нь сайжруулах зүйлс байна. Энэхүү дэд хэмжүүрийн оноо нь өмнө өгүүлсэнчлэн нэг бүлэгт байх хүүхдийн тоо хэт олон байгаатай холбоотой байна.

Гуравдахь хамгийн өндөр оноо бүхий дэд хэмжүүр бол хөгжүүлэх үйл ажиллагаа буюу сургалтын зохион байгуулалт юм. Чөлөөт тоглоомын цагийн зохион байгуулалт дээр төрийн өмчийн цэцэрлэгүүд сайн оноо авсан. Үүнд ойролцоогоор 80-90 хувь нь өдрийн

багагүй хугацааг чөлөөт тоглоомын цагт зарцуулж, хүүхдүүдийнхээ тоглох үйл явцыг зохих хэмжээнд удирдан чиглүүлэхээс гадна тоглоомын хүртээмж ч боломжийн түвшинд байна. Ихэнх цэцэрлэгүүдийн цагийн хуваарь буюу өдрийн дэглэмд (тухайн хэмжүүрээс хамаараад 64-72 хувь) хатуу дэглэм ба уян хатан байдлыг оновчтой хослуулж, үйл ажиллагааны төрөл зүйл, цагийн ашиглалт зэргийг тооцоолон тусгаж байгаа боловч сайжруулах зүйлс ч байна. Харин бүлгээрээ, нийтээрээ хийх үйл ажиллагааны цагийн хувьд үнэлгээ доогуур байх хандлагатай байна. Нийт бүлгээрээ цугларч хийх үйл ажиллагаа тун бага хугацаатай хийгдэж байгаа ба цэцэрлэгүүдийн зөвхөн 63 хувьд хэрэгжиж байгаа бол жижиг бүлэг ба хэсэгт хуваагдан хийх үйл ажиллагаа 68 хувьд нь хэрэгжиж байна. Өдрийн тогтмол дадал зуршлыг (ариун цэвэр гэх мэт) жижиг бүлгээр буюу хэсгээр хийх нь нийтлэг байна (нийт цэцэрлэгүүдийн 81 хувь). Төрийн өмчийн ердийн ажиллагаатай цэцэрлэгүүдийн 46 хувь энэхүү дэд хэмжүүрээр 5 оноо буюу "сайн" үнэлгээг авч, 21 хувь нь 5-аас доош боловч 4-өөс дээш буюу 4-тэй тэнцүү оноо авсан байна.

Хувийн цэцэрлэгүүдийн цагийн хуваарь улсын цэцэрлэгүүдийнхтэй ерөнхийдөө төстэй байна. Чөлөөт тоглоомын цагийн тухайд ажиглагдсан гол ялгаа нь цөөн тооны хувийн цэцэрлэгүүдэд хангалттай тооны тоглоом, материал байв (10 пунктээр бага). Бүлгийн цагийн хуваарь буюу өдрийн дэглэмд 8 хувиар цөөн тооны цэцэрлэгүүд жижиг бүлгийн үйл ажиллагааг зохион байгуулж байв. Энэхүү дэд хэмжүүрээр төрийн өмчийн ердийн ажиллагаатай цэцэрлэгүүдийн 36 хувь нь 5 оноо буюу "сайн" үнэлгээ авсан.

Төрийн өмчийн ердийн ажиллагаатай цэцэрлэгүүдтэй харьцуулахад гэр цэцэрлэгүүд нь сургалтын зохион байгуулалтын хувьд бүх талаар ихээхэн хоцорч байна. 8-12 хувиар цөөн тооны цэцэрлэгүүд уян хатан байдал ба зохион байгуулалттай дэглэмийн хоорондох зохих тэнцвэрийг хадгалж чадсан бол, нэг үйл ажиллагаанаас нөгөө рүү шилжих хугацаа урт байв. 11-21 хувиар цөөн тооны цэцэрлэгүүдэд чөлөөт тоглоомын цаг хангалттай байж, тоглоомын үеэр удирдан чиглүүлэх байдал, тоглоомын тоо зэрэг нь хангалттай байсан. Жижиг бүлгийн үйл ажиллагаа мөн хязгаарлагдмал байв. Жишээ нь гэр цэцэрлэгийн зөвхөн хагаст нь буюу 50 хувьд өдөр тутмын дадал хэвшлийг жижиг бүлгээр хийж байсан нь төрийн өмчийн ердийн ажиллагаатай цэцэрлэгүүдээс 27 пунктээр доогуур байлаа. Гэр цэцэрлэгүүдийн 31 хувь нь төгс 5 оноо буюу "сайн" үнэлгээг тус дэд хэмжүүрээр авч, 18 хувь нь 4-өөс дээш буюу 4-тэй тэнцүү боловч 5-аас доош оноо авсан байна.

Бүтцийн болон үйл явцын чанарыг хоёуланг нь хэмжих ECЕMI аргачлалын дэд хэмжүүрүүд

Хөгжүүлэх үйл ажиллагааны оноо "наад захын шаардлага хангасан" ба "сайн" гэсэн оноодын хооронд хэлбэлзэж, төрийн өмчийн цэцэрлэгүүдийн гуравны нэгд нь сайжруулах зүйлс байна. Үйл ажиллагааны төрөл зүйл цөөн байгаа нь хамгийн том саад бэрхшээл байна.

Хөгжүүлэх үйл ажиллагаа нь хамгийн өндөр оноо авсан дөрөв дэх дэд хэмжүүр байлаа. Ихэнх төрийн өмчийн ердийн цэцэрлэгүүд энэхүү дэд хэмжүүрт хангалттай оноо авч, цэцэрлэгүүдийн 60-70 хувь жижиг булчингийн хөгжил, зураг, гар урлал, дуу хөгжим, өрж байгуулах тоглоом, жүжигчлэх буюу дүрд хувирч тоглох тоглоом хэрэгсэл, байгаль, шинжлэх ухаан, танин мэдэхүйн тоглоомын нөөц хангалттай бөгөөд тэдгээрийг тогтмол ашигладаг ажээ. Харин бага оноо авсан үнэлгээнүүд нь өдөр тутам ашиглаж байгаа дүрслэн урлах үйл ажиллагааны хэрэгсэл, материалын төрөл зүйл цөөн (62 хувь нь дөрөв ба түүнээс дээш төрөлтэй байв), өрж байгуулах тоглоомын булан байхгүй (57 хувьд нь байсан), жүжигчлэн буюу дүрд хувирч тоглох, төсөөлөл хөгжүүлэх тоглоомын хэрэгсэл,

материал (44 хувь нь олон янзын сэдэвт тоглоомыг оруулж болохоор байна) ба байгаль орчин, шинжлэх ухааны үйл ажиллагаанд ашиглах хэрэгсэл материал дутмаг (57 хувьд нь гурав ба түүнээс дээш төрөл байсан), мөн байгаль орчин, шинжлэх ухаан танин мэдэхүйн тоглоом, хэрэгсэл, материалын зохион байгуулалт хангалтгүй (64 хувь нь тоглоом, хэрэгсэл, материалыг эмх цэгцтэй, хангалттай сайн хэмжээнд бэлдсэн) байв. Тиймээс цэцэрлэгүүдийн нэлээд их хувьд (тухайн үйл ажиллагааны төрлөөс хамааран 30-40 хувь) хангалттай хэрэгсэл, материал байхгүй бөгөөд олонхид нь олон улсын стандартын дагуу шаарддаг олон төрлийн хэрэгсэл, тоглоом, материал байсангүй. Төрийн өмчийн ердийн цэцэрлэгүүдийн 16 хувь нь төгс 5 оноо буюу “сайн” үнэлгээг тус дэд хэмжүүрээр авч, 56 хувь нь 4-өөс дээш, 4-тэй тэнцэх боловч 5-аас доош оноо авсан.

Хувийн цэцэрлэгүүд зарим талаар бага зэрэг доогуур оноотой байсан ба энэ нь цөөн хэдэн зүйлийн хувьд ажиглагдаж байна. Цөөн тооны (төрийн өмчийн цэцэрлэгүүдээс 18 хувиар бага) цэцэрлэгүүдэд дүрслэх урлагийн материалын төрөл зүйл хангалттай ба цөөн тооны (төрийн өмчийн цэцэрлэгүүдээс 20 хувиар бага) цэцэрлэгүүд долоо хоног бүр дуу хөгжим орж байна. Төрийн өмчийн цэцэрлэгүүдтэй харьцуулбал 8-13 хувиар цөөн тооны хувийн цэцэрлэгүүдэд жүжигчлэн дүрд хувирч тоглох хэрэгсэл, тоглоомын төрөл ба ашиглалт хангалттай хэмжээнд байж, 16-21 хувиар цөөн тооны цэцэрлэгүүд байгаль орчин, шинжлэх ухааны хөгжлийг дэмжих үйл ажиллагааны зориулалттай хэрэгсэл, материалын хангамж, ашиглалт хангалттай хэмжээнд байна. Тус дэд хэмжүүрийн тухайд нийт хувийн цэцэрлэгүүдийн 16 хувь нь төгс буюу 5 оноо “сайн” үнэлгээг авчээ.

Энэхүү дэд хэмжүүрийн тухайд хамгийн сүүлд жагсаж байгаа нь гэр цэцэрлэгүүд юм. Хөгжүүлэх үйл ажиллагааг хэмжих дэд хэмжүүрт гэр цэцэрлэгүүдийн хамгийн бага оноо авсан үзүүлэлт нь хэл яриа, унших бичихэд бэлтгэх байгаа бол математикийн орчны үзүүлэлт нь нэлээд дээгүүр оноо авсан байна. Жижиг булчин хөгжүүлэх хэрэгсэл, материалын болон өрж байгуулах тоглоомын ашиглалтын зөрүү их байгаа төдийгүй үүнийг төрийн өмчийн ердийн цэцэрлэгүүдтэй харьцуулахад илрүүлэх үзүүлэлтээс хамааран 13-21 пунктээр бага байх магадлалтай байна. Дүрслэн урлахын хувьд ялгаа их байгаа төдийгүй хөгжүүлэх үйл ажиллагааны материал хэрэгсэл, тоглоомын хангамж болон ашиглах боломж 24-32 пунктээр бага байна. Гэхдээ хамгийн том ялгаа нь жүжиглэх, дүрд хувирч тоглох, байгаль, шинжлэх ухааны үйл ажиллагаануудад харагдаж байна. Гэр цэцэрлэгүүдэд хөгжмийн зэмсэг хэрэгсэл цөөн, үүнийг төрийн өмчийн ердийн цэцэрлэгүүдтэй харьцуулахад 41 ба 97 хувь гэсэн үзүүлэлттэй байна. Гэр цэцэрлэгүүдийн 41 хувьд нь 2-3 төрлийн энгийн хөгжмийн зэмсэг байдаг, 47 хувь нь долоо хоногт наад зах нь нэг удаа дуу хөгжмийн хичээл/хөгжүүлэх үйл ажиллагаа орж байна. Гэр цэцэрлэгүүдийн зөвхөн 4 хувь нь хүүхдүүдээр дуу дуулуулдаг, дөнгөж 10 хувь нь 2-3 хөгжмийн зэмсэгтэй байна. Гэтэл төрийн өмчийн ердийн цэцэрлэгүүдийн 81 хувь нь 4 ба түүнээс дээш тооны хөгжмийн зэмсэгтэй байна. Гэр цэцэрлэгүүдийн 20-27 хувь нь жүжиглэх, дүрд хувирч тоглох, төсөөлөл хөгжүүлэх тоглоом, хэрэгслийн нөөцтэй байгаа бол 18-24 хувь нь байгаль, шинжлэх ухаан, танин мэдэхүйн хөгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах боломж, нөхцлийг бүрдүүлсэн байна. Төрийн өмчийн ердийн цэцэрлэгүүдийн 85-93 хувь нь хүүхдүүд жүжиглэх, дүрд хувирч тоглох, тэдний төсөөллийг хөгжүүлэх наад захын орчныг бүрдүүлсэн бол гэр цэцэрлэгүүдийн хувьд энэ үзүүлэлт 31-45 хувь байна. Төрийн өмчийн ердийн цэцэрлэгүүдийн 88-94 хувь нь байгаль, шинжлэх ухаан, танин мэдэхүйн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны наад захын шаардлага хангах орчныг бүрдүүлж чадсан байгаа бол энэ үзүүлэлт гэр цэцэрлэгүүдийн хувьд 44-54 хувьтай байна. Ерөнхийдөө гэр

цэцэрлэгүүд энэ дэд хэмжүүрт төгс 5 оноо буюу “сайн” үнэлгээг аваагүй ба дөнгөж 18 хувь нь 4-өөс дээш ба 4-тэй тэнцүү боловч 5-аас доош оноо авсан.

Гэр цэцэрлэгүүдийн орон зай, талбайн хэмжээ харьцангуй хязгаарлагдмал гэдгийг тооцон үзээд төрийн өмчийн цэцэрлэгүүдэд байх хөгжүүлэх орчныг бүрдүүлнэ гэж үзвэл зарим талаар учир дутагдалтай юм. Чанарын үнэлгээнээс харахад олонхи гэр цэцэрлэгүүд хамгийн энгийн түвшний хөгжүүлэх үйл ажиллагаануудыг зохион байгуулж, тэдгээр нь төрөл зүйлээр цөөн байна.

Хэл ярианы орчны оноо ихэнхдээ “наад захын” ба “сайн” үнэлгээний хооронд хэлбэлзэж, төрийн өмчийн цэцэрлэгүүдийн гуравны нэгд сайжруулах зүйлс байна. Тоглоом, материал хэрэгслийн хангамж сайнгүй, төрөл зүйл цөөн байгаа нь зарим тохиолдолд асуудал болж байсан хэдий ч сайжруулах шаардлагатай хамгийн чухал зүйл нь бүлгийн өрөөний буюу танхимын зохион байгуулалт, үйл ажиллагаанд хүүхдүүдийг идэвхтэй оролцуулах нөхцлийг бүрдүүлэх явдал юм.

Жич: ЕСЕMI аргачлалын энэхүү дэд хэмжүүр нь хүүхдүүдэд үсэг таниулах, ном уншуулах үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулж, энэ нь хэр амжилттай байгааг үнэлэхийг зориогүй болно. Харин үүний оронд цэцэрлэг нь хүүхдүүдэд ном, хэвлэмэл материалыг үзүүлж, таниулах боломжоор хангагдсан эсэх, мөн бүлгийн өрөөний нийтлэг зохион байгуулалт нь хүүхдүүд өөрсдөө ном авч үзэх бололцоог бүрдүүлсэн эсэхийг үнэлэхэд чиглэсэн.

Хэл яриа ба унших бичихэд бэлтгэх үйл ажиллагааны үнэлгээ хамгийн бага онооны дээд хязгаарын оноог авсан юм. Энэ дэд хэмжүүрийн тухайд хамгийн өндөр оноо авсан үзүүлэлт нь шүлэг байсан ба төрийн өмчийн ердийн цэцэрлэгүүдийн багш нарын 86-аас дээш хувь нь хүүхдүүддээ тогтмол шүлэг зааж, уншуулж, дуу дуулуулж энэхүү үйл ажиллагаандаа хүүхдүүдийг идэвхтэй оролцох бололцоог хангаж байв. Харин бусад илрүүлэх үзүүлэлтүүдийн тухайд цэцэрлэгүүд "наад захын" ба "сайн" үнэлгээний хооронд холимог оноо авчээ. Цэцэрлэгүүдийн 47 хувь нь хангалттай олон төрлийн тайлбартай зурагт үзүүлэн, хэрэглэгдэхүүнтэй (5 болон түүнээс дээш төрөл), 57 хувь нь хүүхдүүдэд үг, үсэг таниулахад таатай орчинтой байв. Цэцэрлэгийн бүлгүүдийн 60-аас дээш хувь олон төрлийн номтой, хүүхдүүд бие даан ном үзэх булантай байсан. Цэцэрлэгүүдийн 70 хувь нь хүүхдүүдийг унших, бичихэд бэлтгэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулдаг, хүүхдүүдийг бие даан ном үзэх орчныг бүрдүүлсэн байсан. Нийт цэцэрлэгүүдийн 80-аас дээш хувь нь бичихэд суралцах орчныг тусгайлан бэлдсэн байсан хэдий ч ашиглалт, хүүхдүүдийн оролцоо сулавтар буюу 60 хувьтай байлаа. Харилцан яриаг дэмжих буюу ярих ба сонсох үйл ажиллагааг цэцэрлэгүүдийн 50-иас доош хувь нь хэрэгжүүлж, 60 ба түүнээс дээш хувьд нь багш нар өөрсдийн удирдаж байгаа ярилцлагын цагтаа хүүхдүүдийг оролцуулж байгаа нь харагджээ. Нийтдээ төрийн өмчийн цэцэрлэгүүдийн 16 хувь төгс 5 оноо буюу “сайн” үнэлгээг энэ дэд хэмжүүрээр авч, 55 хувь нь 4-өөс дээш ба 4-тэй тэнцүү, гэхдээ 5-аас бага оноо авчээ.

Энэ дэд хэмжүүрийн тухайд хувийн цэцэрлэгүүд төрийн өмчийн цэцэрлэгүүдээс бага зэрэг хоцорч байна. Хувийн цэцэрлэгүүдэд тайлбартай зурагт үзүүлэнгийн төрөл илүү олон байсан боловч (9-10 хувиар илүү тооны цэцэрлэгүүд), бусад илрүүлэх үзүүлэлтээр доогуур оноо авсан. 10-16 хувиар доогуур тооны цэцэрлэгүүдэд багш нар нь хүүхдүүдтэйгээ ном үзэх, хүүхдүүддээ шүлэг заах зэргийг боломжийн түвшинд хийж байв. Энэ дэд хэмжүүрээр хувийн цэцэрлэгүүдийн 16 хувь нь төгс 5 буюу “сайн” оноог авсан.

Гэр цэцэрлэгүүд хувийн болон төрийн өмчийн цэцэрлэгүүдээс нэлээд доогуур үнэлгээг авсан боловч зөрүү нь өмнө өгүүлсэн үйл ажиллагааны дэд хэмжүүрийнх шиг их байсангүй. Унших, бичихэд бэлтгэх үйл ажиллагааг илрүүлэх үзүүлэлтийн хувьд 5-15 хувиар цөөн тооны цэцэрлэгүүд ердийн цэцэрлэгүүдийн адил өндөр оноо авсан байна. Үүнд хамаарахгүй гурван илрүүлэх үзүүлэлт бол тайлбартай зургийн төрөл, унших, бичихэд бэлтгэх үйл ажиллагаанд хүүхдүүдийг оролцуулах, харилцан яриаг дэмжих буюу яриа ба сонсох чадварыг хөгжүүлэх үйл ажиллагаа байсан бөгөөд эдгээрт “сайн” үнэлгээ авсан хэд хэдэн гэр цэцэрлэгүүд бий. Энэ дэд хэмжүүрээр нийт гэр цэцэрлэгүүдийн 24 хувь нь төгс 5 оноо буюу “сайн” үнэлгээг, 26 хувь нь 4-өөс дээш ба 4-тэй тэнцүү, гэхдээ 5-аас бага оноо тус тус авсан байна.

Математик ба тооны орчны үнэлгээ ихэвчлэн "наад захын" үнэлгээг авч, хамгийн доогуур үнэлгээтэй, бага оноо авсан дэд хэмжүүр байсан. Ихэнх цэцэрлэгүүдэд хөгжүүлэх үйл ажиллагааны үндсэн хэрэгсэл, материал хомс байгаа учир тооны ухагдахууныг таниулах боломжоор хязгаарлагдмал байна.

Анхаарах зүйл: ЕСЕМІ аргачлалын энэхүү дэд хэмжүүрээр хэмжсэн илрүүлэх үзүүлэлтүүд хүүхдүүд уншиж, тоо таниж сурсан эсэх болон эдгээрийг хэр амжилттай сурч байгааг үнэлэхийг зориогүй болно. Харин үүний оронд цэцэрлэг нь хүүхдүүдэд таниулах, үзүүлэх ном, хэвлэмэл материалаар хангагдсан эсэх, мөн бүлгийн ерөөний ерөнхий зохион байгуулалт нь хүүхдүүд өөрсдөө ном авч үзэх орчныг бүрдүүлсэн эсэхийг үнэлсэн.

Төрийн өмчийн цэцэрлэгүүд хамгийн бага оноог авсан дэд хэмжүүр бол математик юм. Математик ба тооны орчны тухайд цэцэрлэгүүд ерөнхийдөө сайн үнэлгээ авсан. Үүнд цэцэрлэгүүдийн 80 ба түүнээс дээш хувь нь хүүхдийн хөгжилд нийцсэн олон төрлийн сургалтын хэрэглэгдэхүүн, материалтай, тэдгээрийг тогтмол ашигладаг байна. Тоо тооллын дасгал, тоо тоолох үйлдлийг өдөр тутмын үйл ажиллагаандаа оруулсан цэцэрлэгүүдийн эзлэх хувь 73 ба түүнээс дээш байсан бол, нэлээд цөөн хувийнх нь (40 хувь) багш нар хүүхдүүдтэйгээ ажиллахдаа тоог идэвхтэйгээр ашиглаж байсан юм. Цөөн цэцэрлэгүүд (61-71 хувь) тоо тооллын хэрэглэгдэхүүн, материалтай байх ба тоог таних, нэрлэх, ялгах, адилтгах ба харьцуулах дасгалыг хүүхдүүдээр хийлгэдэг байна. Хэлбэр дүрсийг таниулж ойлгуулан, хэлбэр дүрсээр өөр эд зүйлсийн дүрсийг бүтээлгэх нь цөөн давтамжтай (49-53 хувь нь хийдэг), мөн хүүхдүүд шинжлэх ухааны энгийн туршилтыг хийх ба ажиглах боломж хангалтгүй (13 хувь) байв. Тус дэд хэмжүүрийн тухайд төрийн өмчийн цэцэрлэгүүдийн дөнгөж 6 хувь нь төгс 5 оноо буюу “сайн” үнэлгээтэй, 43 хувь нь 4-өөс дээш ба 4-тэй тэнцүү, гэхдээ 5-аас бага оноотой байна.

Хувийн цэцэрлэгүүд энэхүү дэд хэмжүүрийн бүхий л илрүүлэх үзүүлэлтээр төрийн өмчийн цэцэрлэгүүдээс бага зэрэг хоцорч байна. Тоо тооллын хэрэглэгдэхүүн, материалуудыг хооронд нь ялгах, харьцуулах, ангилах дасгалууд хийлгэх тал дээр нэлээд их зөрүүтэй байсан (9-10 хувиар цөөн тооны цэцэрлэг). Хувийн цэцэрлэгүүдийн 6 хувь нь төгс 5 оноо буюу “сайн” үнэлгээг тус дэд хэмжүүрээр авч, 43 хувь нь 4-өөс дээш ба 4-тэй тэнцүү, гэхдээ 5-аас бага оноо авсан байна.

Гэр цэцэрлэгүүд нь математикийн дэд хэмжүүрийн бүхий л илрүүлэх үзүүлэлтээр төрийн өмчийн цэцэрлэгүүдээс харьцангуй доогуур оноо авчээ. Хамгийн их зөрүү нь (15 хувиар цөөн тооны цэцэрлэг ба үүнээс ч их) тоо тооллын хэрэглэгдэхүүн, материал ба тэдгээрийн ашиглалт, тоог таних, нэрлэх ба унших чадваруудад ажиглагдсан. Тоог нэрлэж тоолох дасгалыг бараг хийдэггүй бөгөөд 33 хувиар цөөн тооны цэцэрлэгүүд өдөр тутам тоог

нэрлэж тоолох төрлийн дасгалууд хийдэг байна. Гэр цэцэрлэгүүдийн зөвхөн 7 хувь нь төгс 5 оноо буюу “сайн” үнэлгээг тус дэд хэмжүүрээр авч, 24 хувь нь 4-өөс дээш ба 4-тэй тэнцүү, гэхдээ 5-аас бага оноо авчээ.

2.3 Дүгнэлт

Чанарын стандартууд байгаа боловч тэдгээрийг төрийн өмчийн болон хувийн хэвшлийн цэцэрлэгүүд хэрхэн мөрдөж байгааг системтэй хянах механизм алга байна. Монгол улсад чанарын бүтцийн болон үйл явцын талуудыг зохицуулах тун боломжийн стандартууд байна. Стандартууд нь цэцэрлэгийн дэд бүтэц ба сургалтын буюу хөгжүүлэх үйл ажиллагаанд ашиглах хэрэглэгдэхүүн, материалуудыг хянахад зориулсан бол цөм хөтөлбөр нь хүүхдэд мэдүүлэх, эзэмшүүлвэл зохих гол ухагдахуунууд, хөгжүүлэх үйл ажиллагаан үр дүнд хүүхдийн хөгжилд ямар үр дүн гарах ёстой болохыг харуулдаг. Гэвч стандартыг мөрдөж байгаа үйл явц, чанарын үнэлгээг тогтмол хийхгүй бол сайжруулах шаардлагатай зүйлсийг зөв тодорхойлж, тэдгээрт чиглэсэн хөрөнгө оруулалтыг хийх боломжгүй юм. Энэ бүлэгт төрийн өмчийн хот ба хөдөөгийн цэцэрлэгүүдийн, мөн Улаанбаатар хотын хувийн хэвшлийн цэцэрлэгүүдийн хоорондын ялгаатай байдлын талаар өгүүллээ. Судалгааны явцад ажиглагдсан чанарын ялгаанууд цаашид улам даамжрахаас сэргийлэх, мөн нэн чухал хэсэг рүү хөрөнгө оруулалтыг чиглүүлэхийн тулд БСШУСЯ нь улсынхаа янз бүрийн бүс нутагт байрлаж байгаа төрийн өмчийн болон хувийн цэцэрлэгүүдийн чанарыг тогтмол хянах механизмыг бий болгох шаардлагатай байна.

Төрийн өмчийн цэцэрлэгүүдийн дунд бүтцийн болон үйл явцын чанарын ихээхэн хоцрогдолтой хэсэг нь хөдөө орон нутгийн цэцэрлэгүүд бөгөөд энэ нь 1-р бүлэгт дурдсан нөөцийн хүрэлцээгүй байдалтай холбоотой байж болох талтай. 1-р бүлэгт тус улс СӨБ-д их хэмжээний хөрөнгийг зарцуулдаг ч гэсэн төсвийн хүрэлцээ хангалтгүй байгаагийн улмаас сургалтын хэрэглэгдхүүн, материалыг хангаж өгч чадахгүй байгааг өгүүлсэн. Хот, хөдөөгийн төрийн өмчийн цэцэрлэгүүд орон нутгийн захиргаа болон хувийн эх үүсвэрээс нэмэлт нөөц цуглуулах боломж нь янз бүр байдаг тул энэ нь цэцэрлэгүүдийн чанарын ялгаа, ялангуяа бүтцийн чанарын ялгаанд нөлөөлж байж болох талтай. Энэ бүлэгт олонх цэцэрлэгүүдийн өндөр оноо авсан үйл явцын чанарын харилцааны дэд хэмжүүрээс бусад дэд хэмжүүрийн тухайд чанарын ялгаа бодитой оршин байгаа болохыг тодруулав. Түүнчлэн цэцэрлэгүүдийн ЕСЕMI-ийн дэд хэмжүүрүүдийг бүрэн хангаж чадахгүй байгаа болон 5 оноо авч чадахгүй байгаа дэд хэмжүүрүүдэд санхүүжилт дутмаг байгааг тодруулж байна. Тухайлбал, нэн шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүн, материалын төрөл, хангамжаас шалтгаалан хөгжүүлэх үйл ажиллаганы зохион байгуулалт чанар хамаарч байна.

Харилцаанаас бусад бүх дэд хэмжүүрийн тухайд төрийн өмчийн цэцэрлэгүүд “наад захын” ба “сайн” онооны хоорондох үнэлгээг авсан тул бүтцийн ба үйл явцын чанарыг хоёуланг нь сайжруулах шаардлагатай байна. Энэ хэсэгт гарч буй судалгаа нь төрийн өмчийн цэцэрлэгийн цөөхөн хувь ЕСЕMI аргачлалын дэд хэмжүүрийг бүрэн хангаж байна гэдгийг харууллаа (цэцэрлэгүүдийн 6 – 63 хувь тухайн дэд хэмжүүрээс хамаараад төгс 5 оноо буюу “сайн” үнэлгээг авсан)²³. Харилцаа нь (эерэг зан үйлийг

²³Хэрэв чанарыг ЕСЕMI аргачлалын оронд бүрэн ECERS-R аргачлалаар үнэлсэн бол оноо нь нэн доогуур байх байсныг анхаарна уу. Учир нь ECERS-R аргачлалын зарим хэмжүүрүүдийн тухайд “5” ба “сайн” оноог авахын тулд илүү олон илрүүлэх үзүүлэлтийг хангах хэрэгтэй болдог.

дэмжих, багш-хүүхэд, хүүхэд-хүүхдийн буюу үе тэнгийнхний харилцаа) төрийн өмчийн цэцэрлэгийн гол давуу тал байна. Хөгжүүлэх үйл ажиллагаа, орон зай ба сургалт, хөгжүүлэх үйл ажиллагааны зохион байгуулалтын гүйцэтгэлээр нэлээд сайн байж, цэцэрлэгүүдийн 67-74 хувь нь тус дэд хэмжүүрээр хамгийн багадаа 4 оноо авсан бол цэцэрлэгүүдийн үлдсэн гуравны нэгд сайжруулах зүйлс олон байна. Орон зай ба сургалт, хөгжүүлэх үйл ажиллагааны зохион байгуулалтын дэд хэмжүүрүүдэд бага буюу доогуур оноо авсан зарим нэг тохиолдол нь нэг багшид ногдох хүүхдийн тоо нормоос хэтэрсэн, хэт олон байгаатай холбоотой. Хүснэгт 2.6-д авч болох арга хэмжээнүүдийг тусгасан.

Хүснэгт 2.6 Төрийн өмчийн цэцэрлэгүүдийн чанарыг сайжруулахад анхаарах ёстой зүйлс

Дэд хэмжүүр	ЕСЕМІ аргачлалын оноо	Сайжруулах шаардлагатай цэцэрлэгүүдийн эзлэх хувь	Авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ (Ихээхэн тулгамдаж байгаа асуудлаас бага руу эрэмбэлсэн)
Математик ба тооны орчин	3.633	20-30	Сайжруулах зүйлс...
			Тоо тооллын дасгалын давтамж ба тоог өдөр тутмын үйл ажиллагаанд төлөвлөж хэрэгжүүлэх
			Тоог таних ба нэрлэхэд зориулсан хэрэглэгдэхүүн, материалын хангамж, төрөл; үйл ажиллагаан дахь хүүхдийн оролцоо
			Ялгах, ангилах ба харьцуулах зориулалттай сургалтын хэрэглэгдэхүүн, материал; энэ үйл ажиллагаан дахь хүүхдийн оролцоо
			Хэлбэр дүрсийг таних, ойлгох, тоглох
Хэл ба бичиг үсгийн орчин	4.164	30-40	Багш хүүхдүүдтэйгээ харилцахдаа тоог ашиглах
			Шинжлэх ухааны энгийн туршилтуудыг хийх эсвэл ажиглах үйл явцад хүүхдүүд оролцох
			Хүүхдүүд унших бичихэд бэлтгэх үйл ажиллагаанд оролцох
			Унших бичихэд бэлтгэх үйл ажиллагаанд зориулсан бүлгийн өрөө/танхимийн зохион байгуулалт (хүүхдүүд ганцаараа ном үзэх булан, үг үсэг таньж сурахад нь туслах)
Үйл ажиллагаанууд	4.171	30-40	Тайлбартай зурагт хуудас (5 эсвэл түүнээс дээш төрөл), ном олон төрлийн байх
			Багш харилцан яриа өрнүүлэх дасгал бэлдэх (ярих ба сонсох)
			Жижиг булчинг хөгжүүлэх хэрэгсэл, материалын хангамж, хүртээмж
Сургалтын зохион	4.201	30-40	(дүрслэн урлах хэрэгсэл, хэрэглэгдэхүүн; хөгжмийн зэмсэг; өрж байгуулах тоглоом; жүжиглэх, дүрд хувирч тоглох хэрэгсэл, материал; байгаль ба шинжлэх ухаан, танин мэдэхүйг дэмжих үйл ажиллагаанд ашиглах хэрэглэгдэхүүн, материалууд)
			Өдөр тутам ашигладаг соёл урлагийн материалуудын төрөл (дөрөв ба түүнээс дээш) ба байгаль, шинжлэх ухааны, танин мэдэхүйг дэмжих үйл ажиллагаанд ашиглах материалууд (гурав ба түүнээс дээш); өрж байгуулах тоглоомоор тоглох орон зай, орчныг бүрдүүлэх
		50-60	Байгаль, шинжлэх ухаан танин мэдэхүйг дэмжих үйл ажиллагаанд ашиглах хэрэглэгдэхүүн, материалуудыг зөв зохион байгуулах ба хадгалалт, эдэлгээнд анхаарах
			Жүжиглэх ба төсөөлөн тоглох материалын төрөл олон байх
			Жижиг бүлгийн үйл ажиллагааны цаг, давтамжийг нэмэгдүүлэх

байгуулалт			Өдрийн дэглэм хуваарийг боловсруулахдаа сургалтын болон чөлөөт цагийг зөв тэнцвэржүүлж, үйл ажиллагааны төрлийг олшруулах ба цагийг үр дүнтэй ашиглахад анхаарах
Орон зай, тавилга	4.259	20-30	Бүлгийн өрөөнд чөлөөтэй хөдлөх, үйл ажиллагаа зохион байгуулах орон зай, орчныг бүрдүүлэх, хөгжүүлэх үйл ажиллагааны булангуудыг зөв зохистой зохион байгуулж байрлуулах
		40-50	Бүлгийн өрөөнд хүүхдүүд нэгэн зэрэг олон янзын тоглоом тоглох нөхцлийг бүрдүүлэхийн тулд бүлгийн талбайн зай, хэмжээг анхаарах
Харилцаа	4.548	30	Том булчинг хөгжүүлэх хэрэгслийн хүртээмж ба ашиглалт Бүлгийн өрөөний зохион байгуулалт нь хүүхдүүдийн хооронд зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлсэн, хамгаалсан байх (ижил тоглоомууд олон байх, эсвэл хүүхэд дуртай тоглоомоороо тухтай тоглох орчныг бүрдүүлэх гэх мэт)

Төрийн өмчийн ихэнх цэцэрлэгүүд хөгжүүлэх үйл ажиллагааг дэмжих сургалтын хэрэглэгдэхүүн болон тоглоомын үндсэн багцаар хангагдсан боловч материалын төрөл цөөн, чанар хангалтгүйн улмаас ECERI аргачлалын “сайн” үнэлгээний шаардлагад нийцэхгүй байна. Олон цэцэрлэгүүдэд төгс 5 оноо буюу “сайн” үнэлгээ авахад саад болж байсан хамгийн том бэрхшээл бол сургалтын болон тоглоомын хэрэглэгдэхүүн, материалын төрөл цөөн байсан явдал юм. Нэн шаардлагатай үндсэн хэрэглэгдэхүүн, материалаар хангагдсан боловч тэдгээр нь хүүхдийн хөгжлийн хэрэгцээнд нийцсэн байдал, төрөл зүйл асуудалтай байгаа юм. Унших, бичихэд бэлтгэх дэд хэмжүүрийн тухайд хэрэглэгдэхүүн, материалын асуудал нэн тулгамдаагүй боловч бүлгийн өрөөний зохион байгуулалт, хүүхдүүдийг ном үзүүлэх, уншиж, бичихэд бэлтгэх арга зүйг сайжруулах шаардлагатай байна.

Математик ба тооны орчны бүтцийн болон үйл явцын чанарын гүйцэтгэл аль аль нь маш хангалтгүй байна. Бүх цэцэрлэгүүд математикийн орчны хувьд хамгийн сул гүйцэтгэлтэй байсан ба нийт цэцэрлэгүүдийн 50 хүрэхгүй хувь нь 4 оноог авчээ (өөрөөр хэлбэл “наад захын” ба “сайн” гэх үнэлгээний дундуур байв). Саад бэрхшээлүүд нь бүтцийн болон үйл явцын чанартай аль алинтай нь холбоотой байв. Бүтцийн хувьд хөгжүүлэх үйл ажиллагааны үндсэн материалын хүртээмж муу, тоо таниулах ба нэрлүүлэх, хэлбэр дүрсээр тоглуулах боломж тааруу зэрэг орж байна. Харин үйл явцын хувьд бүлгийн өдөр тутмын үйл ажиллагааны үеэр хүүхдэд тоог таньж мэдэх боломжийг хангаж өгөхгүй байгаа явдал багтаж байгаа юм. Энэ нь тоог нэрлэж тоолох дасгалаас гадна хийгдэж байх ёстой зүйл бөгөөд тоог нэрлэж тоолох дасгал нь ихэнх (гэхдээ бүгд биш) цэцэрлэгийн хэвийн үйл ажиллагааны нэг хэсэг байв. Сүүлийн жилүүдэд Монгол улс цэцэрлэг болон бага сургуулиудыг ном унших боломжоор болон гадаад хэл дээрх материалаар хангах тал дээр ихээхэн ахиц дэвшлийг гаргаж, үүний зарим хэсэгт хандивлагч байгууллагууд тусалсан бол²⁴, тоолох чадварыг хөгжүүлэх тал дээр үүнтэй адил хэмжээнд анхаараагүй байна. Сүүлд шинэчлэн боловсруулсан цэцэрлэгийн цөм

²⁴Дэлхийн банкны санхүүжилттэйгээр хэрэгжсэн “Хөдөөгийн боловсролыг дэмжих READ төсөл” нь нэг жишээ байж болох юм.

хөтөлбөр нь нийгэмшихүй, сэтгэлийн хөдөлгөөн болон бие бялдрын хөгжилтэй харьцуулахад тоо болон математикийн ур чадварт арай бага анхаарсан байна.

Улаанбаатар хотын гэр хорооллын болон гэр хорооллоос бусад газруудад байршилтай хувийн цэцэрлэгүүдийн хоорондын чанарын ялгаа нь зөвхөн СӨБ-ын хамран сургалтыг нэмэгдүүлэхэд чиглэх бус, чанарыг эрхэмлэсэн урамшууллын системийг бий болгох хэрэгтэйг харуулж байна. Энэ бүлгээс харахад хувийн цэцэрлэгүүдийн дунджийг авч үзэхэд төрийн өмчийн цэцэрлэгүүдээс бүтцийн болон үйл явцын чанарын хувьд өчүүхэн төдий л ялгаатай байна. Харин харилцааны дэд хэмжүүрийн тухайд хувийн цэцэрлэгүүд төрийн өмчийн цэцэрлэгүүдээс харьцангуй өндөр үзүүлэлттэй байсан нь цорын ганц ялгаатай тал байв. Гэхдээ ЕСЕMI аргачлалаар илэрч харагдахгүй асуудлууд бас бий. Нэгдүгээрт, багш бэлтгэх сургуульд холимог насны хүүхдүүдтэй хэрхэн ажиллах талаар заадаггүй байхад хувийн цэцэрлэгүүдэд хүүхдүүдийн нас их холимог байгаа нь хүүхдийн хөгжлийн хэрэгцээг хангах багшийн чадварт сөргөөр нөлөөлж байж болох юм. Хоёрдугаарт, хувийн цэцэрлэгийн хүүхдүүд төрийн өмчийн цэцэрлэгүүдийн хүүхдээс илүү олон удаа цэцэрлэгээ сольдог учраас багш-хүүхдийн харилцаа богино хугацаанд үргэлжилдэг байна. Багш нар богино хугацаанд олон удаа солигдох давтамж хувийн цэцэрлэгүүдэд төрийн өмчийн цэцэрлэгүүдийнхээс харьцангуй их байгааг судалгааны мэдээлэл харуулж байгаа төдийгүй энэ нь хүүхдүүдийн хамрагдалтыг бага байхад хүргэж байна. Энэ нь 1-р бүлэгт өгүүлж байсан хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх явдал нэн чухал боловч үүнд нэлээд болгоомжтой хандах шаардлагатай байгаа ба ирээдүйд санаачилж болох оновчтой урамшууллын механизмыг зөвхөн СӨБ-ын хамран сургалтыг нэмэгдүүлэхэд бус, чанарыг сайжруулахад чиглүүлэх хэрэгтэй гэдгийг сануулж байна.

Улаанбаатар хотын амьжиргааны түвшин доогуур хэсэгт СӨБ-ын үйлчилгээний чанарыг сайжруулахад хувийн хэвшлийнхэнд тулгардаг асуудлуудыг ойлгохын тулд нарийвчилсан судалгаа хийх хэрэгтэй байна. Энэхүү судалгаанд хамрагдсан Улаанбаатар хотын гэр хороололд байрлалтай хувийн цэцэрлэгүүд нь хөрөнгө мөнгөний гачигдалтай эздийн жижиг бизнесүүд байсан ба түрээс төлөх, аж ахуй үйлчилгээний төлбөр төлөх зэрэг олон асуудал тэдэнд ихээхэн хүндрэлтэй байдаг тухай мэдээлж байсан. Харин гэр хорооллоос бусад газрын хувийн цэцэрлэгүүдийн чанарын хоцрогдол нь хөрөнгө нөөц хангалтгүй, ихэнх нь маш жижиг байдаг учраас цөөн тооны хүүхэд авдаг, бүлгийн тоо цөөхөн байдгаас үйл ажиллагаагаа ашигтай байдлаар зохион байгуулж чаддаггүй зэрэг шалтгаануудтай холбоотой байж болох юм. Бас нэг хүчин зүйл нь чанар муутай хувийн цэцэрлэгүүдээр үйлчлүүлж байгаа хүн ам юм. Хэрэв тухайн цэцэрлэгийн байршил бага орлоготой газрынх бол эдгээр хувийн цэцэрлэгүүд нь зөвхөн амьжиргааны түвшин доогуур өрхүүдийн хүүхдүүдийг авч, тэдний төлбөрийн чадамжаас шалтгаалан цэцэрлэгийн үйлчилгээний чанарыг сайжруулахад хөрөнгө оруулалт хийхүйц хэмжээний орлогыг олж чаддаггүй байж болох юм. Улаанбаатар хотын гэр хорооллын ба гэр хорооллоос бусад газрын цэцэрлэгүүдийн дундах нийтлэг чанарын ялгаанууд нь өмнөх таамаглалыг тодорхой хэмжээнд баталгаажуулж байна. Харин 3-р бүлэгт энэ асуултын хариу улам тодорхой болох юм.

Гэр цэцэрлэгүүд нь харилцаанаас бусад ЕСЕMI аргачлалын явцын ба бүтцийн чанарын бүх дэд хэмжүүрээр төрийн өмчийн цэцэрлэгүүдээс доогуур үнэлгээг авч, зөвхөн энэ хэмжүүрт ердийн цэцэрлэгүүдээс хол зөрүүтэй байсан юм. Гэр цэцэрлэгүүдийн нөөц боломж тааруу, үйлчилгээг хүргэх орчин хэцүү байдаг учраас

чанарын ихэнх үзүүлэлтээр нэлээд их хоцорч байгаад гайхах зүйлгүй юм. Төрийн өмчийн болон хувийн цэцэрлэгүүдээс харилцааны дэд хэмжүүрээр илүү байснаас бусад тохиолдолд, тухайлбал орон зай ба тавилга, хөгжүүлэх үйл ажиллагааны зохион байгуулалт, унших бичихэд бэлтгэх ба хөгжүүлэх үйл ажиллагааны тухайд доогуур оноо авсан байна. Орон зайны хувьд гэр цэцэрлэгийн агааржуулалт, гэрэлтүүлгийн үзүүлэлтээр доогуур оноо авсан. Харин хөгжүүлэх үйл ажиллагаа, унших ба бичихэд бэлтгэх, математикийн орчин дээр гарсан зөрүүнүүд нь эдгээр үйл ажиллагааг зохион байгуулахад ашиглах хэрэглэгдэхүүн, хэрэгсэл, материалын төрөл цөөн байсантай холбоотой. Гэр цэцэрлэгийг бүх хэрэгсэл, тавилгынх нь хамт малчдыг даган нүүлгэх шаардлагатай болдог тул тээвэрлэх материалын тоо, төрөл “цомхон” байхаас аргагүй юм. Эцэст нь дүгнэхэд хөгжүүлэх үйл ажиллагааны зохион байгуулалтаар доогуур оноо авсан нь багш нар хөгжүүлэх үйл ажиллагааны цагийг илүү үр ашигтай төлөвлөн, зохион байгуулахад анхаарах хэрэгтэйг харуулж байна.

Гэр цэцэрлэгүүдийн үргэлжлэх хугацаа богино, мөн хөгжүүлэх орчны нөхцөл тааруу байдаг нь тэдгээрийн бага насны хүүхдийн боловсролд үзүүлэх нөлөөний талаар хэт өндөр хүлээлт байж болохгүйг сануулж байна. Эдгээр хүчин зүйлс нь амьжиргааны түвшин доогуур хүн амын дундах бага насны хүүхдийн боловсролын үр дүнг сайжруулахад гэр цэцэрлэгийн үзүүлэх нөлөө нь хангалтгүй байна гэдгийг илтгэж байна. Гэр цэцэрлэгийн үргэлжлэх хугацаа дөрвөн долоо хоног ба үүнээс бага хугацааны турш үргэлжилдэг, үйлчилгээний чанар болон үйлчилгээнийхээ чанарыг сайжруулахад тулгардаг саад бэрхшээлийг нь бодоод үзэхэд гэр цэцэрлэгийн үр нөлөө нь төрийн өмчийн ердийн цэцэрлэгт дунджаар хоёр жил явсантай тэнцэх үр дүнтэй байх магадлал тун бага байна. Тэгээд ч судалгааны үр дүнгээр төрийн өмчийн цэцэрлэгүүдийн чанар тэднийг хол давсан учир бүр ч боломжгүй юм. Одоогоор СӨБ-д хоёр сараас доош хамрагдсанаар эерэг үр дүн гарсан баримт нотолгоо дэлхийн аль ч оронд байхгүй бөгөөд тэр дундаа чанарын дээд түвшинг хангасан газруудад ч ийм үр дүн гардаггүй байна. Гэр цэцэрлэгүүд нь амьжиргааны түвшин хамгийн доогуур хүн амыг зорьдог учир энэ ажлыг хийхэд бүр ч амаргүй болж байгаа юм. Гэр цэцэрлэгүүд нь бага насны хүүхдийн боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэхэд томоохон үүргийг гүйцэтгэж, тэдгээрийг Монгол улс даяр баяртайгаар хүлээн авч байгаа ч тэдгээрийн үр өгөөжийн талаарх хэт өндөр хүлээлтээ арай багасгаж, үргэлжлэх хугацаа болон суралцах орчинтой нь нийцүүлэх шаардлагатай байна. Энэ асуудлын талаар 3-р бүлэгт илүү дэлгэрэнгүй өгүүлсэн.

Дараагийн бүлэгт төрийн өмчийн, хувийн болон гэр цэцэрлэгүүдэд хамрагдаж байгаа 5 настай хүүхдүүдийн хөгжлийн үр дүнгийн талаарх мэдээллийг танилцуулна. Өндөр болон бага орлоготой өрхүүдийн хүүхдүүдийн хоорондох зөрүү, мөн тус зөрүүг багасгахад СӨБ-ын хамран сургалт хэрхэн нөлөөлсөн зэрэг нь судалгааны хамгийн сонирхолтой хэсэг байх болно. Тиймээс гол тавигдах ёстой асуулт бол судалгаагаар нотлогдсон чанарын зөрүү нь бага насны хүүхдийн боловсролын үр өгөөжийн аливаа зөрүүд ямар нэг байдлаар нөлөөлж байна уу гэдэгт төвлөрнө. 3-р бүлэгт энэхүү төрийн өмчийн, хувийн болон гэр цэцэрлэгүүдэд хамрагдаж буй 5 настай хүүхдүүдийн бага насны хүүхдийн боловсролын үр өгөөжийн талаарх мэдээллийг тодруулснаар өмнөх асуултанд хариулах юм.

Бүлэг 3. СӨБ-д хамрагдаж байгаа 5 настай хүүхдүүдийн сургуульд бэлтгэгдсэн байдал

2-р бүлэгт төрийн өмчийн, хувийн болон гэр цэцэрлэгүүдийн үйлчилгээний чанар ямар байгаа болон тэдгээр нь хоорондоо чанарын хувьд ихээхэн ялгаатай байгааг тодруулан өгүүлсэн. Чанарын асуудалд сайжруулах зүйлс цөөнгүй байгаа бөгөөд хэрхэн сайжруулах шаардлагатай байгаа нь дэд хэмжүүрийн онооноос хамаарч байна. Тухайлбал, төрийн өмчийн цэцэрлэгүүдийн олонхид сургалт, хөгжүүлэх үйл ажиллагааны үндсэн хэрэглэгдэхүүн, материал байгаа боловч тэдгээрийн төрөл цөөн, чанар тааруу учраас үнэлгээний стандартуудад нийцэхгүй, хангалттай үнэлгээг авч чаддаггүй. Хөгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр нь тоо тоолол, математикт анхаарлыг бараг хандуулаагүй байна. Хувийн цэцэрлэгүүд төрийн өмчийн цэцэрлэгүүдийн хангасан олон шаардлагыг хангаж, төрийн өмчийн цэцэрлэгүүдийн нэгэн адил байршлаас хамаарах чанарын ялгаа ажиглагдсан. Эцэст нь гэр цэцэрлэгийн ажиллах хугацаа богино учраас түүнд хамрагдаж байгаа хүүхдүүдийг бусад цэцэрлэгүүдийнхтэй адил түвшинд хүргэж хөгжүүлэх боломж бараг байхгүй байна.

Энэ бүлэгт СӨБ-ын чанарын тухай өмнө нь ярьж байсан зүйлсээ улам гүнзгийрүүлж, цэцэрлэгт хамрагдсан хүүхдүүдийн БНХБ-ын үр өгөөж юу байгааг тодруулах болно. Үүнийг 2-р бүлэгт өгүүлж байсан Дэлхийн банкны санхүүжүүлтээр 2015 онд хийсэн төрийн өмчийн болон хувийн цэцэрлэгүүдийн үйл явцын чанарыг үнэлсэн СӨБ-ын чанарын судалгааны үр дүнд үндэслэн тодруулах болно. Судалгаанд хамрагдсан цэцэрлэгүүдийн 5 настай хүүхдүүдийн тоо, хэл яриа, нийгэм-сэтгэлийн хөдөлгөөн, танин мэдэхүйн чадвар ба жижиг булчингийн хөгжлийн чиглэлээр БНХБ-ын үр өгөөжийг хэмжсэн юм. Судалгааг хоёр удаагийн мэдээлэл цуглуулах замаар хийсэн. Эхний удаагийн судалгааг Монгол улсын хот суурин ба хөдөө орон нутгийн төрийн өмчийн ердийн цэцэрлэгүүдийн дунд хийсэн. Хоёр дахь удаагийн мэдээлэл цуглуулах ажлыг гэр цэцэрлэгүүдийг хамруулан хийсэн.

Хүүхдийн хөгжилд гарч буй өөрчлөлт, үр дүнг тодорхойлогч хүчин зүйлсийн талаар судалгаагаар олж мэдсэн зүйлс нь дэлхий дахины жишээтэй адилхан байна. Цэцэрлэгийн чанарын оноо өндөр байх тусам бага насны хүүхдийн хөгжлийн бүх талын (хөгжлийн айн) хөгжлийн үзүүлэлт өндөр байна. Тэгэхээр чанар үнэхээр чухал болох нь харагдаж байна. СӨБ-д удаан хугацааны турш хамрагдсанаар илүү сайн үр дүн гардаг болох нь нотлогдож, үүний тоо үзүүлэлтийг магадлан харвал тоо тоолол, унших ба бичихэд бэлтгэх, нийгэм-сэтгэлийн хөдөлгөөний хөгжлийн үзүүлэлтүүд нь сайн буюу өндөр байна. Судалгаагаар чанар ба хамран сургалтыг оролцуулан цэцэрлэгийн түвшний бусад асуудлуудыг шинжлэн үзвээс хүүхдийн гэр бүлийн амьжиргаа, нийгэм-эдийн засгийн нөхцөл байдал тэдний бүх талын хөгжлийн үзүүлэлтэд ихээхэн хэмжээгээр нөлөөлж байдаг ажээ. Гэр бүлийнхэн нь хүүхэдтэй байнга харилцаж, хүүхэд гэр бүлийн гишүүдийн анхаарлын төвд байж, хүүхдийн хөгжилд гэр бүлийн оролцоо их байх нь тэдний тоо тоолол, хэл ярианы хөгжилд ихээхэн нөлөөтэй байдаг бол нийгэм-сэтгэлийн хөдөлгөөний хөгжилд бага зэрэг нөлөө үзүүлдэг байна. Казах хүүхдүүд хэл яриа, нийгэм сэтгэл хөдлөлийн ур чадвараар бусдаас хоцорч байсан ба цэцэрлэгийн чанарыг тооцож үзвэл тус зөрүү арилж байв. Мөн тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн хөгжлийн үзүүлэлтүүд харьцангуй доогуур байна.

Энэ бүлэгт Японы Хүүхдийг ивээх сангаас (ЯХИС) Монгол улсын дөрвөн аймгийн 30 суманд хэрэгжүүлсэн гэр бүлийн орчинд хүүхдийг сургуульд бэлтгэх хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүдээс авсан судалгааны үр дүнг толилуулж байгаа юм. Уг хөтөлбөр нь нийгмийн эмзэг бүлгийн нэг хэсэг болох төрийн өмчийн ердийн цэцэрлэгт хамрагдах боломжгүй малчдын хүүхдүүдийг зорилтот бүлэг болгосон юм. Энэхүү зорилтот бүлэгт чиглэсэн хөтөлбөрийн үйл ажиллагаа нь гэр цэцэрлэгийнхтэй тун төстэй учраас Дэлхийн банкны СӨБ-ын чанарын судалгаанд хамрагдсан гэр цэцэрлэгийн түүврийг ЯХИС-ийн хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүдтэй харьцуулж болох юм. ЯХИС-ийн түүврийн мэдээллийн чанар ба төлөөлөх чадамжийг анхаарч үзэх ёстой бөгөөд энэхүү хөтөлбөрийн үр өгөөжийн талаар эцэслэн нэгтгэсэн баримт нотолгоо хараахан гараагүй боловч гэр цэцэрлэгүүдийн цуглуулсан мэдээлэлтэй харьцуулахад ЯХИС-ийн хөтөлбөрийн хэрэгжилтэд гэр бүлийн таатай орчин ихээхэн нөлөөтэй байж, гэр бүлийн гишүүд хүүхэдтэйгээ хамт суралцаж байсан нь бага насны хүүхдийн хөгжлийг асар ихээр дэмжин, судалгааны хөгжлийн таван чиглэлийн оноо, үзүүлэлт өндөр байхад нөлөөлсөн. Тиймээс ДБ ба ЯХИС-ийн аль алиных судалгааны мэдээлэл, үр дүнгүүд гэр бүлд суурилсан БНХБ-ын сургалтын арга барилууд нь цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа бага насны хүүхдүүдийн боловсролын үр дүнг сайжруулахад чухал нөлөө үзүүлж чадахуйц зүйл болохыг харуулж байна.

Энэхүү бүлэг нь дараах бүтэцтэй. 1 дэх хэсэг нь Дэлхийн банкны СӨБ-ын чанарын судалгаанд суурилах ба СӨБ-ын үйлчилгээнд хамрагдсан хүүхдүүдийн дунд БНХБ-ын үр дүнг тодруулах судалгааны мэдээлэл, мэдээлэл цуглуулах үйл явцын тухай дэлгэрэнгүй өгүүлнэ. Түүнчлэн ялгаатай хэв шинж бүхий цэцэрлэгүүдэд хамрагдаж байгаа 5 настай хүүхдүүдийн ар гэрийн нөхцөл байдлын талаарх судалгааны үр дүнг өгүүлнэ. Тус мэдээлэл нь СӨБ-ын үйлчилгээний зорилтот бүлэг хэр оновчтой тодорхойлогдож байгаа болон Монголын хүн амын аль бүлэгт ямар төрлийн байгууллага үйлчилж байгаа тухай мэдээллийг тодруулав. Дараагийн дэд хэсэгт гэр бүлийн БНХБ-ын орчин, эцэг эхийн хүүхдийнхээ хөгжлийг дэмжих туршлага болон гэр бүлээс гадна бага насны хөгжлийн үр дүнд нөлөөлдөг хүчин зүйлс юу болох тухай өгүүлнэ. Сүүлийн дэд хэсэгт бага насны хөгжлийн үр дүнг 2-р бүлэгт өгүүлсэнтэй адил цэцэрлэгийн төрлөөр хувааж (төрийн өмчийн ердийн цэцэрлэг, хувийн цэцэрлэг, гэр цэцэрлэг) харуулсан. Энд сонирхол татах гол зүйл нь 2-р бүлэгт тодруулан өгүүлсэн чанарын ялгаа нь өрхийн болон хүүхдийн түвшний хүчин зүйлстэй нийлээд боловсролын үр өгөөжид хэрхэн нөлөөлж байгааг харах явдал юм.

2 дахь хэсэгт ЯХИС-аас өөрийн байгууллагын хэрэгжүүлсэн гэр бүлд суурилсан сургуульд бэлтгэх хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүдийн дунд хийсэн судалгааны үр дүнг толилуулж, үүнийг ДБ-ны судалгаанд хамрагдсан гэр цэцэрлэгийн хүүхдүүдийнхтэй харьцуулсан.

3 дахь хэсэгт НҮБ-ын Хүүхдийн сангаас дэмжин хийсэн ОУБТС-ны БНХБ-ын үр өгөөжийн талаарх мэдээллийг оруулсан боловч тус мэдээллийг ДБ-ны судалгаатай харьцуулах боломж хязгаарлагдмал юм. Ингээд 4 дэх хэсэгт гол асуудлуудын тухай тодруулж, цаашид авч болох арга хэмжээнүүдийн талаар тусгасан болно.

3.1 Дэлхийн банкны 2015 оны СӨБ-ын чанарын судалгаа: Мэдээлэл цуглуулалт, түүврийн шинж чанар ба БНХБ-ын үр дүн

3.1.1 Судалгааны түүвэр ба мэдээлэл цуглуулалт

БНХБ-ын үр дүнгийн талаарх мэдээллийг 101 төрийн өмчийн ердийн цэцэрлэгийн түүврийн таван настай 1996 хүүхэд болон 50 хувийн цэцэрлэгийн түүврийн 430 хүүхдээс цуглуулсан юм²⁵. Мэдээлэл цуглуулалтыг зөвхөн 5 настнуудаар хязгаарласан. Учир нь Монгол улсад хүүхдийн сургуульд орох нас 6 байдаг ба БСШУСЯ таван настнуудын сургуульд бэлтгэгдсэн байдал ба тэдний дундах хөгжлийн зөрүүг харахыг хүссэн юм. Мэдээлэл цуглуулах ажил 2015 оны 10-р сард хийгдэж, цэцэрлэгүүдийн түүврийг Монгол улсын таван бүс нутгаас сонгож авсан (хүснэгт 3.1). Түүвэрт орсон төрийн өмчийн ердийн цэцэрлэгт Улаанбаатар хотын 35 цэцэрлэг, найман аймгийн 66 цэцэрлэг сонгогдсон. Улаанбаатар хотод цэцэрлэгийн байршлыг сонгохдоо бага орлоготой гэр хороолол ба гэр хорооллоос бусад чинээлэг хэсэг, газруудыг хамруулсан.²⁶ Улаанбаатар хотоос гадна орших цэцэрлэгүүдийн хувьд аймгийн төв ба сумын цэцэрлэгүүдийг сонгосон. Харин хувийн цэцэрлэг зөвхөн хот суурин газарт, ихэнхдээ Улаанбаатар хотод төвлөрсөн байдаг. Тиймээс хувийн цэцэрлэгийн байршлыг сонгохдоо зөвхөн Улаанбаатар ба аймгийн төвөөр хязгаарласан юм.

Хүснэгт 3.1 ДБ-ны СӨБ-ын чанарын судалгаанд хамрагдсан хүүхдийн тоо

Бүс нутаг	Аймаг	Гэр цэцэрлэг	Төрийн өмчийн	Хувийн
Зүүн	Хэнтий	90	220	
Төв	Төв	85	40	
	Сэлэнгэ		40	
	Дорноговь	38	205	15
	Дархан-Уул	7	141	19
Хангайн	Өвөрхангай	126	212	8
	Хөвсгөл	101	140	
Баруун	Баян-Өлгий	75	260	
Улаанбаатар			738	388
Нийт		534	1996	430

Монгол улсын СӨБ-ын хувилбарт үйлчилгээний хамгийн түгээмэл хэлбэр нүүдлийн гэр цэцэрлэг учраас хүүхдийн хөгжлийн үр дүнгийн талаарх мэдээллийг 101 гэр цэцэрлэгийн түүврийн 5 настай 534 хүүхдээс цуглуулсан. Гэр цэцэрлэгүүд нь ердийн цэцэрлэгийн амралтын хугацаанд буюу зөвхөн зуны саруудад ажилладаг учир эдгээр

²⁵Цэцэрлэг бүрээс дээд тал нь 20 хүүхдийг сонгосон. Цэцэрлэг тус бүрээс хүүхдийг сонгохдоо дараах байдлаар ажиллав. Нэгдүгээрт, 5 настай хүүхэдтэй бүлгийн тоог тодорхойлжээ. Үүний дараа 5 настны бүлэг тус бүрээс ижил тооны хүүхдийг санамсаргүй түүврийн аргаар сонгож, улмаар бусад бүлгийн хүүхдийг нэмснээр цэцэрлэг бүрээс хамруулах хүүхдийн тоог 20-д хүргэж байв.

²⁶Улаанбаатар хотын хүн амын сүүлийн жилүүдийн өсөлт нь нэн ядуу иргэд дийлэнхдээ амьдардаг нийтийн сүлжээ үйлчилгээнээс хол, байгалийн гамшигт өртөх магадлал ихтэй гэр хорооллын өсөлттэй ихээхэн холбоотой байв. Энэ газруудын оршин суугчид болох бага орлоготой иргэд өөрсдөө гэрээ барин амьдардаг боловч тэдэнд хатуу хучилттай зам, ногоон байгууламж, гэрэлтүүлэг, ундны ус болон бохирын холболт зэрэг үндсэн үйлчилгээ, дэд бүтцийн муу хөгжсөн (Дэлхийн банк, 2015).

цэцэрлэгийн мэдээлэл цуглуулах ажлыг 2015 оны 6-7-р сарын хооронд хийсэн. Мөн эдгээр цэцэрлэгүүд нь ердийн цэцэрлэгийн хамран сургалт харьцангуй доогуур байдаг газруудад төвлөрсөн байдаг (хэсэг 3.1). Тийм учраас түүврийн байршлууд нь аймгийн төв ба түүвэрт сонгосон аймгуудын сумдаар хязгаарлагдсан юм.

БНХБ-ын үр дүнг "Бага насны хүүхдийн суралцах үйл явцын чанар ба үр дүнг хэмжих аргачлал"-ыг (MELQO) ашиглан хэмжсэн юм. Энэ аргачлал нь Дэлхийн банк, НҮБ-ын Хүүхдийн сан, НҮБ-ын БСШУБ, АНУ-ын Брукинс институтын Бүх нийтийн боловсролын төв ба дэлхийн олон мэргэжилтнүүдийн хамтран боловсруулсан шинэ аргачлал юм (баримт 3.1). Тус аргачлалаар хүүхдийн хөгжлийн ай/талууд болох танин мэдэхүй, хэл яриа, хөдөлгөөн, нийгэм-сэтгэлийн хөдөлгөөний хөгжил болон өөртөө үйлчлэх, өөрийгөө хянах, удирдах чадваруудыг хэмжиж үнэлсэн²⁷. MELQO аргачлалаар үнэлгээ хийхээс гадна өрхийн хэв шинж, тухайлбал өрхийн нийгэм-эдийн засгийн байдал (боловсролын түвшин гэх мэт) ба гэр бүлийн БНХБ-ын орчны тухай нэмэлт мэдээллийг цуглуулсан юм.

Баримт 3.1 MELQO аргачлал: Бага насны хүүхдийн суралцах үйл явцын үнэлгээг дэлхий нийтэд хүртээмжтэй болгохын төлөө хүчин зүтгэж буй хамтын ажиллагаа

"Бага насны хүүхдийн суралцах үйл явцын чанар ба үр дүнг хэмжих" төсөл нь бага насны хүүхдийн суралцах үйл явцын үнэлгээг бүх дэлхий даяар хүртээмжтэй болгосноор бага насны хүүхдийн боловсролын үр дүнг сайжруулахыг зорьж байгаа юм. Тус төсөл нь өмнө нь боловсруулж байсан аргачлалуудын давуу талуудад үндэслэн хоёр хэрэгслийг боловсруулсан юм. Үүнд: нэгдүгээрт, хүүхдийн хөгжлийн түвшинг хэмжих ба хоёрдугаарт, бага насны хүүхдийн суралцах, хөгжих орчны чанарыг үнэлэх арга хэрэгсэл багтаж байгаа юм. Төсөл нь мөн бага насны хүүхдийн суралцах, хөгжих үйл явцын чанар ба үр дүнг сайжруулах арга хэмжээг авахдаа хэрхэн хариуцлагатай бөгөөд үр ашигтай ажиллах тал дээр засгийн газруудыг зөвлөмжөөр хангадаг.

MELQO аргачлалын гол зорилт, онцлог шинжүүд:

- Өөрсдийн улс орны нөхцөлд тааруулан ашиглаж болох "нээлттэй", үнэ төлбөргүй үнэлгээг маш сайн техникийн зөвлөмжийн хамт хангаж өгөх
- Хүүхдийн хөгжлийн үр дүнг бага насны хүүхдийн суралцах, хөгжих орчны үнэлгээтэй холбон үнэлж болох хэрэгслээр хангаж өгөх
- Одоо байгаа судалгаа болон хэрэгсэлд суурилан орон нутгийн болон дэлхийн түвшинд харьцуулж болохуйц мэдээллийг цуглуулах үндсэн агуулгыг боловсруулах
- Боловсруулсан аргачлалуудаа тухайн улсын хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоонд ашиглагдах боломжийг бий болгохын тухайн улс орнуудтай хамтран ажиллах

Энэхүү төслийг Дэлхийн банк, НҮБ-ын Хүүхдийн сан, НҮБ-ын БСШУБ, Брукинс

²⁷Танин мэдэхүйн чадварт бичиг үсгийн суурь ойлголт, асуудлыг шийдвэрлэх, хэмжих ба харьцуулах, дүн шинжилгээ хийх, тогтоох сэргээх санах, математикийн анхан шатны ойлголт зэрэг багтдаг байна. Хэл ярианы үр чадварт хүүхдийн үгийн нөөц ба түүнийг ашиглах, аман ба бичгийн ярианы чадвар зэрэг багтана. Хөдөлгөөний үр чадварт жижиг болон том бүлчингийн хөгжил ордог бөгөөд хүүхэд өдөр тутмын үйлдэлдээ биеийн хөдөлгөөнөө хэр сайн удирдаж байгааг, тухайлбал алхах, гүйх, үсрэх, зурах, бичих, юмсыг барих ба авах зэргийг хэмждэг. Нийгэм-сэтгэлийн хөдөлгөөний хөгжилд хүүхэд өөрийн болон бусдын мэдрэмжийг хэр сайн ойлгож байгаа зэрэг чадвар багтдаг. Үүнд бас хүүхдийн бусадтай харилцах чадвар, туршлага, өөрийгөө хянах байдал зэргийг хэмждэг. Гүйцэтгэх үр чадварт өөртөө үйлчлэх, өөрийгөө удирдах чадварт хүүхдийн өөрийн биеийг хянан захирах чадвар (биеэ барих чадвар), тэсвэр тэвчээр, аливаад анхаарлаа төвлөрүүлэх, санаачлагатай байх зэрэг чадварууд багтдаг (MELQO, 2015).

Институтын Бүх нийтийн боловсролын төв болон дэлхийн өнцөг булан бүрийн туршлагатай судлаач шинжээчид удирдаж байгаа юм.

Бага насны хүүхдийн суралцах үйл явц ба хөгжлийг хэмжих үндсэн загварыг боловсруулсан ба үүнд, эцэг эх, багшийн мэдээлэл ба 3-7 насны хүүхдийг үнэлэх арга хэрэгсэл багтаж байна. Загварт танин мэдэхүй, хэл яриа, гүйцэтгэх ур чадвар ба нийгэм-сэтгэлийн хөдөлгөөний хөгжлийг хэмжих багц багтсан.

Тус загварын дагуу туршилтын үнэлгээг Бангладеш, Кени, Мадагаскар, Судан ба Танзани зэрэг улсуудад хийсэн бөгөөд өөр олон орнууд (жишээ нь Никарагуа) энэ төсөлд нэгдэхээр төлөвлөж, зарим нь удахгүй нэгдэх болно. Тус үнэлгээний агуулгыг одоо байгаа үнэлгээнүүдэд суурилан боловсруулсан учир одоогийн олон аргачлалын хэмжүүрүүдтэй адил төстэй байна. Тухайлбал ASQ (хүүхдийн хөгжлийн үе шатыг настай нь дүйцүүлэн хэмжих арга), EDI (Канад болон бусад орны боловсруулсан хүүхэд хөгжлийн товч асуулга), IDELA (Олон улсын Хүүхдийг ивээх сангаас боловсруулсан арга), PRIDI (Латин Америкийн 4 орны хүүхдийн хөгжлийн харьцуулсан арга), SDQ (хүүхдийн сэтгэл санааг давуу тал, саад бэрхшээлээр нь тодорхойлох арга), SWAN (тусгай хэрэгцээг тодорхойлох аргачлал), and WCARO (Баруун Африкийн орнуудад хийсэн судалгаа) гэх зэрэг олон төрлийн аргуудад суурилсан юм. Үүний зэрэгцээ хүүхдийн хөгжлийн үнэлгээний энэхүү аргачлал нь Бага ангийн унших чадварын үнэлгээ (EGRA) ба Бага ангийн математикийн чадварын үнэлгээ (EGMA)-тэй нийцэж байгаа юм.

Хүүхдийн хөгжил ба суралцах үйл явцын MELQO аргачлал нь хүүхдийн хөгжлийн талаарх аливаа улс үндэстнийг төлөөлж болохуйц тархалтыг бий болгон, улмаар төсвийн хуваарилалт, сургалтын хөтөлбөрийн бүтэц зохион байгуулалт, багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтанд нөлөөлөхүйц мэдээллээр ханган өгч, судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн хувийг хянах боломжтой болгох юм.

Эх сурвалж: MELQO (2015)

Судалгааны түүвэрт багтсан хүүхдүүдийн нас, хүйс, яс үндэс: Төрийн өмчийн болон хувийн цэцэрлэгүүдийн түүвэрт багтсан хүүхдүүдийн дундаж нас 63 сар байв (5.3 нас). Харин гэр цэцэрлэгийн түүврийн дундаж нас арай “ахмад” 65 сар байж, хүүхдүүдийн насны ялгаа нэлээд хол зөрүүтэй байв²⁸. Ердийн болон гэр цэцэрлэгүүдийн дөнгөж талаас доош хувь нь охидоос бүрдэж байна. Гэр цэцэрлэгийн хүүхдийн 78 хувь ба ердийн цэцэрлэгийн хүүхдийн 80 хувь нь халх өрхийн тэргүүнтэй айлын хүүхдүүд байгаа бол²⁹; 14 ба 13 хувь нь казах, 7 хувь нь бусад ястных байв³⁰.

Төрийн өмчийн цэцэрлэгийн таван настай хүүхдүүдийн 5 хувь нь тусгай хэрэгцээтэй хүүхдүүд байдаг болох нь багш нарын өгсөн мэдээллээр баримтжив. Хувийн цэцэрлэгүүдэд тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн эзлэх хувь өндөр байна. Судалгаанд биеийн эрүүл мэндийн байдлыг илтгэх хэмжүүрүүд (жишээ нь антропометрик хэмжээсүүд) ороогүй боловч багш нараас өөрийнх нь бүлэгт байгаа хүүхдүүдийн эрүүл мэндийн ерөнхий байдлын талаар асуусан юм. Төрийн өмчийн ердийн цэцэрлэгийн

²⁸Гэр цэцэрлэг ба төрийн өмчийн ердийн цэцэрлэгийн түүврийн хоорондох насны ялгаа их байгаа учир үр дүнгийн талаарх аливаа харьцуулалтыг хийхийн тулд гэр цэцэрлэгийн түүврийг зөвхөн 5 настнуудаар хязгаарласан юм. Энэхүү тайлангийн дараагийн хэсэгт өгүүлэх бүхий л дүн шинжилгээ нь насны ангиллын дагуу хийгдсэн.

²⁹Монгол улсын хүн амын 95 хувь нь халх ястан юм.

³⁰“Бусад” ястанд дөрвөд, баяд, урианхай, буриад ба бусад орно.

хүүхдийн 10-аас илүү хувь нь амархан өвдөж, ядардаг гэсэн бол 5 хувьд нь тусгай анхаарал шаардах хөгжлийн бэрхшээл байдаг гэжээ. Хувийн болон гэр цэцэрлэгүүдэд амархан өвчилдөг хүүхдийн тоо харьцангуй бага (5 хувь) байсан боловч хүүхдүүдийн ядрах байдал төрийн өмчийн ердийн цэцэрлэгийнхтэй адилхан байсан юм. Гэр цэцэрлэгүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эзлэх хувь төрийн өмчийн цэцэрлэгийнхтэй адил байсан бол хувийн цэцэрлэгийн түүвэрт хоёр дахин илүү (10 хувь) байв.

3.1.2 Цэцэрлэгт хамрагдсан 5 настай хүүхдүүдийн ар гэрийн нөхцөл байдал

Энэхүү тайлангийн гол зорилгуудын нэг бол СӨБ-д оруулж байгаа төрийн хөрөнгө оруулалтаас хэн үр шим хүртэж байгаа, мөн үйлчилгээний чанар нийгэм-эдийн засгийн нөхцөл байдлаас хамааран хэр ялгаатай байгааг тодруулах юм. Энэ зорилгын үүднээс судалгаанд хамрагдсан хүүхэд бүрээс нийгэм, эдийн засгийн хэдэн чухал үзүүлэлтээр мэдээлэл цуглуулсан юм. Эцэг эхийн боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн байдал, өрхийн эзэмшилд байгаа өмч хөрөнгө зэргийн талаар хүүхдийн эцэг эх болон хамгийн ойрын асран хамгаалагчдаас асууж, ярилцан мэдээлэл авсан юм. Энэ мэдээллийг авснаар бид СӨБ-ын үйлчилгээний үр шим хүртэгчдийн нийгэм, эдийн засгийн шинж чанаруудыг илүү сайн ойлгож, СӨБ-ын үйлчилгээ нь хамгийн их хэрэгцээтэй хүүхдүүд, иргэдэд хэр хүрч байгааг тодруулж, СӨБ-д хийж буй төрийн хөрөнгө оруулалт нь ядуу ба чинээлэг өрхөд төрсөн хүүхдүүдийн хоорондох зөрүүг багасгахад хэрхэн тус нэмэр болж байгааг харах болно. Судалгааны хүрээнд мөн БНХБ-ын үр дүнд цэцэрлэгийн үйл ажиллагаанаас гадуур нөлөөлж байгаа хүүхдийн гэр бүлийн орчны цөөн хэдэн түлхүүр нөлөөний талаар мэдээллийг цуглуулав³¹. Үр дүнг энэ хэсэгт танилцуулсан болно.

Төрийн өмчийн ердийн цэцэрлэгүүд нийгэм, эдийн засгийн янз бүрийн түвшинд амьдарч байгаа өрхийн хүүхдүүдэд үйлчилж байна.

Төрийн өмчийн ердийн цэцэрлэгүүдийн хүүхдүүдийн ээжүүдийн боловсролын түвшин тухайн цэцэрлэгийн байршлаас хамаараад янз бүр байв (зураг 3.1). Улаанбаатар хотын гэр хорооллоос бусад газруудад ээжүүдийн боловсролын түвшин хамгийн өндөр байж, үүнд түүвэрт хамрагдсан ээжүүдийн 71 хувь нь бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй байгаад гайхах зүйлгүй юм. Улаанбаатар хот болон аймгийн төвийн гэр хороололд энэ хувь 46-48 хүртэл буурч, сумдад 34 хувьтай байв. Дунд болон дундаас доош боловсролтой ээжүүдийн эзлэх хувь Улаанбаатар хотын гэр хорооллоос бусад газарт 5 хувь байснаа сумдад 26 хувь болж өсөв. Аавуудын боловсролын түвшин ерөнхийдөө ээжүүдийнхээс доогуур байсан бол (зураг 3.2) байршлаас шалтгаалах ялгаа байсангүй. Бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй аавуудын эзлэх хувь Улаанбаатар хотын гэр хорооллоос бусад газарт 58 хувь байснаа сумдад 21 хувь болж буурсан бол бага болон түүнээс доош боловсролтой аавуудын эзлэх хувь 0 -11 хүртэл байв.

Өрхийн тэргүүний хөдөлмөр эрхлэлтийн байдлын хувьд нөхцөл байдал адилхан харагдаж байна. Улаанбаатар хотын гэр хорооллоос бусад газарт гайгүй түвшинд байснаа сумдад улам дордож байна (зураг 3.3). Өрхийн тэргүүн нь ажилгүй эсвэл тодорхой хөдөлмөр эрхлэдэггүй гэж хэлсэн өрхүүдийн хүүхдүүдийн эзлэх хувь Улаанбаатар хотын гэр хорооллоос бусад газарт 10 хувь байсан бол сумдад 21 хувь болж өсөв. Аймгийн төв ба


³¹Үүнд эцэг эхчүүдийг дараах үйл ажиллагаанд хэр оролцдог болохыг хэмжсэн: хүүхдэдээ ном уншиж өгөх эсвэл тэдэнтэй хамт зурагтай ном үзэх, үлгэр ярих, дуу дуулах, тоглох, хамтдаа гадуур цагийг өнгөрүүлэх, мөн янз бүрийн эд зүйлсийг хамтдаа нэрлэх, тоолох ба зурах гэх мэт.

сумын цэцэрлэгүүдэд голчлон мал аж ахуй эрхлэдэг тэргүүнтэй өрхүүдийн хүүхдүүдийн эзлэх хувь нэлээд өндөр байсан ба Улаанбаатар хотын 1 хувьтай харьцуулахад аймгийн төвүүдэд 6, сумдад 25 хувьтай байна.


Цэцэрлэгт хамрагдаж байгаа хүүхдүүдийн нийгэм, эдийн засгийн байдалтай холбоотой бас нэг зүйл бол хүүхэд бүрийн ар гэрийн аж байдлын түвшин юм. Өрхийн хэрэглээ ба орлогын талаар мэдээлэл байхгүй тохиолдолд "хөрөнгийн индекс" буюу хөрөнгө эзэмшлийн илрүүлэх үзүүлэлтийг ашиглан гаргасан шугаман илэрхийллийн индексийг ашиглан, үндсэн бүрэлдэхүүний шинжилгээг хийснээр аж байдлын түвшинг тодорхойлж болно (индексийг хэрхэн боловсруулж гаргасан тухай дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт 6-аас харна уу).

Зураг 3.4-д байршил бүрийн төрийн өмчийн цэцэрлэгт хамрагдаж байгаа хүүхдүүдийн өрхийн аж байдлын индексийн дундаж оноог харуулсан байна. Тус оноонууд нь боловсролын түвшин ба хөдөлмөр эрхлэлтийн байдлын талаар хийсэн судалгааны үр дүнг тусган харуулж байна. Аж байдлын түвшний оноо нь Улаанбаатар хотын гэр хорооллоос бусад газруудад дунджаар 0.70 байснаа гэр хорооллуудад 0.33 болтлоо буурч, сумдад 0.24 хүртэл багасч байна.

Зураг 3.1 Монгол улсын цэцэрлэгт хамрагдсан 5 настай хүүхдүүдийн ээжүүдийн боловсрол, 2015 оны байдлаар




Зураг 3.2 Монгол улсын цэцэрлэгт хамрагдсан 5 настай хүүхдүүдийн аавуудын боловсрол, 2015 оны байдлаар




Эх сурвалж: Дэлхийн банкны СӨБ-ын чанарын судалгааны (2015) мэдээлэлд үндэслэв.

Зураг 3.3 Монгол улсын цэцэрлэгт хамрагдсан 5 настай хүүхдүүдийн гэр бүлийн өрхийн тэргүүний хөдөлмөр эрхлэлт, 2015 оны байдлаар



Зураг 3.4 Монгол улсын цэцэрлэгт хамрагдаж байгаа 5 настай хүүхдүүдийн өрхийн аж байдлын индексийн оноонууд, 2015 оны байдлаар



Эх сурвалж: Дэлхийн банкны СӨБ-ын чанарын судалгааны (2015) мэдээлэлд үндэслэв.

Хавсралт 7-д ДБ-ны чанарын үнэлгээний судалгааг 2010 оны бүх улсыг төлөөлж чадахуйц Олон Үзүүлэлтийн Бүлгийн Түүвэр Судалгаа (ОУБТС)-тай харьцуулсан байна. ДБ-ны дэд түүвэрт сонгосон төрийн өмчийн цэцэрлэгийн нэн ядуу өрхүүдийн хүүхдүүдийн байдал өрхийн эд хөрөнгө, эцэг эхийн боловсролын хувьд нь ОУБТС-ны нэн ядуу өрхүүдийнхтэй ижил харагдаж байгаа бол хамгийн чинээлэг өрхүүдийн хүүхдүүдийн байдал нэлээд сайн байна.

Хувийн цэцэрлэгүүд нь төрийн өмчийн цэцэрлэгүүдтэй харьцуулахад нийгэм, эдийн засгийн байдлаарх ангиллын хамгийн дээд эсвэл доод хязгаарын хүүхдүүдийг хамруулах магадлалтай байна.

Улаанбаатар хотын гэр хорооллоос бусад газрын хувийн цэцэрлэгүүд нь үүнтэй адил байршлын төрийн өмчийн цэцэрлэгүүдээс нэлээд өөр хүн амын бүлэгт үйлчилдэг байна (зураг 3.1-3.4). Харин хөдөлмөр эрхлэлтийн хувьд нь энэ хоёр цэцэрлэгийн ялгаа багасч, гол ялгаа нь хувийн цэцэрлэгт хамрагдаж байгаа хүүхдүүдийн өрхийн тэргүүнүүд тогтмол цалинтай ажил хийхээс илүү хувиараа хөдөлмөр эрхлэх нь нэлээд илүү байсан ба ажилгүй эсвэл мэргэжилгүй гэж хариулах тохиолдол харьцангуй бага байсан. Харин хамрагдсан хүүхдүүдийн эцэг эхчүүдийн боловсролын түвшинг харахад гайхмаар ялгаа харагдаж байна. Бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй ээжүүдийн эзлэх хувь хувийн цэцэрлэгт 88 хувь байгаа нь үүнтэй адил байршлын төрийн өмчийн цэцэрлэгүүдийнхээс бүхэл бүтэн 17 пунктээр илүү байгаа юм. Аавуудын хувьд энэ зөрүү бүр ч их байна. Аавуудын бакалавр эсвэл түүнээс дээш зэрэгтэй байх магадлал 19 пунктээр илүү байна. Хүүхдүүдийн өрхийн аж байдлын индексийн оноо 1.08 байгаа нь яг ижил байршлуудад байгаа төрийн өмчийн цэцэрлэгүүдийн өрхүүдээс нэлээд дээгүүр (0.70) байна.

Улаанбаатар хотын гэр хороололд байршилтай төрийн өмчийн болон хувийн цэцэрлэгүүдийн хүүхдүүдийн хоорондын ялгаа маш бага байлаа. Ээжүүдийн боловсролын түвшин нь ялгаа багатай, мөн аавуудын боловсролын түвшин бараг нэг түвшинд байна. Хувийн цэцэрлэгийн хувьд бакалавр эсвэл түүнээс дээш зэрэгтэй байх магадлал бага зэрэг илүү байсан ба дунд болон түүнээс доош боловсрол, эсвэл боловсролын түвшин тодорхойгүй ээж, аавуудын эзлэх хувь бага зэрэг өндөр байв. Хүүхдүүдийн өрхийн аж байдлын дундаж оноо 0.21 байгаа нь тус байршилд орших төрийн өмчийн цэцэрлэгүүдийн өрхүүдийнхээс ялимгүй бага (0.33) байна.


Судалгааны энэхүү үр дүнгээс харахад Улаанбаатар хотын гэр хороололоос бусад газрын хувийн цэцэрлэгүүд нь гэр хорооллын хувийн цэцэрлэгүүдээс нийгэм, эдийн засгийн байдлын хувьд олон үзүүлэлтээр дээгүүр хүн амд үйлчилдэг болох нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл Улаанбаатар хотын төрийн өмчийн болон хувийн хэвшлийн цэцэрлэгүүд нь ялгаатай түвшний хэрэгцээтэй хүн амд үйлчилж, хувийн хэвшил нь чинээлэг иргэдийн арай илүү хувьд (нэн ядуу иргэдэд арай бага хувиар), төрийн өмчийн цэцэрлэгүүд нь дундаж буюу арай өргөн хүрээний хүн амд үйлчилж байна (зураг 3.5).

Хавсралт 7-д ДБ-ны чанарын үнэлгээний судалгааг улсыг төлөөлж чадахуйц 2010 оны Олон Үзүүлэлтийн Бүлгийн Түүвэр судалгаатай (ОУБТС) харьцуулсан байгаа. ДБ-ны дэд түүвэрт сонгосон төрийн өмчийн цэцэрлэгийн нэн ядуу өрхүүдийн хүүхдүүдийн байдал өрхийн өмч хөрөнгө, эцэг эхийн боловсролын түвшний хувьд ОУБТС-ны нэн ядуу өрхүүдийнхтэй адилхан тааруу харагдаж байгаа бол чинээлэг өрхүүдийн хүүхдүүдийн байдал нэлээд сайн байна.

Сумдад нэн эмзэг бүлгийн хүүхдүүдэд хүрч чадаж байгаа бол аймгийн төвүүдэд төдийлөн сайн биш байна.

Гэр цэцэрлэгүүд нь төрийн өмчийн ердийн цэцэрлэгүүдтэй харьцуулахад огт өөр зорилтот бүлэгтэй байна гэж заасан нь нүүдлийн ахуй амьдралаасаа болж хүүхдүүдээ ердийн цэцэрлэгт хамруулж чадахгүй байгаа, хүрч очиход бэрхшээлтэй нүүдлийн мал аж ахуй эрхлэдэг өрхүүдийн хүүхдүүд юм. Суманд ажиллаж байгаа гэр цэцэрлэгүүдийн хувьд энэ зорилтод тодорхой хэмжээнд хүрч байна (зураг 3.1-3.4). Түүвэрт хамрагдсан хүүхдүүдийн 74 хувь мал маллаж амьдардаг өрхийн хүүхдүүд байсан бол 10 хувь нь ажилгүй эсвэл мэргэжилгүй хүмүүсийн хүүхдүүд байжээ. Эцэг, эх хоёрын боловсролын түвшин ч бас адилхан доогуур түвшинд байна. Эхийн боловсролын түвшин судалгаанд хамрагдсан бусад газрын төрийн өмчийн ердийн ба хувийн цэцэрлэгүүдийн аль алиныхаас харьцангуй доогуур байсан бөгөөд аавуудын хувьд ч бас энэ байдал ажиглагдаж байна. Эцэст нь, сумын гэр цэцэрлэгүүдэд хамрагдаж байгаа хүүхдүүдийн өрхийн аж байдлын индекс нь дунджаар -1.26 оноотой байгаа нь бүх байршлын түүвэр дундаас хамгийн бага оноотой нь

Зураг 3.5 Улаанбаатар хотын цэцэрлэгт хамрагдсан 5 настай хүүхдүүдийн өрхийн аж байдлын индексийн оноо, Монгол улс, 2015 он



Эх сурвалж: Дэлхийн банкны СӨБ-ын чанарын судалгааны (2015) мэдээлэлд үндэслэв.

бөгөөд Улаанбаатар хотын гэр хорооллоос бусад газрын цэцэрлэгийн хүүхдүүдийнхээс 2 стандарт хазайлтаар доор байна. Тиймээс сумд эмзэг бүлгийнхэнд хүрэх тал дээр чамгүй амжилттай ажиллаж байна.

Гэхдээ энэ дунд цалинтай ажил хийдэг эсвэл хувиараа хөдөлмөр эрхэлдэг өрхүүдийн хүүхэд 16 хувийг эзэлж байна. Үүнээс гадна аймгийн төвд ажиллаж байгаа гэр цэцэрлэгүүдийн хүүхдүүдийн зөвхөн 8 хувь нь малчин өрхийнх байсан ба дийлэнх хувь нь ажил эрхэлдэггүй эсвэл ажил мэргэжилгүй өрхүүдийн хүүхдүүд байсан юм (50 хувь). Хэрэв энэхүү дийлэнх хувь нь хөдөлмөр эрхэлдэггүй, ердийн цэцэрлэгт хамрагдах боломжгүй эмзэг бүлгийн иргэдийг төлөөлж байгаа хувь бол хүлээн зөвшөөрч болох үзүүлэлт юм. Гэхдээ үлдсэн 42 хувь нь өрхийн тэргүүн нь цалинтай ажил эрхэлдэг, эсвэл хувиараа хөдөлмөр эрхэлдэг өрхийн хүүхдүүд гэж бодоход гэр цэцэрлэгийн зорилгод хүрч байгаа эсэхийг хүлээн зөвшөөрөхөд хэцүү байна. Аймгийн төвийн гэр цэцэрлэгийн хүүхдүүдийн өрхүүд аж байдлын түвшингээр дунжаар -0.5 оноо авсан байгаа нь бусад цэцэрлэгүүдийнхээс нэлээд доогуур боловч сумдынхаас хавьгүй дээгүүр байна (-1.26). Аймгийн төвийн гэр цэцэрлэгүүдийн хувьд ээж, аавуудын боловсролын түвшинг харахад зорилтот бүлэгт чиглэсэн байдал бас алдагдсан мэт ажээ. Ээжүүдийн 46 хувь, аавуудын 10 хувь нь дээд сургууль төгсжээ. Энэ бол маш өндөр үзүүлэлт бөгөөд аймгийн төвийн гэр цэцэрлэгүүд нэн эмзэг бүлэгт хүрэхгүй байгааг тодруулж байна.

Хавсралт 7 нь ДБ-ны чанарын үнэлгээний судалгааны гэр цэцэрлэгийн дэд түүврийг 2010 оны ОУБТС СӨБ-д хамрагдаагүй 5 настнуудын дэд түүвэртэй харьцуулсан юм. ОУБТС нь бүх улсыг төлөөлөхүйц судалгаа учир, гэр цэцэрлэгүүдэд хамрагдсан хүүхдүүдийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлын шинж чанаруудыг улсын хэмжээнд байгаа цэцэрлэгт хамрагдаагүй 5 настай хүүхдүүдийнхтэй харьцуулах боломжийг өгч байгаа юм. Тэгэхээр ДБ-ны судалгааны гэр цэцэрлэгийн түүвэрт Монгол улсын хамгийн эмзэг бүлгийн хүн амын хүүхдүүд орсон байгаа ч гэлээ, боломжийн амьдралтай өрхүүдийн хүүхдүүд бас орсон байна.

Энэ асуудлын учир шалтгаан нь өмнө нь ярьж байсан СӨБ-ын үйлчилгээний өндөр эрэлт хэрэгцээтэй холбоотой байх талтай. Тус тайлангийн хүрээнд цэцэрлэгийн захиргаатай хийсэн ярилцлагын үеэр олон эрхлэгч төрийн өмчийн ердийн цэцэрлэгт орж чадаагүй, хүлээлгийн жагсаалтанд орсон хүүхдүүдийг авах зай, боломж байхгүй учраас гэр цэцэрлэгт хамрагдахыг зөвшөөрсөн гэж хэлж байсан юм. Энэ нь гэр цэцэрлэгүүдэд малчин бус өрхийн хүүхдүүдийн эзлэх хувь нэлээд өндөр байгаагийн нэг шалтгаан байж болох юм. Бас нэг шалтгаан нь сумдтай харьцуулахад аймгийн төвүүдэд цөөн тооны малчид амьдардагтай холбоотой юм.

3.1.3 Хүүхдийн хөгжилд гэр бүл ба эцэг эхчүүдийн оролцоо

Цэцэрлэгээс бусад орчны талаар цуглуулсан мэдээлэл нь хүүхдийн гэр бүлийн орчин тэдний хөгжилд нөлөөлдөг болохыг харуулж байна. Хүүхдүүд БНХБ-ын хөтөлбөрт хамрагдсан эсэхээс үл шалтгаалан амьдралынхаа дийлэнх хугацааг гэртээ ээжтэйгээ, эсвэл хамгийн дотны асран хамгаалагчтайгаа өнгөрөөдөг. Тиймээс түүвэрт хамрагдсан хүүхдүүдийг тэдний хөгжлийг дэмжих гэр бүлийн орчинд өсөж байгаа эсэхийг үнэлэх нь чухал байсан юм. ДБ-ны судалгаа нь хүүхдүүд гэртээ байхдаа ямар тоглоомоор тоглодог, хүүхдийг гэрт нь үлдээхдээ зохих хяналттай үлдээж байна уу, мөн гэр бүлийн гишүүд судалгааны хүрээнд сонгосон үйл ажиллагаануудыг гэртээ хүүхдүүдтэйгээ хамт хийж байгаа эсэхийг үнэлсэн. Хамгийн сонирхолтой хэсэг бол эцэг эх нь хүүхдүүдтэйгээ

хамт ном уншдаг эсэх, үлгэр ярьж өгдөг эсэх байсан юм. Энэ зүйлийг хийдэг эцэг эхчүүдийн хүүхдүүд үгийн баялгаар илүү, ойлгох чадвар сайн бөгөөд ном унших сонирхолтой, мөн ирээдүйд ч бас сайн уншигчид болдог байна (Duursma et al., 2008).

Хүүхдүүдийн гэртээ хамгийн их тоглодог тоглоом цэцэрлэгийн төрлөөс хамаараад янз бүр байсан ба ихэнх хүүхдүүдэд дор хаяж нэг төрлийн тоглох дуртай тоглоом байв. Хувийн цэцэрлэгүүдийн хүүхдүүдийн боломж бусдаас хол давсан байлаа.

Тоглоом: Судалгаанд хамрагдсан төрийн өмчийн ердийн цэцэрлэгүүдэд бараг бүх хүүхдүүд буюу 98 хувь нь, хамгийн бага орлоготой өрхийн хүүхдүүдийн 92 хувь нь гэртээ үйлдвэрийн, дэлгүүрээс худалдаж авсан тоглоомоор тоглож байна. Судалгаанд хамрагдаж буй хүүхдүүдийн тоглоомд энгийн аргаар гэрийн нөхцөлд хийсэн тоглоом нэлээд бага (28 хувь) болон гэрийнхээ сонирхол татсан эд зүйлс, гадаах тоглоомоор тоглож байгаагаас (65 хувь) үзэхэд аж байдлын түвшний зөрүү бас их байлаа (20-23 пункт).

Хувийн цэцэрлэгүүдэд бараг бүх хүүхдүүд үйлдвэрийн тоглоомоор тоглож байсан бөгөөд аж байдлын түвшний ялгаа их (16 пункт) байв. Гэвч энэ ялгаанаас бусад талаар хувийн цэцэрлэгийн хүүхдийн түүвэр төрийн өмчийн ердийн цэцэрлэгийнхтэй ерөнхийдөө адил байв. Гэртээ өөрсдөө хийсэн тоглоом нэлээд бага (35 хувь) эсвэл гэр ахуйн эд зүйлсээр тоглож байгаагаас (69 хувь) аж байдлын түвшний хувьд их ялгаатай (19-23 пункт) байлаа.

Гэр цэцэрлэгийн хүүхдүүдийн 92 хувь нь гэртээ үйлдвэрийн тоглоомоор тоглодог, 20 хувь нь өөрсдөө хийсэн тоглоомоор, 60 хувь нь гэр ахуйн эд зүйлсээр тоглож байгаа нь төрийн өмчийн ердийн цэцэрлэгийнхтэй ойролцоо байв.

Хүүхдүүдийг гэрт нь ганцааранг нь үлдээх, эсвэл зохих хараа хяналтгүй үлдээх нь ховор байв.

Хүүхдийг гэрт нь ганцааранг нь үлдээх нь маш ховор гэсэн мэдээлэл байна. Бүхий л цэцэрлэгүүдэд өнгөрсөн долоо хоногт хүүхдийг гэрт нь нэг буюу түүнээс дээш цагаар ганцааранг нь үлдээх тохиолдол дунджаар 0.09 өдрөөс илүүгүй байв. Хүүхдийг ах эгч нартай нь (10 ба түүнээс доош насны) үлдээх нь маш ажээ. Энэ тохиолдол бүх цэцэрлэгүүдэд хүүхдийг ах эгчтэй үлдээсэн өдөр дунджаар 0.16 өдрөөс илүүгүй байлаа.

Төрийн өмчийн ердийн цэцэрлэгийн хүүхдүүдийн ээж нарын хүүхэдтэйгээ хамт гэртээ аливаа үйл ажиллагаа хийх нь аав нартай харьцуулахад харьцангуй өндөр үзүүлэлттэй байсан бөгөөд, оролцооны түвшин нь аж байдлын түвшнээс шалтгаалан их ялгаатай байсан.

Судалгааны сонгосон үйл ажиллагааны төрлөөс хамааран ээжүүдийн 30 хувиас (хүүхдүүдтэйгээ тоглосон) 42 хүртэлх хувь (гадаа тоглуулсан) нь сүүлийн гурван хоногт судалгаанд дурьдсан үйл ажиллагааны аль нэгийг хүүхэдтэйгээ хамт хийжээ. Илүү чинээлэг айлын хүүхдүүд жагсаасан үйл ажиллагаануудад илүүтэй оролцсон байв (зураг 3.6)³². Аавуудын хүүхдүүдтэйгээ цагийг хамтдаа өнгөрүүлэх магадлал харьцангуй бага (10-22 хувь) байлаа. Харин аавуудын хүүхдүүдтэйгээ хамт хамгийн ихээр хийдэг зүйл бол тэднийг гадаа тоглуулах байсан бөгөөд энэ нь ээжүүдийн үзүүлэлттэй ажил байсан. Энэ

³²Хүүхдүүдийн гэртээ хийдэг зүйлс улирлаас хамаараад ялгаатай байна. Төрийн өмчийн болон хувийн ердийн цэцэрлэгээс 2015 оны 10 сард судалгаа авахад хүйтэрч амжаагүй байсан учир гадаа тоглох боломжтой байв.

хэсэгт өмнөхийн мөн адил өрхийн орлогоос (хамгийн чинээлэг ба ядуу) шалтгаалсан зөрүү их (10 - 21 пунктийн зөрүүтэй, хамтдаа гадуур явах, тоглуулах үйл ажиллагааны хувьд хамгийн их зөрүүтэй) байв. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн ах эгч нар тэдэнтэй хамтран үйл ажиллагаа, юм хийх нь маш бага (9-14 хувь) байсан нь түүвэрт сонгосон өрхүүдийн харьцангуй цөөн хувь нь нэгээс олон хүүхэдтэй байсантай холбоотой байж болох юм³³. Сүүлийн гурван өдөр бусад хүмүүстэй (авга, нагац ах/эгч, өвөө, эмээ гэх мэт) хамтдаа үйл ажиллагаа, юм хийсэн нь бас л харьцангуй бага (нийт хүүхдийн 6-11 хувь) байв.

Хувийн цэцэрлэгүүдийн хувьд төрийн өмчийн ердийн цэцэрлэгүүдийнхтэй харьцуулахад ээж, аав хоёулаа хүүхэдтэйгээ цагийг хамтдаа өнгөрөөх нь илүү байсан боловч аж байдлын түвшнээс шалтгаалсан зөрүү нь ихээхэн байгаа юм.

Сүүлийн гурван өдөр үйл ажиллагааны төрлөөс хамаараад 36 хувиас (гадаа цаг өнгөрөөсөн) 48 хувь хүртэлх хүүхдүүдийн (хүүхдүүдтэйгээ хамт дуу дуулсан) ээж нар судалгаанд заасан үйл ажиллагааны аль нэгийг хүүхэдтэйгээ хамт хийжээ. Ялангуяа ээжүүдийн оролцоо төрийн өмчийн ердийн цэцэрлэгийн түүврийнхээс бага зэрэг өндөр (6 пунктээр) байсан. Хамгийн чинээлэг болон нэн ядуу өрхүүдийн хоорондын зөрүү их байсан ба аж байдлын түвшний зөрүү хүүхдэдээ үлгэр уншиж өгөх үйл ажиллагаан дээр хамгийн их (34 пунктээр), үүний дараа ном унших ба дуулах (25-26 пунктээр) орсон байна.

Харин аавууд нь төрийн өмчийн ердийн цэцэрлэгүүдийнхтэй харьцуулахад хүүхэдтэйгээ цагийг хамтдаа өнгөрөөх нь илүү байж, ном унших ба үзэхэд 17 хувь, гадаа тоглох, гадуур цагийг өнгөрөөхөд 32-33 хувь хүртэл байв. Хамгийн баян болон нэн ядуу өрхийн хоорондын ялгаа нь төрийн өмчийн ердийн цэцэрлэгийн бүлгийнхээс ихээхэн зөрүүтэй (14-40 пунктээр, хамгийн их зөрүү нь гадаа тоглох дээр) байсан. Түүвэрт хамрагдсан хүүхдүүдийн ах, эгч, дүү нар дээрх үйл ажиллагаануудыг тэдэнтэй хамт хийх нь бага (10-18 хувь) байсан нь түүвэрт сонгосон өрхүүдийн маш цөөн хувь нь нэгээс дээш тооны хүүхэдтэй байсантай холбоотой юм. Гэхдээ ах, эгч нарын оролцоо төрийн өмчийн ердийн цэцэрлэгийн түүврийнхээс илүү байсан. Сүүлийн гурван өдөр бусад хүмүүстэй өнгөрөөсөн цаг (хамаатан, ах дүү, өвөө, эмээ г.м.) мөн л арай илүү (хүүхдүүдийн 8-13 хувь) байж аж байдлын түвшний ялгаа аль алинд нь байсан (тухайлбал, ядуу

Зураг 3.6 Монгол улсын төрийн өмчийн цэцэрлэгт хамрагдаж байгаа 5 настай хүүхдүүдийн ээжүүдийн сүүлийн гурван өдөр хүүхдүүдтэйгээ цагийг хамтдаа өнгөрөөсөн байдал, аж байдлын түвшин тус бүрээр, 2015 он



Эх сурвалж: Зохиогчийн Дэлхийн банкны СӨБ-ын чанарын судалгааны (2015) мэдээлэлд үндэслэв.

³³Харин нэг сонирхолтой зүйл бол аж байдлын хамгийн доод түвшний квинтил буюу нэн ядуу өрхийн хүүхдүүд судалгаанд нэрлэсэн бүх үйл ажиллагааг ах, эгч, дүү нартайгаа хамтран хийх харьцангуй илүү байлаа. Энэхүү судалгааны түүвэрт ядуу өрхүүд баян өрхүүдээс илүү олон тооны бага насны хүүхэдтэй байсан.

өрхүүдийн хүүхдүүд “бусад” хүмүүстэй хамт ном унших, дуу дуулах нь илүү байсан бол үлгэр ярих, тоглоход эсрэгээр байв).

Гэр цэцэрлэгт хамрагдаж байгаа хүүхдүүдийн гэр бүлийн оролцоо төрийн өмчийн ердийн цэцэрлэгүүдийнхтэй харьцуулахад маш доогуур үзүүлэлттэй байна.

Тухайн үйл ажиллагааны төрлөөс хамаараад хүүхдүүдийн 13 хувиас (хүүхэдтэйгээ тоглосон) 28 хүртэлх хувийн (дуу дуулсан) ээжүүд сүүлийн гурван өдөр судалгаанд нэрлэсэн үйл ажиллагааны аль нэгийг хүүхэдтэйгээ хамт хийжээ. Энэ нь төрийн өмчийн ердийн цэцэрлэгийн түүврийнхээс хамаагүй доогуур үзүүлэлт юм. Аж байдлын түвшин дээшлэх тусам өмнө дурдсан үйл ажиллагаанд хүүхдүүдийн оролцоо (19-41 пунктын ялгаа, хамгийн их ялгаа нь үлгэр ярьж өгөхөд, хамгийн бага ялгаа нь ном үзэхэд) нэмэгдэж байна. Аавууд хүүхдүүдтэйгээ цагийг өнгөрөөх нь хамаагүй бага (3-19 хувь), харин хүүхэдтэйгээ хамт гадуур цагийг өнгөрөөх нь илүүтэй байв. Харин хүүхдүүдийн ах, эгч, дүү нар эдгээр үйл ажиллагаанд ээж, аав нараасаа илүү (16-33 хувь) оролцож байсан нь төрийн өмчийн ердийн болон хувийн цэцэрлэгүүдийнхээс нэлээд өндөр хувьтай байна. Гэр цэцэрлэгт хүүхэд нь явж буй ядуу өрхүүд бусадтай харьцуулахад бага насны хүүхдийн тоогоор илүү байв. Сүүлийн гурван өдөр бусад хүмүүстэй (хамаатан, өвөө, эмээ гэх мэт) цагийг өнгөрөөсөн хүүхдийн эзлэх хувь хамгийн бага (4-8 хувь) байсан.

3.1.4 Цэцэрлэгт хамрагдсан 5 настай хүүхдүүдийн БНХБ-ын үр дүн

Энэ хэсэгт хүүхэд хөгжлийн тал, ай тус бүрээр гүйцэтгэлийг өрхийн, хүүхдийн болон цэцэрлэгийн түвшний хүчин зүйлстэй холбон авч үзэх юм. БНХБ-ын үр дүн өрхийн аж байдал, тухайн хүүхдийн онцлогоос хамаардаг болохыг бид дэлхий дахины туршлагаас сайн мэднэ. Ялангуяа өрхийн амьжиргаа, эцэг эхийн боловсрол нь бага насны боловсролын үр дүнд ихээр нөлөөлдгөөс гадна хүүхэдтэйгээ ажилладаг, цагийг хамтдаа үр өгөөжтэй өнгөрөөдөг, гэр бүлийн хүмүүжлийн арга барил зэрэг нь чухал байдаг. Тиймээс хүүхдүүдийн цэцэрлэгтээ үзэж, сурч байгаа зүйлс, цэцэрлэгийн үйлчилгээний чанар нь ижил түвшинд байсан ч, хоорондоо ялгаатай амьжиргааны түвшний хүүхдүүдийн хөгжил өөр өөр хурдацаар ахидаг ба энэ нь цэцэрлэгийн дотоод орчны чанараас ч үл хамаардаг юм (гэхдээ энд анхаарах зүйл бол ихэнхээ цэцэрлэгүүдийн дотоод орчин нь ямагт ялгаатай байдаг гэдгийг мартаж болохгүй). Үүнийг бодлогын түвшинд авч үзвэл, харагдаж буй хөгжлийн ялгаа, үр дүнгийн хэдэн хувь нь өрхийн аж байдлын түвшнээс, хэдэн хувь нь цэцэрлэгийн чанараас хамаардаг болохыг тодруулах нэн чухал юм.

Танин мэдэхүйн болон хэл ярианы хөгжлийн хувьд гэр цэцэрлэгийн хүүхдүүд төрийн өмчийн ердийн цэцэрлэгээс нэлээд хоцорч, хувийн цэцэрлэгийн хүүхдүүд хамгийн өндөр оноог авсан байна. Хавсралт 8-д төрийн өмчийн ердийн, гэр цэцэрлэг ба хувийн цэцэрлэгийн танин мэдэхүйн чадварын онооны тархалтыг нэгж стандарт хазайлтаар харуулсан байна (баримт 3.2). Гэр цэцэрлэгийн онооны тархалт төрийн өмчийн ердийн цэцэрлэгүүдийн онооны тархалтын доод хэсэгт явж байгаа бол хувийн цэцэрлэгийн хувьд нөхцөл яг эсрэгээрээ, дээд талд нь байна. Гэр цэцэрлэгийн дундаж оноо төрийн өмчийн ердийн цэцэрлэгийнхээс 0.30 нэгж стандарт хазайлтаар бага байсан бол (зураг 3.7), хувийн цэцэрлэгүүдийнх 0.30 нэгж стандарт хазайлтаар илүү байна. Энэ хоёр ялгаа нь 1 хувийн түвшинд маш хол зөрүүтэй байна (баримт 3.2). Мөн үүний адил гэр цэцэрлэгийн хүүхдүүдийн хэл ярианы дундаж оноо төрийн өмчийн ердийн

цэцэрлэгүүдийнхээс 0.43 нэгж стандарт хазайлтаар бага байгаа бол хувийн цэцэрлэгүүдэд 0.19 нэгж стандарт хазайлтаар илүү байна.


Баримт 3.2 MELQO үнэлгээний үр дүнг шинжлэн дүгнэх нь: Онооны дундаж ба статистик ач холбогдол

Үнэлгээний оноог дундажлах нь хүүхдийн MELQO үнэлгээний үр дүнг шинжлэн дүгнэхийн эхний алхам бол хүүхэд хөгжлийн ай тус бүрээр үнэлгээний дундажласан оноог судалгаанд оролцсон хүүхэд бүрээр гаргах юм. MELQO аргачлал дараах хөгжлийн айг нэрлэж ашигласан, үүнд танин мэдэхүй, хэл яриа, нийгэм-сэтгэлийн хөдөлгөөн, гүйцэтгэх чадвар ба жижиг булчингийн ажиллагаа зэрэг болно. Талбар бүрийн хувьд дундажласан оноог³⁴ төрийн өмчийн ердийн болон хувийн цэцэрлэгүүд, гэр цэцэрлэг гэсэн гурван түүврийн хүүхдээс бүрдэх холимог секцээс бодож гаргасан. Ийнхүү бодож гаргасан нэгж стандарт хазайлт (СХ)-аар илэрхийлсэн оноонуудаар дамжуулан гурван түүврийн хөгжлийн ай тус бүрийн гүйцэтгэлийн ялгааг харьцуулж, мөн өрхийн, хүүхдийн болон цэцэрлэгийн түвшний хүчин зүйлс хөгжлийн үр дүнд хэрхэн нөлөөлж байгааг харах боломжтой болно. Оноог СХ-ын нэгжээр илэрхийлэх үед тэдгээр нь нэмэх (+) эсвэл хасах (-) үзүүлэлттэй гардаг. Дундажласан “0” оноо нь тухайн хүүхэд дундаж оноог авсныг харуулна. Харин дундажласан оноо нь их байх тусам тухайн хүүхэд дундаж утгаас илүү дээгүүр оноог авсан гэсэн үг юм. Дундажласан оноо хасах гарах нь тухайн хүүхдийг дундаж онооноос доош оноо авсныг илтгэнэ. Тиймээс дундажласан оноо “-0.5 нэгж СХ”-тай байвал энэ нь “-1 нэгж СХ”-тай дундажласан онооноос өндөр, дундажласан “0” оноо нь энэ хоёроос хоёулангаас илүү бөгөөд дундажласан “1.2 нэгж СХ”-тай оноо нь дээрх дөрвөн онооноос хамгийн өндөр оноо болно.

Статистик ач холбогдлыг ойлгох нь Бүлэг тус бүрийн хүүхдүүдийн дундаж онооны ялгааг харахад, тус секц нь эдгээр ялгаа нь 1, 5, эсвэл 10 хувийн түвшинд үнэхээр “статистик ач холбогдолтой” байгаа эсэхийг харуулдаг. Мөн үр дүн буюу оноонд гэр бүлийн ба цэцэрлэгийн түвшний хүчин зүйлс нөлөөлдөг эсэхийг харахад тусалдаг регрессийн дүн шинжилгээний хувьд тус секц нь аль нэг хүчин зүйлийн коэффициент “статистик ач холбогдолтой” эсэхийг бас харуулдаг. Энэ нь ямар учиртай вэ? гэхээр уг тайланд орсон бүх тооцоолол нь судалгааны асуулгад үндэслэсэн учир алдаа байх магадлалтай гэсэн үг юм. Энэхүү тайланд өгүүлж байгаа статистик ач холбогдлын тест нь үргэлж тухайн тооцоо (дундаж утга, эсвэл регрессийн коэффициентын ялгаа) статистикийн хувьд тэгээс зөрүүтэй байна уу гэдгийг шалгаж байгаа тест юм (тэгээс их эсвэл бага). Статистик ач холбогдлын тест нь тооцоолол тэгээс хэр “ялгаатай” байгааг нарийн зөв тооцоолж чадсан эсэхийг харуулж, уншигчдад алдаа хэр их, эсвэл хэр бага байгаа талаар мэдээллийг өгдөг. Ач холбогдлын түвшин бага байх тусам, тооцоо нарийн гарсан байх ба тухайн тооцоо тэгээс ялгаатай ба “статистик ач холбогдолтой” гэдэгт итгэлтэй байж болно. Өөрөөр хэлбэл 1 хувийн түвшинд ач холбогдолтой регрессийн коэффициент судалгаанд хамрагдсан хүн амын дунд үнэхээр тэгээс өөр байх магадлал 5 ба 10 хувийн ач холбогдлын түвшингүүдийнхээс илүү өндөр байх юм.

³⁴Дундажласан оноонууд нь Z оноонууд ба эдгээрийг хүүхэд бүрийн онооноос ай тус бүрээр авсан онооны дунджийг хасаад, тухайн айн оноонуудын СХ-аар хувааснаар гаргасан юм. Ийнхүү тооцож гаргасан оноонууд нь СХ-ын нэгжээр илэрхийлсэн.

Зураг 3.7 5 настай хүүхдүүдийн MELQO үнэлгээний дундаж оноонууд, цэцэрлэгийн төрлөөр, Монгол улс, 2015 он




Эх сурвалж: Дэлхийн банкны СӨБ-ын чанарын судалгааны (2015) мэдээлэлд үндэслэв.

Жич: Гэр цэцэрлэгт хамрагдсан хүүхдүүдийг цэцэрлэг нь ажиллаж эхлээд 2-3 долоо хоног өнгөрч байхад үнэлсэн нь дундажаар гэр цэцэрлэгийн ажилладаг хугацааны талаас илүү хугацаа юм.


Төрийн өмчийн ердийн болон хувийн цэцэрлэгүүд, гэр цэцэрлэгүүдийн бусад хөгжлийн ай тус бүрээр авсан оноо өмнөхтэй адил дүр зургийг харуулж байна. Төрийн өмчийн ердийн, гэр ба хувийн цэцэрлэгүүдийн бусад хөгжлийн ай тус бүрээр авсан онооны гүйцэтгэл өмнөх гүйцэтгэлтэй ижил байна (хавсралт 8). Нийгэм-сэтгэлийн хөдөлгөөний айн онооны хувьд гэр цэцэрлэгийн хүүхдүүд төрийн өмчийн ердийн цэцэрлэгийнхээс нэлээд хол хоцорсон бол (дунджаар 0.84 СХ-ын нэгжээр – зураг 3.7), хувийн цэцэрлэгүүдийнх дунджаар 0.19 СХ-аар доогуур байв. Хувийн цэцэрлэгүүдийн төрийн өмчийн ердийн цэцэрлэгүүдээс хоцорсон цорын ганц ай бол нийгэм-сэтгэлийн хөдөлгөөн байсан. Гүйцэтгэх чадварын хувьд гэр цэцэрлэгт хамрагдаж байгаа хүүхдүүд төрийн өмчийн ердийн цэцэрлэгүүдийнхээс ихээхэн хоцорч, бараг гуравны нэгээс илүү СХ-аар зөрүүтэй байсан бол хувийн цэцэрлэгүүд дөрөвний нэг СХ-аар түрүүлж байлаа. Жижиг булчингийн хөгжлийн айн хувьд гэр цэцэрлэгт хамрагдсан хүүхдүүд төрийн өмчийн ердийн цэцэрлэгүүдийнхээс мөн нэлээд ихээр, бараг хагас стандарт хазайлтаар хоцорсон боловч хувийн болон төрийн өмчийн ердийн цэцэрлэгүүдийн хооронд ялгаа бараг байсангүй.

Хөдөө орон нутгийн төрийн өмчийн ердийн цэцэрлэгийн хүүхдүүд танин мэдэхүй, хэл яриа, гүйцэтгэх чадварын айн үзүүлэлтээр хот суурин газруудынхаас харьцангуй хоцорч байв. Төрийн өмчийн ердийн цэцэрлэгүүдийн дунд танин мэдэхүй, хэл яриа ба гүйцэтгэх чадварын айнуудын хөгжлийн үр дүн Улаанбаатар хотод хамгийн өндөр байж, үүний дараа нь аймгийн төвүүд орсон бол сумдын цэцэрлэгийн хүүхдүүд нэлээд ард байна (зураг 3.8). Сум ба Улаанбаатар хотын дундаж онооны ялгаа тухайн хөгжлийн айнаас хамааран 0.22-0.28 хүртэлх нэгж СХ-ын хооронд хэлбэлзэж байсан. Нийгэм-сэтгэлийн хөдөлгөөний айн хувьд аймгийн төвийн цэцэрлэгийн хүүхдүүд өмнө дурьдсан гурван байршлын хүүхдүүдийн дундажаас хамгийн өндөр оноо авсан бол, Улаанбаатар болон сумын цэцэрлэгийн хүүхдүүдийн хооронд ялгаа бараг байсангүй. Жижиг булчингийн хөгжлийн хувьд бас адилхан үр дүн гарч байна.

Зураг 3.8 Төрийн өмчийн ердийн цэцэрлэгт хамрагдсан 5 настай хүүхдийн MELQO үнэлгээний дундаж оноо, байршлаар, Монгол улс, 2015 он



Зураг 3.9 Хувийн цэцэрлэгт хамрагдсан 5 настай хүүхдийн MELQO үнэлгээний дундаж оноо, байршлаар, Монгол улс, 2015 он




Эх сурвалж: Дэлхийн банкны СӨБ-ын чанарын судалгааны (2015) мэдээлэлд үндэслэв.

Улаанбаатар хотын гэр хорооллын хувийн цэцэрлэгүүдэд хамрагдсан хүүхдүүд гэр хорооллоос бусад газруудынхаас хоцорч байна. Хувийн цэцэрлэгүүдийн хувьд Улаанбаатар хотын гэр хорооллын хүүхдүүд гэр хорооллоос бусад газруудынхаас хөгжлийн таван ай тус бүрээр нэлээд ихээр хоцорч байна (зураг 3.9). Гэр хорооллын цэцэрлэгийн хүүхдүүдийн хоцрогдол нь ялангуяа танин мэдэхүй ба гүйцэтгэх чадварын айд илүүтэй (0.6нэгж СХ) харагдаж байгаа бол үүний дараа хэл яриа (0.4СХ), жижиг булчингийн айн үзүүлэлтүүд жагсаж байна. Харин гэр хорооллын цэцэрлэгийн хүүхдүүд дундаж оноогоор сумын цэцэрлэгүүдийнхээс доогуур байсан нь тун анхаарууштай зүйл юм (зураг 3.8).

Төрийн өмчийн ердийн цэцэрлэгийн хүүхдүүдийн хөгжлийн үр дүнд нөлөөлөх голлох хүчин зүйл нь нийгэм-эдийн засгийн байдлын үзүүлэлтүүд байв. Судалгаагаар үнэлэгдсэн өрхийн түвшний хүчин зүйлс дотроос (зураг 3.10) ээжийн боловсролын түвшингийн коэффициентууд их өндөр байж, бусад хүчин зүйлсийн хувьд ерөнхийдөө ижил түвшинд, ялангуяа хэл яриа ба жижиг булчингийн айн хувьд бага болон түүнээс доош боловсролтой ээжүүдийн хүүхдүүд болон их дээд сургууль төгссөн, түүнээс дээш боловсрол эзэмшсэн ээжүүдийн хүүхдүүдийн онооны ялгаа нь 0.49 - 0.63 хүртэлх СХ-ын хооронд хэлбэлзэж байсан. Аавуудын боловсролын үр нөлөө мөн их байсан боловч коэффициентууд нь ээжүүдийн боловсролын түвшнээс ерөнхийдөө бага байв.³⁵ Бусад зүйлсийг ижил түвшинд гэж үзэхэд, өрхийн амьжиргаа сайн байх тусам хүүхдийн хөгжлийн үр дүн сайн байгаа нь ялангуяа математик ба гүйцэтгэх чадварын айнуудад тодорхой ажиглагдаж, хамгийн ядуу ба чинээлэг өрхийн хоорондын ялгаа 0.31 СХ-д хүрсэн юм. Эцэст нь хэлэхэд өрхийн нийгэм-эдийн засгийн хувьсагчдын хамсарсан нөлөө нь судалгаагаар үнэлэгдсэн хүүхдүүдийн хөгжлийн ай бүрт чухал нөлөөтэй байсан ба цэцэрлэгийн түвшний хувьсагчдаас ч илүү өндөр нөлөөтэй байлаа (хавсралт 10).

³⁵Эцэг эхийн боловсролын түвшин тэр бүр статистикийн ач холбогдолтой биш байсан боловч коэффициентуудын хэмжээ нь бусад статистикийн ач холбогдолтой предикторуудынхтай харьцуулж болохоор байлаа. Ээжүүд, аавуудын боловсролын индикаторын хувьсагчийн коэффициент нь бүгд нийлээд хөгжлийн ай тус бүрийн хувьд ач холбогдолтой байсныг анхаарах нь зүйтэй (хавсралт10).

Зураг 3.10 Төрийн өмчийн цэцэрлэгт хамрагдсан 5 настай хүүхдүүдийн өрхийн шинж чанар, СӨБ-ын хамрагдалт нь MELQO үнэлгээний дундаж оноонд нөлөөлж буй харилцан хамаарал, 2015 оны байдлаар



Эх сурвалж: Дэлхийн банкны СӨБ-ын чанарын судалгааны (2015) мэдээлэлд үндэслэв.

Жич: Регрессийн үр дүнгийн бүтэн хүснэгт, хүүхдийн хөгжлийн ай тус бүрийн үр дүнгийн талаар хавсралт 9-с харна уу. Энэхүү тайланд орсон регрессийн үр дүн нь өрхийн, хувь хүний, цэцэрлэгийн түвшний бүх шинж чанарыг хянаж, эдгээрийн тухай хавсралтад бичсэн байгаа. Ач холбогдлын түвшин: *** = 1 хувь, ** = 5 хувь, * = 10 хувь. Баганын өндөр нь дараах зүйлстэй холбоотой дундажлагдсан тестийн онооны өөрчлөлтийг харуулна: (i) гэр дэх оролцооны индексийн 1-СХ өсөлт (хайрцаг 3.3); (ii) бакалавр ба түүнээс дээш зэрэгтэй ээжүүдийн хүүхдүүдийг бага болон түүнээс доош боловсролтой ээжүүдтэй харьцуулсан нь; (iii) бакалавр эсвэл түүнээс дээш боловсролтой аавуудын хүүхдүүдийг бага болон түүнээс доош боловсролтой аавуудын хүүхдүүдтэй харьцуулсан; (iv) хамгийн баян квинтилын хүүхдүүдийг хамгийн ядуу квинтилынхтай харьцуулсан нь; (v) нийт ЕСЕМІ чанарын оноонд 1 онооны өсөлт; (vi) цэцэрлэгт хамрагдсан нэмэлт нэг жил.

Гэртээ хийх үйл ажиллагаануудад гэр бүлийн гишүүдийн оролцоо өндөр байх нь тоо ба хэл ярианы айн хөгжлийн үр дүнд маш ихээр нөлөөлж, нийгэм-сэтгэлийн хөдөлгөөний айн хөгжлийн үр дүнд бага зэрэг нөлөөлж байв. Гэр бүлд оролцооны индекс 1-СХ-аар нэмэгдэх нь (баримт 3.3) танин мэдэхүй ба хэл ярианы айд ойролцоогоор 0.07 СХ-ын дундажилсан онооны өсөлтийг бий болгож байв. Гэр бүлийн орчинд өрнөж буй БНХБ-ын үйл ажиллагаанууд албан ёсны СӨБ-д хамрагдах боломжоор хязгаарлагдмал эсвэл ийм боломжгүй хүүхдүүдийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг сайжруулахад чухал ач холбогдолтой болох нь харагдаж байна. Энэ нь ялангуяа БНХБ-ын үйл ажиллагаанд эцэг эхийн оролцоо чинээлэг өрхүүдийнхтэй харьцуулахад тун бага байдаг нэн ядуу өрхүүдийн хувьд анхаарууштай зүйл болж байгаа юм (3.3 дахь хэсэг).

Баримт 3.3 Гэр бүлийн оролцооны индексийг хэрхэн боловсруулсан тухай

Гэр бүлийн орчин, ялангуяа аав, ээжийн гэртээ байх үеийн оролцооны үр нөлөөг хэмжихийн тулд ДБ-ны СӨБ-ын чанарын үнэлгээний судалгааны хүрээнд цуглуулсан мэдээллийг ашиглан зураг 3.10-т тусгасан “гэр бүлийн оролцооны индекс”-ийг боловсруулсан. 3.3 дахь хэсэгт өгүүлснээр судалгаанд хамрагдсан хүүхэд бүрээс сүүлийн гурван өдрийн турш сонгосон үйл ажиллагааны аль нэгэнд хүүхдийн ээж, аав, ах, эгч эсвэл өөр хэн нэгэн оролцсон талаарх мэдээллийг цуглуулсан. Эдгээр ажиллагаануудад ном унших ба үзэх, үлгэр ярих, дуу дуулах, хамтдаа гадуур цагийг өнгөрөөх, тоглох, эд юмсыг нэрлэх, тоолох ба зурах үйлдлүүд орсон. Хүүхэд бүрийн хувьд эхлээд оролцооны түвшний оноог гаргахдаа судалгаа авахаас өмнөх гурван хоногт гэр бүлийн аль нэг гишүүн хүүхэдтэй хамтран тухайн үйл ажиллагааг хийсэн бүх тохиолдлыг хооронд нь нэмж гаргасан юм.


Жишээ нь, нэг хүүхдийн ээж 5 үйл ажиллагаанд, аав нэг үйл ажиллагаанд оролцсон бол ах, эгч нь хоёр үйл ажиллагаанд оролцсон байж болно. Тэгэхээр энэ хүүхдийн оролцооны түвшингийн оноо 8 болно. Энэхүү тооцооны бүтэц нь “хүн-үйлдэл” гэсэн нэгжийг бий болгож байгаа юм. Гэхдээ энэ оноо нь бүтцийн хувьд тухайн үйлдэл хэр удаан үргэлжилсэн, гурван хоног дотор ямар давтамжтай байсныг хэмжих зорилгогүй гэдгийг анхаараарай (энэ талын мэдээллийг цуглуулах нь судалгааны зорилго байгаагүй). Гол анхаарч байсан зүйл бол зөвхөн тухайн үйлдлийг хийсэн эсэхэд оршиж байсан юм.

Үүний дараа оролцооны түвшний оноог хүүхдийн үнэлгээний оноог стандартчилахад ашигласантай адил аргаар дундажлан, стандарт хазайлтын нэгжээр илэрхийлсэн юм (3.2). Онооны тархалтын стандарт хазайлт (СХ) 2.6 хүн-үйлдэлтэй тэнцүү байв. Өөрөөр хэлбэл зураг 3.10-т тусгасан гэр бүлийн оролцооны үр нөлөө буюу танин мэдэхүйн дундажилсан онооны 0.07 СХ-ын өөрчлөлт нь оролцооны түвшний оноо 2.6 хүн-үйлдлийн өсөлттэй холбоотой байв. Энэ нь судалгаанаас өмнөх гурван хоногт гэр бүлийн аль нэг гишүүн хүүхэдтэй 2-3 үйлдлийг хийсэнтэй тэнцүү үзүүлэлт юм.

СӨБ-д хамрагдах хугацаа урт байх тусам математик, тоо тоолол, хэл яриа, нийгэм-сэтгэлийн хөдөлгөөний айн хөгжлийн үзүүлэлтүүд нэмэгдэж байв. Цэцэрлэгийн хамрагдалт нэг жилээр нэмэгдэхэд танин мэдэхүй, унших бичихэд бэлтгэх ба нийгэм-сэтгэлийн хөдөлгөөний айн оноо 0.05-0.07 СХ оноогоор нэмэгдэж байв (зураг 3.10). Өөрөөр хэлбэл бусад хүчин зүйлс өөрчлөлтгүй байхад судалгаанд хамрагдсан цэцэрлэгт дөнгөж явж эхлээд удаагүй байгаа 5 настай хүүхдүүдийн оноо хоёр жил цэцэрлэгт тасралтгүй явсан хүүхдүүдийнхээс 0.11-0.15 СХ оноогоор бага байсан. СӨБ-ын

хамрагдалтын хугацаа ба хүүхдийн хөгжлийн үр дүнгийн харилцан хамаарлын талаар хийсэн бусад судалгаанд СӨБ-ын хамрагдалт эерэг ба сөрөг үр дүнтэй байж болно гэсэн үр дүн гарсантай харьцуулахад эдгээр үр дүн нь үнэхээр сайшаалтай байгаа юм (Vandell, 2004; Brinkman et al, 2016).

Зураг 3.11 Монгол улсын төрийн өмчийн цэцэрлэгт хамрагдсан 5 настай хүүхдүүдийн гэр бүлийн шинж чанарууд ба MELQO үнэлгээний аргачлалын дундаж оноо хоорондын хамаарал, 2015 оны байдлаар



Эх сурвалж: Дэлхийн банкны СӨБ-ын чанарын судалгааны (2015) мэдээлэлд үндэслэв.

Жич: Регрессийн үр дүнгийн бүтэн хүснэгт, хүүхлийн хөгжлийн ай бүрийн үр дүнгийн талаар хавсралт 9-өөс харна уу. Энэ тайланд орсон регрессийн үр дүн нь өрхийн, хувь хүний, цэцэрлэгийн түвшний бүх шинж чанарыг хянаж, цэцэрлэгийн түвшний хяналтуудыг хооронд нь нэмсэн үр дүнг харуулж байна. Хяналтын жагсаалтыг хавсралтаас харна уу. Ач холбогдлын түвшин: *** = 1 хувь, ** = 5 хувь, * = 10 хувь. Баганын өндөр нь дараах зүйлстэй холбоотой дундажилсан тестийн онооны өөрчлөлтийг харуулна: (i) хүйс эмэгтэй байх; (ii) өрхийн тэргүүн Казах байх; (iii) багшийн хэлснээр ямар нэг хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй байх.

Хүүхдийн хөгжлийн үр дүн цэцэрлэгийн чанартай холбоотой байх магадлал хөгжлийн ай тус бүрийн хувьд янз бүр байсан бол нийгэм-сэтгэлийн хөдөлгөөний айн оноо хамгийн өндөр, дараа нь хэл ярианы айнх байв. Өрхийн, хувь хүний ба цэцэрлэгийн түвшний бүх хүчин зүйлсийг хянан үзсэний дараа ч бас анги танхимын

чанарын нөлөөний хэмжээ нэлээд өндөр хэвээр байгаа нь ажиглагдсан (зураг 3.10). Анги танхимын чанар 1-оноогоор нэмэгдэхэд тухайн хөгжлийн айнаас хамаараад 0.10СХ (гүйцэтгэх чадварын хөгжил)-аас 0.43 СХ (нийгэм-сэтгэлийн хөдөлгөөний хөгжил) хооронд өсөлт болж байв. Үр нөлөөний цар хүрээ ийм байгаа нь АНУ болон хөгжиж буй орнуудад хийгдсэн анги танхимын чанарын нөлөөг хяналтын олон нарийн хувьсагчийг ашиглан болон тогтмол нөлөөг ашиглан тооцоолсон бусад судалгааны үр дүнгээс ч илүү үзүүлэлттэй байгаа юм. Тухайлбал, АНУ-д хийсэн томоохон хэмжээний судалгаануудад хүүхдийн хэл яриа, танин мэдэхүйн хөгжилд үзүүлсэн үр нөлөөний хэмжээ 0.04 (Duncan, 2003) - 0.18 (Peisner-Feinberg et al., 2001) байна. Нийгэм-сэтгэлийн хөдөлгөөний хөгжлийн хувьд өмнө хийж байсан судалгаануудаас харахад нөлөө нь АНУ-д дөнгөж 0.02 байсан бол (Peisner-Feinberg et al., 2001) Их Британид бүр 0.13-д хүрч байсан байна (Sylva et al., 2006). Харин Зүүн Африкт хийсэн судалгаагаар хүүхдийн танин мэдэхүйн чадварт үзүүлэх нөлөөний хэмжээ 0.15 гэсэн үзүүлэлттэй гарчээ (Malmberg et al., 2011). Эквадор улсад CLASS аргачлалыг ашиглан хийсэн судалгаагаар анги танхимын чанар ба хүүхдийн суралцах үйл явцын харилцан хамаарал өмнөхийн адил үр дүнтэй гарсан ба нөлөөний хэмжээ нь 0.06 - 0.13 хэлбэлзэлтэй байсан байна. Индонезийн хөдөө орон нутагт анги танхимын чанар 1-СХ-аар нэмэгдэхэд нөлөө нь 0.071 - 0.082 СХ-аар нэмэгдэж байжээ (2016 оны тайлан).

Эрэгтэй, Казах эсвэл тусгай хэрэгцээтэй байх зэрэг хүчин зүйлс нь хөгжлийн айн хувьд бага оноо авахад нөлөөлж байв. Энэхүү судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн хөгжлийн бүхий л айд охид хөвгүүдээс илүү оноо авч байв (зураг 3.11). Хөгжлийн үр дүнгийн зөрүү нь хөгжлийн 5 айн тухайд, охид эерэг үр дүнтэй байсан ба бусад өрхийн, хувь хүний, цэцэрлэгийн түвшний хүчин зүйлсийг авч үзэхэд хэл яриа, гүйцэтгэх чадвар ба жижиг булчингийн айнуудад хамгийн их зөрүүтэй, статистик ач холбогдолтой байв (0.15-0.22 СХ нэгжээр илүү). Казах өрхүүдийн хүүхдүүдийн өрхийн, хувь хүний түвшний хүчин зүйлсийг хянаж үзэхэд хэл яриа (0.31 СХ-аар доогуур), нийгэм-сэтгэлийн хөдөлгөөний ай (0.46 СХ-аар доогуур) бусдаас доогуур оноотой байсан. Гэхдээ цэцэрлэгийн түвшний хувьсагчдыг хянахад, тухайлбал СӨБ-ын хамрагдалтын хугацаа ба үйлчилгээний чанарын хяналтуудыг нэмж үзэхэд Казах хүүхдүүдийн хоцрогдол ихээхэн хэмжээгээр буурч, статистик ач холбогдолгүй болсон нь тун сайшаалтай хэрэг байв. Хүүхдийн хөгжлийн бэрхшээл нь жижиг булчингийн хөгжлөөс бусад бүх айд ихээр нөлөөлж байв (зөрүү нь 0.2-0.44 нэгж СХ-тай байв).

3.2 Монгол улсад хэрэгжүүлсэн гэр бүлд суурилсан сургуульд бэлтгэх хөтөлбөрийн БНХБ-ын үр дүн

Японы хүүхдийг ивээх сан (ЯХИС) MELQO үнэлгээний аргачлалыг ашиглан гэр бүлийн орчинд хүүхдийг сургуульд бэлтгэх хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүдийг үнэлсэн юм. СӨБ олгох ердийн цэцэрлэгийн үйлчилгээ нь малчлын болон алслагдсан орон нутгийн хүүхдүүдэд хүрэх боломж хязгаарлагдмал байдаг нь СӨБ-ын хувилбарт сургалтуудын хэрэгцээг бий болгодог юм. Нүүдлийн гэр цэцэрлэгүүд нь энэ асуудлыг шийдвэрлэх нэг арга хэлбэр болдог хэдий ч ложистикийн болон санхүүгийн бэрхшээлтэй тулгардаг. Тайлангийн энэ бүлгийн өмнөх хэсэгт өгүүлсэн дүн шинжилгээ нь гэр бүлд хүүхдийн хөгжлийг дэмжих, хүүхэдтэйгээ ажиллахын ач холбогдлыг тодорхой харуулсан учраас гэр бүлийн орчинд хүүхдийн хөгжилд ээж, аавуудын оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээнүүд нь СӨБ-д хамрагдах боломжгүй хүүхдүүдийн бага насны хөгжлийн үр дүнг сайжруулах үр дүнтэй аргачлал болох магадлалтайг харуулж байна. ЯХИС энэ чиглэлд

“Алслагдсан хөдөөгийн малчдын хүүхдүүдийн бага боловсролын үр дүнг сайжруулах нь” төслийг 2012-2017 онд хэрэгжүүлсэн. Төслийн нэг бүрэлдхүүн хэсэг нь малчдын 5-6 настай хүүхдүүдийг гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх явдал байв. Тус бүрэлдхүүн хэсэг нь гэр бүлд суурилсан сургалтын хөтөлбөр, эцэг эхчүүд ба багш нарын чадавхыг бэхжүүлэх, техникийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх, олон нийтийг хамруулах, идэвхижүүлэх зэрэг арга хэмжээгээр дамжуулан хүүхдүүдийн сургуульд бэлтгэгдэх байдлыг сайжруулахыг зорьсон юм. Энэ талаар илүү дэлгэрэнгүй мэдээллийг баримт 4.1-ээс харна уу. 2015 онд ЯХИС ДБ-ны СӨБ-ын чанарын үнэлгээний судалгаанд ашигласан MELQO аргачлалыг ашиглан өөрсдийн хэрэгжүүлсэн гэр бүлд суурилсан бага насны боловсролын хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүдийг үнэлсэн.

ЯХИС-гийн судалгааны мэдээлэл нь тус сангийн хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүдийн үр дүнг ДБ-ны СӨБ-ын чанарын үнэлгээний гэр цэцэрлэгийн түүвэрт хамрагдсан хүүхдүүдийн үр дүнтэй харьцуулах боломжийг олгосон. ЯХИС-ийн хөтөлбөр нь гэр цэцэрлэгийн нэг адил албан СӨБ-д хамрагдах боломжгүй хүүхдүүдэд чиглэсэн юм. Иймд ЯХИС-ийн хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүд болон энэхүү бүлгийн эхэн хэсэгт танилцуулсан гэр цэцэрлэгийн хүүхдүүдийн хөгжлийн үр дүнгийн мэдээллийг харьцуулан, гэр бүлд суурилсан бага насны боловсролын хөтөлбөр нь гэр цэцэрлэгтэй харьцуулахад хүүхдийн хөгжлийн үр дүнд хэр сайн нөлөөлж байгааг харьцуулж болох уу гэдэг асуулт гарсан. Гэхдээ энэ хоёр хөтөлбөрийн үр дүнг харьцуулахад шаардагдах бодит хяналтын бүлгүүд байгаагүй учир үр нөлөөний харьцуулалтыг шууд хийх боломжгүй юм. Тус хоёр хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүдийн аль алийг хөтөлбөрийн төгсгөлд эсвэл хөтөлбөр дуусах дөхөж байх үед үнэлсэн учраас “хөтөлбөр дуусах үеийн” үр дүнгүүдийг хөтөлбөр эхлэх үеийнхтэй харьцуулах боломжгүй байсан. Гэхдээ ЯХИС-ийн хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүд дунджаар гэр цэцэрлэгийн хүүхдүүдтэй адил төстэй, ялангуяа нийгэм-эдийн засгийн байдал болон нас гэх мэт үзүүлэлтүүд нь адил байсан, хоёр бүлгийн үр дүнд нөлөөлж байгаа ялгаатай цорын ганц хүчин зүйл нь тэдний хамрагдсан хөтөлбөр гэж үзвэл тус хоёр түүврийн хүүхдүүдийн үр дүнгийн харьцуулалт ач холбогдолтой байна. Гэхдээ ийм харьцуулалтын үр дүнд болгоомжтой хандаж, ийм байх магадлалтайг зөвхөн илтгэж буй үзүүлэлт гэж үзэх хэрэгтэй бөгөөд судалгааны хүрээнд тооцоогүй бусад хүчин зүйлсийн нөлөө байж болох тул дээрх бүх үр дүн нь зөвхөн эдгээр хоёр хөтөлбөрийн шууд үр нөлөө гэж хэлэх боломжгүй.

Дээрх хоёр түүврийн мэдээлэл цуглуулах үйл явцыг хоёр тусдаа судлаачдын бүлэг өөр нөхцөл байдалд цуглуулсан учир түүврүүдийн харьцуулагдах байдалд зарим хязгаарлалтыг бий болгож байна. ЯХИС-ийн түүврийн хүүхдүүдийн мэдээлэлд хийсэн дүн шинжилгээний үр дүнг ойлгохдоо хэд хэдэн чухал хүчин зүйлсийг анхаарах хэрэгтэй. Нэгдүгээрт, ЯХИС-ийн мэдээлэл цуглуулсан тоологчид нь ДБ-ны судалгааны тоологчдоос өөр хүмүүс байсан, гэхдээ тэд бүгд нэг ижил сургалтанд хамрагдсан. Ялангуяа ЯХИС-гаас хэрэгжүүлсэн гэр бүлд суурилсан бага насны боловсролын хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүдийг үнэлэхэд өөрийн байгууллагын ажилтнуудыг оролцуулсан бол ДБ-ны судалгааг БСШУСЯ-аас тусдаа хөндлөнгийн судалгааны байгууллага хийсэн.

ЯХИС-ийн хөтөлбөрт хамрагдсан нэлээд олон хүүхдийн мэдээллийн чанар хангалтгүй байсан тул дүн шинжилгээ хийхэд тэдгээрийг оруулалгүй хасах хэрэгтэй болсон нь ЯХИС-гийн түүврийн төлөөлөх чадамжийг асуудалтай болгож байгаа юм. ЯХИС-ийн хөтөлбөрт хамрагдсан олон хүүхдийн үнэлгээний мэдээллийн чанар хангалтгүй, мэдээлэл цуглуулах шатанд гарсан алдаанаас болоод ашиглах боломжгүй

болсон. ЯХИС үнэлгээнд анх 4 аймгийн 30 суманд өөрийн хэрэгжүүлсэн хөтөлбөрт хамрагдсан нийт 490 хүүхдийг хамруулсан. Эдгээрээс 315 асуулга нь чанарын шаардлага бүрэн хангасан, мэдээллийг цахим байдлаар оруулах боломжтой, бүрэн байсан. Гарсан гол асуудал нь нэлээд тохиолдолд эцэг эхийн асуулгыг авах боломжгүй байсан бол зарим тохиолдолд кодын алдааны улмаас хүүхдүүдийн мэдээллийг тэдний эцэг эхийнхтэй нь холбож харах боломжгүй болсон байсан. Энэ түүвэрт хамрагдсан хүүхдүүд нь ЯХИС-ийн хөтөлбөрийн зорилтот бүлгийг хэр сайн төлөөлж байгааг тооцоолох мэдээлэл байхгүй учир энэхүү тайланд танилцуулж буй үр дүнд болгоомжтой хандах хэрэгтэй юм. Ялангуяа мэдээллийн чанар болон бүрэн байдал дутмаг байсан нь MELQO аргачлалын үнэлгээнд ямар нэг байдлаар сөргөөр нөлөөлсөн бол энэ нь дүн шинжилгээнд тусгасан хөгжлийн үр дүнгүүдийг өргөсөн байж болох талтай.

ЯХИС-ийн түүвэрт хамрагдсан хүүхдүүд гэр цэцэрлэгийн түүврийн хүүхдүүдээс нийгэм-эдийн засгийн байдлын хувьд доогуур байв. Хариулах ёстой эхний асуулт бол ЯХИС-гийн хөтөлбөрийн болон гэр цэцэрлэгийн түүврүүд нь харьцуулагдахуйц түүврүүд мөн үү гэдэг асуулт юм. Хэрэв ЯХИС-ийн түүврийн хүүхдүүд нийгэм-эдийн засгийн үзүүлэлтүүдээр илүү өрхийн хүүхдүүд байсан бол тэдний гэр бүлийн орчин шууд суурь үзүүлэлтээсээ эхлээд илүү таатай байх учраас хөтөлбөрийн үр нөлөөнөөс үл шалтгаалан эдгээр хүүхдүүдийн MELQO үнэлгээний үр дүн илүү сайн гарах ёстой гэдэг нь тодорхой. Үүнтэй нэг адилаар, насаар илүү хүүхдүүд түүвэрт хамрагдсан байвал тус хөтөлбөрт хамрагдаагүй байсан ч илүү сайн үр дүнг үзүүлэх байсан. Хүснэгт 3.2-т хоёр түүврийн хүүхдүүдийн гол шинжүүдийг үзүүлсэн байна. Хүүхдүүдийн дундаж нас ба хөвгүүдийн эзлэх хувийн жин ЯХИС-ийн түүвэрт үл ялиг илүү байсан. Гэр цэцэрлэгийн түүвэрт Баян-Өлгий аймаг, казах өрхүүдийг оролцуулсан бол ЯХИС-ийн түүвэр казах өрхийн төлөөлөл ороогүй боловч түүврийн 10 хувь нь казахаас өөр үндэсний цөөнхийн төлөөлөл орсон байсан. Нийгэм-эдийн засгийн бусад гол үзүүлэлтүүдийн хувьд ЯХИС-ийн түүврийн хүүхдүүд гэр цэцэрлэгийн хүүхдүүдээс арай доогуур түвшинд байсан байна. ЯХИС-ийн түүврийн хүүхдүүдийн ээжүүдийн 32 хувь ба аавуудын 20 хувь нь бүрэн дунд болон түүнээс дээш түвшний боловсролтой байсан бол гэр цэцэрлэгийн түүврийн хүүхдүүдийн ээжүүдийн 41 хувь, аавуудын 27 хувь ийм түвшний боловсролтой байв. Судалгаа авах үед ЯХИС-ийн түүврийн хүүхдийн 16 хувийн, гэр цэцэрлэгийн түүврийн хүүхдүүдийн 10 хувийн өрхийн тэргүүн ажилгүй байжээ. Мал аж ахуй эрхэлдэг өрхийн тэргүүний эзлэх хувийн жин ЯХИС-ийн түүвэрт үл ялиг бага байсан. Аж байдлын индексийн дундаж оноо ч бас бага зэрэг доогуур байлаа.

Хүснэгт 3.2 Гэр цэцэрлэг ба ЯХИС-ийн хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүдийн шинж чанарууд, 2015 он

	Нас (саруудаар)			Охидын эзлэх хувь (хувиар)	Хүүхдүүд ³⁶
Гэр цэцэрлэг ЯХИС хөтөлбөр	Дундаж	СХ	Голч		
	72.9	2.1	73	46.5	155
	73.6	2.2	74	43.1	248
Өрхийн тэргүүний яс үндэс					
Гэр цэцэрлэг ЯХИС хөтөлбөр	Халх	Казах	Бусад цөөнх		
	76.1	19.4	4.5		
	89.9	0	10.1		
Эхийн боловсрол (хувиар)					
Гэр цэцэрлэг ЯХИС хөтөлбөр	Бага ба доош	Дунд	Бүрэн дунд	Их дээд ба дээш	
	17.5	41.6	33.1	7.8	
	19.4	48.8	28.2	3.6	
Эцгийн боловсрол (хувиар)					
Гэр цэцэрлэг ЯХИС	Бага ба доош	Дунд	Бүрэн дунд	Их дээд ба дээш	Тодорхойгүй
	27.9	44.8	25.3	1.9	0
	32.1	42.7	18.3	2.4	4.5
Өрхийн тэргүүний эрхэлдэг ажлын төрөл (хувиар)					
Гэр цэцэрлэг ЯХИС	Цалинтай	Хувиараа	Малчин	Байхгүй	
	9.7	5.2	74.8	10.3	
	9.3	3.6	71	16.1	
Аж байдлын индексийн дундаж оноо					
Гэр цэцэрлэг ЯХИС	Дундаж	СХ	Голч		
	-0.98	0.78	-1.2		
	-1.15	0.69	-1.3		


Эх сурвалж: Дэлхийн банкны СӨБ-ын чанарын судалгаа (2015) болон ЯХИС-ийн судалгаанд (2015) үндэслэн хийсэн тооцоо.

Хэдийгээр ЯХИС-ийн хөтөлбөрт хамрагдсан өрхүүдийн нийгэм эдийн засгийн үзүүлэлтүүд доогуур байсан ч бага насны хүүхдийн хөгжлийг дэмжихэд таатай орчин бүрдүүлэх тал дээр гэр цэцэрлэгийн хүүхдүүдийн гэр бүлээс хол илүү байв. Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих бас нэг чухал зүйл нь гэр бүлийн орчин, энэ орчин дахь хүүхэд хөгжүүлэх үйл ажиллагаанд гэр бүлийн гишүүдийн оролцоо юм. ЯХИС-ийн хөтөлбөрийн хувьд эцэг эхийн оролцоо нь хүүхдийн хөгжлийн үр дүнг сайжруулах гол хөдөлгөгч хүч болсон байна. Зураг 3.12а-аас харахад үйлдвэрийн буюу дэлгүүрээс худалдаж авсан тоглоомын хүртээмж хоёр түүврийн аль алинд нь өндөр (хүүхдүүдийн 91-93 хувь) байсан бол ЯХИС-ийн түүврийн хүүхдүүд гэртээ хийсэн тоглоом, гэр ахуйн зүйлсээр тоглох нь харьцангуй илүү байв. Мөн ЯХИС-ийн түүврийн ээжүүд хүүхэдтэйгээ гэртээ ажиллах, хүүхдийнхээ хөгжлийг дэмжих нь илүү байлаа (зураг 3.12b). Гэр бүлийн оролцооны индексийн оноо ерөнхийдөө (энэ индексийг гаргасан аргачлалыг баримт 3.3-с харна уу) ЯХИС-ийн түүвэрт харьцангуй өндөр, 1.7 СХ-аар илүү байсан (99 хувийн түвшинд ач холбогдолтой) бөгөөд хувь хүний болон өрхийн түвшний бүх хүчин зүйлсийг хянаж үзсэний дараа ч гэсэн энэ зөрүү хэвээр, статистик ач холбогдол ч өөрчлөлтгүй байлаа (хавсралт 11). Судалгааны мэдээллийг хөтөлбөр хэрэгжүүлж дууссаны дараа


³⁶ДБ-ны СӨБ-ын чанарын үнэлгээний судалгааны түүврийн зорилтот насны бүлэг нь 5-6 насны хүүхдүүд байв. Харин ЯХИС-ийн түүвэрт хамрагдсан ихэнх хүүхэд 6 нас хүрсэн хүүхдүүд байв. Хоёр түүврийг харьцуулж болохуйц болгохын тулд ижил настай хүүхдүүдээр түүврийг хязгаарлах шаардлага гарсан (хавсралт 11). Ингээд түүврийн насыг 70 – 77 сараар хязгаарлагдаж, гэр цэцэрлэгийн түүврийн тоо 534 хүүхэд байсныг 155

авсан учраас гарсан үр дүнгүүд нь үнэхээр хөтөлбөрийн үйл явцад гарсан, зөвхөн энэ хөтөлбөрийн үр нөлөө гэдгийг батлах боломжгүй хэдий ч ЯХИС-ийн хөтөлбөрийн хүүхдүүдийн өрхүүд гэр цэцэрлэгийнхтэй харьцуулахад БНХБ-ыг дэмжихэд илүү таатай орчин бүрдүүлж чадсан нь чухал ололт юм.

Зураг 3.12а Гэр цэцэрлэг ба ЯХИС-ийн хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүдийн гэртээ тоглодог тоглоомын төрөл, Монгол улс, 2015



Зураг 3.12б Гэр цэцэрлэг ба ЯХИС-ийн хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүдийн ээжүүдийн сүүлийн 3 өдөр гэртээ хүүхдүүдтэйгээ ажилласан байдал, Монгол улс, 2015



Эх сурвалж: Дэлхийн банкны СӨБ-ын чанарын судалгааны (2015) болон ЯХИС-гийн судалгаанд (2015) үндэслэв.

ЯХИС-ийн хөтөлбөр хэрэгжиж дуусахад бага насны хүүхдийн хөгжлийн таван айн үр дүн ЯХИС-ийн түүвэрт гэр цэцэрлэгийнхээс хол өндөр гарсан байна. Өрхийн нийгэм эдийн засгийн байдал хүүхдийн хөгжлийн үр дүнд нөлөөлдгийг харгалзан үзвэл ЯХИС-ийн түүврийн хүүхдүүд гэр цэцэрлэгийн түүврийн хүүхдүүдийнхээс нийгэм-эдийн засгийн нөхцөл байдлын хувьд илүү доогуур байсан учраас тэдгээр хүүхдийн хөгжлийн үр дүнг сайжруулах нь гэр цэцэрлэгийн хүүхдүүдийнхийг сайжруулахаас илүү бэрхшээлтэй байх юм. Гэсэн хэдий ч хүснэгт 3.3-ыг харахад ЯХИС-ийн түүврийн хүүхдүүд тус хөтөлбөрт хамрагдсаны дараа бага насны хүүхдийн хөгжлийн ай тус бүрээр гэр цэцэрлэгийн түүврийн хүүхдүүдээс ихээхэн дээгүүр оноо авчээ. Илүү зөрүүтэй давуу байдал нь гүйцэтгэх чадварын хувьд 1.06 СХ-тай байсан бол жижиг булчингийн хувьд 0.19 СХ-тай байв. Ажиглаж болох хувь хүний түвшний болон өрхийн түвшний бүх шинж чанаруудыг хянасны дараа ч бас энэ давуу тал ЯХИС-ийн түүвэрт өндөр хэвээр байсан нь анхаарал татаж байгаа юм (зураг 3.13).


Хүснэгт 3.3 Гэр цэцэрлэг ба ЯХИС-ийн хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүдийн MELQO үнэлгээний аргачлалын дундаж оноо, Монгол улс, 2015 (стандарт хазайлтын нэгж)

	Танин мэдэхүй	Хэл яриа	Нийгэм-сэтгэлийн хөдөлгөөн	Гүйцэтгэх чадвар	Жижиг булчин
Гэр цэцэрлэг	0.257	0.087	-0.418	-0.022	0.081
ЯХИС хөтөлбөр	1.031	1.01	0.318	1.042	0.267
ЯХИС-ийн хөтөлбөрийн давуу тал	0.774	0.923	0.736	1.064	0.186

Эх сурвалж: Дэлхийн банкны СӨБ-ын чанарын судалгаа (2015) болон ЯХИС-ийн судалгаанд (2015) үндэслэн хийсэн тооцоо

Нийгэм эдийн засгийн бусад шинж чанарын зэрэгцээ гэр бүлийн орчин, гэр бүлийн оролцоог хянан үзэхэд ЯХИС-ийн хөтөлбөрийн үр нөлөө ихээхэн өндөр хэвээр байсан. Гэр бүл, нийгэм эдийн засгийн байдалтай холбоотой бүх хүчин зүйлсийг хянасны дараа ч бас ЯХИС-ийн үзүүлэлтийн коэффициент статистик ач холбогдолтой, өндөр хэвээр байж, тэр ч байтугай бусад коэффициентээс илүү өндөр гарсан байна (зураг 3.13 ба хавсралт 11). Энэ үр дүн нь гэр бүлийн нөлөө ба гэр бүлийн оролцоог хянасны дараа ч өөрчлөгдөөгүй адилхан байсан ба ЯХИС-ийн хөтөлбөрт гэр бүлийн оролцоог гол “хөдөлгөгч хүч” болгосноор ийм үр дүн гаргахыг зорьсон юм. Өөрөөр хэлбэл, хөтөлбөрийн үр нөлөөг бий болгох гол механизмыг регресс оруулсан гэр бүлийн оролцооны индексээр харуулж болохоор бол тус индексийг регрессд оруулахад ЯХИС-ийн үзүүлэлтийн хувьсагчийн коэффициент ихээхэн буурах учиртай. Гэхдээ хөгжлийн ай тус бүрт коэффициент нь СХ-ын гуравны нэгээр багасч байгаа ч гэсэн коэффициентийн хувь их, статистик ач холбогдолтой хэвээр байгаа нь “ЯХИС-ийн хөтөлбөрийн үр нөлөө” үнэхээр байгаа бөгөөд энэ нь зөвхөн оролцооны индексийн хувьсагчаар тайлбарлагдах зүйл биш гэдэг нь харагдаж байна. Энэ индекс нь зөвхөн БНХБ-той холбоотой үйл ажиллагаа хүүхдийн гэр бүлд өрнөсөн эсэхийг л харж, үнэлгээний үеэр тухайн үйлдэл нь хэр удаан, ямар давтамжтай өрнөсөн болохыг илтгэхгүй байх талтай. Тиймээс энэ индекс нь ЯХИС-ийн хөтөлбөрийн хүүхдүүдэд эцэг эхийн гэр бүлийн оролцооны үзүүлсэн бодит үр нөлөөг тайлбарлах мэдээллийн багахан хэсгийг харуулж байгаа юм.

Зураг 3.13 Гэр цэцэрлэг ба ЯХИС-ийн хөтөлбөрт оролцсон хүүхдүүдийн MELQO үнэлгээний дундаж оноонд ЯХИС-ийн хөтөлбөрийн давуу тал, Монгол улс, 2015 оны байдлаар



Эх сурвалж: Дэлхийн Банкны СӨБ-ын чанарын судалгаа (2015) болон ЯХИС-ийн судалгаанд (2015) үндэслэн гаргасан тооцоо
 Жич: Баганын өндөр нь ЯХИС ба гэр цэцэрлэгийн түүврийн хүүхдүүдийн MELQO онооны ялгааны хэмжээг харуулна. Бүх ялгаа нь 1 хувийн түвшинд ач холбогдолтой байв. Регрессийн хүснэгт хавсралт 11-т бий.

3.3 Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаанд БНХБ-ын үр дүнг тодруулсан нь

НҮБ-ын Хүүхдийн сангийн 2010 оны Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаанд (ОУБТС) 5 хүртэлх насны хүүхдийн БНХБ-ын зарим үр дүнг тодруулжээ. НҮБ-ын Хүүхдийн сангийн 2010 ба 2013 оны ОУБТС нь 36-59 сартай хүүхдүүдийн дундах бичиг үсэг ба тоо, биеийн хөдөлгөөн, нийгэм-сэтгэлийн хөдөлгөөн ба суралцах чадварын талаар БНХБ-ын цөөн хэдэн үр дүнгийн мэдээллийг цуглуулсан юм³⁷. Энэ мэдээллийн нэг давуу тал бол ОУБТС нь үндэсний хэмжээг хамарсан өрхийн судалгаа учир СӨБ-д хамрагдсан ба хамрагдаагүй хүүхдүүдийн ялгааг харах боломжтой юм. ОУБТС нь нийт арван дөрвөн (тийм/үгүй) хоёр сонголттой илрүүлэх үзүүлэлтүүдээр БНХБ-ын үр дүнгийн зарим мэдээллийг цуглуулсан. Зураг 3.14а-аас харахад судалгаанд ашигласан илрүүлэх үзүүлэлтүүд нь нарийн хэмжилт хийхэд асуудалтай болох нь ажиглагдаж байна. Арван дөрвөн илрүүлэх үзүүлэлтийн есийг нь харахад хүүхдүүдийн бараг 100 хувь эсвэл тун цөөхөн хувь нь тухайн асууж байгаа үйлдлийг хийх чадвартай байна. Тиймээс тус судалгааны мэдээлэл нь хүүхдүүдийн хөгжлийн зарим тал/айн хөгжил тун муу эсвэл тун сайн байгаа талаар тодорхой ойлголтыг өгч байгаа боловч хэмжилт нь зөвхөн хоёр сонголттой, хэмжиж буй ай тооны хувьд цөөн байгаа учраас хүүхдийн хөгжлийн үр дүнгийн зохих хэмжээний тархалтыг бий болгох боломжийг олгож чадахгүй байна.

Эцэг эх/асран хамгаалагчид бичиг үсэг ба тоо тооллын айд хамгийн бага үнэлгээг өгчээ. ОУБТС-ны бичиг үсгийн илрүүлэх үзүүлэлтэд эцэг эхчүүд хүүхдээ маш доогуур үнэлсэн байна (зураг 3.14а). СӨБ-ын сургалтын хөтөлбөрт цагаан толгойн үсэг таниулах тухай байдаггүй боловч 36-59 сартай Монгол хүүхдүүдийн 15 хувь нь цагаан толгойн дор хаяж 10 үсгийг нэрлэж чадаж байгаа нь хүүхдүүдийн дунд суралцах чадварын зөрүү гарч ирж байгаа бөгөөд энэ нь цаашид өсөж том болох тусам нь улам ихэсч магадгүй болохыг харуулж байна. Харин дор хаяж дөрвөн энгийн үг унших чадвартай хүүхэд тун ховор байв. ОУБТС-ны тоо, тооллын хөгжлийг илрүүлэх үзүүлэлт бичиг үсгийнхээс арай дээр үнэлгээтэй гарсан ба чадварууд нь арай олширч эхэлж байгааг тодруулж байна. Хүүхдүүдийн 66-70 хувь нь зарим нэг өнгө, хэлбэр дүрсийг ялгаж чаддаг, 86 хувь нь тоолж чаддаг, 61 хувь нь 10 хүртэлх тоог таньж чаддаг байв. Нийгэм-сэтгэлийн хөдөлгөөний айн тухайд бараг бүх хүүхдүүд бусад хүүхдүүдтэй сайнхарилцаатай, эвтэй “таардаг” боловч 26 хувь нь бусдыг өшиглөдөг, цохидог, 29 хувь нь анхаарал нь амархан сарнидаг гэсэн үнэлгээтэй байна. Биеийн хөдөлгөөний айн тухайд бараг бүх хүүхэд судалгаагаар шалгасан жижиг булчингийн хөгжлийн хоёр төрлийн үйлдлийг хийж чадаж байсан ба 14 хувь нь тоглох тамир тэнхээгээр сул байдаг гэсэн мэдээлэл байна. Суралцах чадварын айн тухайд бүх хүүхэд аливаа зүйлийг хэрхэн зөв хийх талаарх энгийн зааврыг дагадаг, мөн энгийн даалгаврыг өөрсдөө бие даан хийж чаддаг гэсэн үнэлгээтэй байна.

Хөдөө орон нутгийн болон СӨБ-д хамрагдаагүй хүүхдүүд бусдаасаа ихээхэн хоцорч байна. Зураг 3.14б-д Монгол орны янз бүрийн хэсэгт орших хүүхдүүдийн ОУБТС-ны БНХБ-ын үр дүнгийн ялгааг харуулж, судалгааны илрүүлэх үзүүлэлтүүдийн аль нэг шаардлагыг бараг бүх эсвэл дэндүү цөөн хүүхэд хангаж байгаа илрүүлэх үзүүлэлтүүдийг

³⁷ Энэ тайланг бичих үед 2013 оны ОУБТС-ны мэдээллийг олон нийтэд зарлаагүй байсан боловч тайлан сүүлийн хэлбэрээ гарсан байв. Тиймээс энэхүү тайланд ОУБТС-ны мэдээллийг ашиглан хийсэн бүх дүн шинжилгээ нь 2010 оны судалгаанд үндэслэсэн юм. Харин зарим хэсэгт 2013 оны тайланд туссан судалгааны үр дүнг оруулсан.

хассан байна (зургийн доорх тайлбарыг харна уу). Хөгжлийн үр дүн ихээхэн ялгаатай цор ганц ай нь бичиг үсэг байсан ба үүнд хөдөө орон нутгийн хүүхдүүд хотын хүүхдүүдээс нэлээд хоцорсон байв. Үүнээс гадна СӨБ-д хамрагдаагүй хүүхдүүд хамрагдаж байгаа хүүхдүүдээс хоцрох талтай байсан бөгөөд хамгийн том зөрүү бичиг үсгийн айд байв.

Тоо тооллын айн хөгжлийн тухайд өрхийн нийгэм-эдийн засгийн байдлын зэрэгцээ СӨБ-ын хамрагдалт амжилтанд хүрэх чухал түлхүүр болж байна. ОУБТС-ны БНХБ-ын ихэнх илрүүлэх үзүүлэлтүүдэд хүүхдүүд маш сайн эсвэл маш доогуур гүйцэтгэлтэй байсны улмаас хоорондын ялгаа багасч, хүн ам зүй болон нийгэм эдийн засгийн шинж чанараар ялгаж харахад хүндрэлтэй болсон юм³⁸. Энэхүү дүн шинжилгээг хийж болох айд зөвхөн тоо тоолол ба нийгэм-сэтгэлийн хөдөлгөөний айд багтаж байна. Бичиг үсгийн айтай харьцуулахад тоо тооллын илрүүлэх үзүүлэлтүүд бага зэрэг дээгүүр гарч, хөгжлийн айн талаар дэлгэрүүлэн харах боломжтой. MELQO аргачлалаар хэмжсэн үр дүнгийн адил бусад хүчин зүйлс хэвээрээ байхад, өрхийн түвшний хүчин зүйлс дундаас эхийн боловсрол гол тодорхойлогч байсан бол, БНХБ-ыг дэмжих гэр бүлийн орчны хувьд гэрт байгаа хүүхдийн номын тоо чухал нөлөө үзүүлсэн байна (хавсралт 12). Тухайлбал, коллеж, их дээд сургууль төгссөн ээжүүдийн хүүхдүүд бага болон түүнээс доош боловсролтой ээжүүдийнхтэй харьцуулахад 10 хүртэлх тооны цифрийг таньж ялгах нь 16 пунктээр илүү, гэрт 1-5 (эсвэл дээш) хүүхдийн ном байх нь өмнө дурдсан илрүүлэх үзүүлэлтүүдийн тухайд 10 пунктээр илүү байв. Охид судалгааны шалгуурыг хангах магадлалаар хөвгүүдээс илүү (7 пунктээр илүү) байсан бол бусад хүчин зүйлс хэвээр байхад Казах хүүхдүүд бусад хүүхдүүдээс хоцорч (16 пунктээр) байв. Өрхийн түвшний бүх шинж үзүүлэлтийг хянасны дараа СӨБ-д хамрагдахын үр нөлөө ихээхэн ач холбогдолтой (20 пункт) хэвээр байв.


³⁸ Ялангуяа өрхийн болон хувийн хүчин зүйлсийн нөлөөг нарийвчлан гаргах боломжгүй байна. Жишээ нь "Хүүхэд цагаан толгойн 10 хүртэлх үсгийг мэдэх үү?" гэдэг хоёр сонголттой хувьсагчийг цөөн тооны өрхийн болон хувийн шинж чанарын регресс хийхэд тухайн коэффициентээс өөрөөс нь хамаагүй илүү стандарт алдаатай коэффициентийг бий болгож байна.

Зураг 3.14а ОУБТС-ны БНХБ-ын үр дүнг тодорхойлох даалгавруудыг биелүүлж чадаж байгаа 36-59 сартай хүүхдүүдийн эзлэх хувь, Монгол улс, 2010



Эх сурвалж: ОУБТС (2010)-д үндэслэв.

Зураг 3.14б Хөгжил нь зохистой түвшинд байгаа 36-59 сартай хүүхдүүдийн эзлэх хувь (зөвхөн тус улсын шалгуураар), Монгол улс, 2010



Эх сурвалж: ОУБТС (2013)-д үндэслэв.

Жич: * Бичиг үсэг-тоо тоолол: Дараахаас хоёрыг нь хийж чаддаг бол хөгжлийн зохих түвшинд байна гэж үзнэ: Хүүхэд зарим өнгийг ялгаж чадна, энгийн дүрсийг таньж нэрлэнэ, тоолно. Наад зах нь цагаан толгойн 10 үсгийг мэдэх, энгийн дөрвөн үг унших ба 10 хүртэлх тоог таних зэрэг илрүүлэх үзүүлэлтүүийг хассан.

** Биеийн хөдөлгөөн: Дараахаас хоёрыг нь хийж чаддаг бол хөгжлийн зохих түвшинд явж байна гэж үзнэ: Хүүхэд жижиг зүйлсийг барьж авч чадна, эсвэл заримдаа тоглох хүч тэнхээгүй болдоггүй.

СӨБ-ын хамрагдалт, өрхийн болон хувийн бусад хүчин зүйлс төдийлөн нөлөөгүй байхад ч гэсэн хөвгүүд нийгэм-сэтгэлийн хөдөлгөөний айн хөгжлийн үр дүнгээр охидаас хоцорч байв. Өрхийн нийгэм-эдийн засгийн хүчин зүйлс нийгэмшихүйн ур чадварт сөрөг нөлөө үзүүлэх хандлага ажиглагдаагүй боловч охидууд хөвгүүдээс илүү дээгүүр үзүүлэлттэй байв (сөрөг зан төлөв байдал гаргах магадлалаар 6 пунктээр бага). ДБ-ны чанарын үнэлгээний судалгаатай харьцуулахад СӨБ-д хамрагдалтын үр нөлөө ажиглагдаагүй байна.

Шууд харьцуулалт хийх боломжгүй ч гэсэн ОУБТС-ны тоо тоолын айн хөгжлийн үр дүнгүүд Дэлхийн банкны судалгааны үр дүнтэй адилхан байна. Дэлхийн банкны судалгааг ОУБТС-тай шууд харьцуулах боломжгүй олон шалтгаан бий. Нэгдүгээрт MELQO аргачлалаар үнэлсэн зүйлсийн тоо нь ай тус бүрийн хувьд ОУБТС-ныхаас харьцангуй олон байсан юм. Хоёрдугаарт, ОУБТС-д хамрагдсан хүүхдүүд насны хувьд бага байв. ОУБТС нь 5-аас доош насны хүүхдийг хамруулсан байхад ДБ-ны судалгаанд 5-6 настай хүүхдүүдийг хамруулжээ³⁹. Гэсэн хэдий ч ОУБТС-ны бага насны хүүхдүүдийн тоо тооллын айн үзүүлэлтүүд ихээхэн ялгаатай байгаа нь суралцах үр чадварын ялгаа бага наснаас эхэлдэг болохыг тодруулж байна. Ямартай ч ОУБТС-ны тоо тооллын айн хөгжлийн үр дүнгүүд ДБ-ны судалгааны үр дүнтэй адилаар байна. Жэндэрийн хамраалтай ялгаа, мөн эхийн боловсролын түвшний нөлөө ч бас чухал хэвээр байна. Өрхийн болон хувийн түвшний хүчин зүйлсийг хянасны дараа ч бас СӨБ-ын хамрагдалт чухал нөлөөтэй хэвээр байлаа. ОУБТС-ны тоон харьцуулалт хийж болох цорын ганц ай болох нийгэм-сэтгэлийн хөдөлгөөний айд жэндэрийн ялгаа чухал ач холбогдолтой байв. Харин ДБ-ны судалгаанд тус айн хөгжлийн үр дүнд нийгэм-эдийн засгийн нэлээд хэдэн шинжүүд болон СӨБ-ын хамрагдалт багагүй нөлөөтэй байсан. Эдгээр үр дүн нь олон шалтгааны улмаас хоорондоо өөр өөр байж болох боловч хамгийн гол нь энэхүү хоёр судалгаанд үнэлсэн зүйлс нь өөр байсантай холбоотой байж болох юм.⁴⁰

3.4 Дүгнэлт

Төрийн өмчийн цэцэрлэгт хамрагдаж байгаа хүүхдүүдийн тухайд цэцэрлэгийн шинж чанарууд дотроос бага насны хүүхдийн хөгжлийн бүх 5 айд эерэгээр нөлөөлж байсан цорын ганц зүйл бол чанар юм. Цэцэрлэгийн чанар хүүхдийн хөгжлийн үр дүнд нөлөөлэх хэмжээ ялгаатай байгаа боловч судалгаанд хамрагдсан бага насны хүүхдүүдийн хөгжлийн таван айн дөрвийн тухайд 1 хувийн ач холбогдлын түвшинд нөлөөлсөн хэвээр байсан бол жижиг булчингийн айн хөгжлийн тухайд 5 хувийн ач холбогдлын түвшинд нөлөөлж байжээ. Нийгэм-сэтгэлийн хөдөлгөөний айд үр нөлөө нь хамгийн их, үүний дараа хэл яриа орсон. Энэ нь дэлхий нийтийн туршлагатай адил байгаа бөгөөд СӨБ-ын хүртээмж чухал хэдий ч чанар хангалттай сайн байсан цагт л үр дүн илүү байх болно гэдгийг нотолж байна.

СӨБ-д урт хугацаагаар хамрагдах нь сайн үр дүнг авчирч, тоо тоолол, бичиг үсэг ба нийгэм-сэтгэлийн хөдөлгөөний айнуудад статистик ач холбогдол өндөр байв. Цэцэрлэгт хамрагдсан хугацаа нь бага насны хөгжилд сайнаар нөлөөлж, бусад бүх хүчин зүйлсийг хянаж үзсэний дараа ч бас цэцэрлэгийн чанараас илүүгээр нөлөөлж байв. Судалгаанд үнэлсэн таван айны гуравт нь тус нөлөө статистик ач холбогдолтой байв. Үүнд тоо тооллын ай (1 хувийн түвшний), бичиг үсэг ба нийгэм-сэтгэлийн хөдөлгөөний ай (5 хувийн түвшний) орсон.

³⁹ Сүүлчийн гол ялгаа гэвэл ОУБТС-ны үр дүнгийн мэдээллийг эцэг эх, асран хамгаалагчдаас авсан бол ДБ-ны судалгаанд хүүхдүүдийг хамруулж үнэлсэн. Эцэг эх нь хүүхдэд байгаа аль нэг үр чадварыг мэдэхгүй байж болох учир хүүхдээ үнэлэхдээ алдаа гаргаж, ялангуяа бичиг үсэг, тоо тооллын айн тухайд өрхийн хүчин зүйлс хүүхдийн бичих, унших чадварыг ажиглах боломжийг хязгаарлаж болох юм. Эцэг эхээс мэдээлэл авах ба тусгайлан бэлдсэн үнэлээчээр үнэлүүлэх хоёр арга нь хоёулаа сул ба давуу талуудтай боловч MELQO аргачлал нь судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн хөгжлийн үр дүнгийн тархалтыг бий болгох боломжоор илүү байгаа нь янз бүрийн нөхцөл байдалтай хүүхдүүдийн хоорондын ялгаа, зөрүүг сайтар хэмжихэд тусалж чадна.

⁴⁰ MELQO үнэлгээнд хамрагдсан хүүхдүүдээс найзуудынхаа нэрийг хэлэхийг хүсч, сэтгэлийн хөдөлгөөний хариу үйлдлийг нь хэмжихийн тулд төрөл бүрийн нөхцөл байдал өгч, хэл яриагаараа сэтгэлийн хөдөлгөөнөө илэрхийлэх (бусадтай хуваалцах, бусдын сэтгэлийг ойлгох, өөрийн сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох) даалгаврыг өгч байв. Харин ийм зүйл ОУБТС-д огт байсангүй (зураг 3.12a). Тоо тооллын айн үр дүнгийн хувьд ОУБТС-аар үнэлсэн зүйлс нь бага зэрэг өөрчлөлт орсон ч гэсэн бүгд MELQO аргачлалд туссан. Ялгаатай цорын ганц зүйл нь MELQO аргачлалд өнгө ялгах чадварыг үнэлээгүй явдал юм.

Хүүхдийн өрхийн нийгэм-эдийн засгийн байдал цэцэрлэгийн түвшний хүчин зүйлсийг хянаж үзсэний дараа ч гэсэн хөгжлийн бүх айн үр дүнд чухал нөлөөтэй хэвээр байв. Өрхийн, хувийн ба цэцэрлэгийн түвшний бүх хүчин зүйлсийг хянасны дараа ч бас бага насны хүүхдийн хөгжлийн таван айн үр дүн сайн байхад цэцэрлэгийн чанараас гадна эхийн боловсрол (дээд боловсролтой байх) нөлөөлж байна. Дээд боловсролын зэргийн индикаторын хувьсагчийн коэффициент нь бага болон боловсролгүй ээжүүдийнхтэй харьцуулсан үр дүнгийн ялгааг харуулж байгаа учир энэ нь Монгол улсын түвшинд дээд болон доогуур боловсролтой иргэдийн хоорондын тэгш бус байдлыг харуулж байгаа юм⁴¹. Эцэг, эхийн боловсролын хувьсагчдыг регрессын загварт хэрхэн оруулснаас үл хамааран тэдгээр нь хөгжлийн таван айд ихээхэн нөлөөтэй байсан. Өрхийн амьжиргаа хөгжлийн үр дүнтэй холбоотой байсан боловч тоо тоолол болон гүйцэтгэх чадварын айн коэффициентууд ихээхэн нөлөөтэй байж, бичиг үсгийн хувьд ач холбогдлын түвшин доогуур байв. Эцэг, эхийн боловсролын нөлөөний талаар олж мэдсэн зүйлс нь бас чухал зүйл юм. Ерөнхийдөө Монгол улсын хүн амын боловсролын түвшинг эрчимтэйгээр сайжруулахаар боловсролын салбарт хөрөнгө оруулах нь алсдаа бага насны хүүхдийн хөгжлийн үр дүнд эерэгээр нөлөөлөх тасралтгүй үргэлжлэх үр нөлөөтэй байх болно.

Гэр бүлийн оролцоо сайн байснаар танин мэдэхүй ба хэл ярианы хөгжлийн үр дүн сайжирч байв. Хүүхдүүдтэйгээ гэртээ цагийг хамтдаа үр өгөөжтэй өнгөрүүлэх, хүүхэдтэйгээ ажиллах нь хөгжлийн сайн үр дүнг бий болгож байсан бол энэ үр нөлөө нь зөвхөн танин мэдэхүй ба хэл ярианы айн үр дүнд статистик ач холбогдолтой байсан. Нийгэм-сэтгэлийн хөдөлгөөний айн хувьд үр нөлөө бага байв. Энэ нь БНХБ-д гэр бүлийн оролцоог нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулж буй гэр бүлд суурилсан БНХБ-ын хөтөлбөр нь цэцэрлэгт хамрагдсан болон хамрагдаагүй хүүхдүүдийн хөгжилд эерэг үр нөлөөг үзүүлнэ гэдгийг нотолж байна. Гэхдээ иймэрхүү хөтөлбөрүүд нь БНХБ-ын үр дүнд үр нөлөө үзүүлэх үйл ажиллагаанд эцэг эхийн оролцоо чинээлэг өрхүүдтэй харьцуулахад нэлээд доогуур байдаг бага орлоготой, нэн ядуу буюу зорилтот бүлгийн өрхүүдэд илүүтэй ач холбогдолтой юм.

Түүврийн төлөөлөх чадварт зарим нэг асуудал байгаа боловч ЯХИС-ийн гэр бүлд суурилсан сургуульд бэлтгэх хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүдийн сайн үр дүн нь урам зоригийг өгч байна. ЯХИС-ийн гэр бүлд суурилсан сургуульд бэлтгэх хөтөлбөрийн мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд СӨБ-ын үйлчилгээний хүртээмж хягаарлагдмал, эсвэл СӨБ-ын үйлчилгээ байхгүй газруудад хүүхдийн хөгжлийн үр дүнг сайжруулахад гэр бүлд суурилсан БНХБ-ын хөтөлбөр үр дүнтэй байж чадах талаар тун хязгаарлагдмал боловч сайшаалтай үр дүнг тодруулж байна. ЯХИС-ийн түүврийн мэдээллийн чанар, төлөөлөх чадвар зарим талаар асуудалтай байгаа гэдгийг мартаж болохгүй ч энэхүү хөтөлбөрийн үр нөлөөний талаар баримт нотолгоо хараахан гараагүй бөгөөд гэр цэцэрлэгүүдийн оролцоотой харьцуулахад ЯХИС-ийн хөтөлбөрийн оролцоонд гэр бүлийн таатай орчин сайнаар нөлөөлж, эцэг эх, гэр бүлийн гишүүд хүүхдүүдтэйгээ цагийг хамтдаа үр өгөөжтэй өнгөрөөж, хичээллэж байсан нь бага насны хөгжлийг дэмжин улмаар хөгжлийн айн үр дүн сайжрах үндсийн үндэс болж байна.

ДБ ба ЯХИС-ийн хоёулангийнх нь судалгааны үр дүнгүүд гэр бүлд суурилсан БНХБ-ын сургалтын арга барилууд нь цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа бага насны хүүхдүүдийн боловсролын үр дүнг сайжруулахад чухал нөлөө үзүүлж болохыг тодруулж байна. Гэр бүлийн оролцоо, ЯХИС-ийн гэр бүлд суурилсан сургуульд бэлтгэх хөтөлбөр зэрэгтэй холбоотой хөгжлийн үр дүнг шинжлэн үзэхэд, гэр бүлд суурилсан арга барилыг Монгол улсын СӨБ-д хамрагдах боломж хязгаарлагдмал, эсвэл СӨБ-ын гадна байгаа хүүхдүүдийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг сайжруулахад өргөнөөр ашиглаж болох юм. 4-р бүлэгт энэ тухай дэлгэрүүлэн өгүүлнэ. Гэхдээ гэр бүлд суурилсан хөтөлбөр

⁴¹ 2013 оны ОУБТС-д, насанд хүрсэн эмэгтэйчүүдийн 8.2 хувь бага болон түүнээс доош боловсролтой байсан бол, 34 хувь нь коллеж, их дээд сургууль төгсжээ (НҮБ-ын Хүүхдийг сан, 2016).

нь албан ёсны СӨБ буюу цэцэрлэгийн үйлчилгээтэй эн тэнцэх үр өгөөжтэй байж чадахгүй гэдгийг анхаарах хэрэгтэй. СӨБ нь хүүхдүүдэд өөр хоорондоо харилцах, нийгэм-сэтгэлийн хөдөлгөөний чадвараа хөгжүүлэх, багаар ажиллах, асуудлыг шийдвэрлэх, хувь хүмүүсийн ялгааг ойлгох боломжуудыг олгодог бол гэр бүлийн орчин сайн, эцэг эхчүүд өндөр боловсролтой, амьжиргаа нь сайн байсан ч ийм үр дүнг бий болгож чадахгүй. ДБ-ны судалгааны мэдээлэлд нийгэм-сэтгэлийн хөдөлгөөний ай нь цэцэрлэгийн чанарын хамгийн өндөр коэффициентийг авсан нь тус айн чадварууд нь СӨБ-ын орчинд илүүтэй хөгждөг болохыг харуулж байна. ЯХИС-ийн түүврийн хүүхдүүд гэр цэцэрлэгийн хүүхдүүдээс нийгэм-сэтгэлийн хөдөлгөөний чадвараар илүү байсан нь анхаарууштай зүйлүүдийн нэг байлаа. ЯХИС-ийн загварыг ирээдүйд үнэлэхдээ эдгээр ур чадварыг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн загвар, бүтцийн шинж чанаруудыг нь тодруулах нь зүйтэй.

Гэр цэцэрлэгийн хүүхдүүд судалгааны талаас илүү хэсэгт бусад хүүхдүүдээс нэлээд хоцорч байсан нь гэр цэцэрлэгийн үргэлжлэх хугацаа маш богино байдагтай холбоотой байх талтай. 2-р бүлэгт гэр цэцэрлэгүүд харилцаанаас бусад айн тухайд чанарын үйл явц ба бүтцийн хувьд төрийн өмчийн ердийн цэцэрлэгээс доогуур оноо авч, тус цэцэрлэгийн үйл ажиллагааны хангамжийн асуудлууд чанарыг сайжруулах боломжийг хязгаарладаг тухай өгүүлсэн. Түүнчлэн гэр цэцэрлэгийн үргэлжлэх хугацаа бага байдаг тул тэдний суралцах орчин зарим талаар хязгаарлагдмал учир 2-р бүлэгт хэтэрхий өндөр хүлээлттэй байхаас болгоомжлуулж байсан. Харин тус бүлэгт гэр цэцэрлэгийн хүүхдүүдийг үнэлэхэд тэд бусдаас хоцорч байгааг харуулснаар энэ санааг баталгаажуулав. Судалгаанд хамрагдсан гэр цэцэрлэгүүд БНХБ-ын үр дүнг хэмжих үед үйл ажиллагаагаа эхлээд 2-3 долоо хонож байв. Тус судалгаа нь үйлчилгээний үр нөлөөг хэмжихийг зориогүй хэдий ч үйл ажиллагаа нь эхлээд дундаа орж байх үед судалгаа⁴² хийж үнэлэхэд үр дүн нь төрийн өмчийн ердийн цэцэрлэгүүдийнхээс харьцангуй доогуур үнэлгээтэй гарсан нь хүүхдийн хөгжилд үзүүлэх үр нөлөө хязгаарлагдмал, гэр цэцэрлэгийн үргэлжлэх хугацаанд төрийн өмчийн ердийн цэцэрлэгт 1-2 жил хамрагдсан хүүхдүүдтэй адил үр дүнд огтхон ч хүргэж чадахгүй нь харагдаж байна. Одоогоор СӨБ-д хоёр сараас доош хамрагдсанаар эерэг үр дүн гарсан баримт нотолгоо дэлхийн аль ч оронд байхгүй бөгөөд тэр дундаа чанарын дээд түвшинг хангасан газруудад ч ийм үр дүн гардаггүй байна.

Эдгээр хязгаарлалтуудыг үл харгалзан эцэг эхчүүд гэр цэцэрлэгийг сайнаар үнэлж, сэтгэл ханамжтай байгаа нөхцөлд цаашдаа гэр цэцэрлэгийн орчин нөхцөл, хангамжийг сайжруулах төлөвлөгөөг гаргахдаа тэдгээрийн үнэ өртөг ба үр ашгийг БНХБ-ын бусад хувилбаруудтай харьцуулан тооцоолох нь зүйтэй.

Монгол улс сүүлийн хэдэн жил гэр цэцэрлэгийн хүрээг нэмэгдүүлж, хүрч үйлчлэхэд хүндрэлтэй хүн амд хүрэх тал дээр хичээнгүйлэн ажилласныг харахад гүн сэтгэгдэл төрж байна. Гэр цэцэрлэгүүдийн үйл ажиллагааг эцэг эхчүүд баяртайгаар хүлээн авч байгаа төдийгүй сэтгэл ханамжийн түвшин өндөр байсан (Дэлхийн банк, 2015). Малчин өрхүүдийн хүүхдүүдийн ихэнхийнх нь тухайд гэр цэцэрлэг нь СӨБ-д хамрагдах, ялангуяа нийгэм-сэтгэл зүйн хөдөлгөөний чадвараа хөгжүүлэх цорын ганц боломж хэдий ч үйл ажиллагааны хэрэгжилтийн түвшинд гэр бүлийн оролцоо бараг байхгүйтэй адил байна. Үүний зэрэгцээ гэр цэцэрлэгүүдийн үргэлжлэх хугацаа, суралцах орчны чанарыг бодож үзэхэд тус цэцэрлэгт хамрагдаж байгаа хүүхдүүдийг бусад хүүхдүүдтэй эн тэнцүүлэн харьцуулах боломжгүй байна. Тэгэхээр гэр цэцэрлэгийн үйл ажиллагааны үргэлжлэх хугацааг нэмж болох ч үнэ өртөг нь багагүй нэмэгдэх зэргээр асуудал урган гарах

⁴² Гэр цэцэрлэгийн үйл ажиллагаан нь зөвхөн зуны улиралд дөрвөн долоо хоногоос илүүгүй хугацаанд үргэлжилдэг.

талтай⁴³. Мөн зай багтаамж бага, үйл ажиллагаа явуулах тоног төхөөрөмж, хангамжийн чиглэлээрх чанарын ялгааг арилгах бараг боломжгүй байна. Энэ төрлийн цэцэрлэгийн үйлчилгээг дэмжих, БНХБ-ын санхүүжилтийн талаар шийдвэр гаргахдаа бүх талын өртөг ба үр ашгийг нарийвчлан тооцоолж, үүнд бас БНХБ-ын хувилбарт арга барил буюу олон нийт, гэр бүлд суурилсан хэлбэр, аргуудыг тооцож үзэх хэрэгтэй.

Гэр хороололд байршилтай хувийн цэцэрлэгийн хоцрогдол нь Улаанбаатар хотын гэр хорооллын ба гэр хорооллын бус хувийн цэцэрлэгүүдийн чанарын ялгаатай холбоотой байна. 2-р бүлэгт хувийн цэцэрлэгүүд чанарын хувьд дунджаар төрийн өмчийн ердийн цэцэрлэгүүдийнхтэй ижил түвшинд байгаа боловч Улаанбаатар хотын гэр хорооллын бус газруудын чинээлэг өрхүүдэд үйлчилж байгаа хувийн цэцэрлэгүүд гэр хороололд байршилтай цэцэрлэгүүдээс илүү чанартай үйлчилгээг үзүүлж байна. Энэ бүлэгт гэр хорооллын хувийн цэцэрлэгүүдийн бага насны хүүхдийн хөгжлийн үр дүнгүүд гэр хорооллын бус цэцэрлэгүүдээс хоцорч байгааг тодруулсан. Энэ нь чанар ба үр дүнд нөлөөлж байгаа хүчин зүйлс нь төрийн өмчийн цэцэрлэгүүдийнхээс өөр байна гэдгийг харуулж, цаашид БНХБ-ын үйлчилгээг үзүүлэхэд хувийн цэцэрлэгүүдийн оролцоог нэмэгдүүлэхдээ нэлээд анхааралтай хандах шаардлагатайг нотолж байна.

Бага насны хүүхдийн хөгжлийн үр дүнгүүд нь жэндэр, яс үндэс, хөгжлийн бэрхшээлтэй холбоотой хоцрогдлыг тодруулж байна. Хэл яриа, гүйцэтгэх чадвар болон жижиг булчингийн хөгжилд эрэгтэй хүүхдүүд тааруу байгааг нарийвчлан судлах хэрэгтэй. Учир нь насанд хүрсэн эрчүүдийн боловсролын түвшинг харахад эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс боловсролын хувьд “хойно” байна. Гэр бүл эсвэл сургуулийн орчинд байгаа нийгэм, соёлын аливаа хүчин зүйлсийн тоон судалгаа нь жэндэрийн ялгааг ойлгоход тусалж болох юм. Мөн казах хүүхдүүд хэл яриа ба нийгэм-сэтгэлийн хөдөлгөөний айд бусад хүүхдүүдээс багагүй хоцорч байгаа бол ханган нийлүүлэлттэй холбоотой хүчин зүйлсийг хянаж үзсэний дараа тус зөрүү арилж байна. Тэгэхээр чанарын үр дүнг зорилтот бүлгийн хувьд сайжруулснаар үндэсний цөөнхөд ажиглагдах хоцрогдлыг арилгаж болно гэдгийг энэ жишээ харуулж байгаа нь сайшаалтай хэрэг юм. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тусгай хэрэгцээнд зориулсан арга хэмжээ байх ёстой.

⁴³Хугацааг нь хоёр дахин нэмэгдүүлэхэд одооны нэг гэр цэцэрлэгийн урсгал зардал 658 сая орчим төгрөгийн нэг жилийн зардлыг хоёр дахин нэмнэ. Нэг жилийн нэг цэцэрлэгт ногдох төгрөг (бүлэг 1) 1,030 сая гаруй төгрөг болсноор гэр цэцэрлэгүүд нь нэг хүнд ногдох зардлын хувьд ердийн цэцэрлэгээс илүү зардалтай болж байгаа юм.

Бүлэг 4. Цаашид авах голлох арга хэмжээ

Энэхүү тайлангийн өмнөх бүлгүүдэд бид цэцэрлэгийн чанар ба Монгол хүүхдүүдийн бага насны хөгжлийн үр дүнг хэлэлцэж, хөгжлийн ижил түвшний улс орнуудтай харьцуулахад харьцангуй өндөр хувьтай байдаг Монгол улсын БНХБ-д хийж буй хөрөнгө оруулалтын үр нөлөө, эрх тэгш байдлыг үнэлэн дүгнэсэн юм. Тус дүн шинжилгээнээс харахад улсын хэмжээнд СӨБ-ын хүртээмжийг сайжруулах талаар ихээхэн ахиц гарсан боловч хамгийн их хоцрогдолтой, эмзэг бүлгийн хүүхдүүд үйлчилгээний гадна байсаар байна. Үүнээс гадна хөгжлийн үр дүнгийн судалгаа хийхэд төрийн өмчийн СӨБ-ын үйлчилгээнд удаан хугацаагаар хамрагдсан ч гэсэн нийгэм-эдийн засгийн түвшний ялгаа үр дүнд маш ихээр нөлөөлсөөр байна. Гэвч үнэ өртөг багатай хэдий ч өндөр үр ашгийг авчрах боломжуудыг эрж хайх хэрэгцээ байсаар байна. Үүний гол түлхүүр нь СӨБ-д хамрагдаагүй хөдөө орон нутгийн хүүхдүүдийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг сайжруулахын тулд гэр бүл эсвэл олон нийтэд суурилсан БНХБ-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, жишээ нь ЯХИС-ийн хэрэгжүүлсэн гэр бүлд суурилан хүүхдийг сургуульд бэлтгэх хөтөлбөр юм. Өөр нэг гарц бол хот суурин газруудад хувийн хэвшлийн СӨБ-ын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх явдал юм. Хүснэгт 4.1-д санал болгож буй голлох үйл ажиллагаануудыг нэгтгэн харуулж, цаашид анхаарах зүйлс, зөвлөмжүүдийн тухай өгүүлэх болно.

Хүснэгт 4.1 Монгол улсад БНХБ-ын хүртээмж, чанарыг сайжруулахад авах голлох арга хэмжээ

Гол арга хэмжээ	Хэрэгжүүлэх арга зам	Хүсч буй үр дүн, үр нөлөө
1. Хөдөө орон нутгийн БНХБ-ын хүртээмжийг сайжруулах	Гэр бүлд болон олон нийтэд түшиглэсэн хөтөлбөр	Малчид гм хүрч үйлчлэхэд хүндрэлтэй өрхийн бага насны хүүхдүүдийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг сайжруулах
	Гэр цэцэрлэгийн давуу, сул талуудыг бусад БНХБ-ын хөтөлбөрүүдтэй харьцуулах	БНХБ-д зарцуулж байгаа төсвийн зарцуулалтын үр нөлөөг сайжруулах; малчдын бага насны хүүхдүүдийн БНХБ-ын үйлчилгээний хүртээмжийг сайжруулах
2. Хот суурин газарт СӨБ-ын үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, ингэхдээ хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх	Төрийн өмчийн болон хувийн хэвшлийн цэцэрлэгийн үйлчилгээг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалт хийх	БНХБ-ын хүртээмж сайжрах; нэг бүлэгт байх хүүхдийн тоо хэт олон байгааг багасгах.
	Хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэхдээ чанарыг сайжруулах, урамшууллын системийг бий болгох	Хувийн хэвшлийн чанарын ялгааг арилгах
3. Хөдөө орон нутаг руу чиглэсэн хөрөнгө оруулалтаар дамжуулан төрийн өмчийн ердийн цэцэрлэгүүдийн чанарыг сайжруулах	Чанарын баталгаажилтын механизмыг бий болгох	Чанарын стандартын биелэлтийг хянаж, чанарын үнэлгээг тогтмол хийх
	Чанарыг сайжруулахдаа хөдөө орон нутаг руу чиглэх	Одоо байгаа төрийн хөрөнгө оруулалтын эрх тэгш байдал, үр нөлөөг сайжруулах
	Математик, тооны орчныг сайжруулах	Танин мэдэхүйн үр дүнг сайжруулах
4. Чухал асуудлуудыг хөндөж байгаа хэсгүүдийг илүү гүн судлах	Одоогоор цэцэрлэгийн бүлгүүдэд байгаа хүүхдийн суралцах буланг ашиглан тоо, үсэг таниулах боломжийг нэмэгдүүлэх	Танин мэдэхүй, хэл ярианы хөгжлийн айн үр дүнд ажиглагдаж байгаа нийгэм-эдийн засгийн түвшний ялгааг арилгах
	БНХБ-ын санхүүжилтийн норм ба эцэг эхийн төлөх төлбөр Бага насны боловсрол дахь хөвгүүдийн хоцрогдол Үндэсний цөөнх ба хөгжлийн бэршээлтэй холбоотой тусгай хэрэгцээ	Төрийн хөрөнгө оруулалтын тэгш байдлыг сайжруулах зорилтот арга хэмжээг зөв боловсруулахад шаардагдах мэдээллээр хангах

Гол арга хэмжээ 1: Олон нийт болон гэр бүлд суурилсан БНХБ-ын туршин хэрэгжүүлсэн хөтөлбөрүүдээр дамжуулан хөдөө орон нутагт БНХБ-ын хүртээмжийг сайжруулах

Хөдөө орон нутаг руу чиглэсэн арга барилаар дамжуулан БНХБ-ын үйлчилгээний хүртээмжийн тэгш бус байдлыг яаралтай арилгах хэрэгтэй байна. Энэхүү тайланд Монгол улсын хөдөө орон нутагт СӨБ-ын үйлчилгээний хүртээмж хангалтгүй хэвээр, мөн СӨБ-д хамрагдаагүй хүүхдүүд нийгэм-эдийн засгийн байдлын хувьд хамгийн доогуур түвшинд байна гэдгийг ОУБТС-ны мэдээлэлд үндэслэн өгүүлсэн. Гэхдээ цэцэрлэгт хамрагдаж байгаа ч амьжиргааны түвшин доогуур байгаа өрхүүдийн хүүхдүүдийн хөгжлийн үр дүн доогуур байна гэдгийг энэхүү тайлан тодруулж байгаа юм. Тиймээс СӨБ-д хамрагдаагүй эсвэл богино хугацаанд хамрагдсан хүүхдүүдийн хөгжлийн үр дүн энэхүү тайланд өгүүлснээс ч дор байж болох юм. Эндээс дүгнэхэд, СӨБ-д удаан хугацаанд хамрагдсан хүүхдүүд богино хугацаанд хамрагдсан хүүхдүүдээс харьцангуй өндөр хөгжлийн үр дүнг үзүүлж, энэ нь өрхийн, хувь хүний ба цэцэрлэгийн түвшний хүчин зүйлсийг хянасны дараа ч тогтвортой байна. Судалгааны явцад тодорхойлсон хөгжлийн зөрүүг анхаарч үзэхгүй бол цаг хугацаа өнгөрөх тусам улам нэмэгдэх хандлагатай байна. Энэ тухай одоогийн бичил-эдийн засгийн хэвлэлүүдэд бичсэнээс үзэхэд бага насны хүүхдийн танин мэдэхүй ба танин мэдэхүйн бус чадварууд насан туршийн урт хугацааны үр нөлөөтэй байдаг ажээ. Хөдөө орон нутагт болон СӨБ-ын үйлчилгээ хангалтгүй байгаа орон нутагт үйлчилгээний хүртээмжийг сайжруулах явдал нь улсын нэн тэргүүний асуудал байх ёстой.

Малчин өрхүүд зэрэг хүрч үйлчлэхэд хүндрэлтэй хүн амын бүлгүүд буюу зорилтот бүлгүүдэд чиглэсэн олон нийт болон гэр бүлд суурилсан СӨБ-ын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх боломжийг судлах хэрэгтэй. Энэхүү тайлангийн дүн шинжилгээнд хүүхдийг ном унших, дуу дуулах, тоглох зэрэг үйл ажиллагаанд цэцэрлэгээс гадуур буюу гэр бүлийн орчинд оролцуулах нь танин мэдэхүй ба хэл ярианы хөгжлийг дэмждэг болохыг тодруулсан. Эдгээрээс харахад цаашид бага насны хүүхдийн хөгжлийн гэр бүлийн орчныг сайжруулахад чиглэсэн, чанарын зохих шаардлагыг хангасан олон нийтийн оролцоотой арга хэмжээнүүдийг өргөжүүлэх боломжтой юм. Үнэхээр ч одоогоор ЯХИС-аас хэрэгжүүлж буй гэр бүлд суурилсан хүүхдийг сургуульд бэлтгэх хөтөлбөрт (хайрцаг 4.1) эцэг эхчүүд унших материал их ашигладаг болсон, бусадтай харилцах болон өөртөө итгэх чадварууд нь нэмэгдсэн гэх мэдээллийг олон давтамжтай өгсөн байна. Тус хөтөлбөрийг санамсаргүй түүвэр, туршилт судалгааны арга, БНХБ-ын үр дүнгийн суурь ба эцсийн үзүүлэлтийг хэмжих зэргээр нарийвчлан судлаагүй боловч үнэлгээний мэдээллээс харахад гэр цэцэрлэгийн оролцоотой харьцуулахад ЯХИС-ийн хөтөлбөрийн хамрагдалт сайн үр дүнтэй байсан нь гэр бүлийн орчин БНХБ-ыг дэмжсэн байдалтай, бага насны хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд гэр бүлийн гишүүдийн оролцоо нэмэгдсэн, мөн хөгжлийн бүхий л айд нийгэм, эдийн засгийн байдал ба хувийн шинж чанаруудыг хянасны дараа ч өндөр үр дүнтэй гарсантай холбоотой байв. Энэ үр дүн нь 1-р ангийн багш нараас авсан албан бус мэдээлэлтэй таарч байна. Учир нь бага ангийн багш нар *энэ хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүд амьжиргааны ижил түвшнийх боловч СӨБ-д хамрагдаагүй эсвэл богино хугацаанд хамрагдсан хүүхдүүдтэй харьцуулахад сургуульд бэлтгэгдсэн байдал нь нэн сайн байдаг* гэжээ. Гэр цэцэрлэг ба ЯХИС-ийн хөтөлбөрт хамрагдаж байсан

хүүхдүүдтэй ажиллаж байсан туршлагатай багш нар ЯХИС-ийн хөтөлбөрийн хүүхдүүд сургуульд бэлтгэгдсэн байдлаар илүү хэмээн мэдээлжээ ⁴⁴.

Баримт 4.1: Гэр бүлд суурилсан сургуульд бэлтгэх хөтөлбөрийн хоёр жишээ

Монгол улсын хөдөө орон нутгийн сургуульд элсэн орох гэж буй хүүхдүүдэд зориулсан гэр бүлд суурилсан сургуульд бэлтгэх хөтөлбөр

Японы Хүүхдийг Ивээх сан 2012-2017 онд "Алслагдсан хөдөөгийн малчдын хүүхдүүдийн бага боловсролын үр дүнг сайжруулах нь" төслийг Японы Нийгмийн Хөгжлийн Сангийн (ЯНХС) тэтгэлэгтэйгээр хэрэгжүүлсэн юм. Төслийн гурван чухал бүрэлдхүүний нэг нь "Орон нутгийн бага сургуульд элсэн орох гэж буй хүүхдүүдийг (5-6 насны) сургуульд бэлтгэх хөтөлбөрүүдийг сайжруулах" бүрэлдхүүн хэсэг байв. Энэ бүрэлдхүүн хэсэг нь гэр бүлд суурилсан сургалтын хөтөлбөр, чадавх бэхжүүлэх ба техникийн дэмжлэг үзүүлэх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээгээр дамжуулан гэр бүлд суурилсан сургуульд бэлтгэх хөтөлбөрийг дэмжих зорилготой байлаа. Төсөл дөрвөн аймгийн 30 суманд хэрэгжсэн.

Үүнд эцэг эхчүүд багшийн үүргийг гүйцэтгэдэг. Эцэг эхчүүдэд аргагүйн зөвлөмж, удирдамж өгөхийн зэрэгцээ эцэг эхийн гарын авлага, хүүхдийн дасгал ажлын дэвтэр зэргээр хангадаг. Түүнчлэн эцэг эх ба хүүхдэд аль алинд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор цахим хэрэгслээр (дуу шүлэг болон үйл ажиллагааны заавар гэх мэт бичлэгтэй) хангадаг. Өдөрт 20-30 минут, долоо хоногт 3-4 цагийг хүүхдүүдтэйгээр үр бүтээлтэй хамтдаа өнгөрөөхийг эцэг эхчүүдэд зөвлөдөг.

Гэр бүлийн орчинд тоглоом, номын дэмжлэгтэйгээр сургуулийн бэлтгэлийг сайжруулахын тулд явуулын "Тоглоом ба номын багц" –ыг санаачилсан юм. Тус бүрдээ 10 хүүхдийн ном, 3 тоглоомын багцтай арван хайрцгийг төслийн хүрээнд сонгогдсон сумын төвийн цэцэрлэгт хуваарилан өгсөн. Эцэг эхчүүд энэхүү багцыг нэг нэгээр нь гэртээ авчирдаад, хүүхэдтэйгээ 1-2 долоо хоногийн турш хичээллэхэд тоглож ашиглана. Эцэг эх бас хүүхдийнхээ хөгжлийн талаарх тэмдэглэлийг тусгай дэвтэрт бичнэ. Ингэхдээ эцэг эхчүүд тус дэвтрийн асуултанд хариулж, хүүхдүүд нь эцэг эхийнхээ уншиж өгсөн үлгэрийн тухай зураг зурдаг байна. Ингээд эцэг эхчүүд номын багцаа солихоор сумын цэцэрлэг дээр ирэх үед номын санч дэвтрийн тэмдэглэлийг шалгаж зөвлөдөг. Хөтөлбөрийн төгсгөлд хүүхэд бүр танин мэдэхүй ба хэл ярианы хөгжлийг дэмжих 30 шинэ тоглоомоор тоглож, 100 ном уншсан байдаг.

Хүүхдүүдийн танин мэдэхүй, зан төлөв, бие махбод ба нийгэм-сэтгэлийн хөдөлгөөний хөгжлийг хөтөлбөрийн эхэн ба төгсгөлд асуумжаар үнэлдэг. 96 хоногийн турш үргэлжлэх хөтөлбөрийн төгсгөлд сумын цэцэрлэгт ажилладаг зөвлөх багш үнэлгээг хийж, хүүхдийн дасгал ажлын дэвтэр, ном ба тоглоомын багцын ашиглалтыг үнэлдэг. Өвөрхангай аймгийн Уянга суманд (2015 оны 5 сард цуглуулсан мэдээлэл) тус хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүдийн хөгжил ерөнхийдөө 26 пунктээр нэмэгджээ (үнэлгээний тайлан ба мэдээлэл хараахан гараагүй байна)⁴⁵.

⁴⁴ Багш нараас цуглуулсан мэдээллээр гэр цэцэрлэгт хамрагдсан хүүхдүүдийн хөгжлийн үр дүн холимог насны, үргэлжлэх хугацаа хугацаа богино байдаг зэргээс шалтгаалан эцэг эхтэйгээ хамтдаа гэрийн бүлийн орчинд 5-6 сарын турш "хичээллэсэн" ЯХИС-ийн хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүдийн үр дүнгээс доогуур байхад хүргэдэг гэжээ.

⁴⁵Тус хөтөлбөр нь СӨБ-ын үйлчилгээг хүргэх шинэлэг санааг Монгол улсад ажил хэрэг болгосон юм. Уг хөтөлбөр нь гэр бүл, сумын сургууль, цэцэрлэгүүдийг холбосон Олон Нийтийн Боловсролын Зөвлөлийг (ОНБЗ) бий болгосон. Хөтөлбөрт зориулан зөвлөх багш нарыг бэлдсэн нь эцэг эхчүүдийг чиглүүлэх, хүүхдийн хөгжлийн түвшинг үнэлэхэд чухал үүрэгтэй байна. Энэхүү төслийг хэрэгжиж эхлээс өмнө сумдад гэр бүл,

Турк улсын "Эх-хүүхдийн боловсролын хөтөлбөр"-ийг үндэсний хэмжээнд нэвтрүүлэх болсон нь

Турк улсад маш амжилттай хэрэгжиж байсан Эх Хүүхдийн Боловсролын Хөтөлбөр (ЭХБХ)-ийг саяхан өргөжүүлэхээр болсон нь ээжүүд болон 5-6 настай хүүхдүүдэд зориулсан 25 долоо хоногийн хөтөлбөр юм. Тус хөтөлбөр нь хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн ерөнхий байдал, ээжийн сургуулийн үйл ажиллагаанд оролцох сонирхол, өөртөө итгэх итгэл ба нөхөртэйгээ харилцах харилцаанд эерэг нөлөөлсөн байна. Эх Хүүхдийн Боловсролын Сан (ЭХБС) сургалтыг зохион байгуулах сургагч, орон нутгийн зохицуулагч, зөвлөх багш нарын сургалтыг хийж, хөтөлбөрийн ерөнхий менежмент, чанарын хяналтыг хариуцсан байна. Туркийн Үндэсний Боловсролын яам (ТҮБЯ)-аас ЭХБС-ийн сургалтаар бэлтгэгдэх сургагч, бүлгийн удирдагч нарыг гарган өгч, Турк улс даяар 500 гаруй насанд хүрэгчдийн боловсролын төвүүдэд сургалт явуулах боломжоор хангажээ. Дэлхийн банк тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх эхний шатны санхүүжилтийг олгожээ. 1993-2010 оны хооронд ЭХБС нь 1100 гаруй бүлгийн удирдагч, 150 орон нутгийн зохицуулагчийг бэлдэн, ЭХБХ-ийг Туркийн 81 мужийн 71-д нь хүргэж, нийтдээ 310000 гаруй ээж, хүүхдүүдэд хүрсэн байна. Энэ үеэр төслийн удирдлага болон хэрэгжилтэд нийт 17 сая ам. долларыг зарцуулсан нь дунджаар нэг үр шим хүртэгчид 56 ам. доллар ногдож байгаа юм. 2010 онд ЭХБХ-ийг үндэсний хэмжээнд нэвтрүүлж, ТҮБЯ-ны ЭХБС-ийн дэмжлэгтэйгээр боловсруулсан Үндэсний Гэр бүлийн Хөтөлбөрт оруулан, цар хүрээг нь улам тэлсэн юм. ТҮБЯ-ны хөтөлбөрт багтан өөрчлөгдөхөөс ч өмнө нэг үр шим хүртэгчид ногдох зардал 40 ам.доллар болж буурсан нь өмнөх жилүүдэд энэхүү тогтолцоонд оруулсан хөрөнгө оруулалт ба төслийн эдийн засгийн тооцоо, бүх зүйлс тогтсон байсны ач тус юм.

Турк улсаас гадна байгаа улсуудын хувьд орон нутгийн хамтын ажиллагаагаар дамжуулан ЭХБХ-ийг англи, араб, испани хэл дээр орчуулж, Европ (Бельги, Франц, Швейцар), Ойрхи Дорнод (Бахрэн, Иордан, Ливан, Саудын Араб) ба Латин Америкийн (Мексик) 12000 ээж, хүүхдүүдэд хүргэжээ. ЭХБХ-ийн агуулга, аргагүй нь мөн ЭХБС-гаас эцэг эхийн (аавуудыг оролцуулан) болон насанд хүрэгчийн сургалт, түүнчлэн зурагт/интернэт/гар утсанд суурилсан зэрэг БНБХ-ын нэмэлт хөтөлбөрүүдийг боловсруулахад хүргэжээ. Өмнө хэрэгжүүлсэн зөвхөн биечлэн ажиллах хөтөлбөрөөр л гэхэд ЭХБС 1 сая гаруй үр шим хүртэгчдэд хүрч, Турк улс болон бусад 13 улс орнуудад энэхүү сургалтыг түгээн дэлгэрүүлэх бүлгийн ахлагч нарыг ойролцоогоор 10000-ыг бэлдсэн байна (дээр нэрлэсэн найман улсын зэрэгцээ Герман, Нидерланд, Хойт Киприйн Бүгд Найрамдах Турк Улс, Их Британи, Лаос зэрэг улсад).

Гэр цэцэрлэгийн үйлчилгээг алслагдсан орон нутгийн хүн амд хүргэх, санхүүжүүлэх төлөвлөгөөг боловсруулахдаа бусад БНБХ-ыг дэмжих хөтөлбөрийн үнэ өртөг, ашиг тустай харьцуулж үзэх хэрэгтэй. Монгол улс сүүлийн хэдэн жилүүдэд гэр цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх асуудлаар ахиц дэвшлийг гаргаж, алслагдсан орон нутгийн иргэддээ хүрч ажиллах, үйлчилгээг хүргэхийн төлөө хичээнгүйлэн ажиллаж байна. Гэр цэцэрлэгийн үйлчилгээг эцэг эхчүүд баяртайгаар хүлээн авч байгаа төдийгүй тэдний сэтгэл ханамж өндөр байсан. Малчин өрхийн хүүхдүүдийн ихэнхийн хувьд гэр цэцэрлэг нь

цэцэрлэг, сургуулийг холбох механизм бүтэц байсангүй, ОНБЗ-ийг байгуулж ажиллуулснаар хүүхдийн СӨБ-оос бага боловсрол руу шилжих шилжилтийн үе шатыг дэмжихэд үр дүнтэй болсон.

СӨБ-д хамрагдах, ялангуяа нийгэм-сэтгэлийн хөдөлгөөний чадвараа хөгжүүлэх цорын ганц боломж юм. Нийгэм-сэтгэлийн хөдөлгөөний хөгжил нь хүүхэд гэр бүлээс гадна өөр “нийгмийн орчинд” орсноор илүүтэй дэмжигдэн хөгждөг жамтай. Өмнөх бүлгүүдэд гэр цэцэрлэгийн үргэлжлэх хугацаа богино, суралцах орчны чанар тааруухан байдаг нь тус цэцэрлэгт хамрагдаж байгаа хүүхдүүдийг нийтлэгээр төрийн өмчийн ердийн цэцэрлэгийн хүүхдүүдийн хөгжлийн ахиц, үзүүлэлтүүдтэй ижил хэмжээнд очих боломжгүй гэдгийг өгүүлсэн. Гэхдээ гэр цэцэрлэгийн үргэлжлэх хугацааг нь уртасгахад үнэ өртөг нь байж боломгүй ихээр нэмэгдэнэ гэдэгт гол асуудал оршиж байна. Мөн зай багтаамж хангалтгүй, үйл ажиллагааг зохион байгуулахад тулгардаг сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийн хангамжийн асуудал нь чанарын ялгааг арилгахад боломжгүй нөхцөлд хүргэж байна. Цаашид гэр цэцэрлэгийн үйлчилгээг өргөжүүлэх шийдвэр гаргахдаа бүхий л өртөг ба үр ашгийг нарийвчлан тооцоолохын зэрэгцээ БНХБ-ын хувилбар болох гэр бүл, олон нийтэд суурилсан аргуудыг бодолцох хэрэгтэй.

Гол арга хэмжээ 2: Хот суурин газруудад хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлснээр цэцэрлэг буюу СӨБ-ын хүртээмжийг нэмэгдүүлэх

Хот суурин газруудад, ялангуяа Улаанбаатар хотод төрийн өмчийн болон хувийн хэвшлийн цэцэрлэгүүдийн тоог нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтыг хийх нь СӨБ-ын хүртээмжийг сайжруулах боловч үнэ өртгийг нь сайтар судлах хэрэгтэй. Хот суурин газруудад цэцэрлэгийн үйлчилгээг нэмэгдүүлж болох бөгөөд үүнийг төрийн өмчийн цэцэрлэгүүдийг шинээр барьснаар хэрэгжүүлж болох юм. Нийт хүүхдүүдийн 28 хувь нь 3-5 насны хүүхдээс бүрдэж байгаа нийслэл хотын хувьд энэ үнэхээр хэрэгтэй зүйл юм. Хот суурин газрууд хүн амын нягтаршил ихтэй учраас хөдөө орон нутагтай харьцуулахад үйлчилгээний үнэ өртөг нь бага байх магадлалтай боловч БНХБ-ын үйлчилгээний зарцуулалт одоогоор ч өндөр байгаа нь энэ талаар сайн бодолцож үзэх хэрэгтэйг харуулж байна⁴⁶. Монгол улсын хот суурин газруудад хувийн хэвшлийн цэцэрлэгийн үйлчилгээ ихээхэн өсөлттэй байгаа тухай тайлангийн өмнөх бүлгүүдэд өгүүлсэн. Тиймээс хувийн цэцэрлэгүүдэд улсаас санхүүгийн дэмжлэг үзүүлэх нь хүртээмжийг нэмэгдүүлэх бас нэгэн зохистой арга байж болох юм. Гэвч хувийн цэцэрлэгүүдийг өргөжүүлэхэд тулгарч байгаа асуудлуудыг илүү сайтар судлах хэрэгтэй.

Улаанбаатар хотын гэр хороолол ба гэр хорооллоос бусад газруудын хувийн цэцэрлэгүүдийн чанарын ялгаа нь зөвхөн хамрагдалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн бус, чанарыг эрхэмлэсэн урамшууллын системийг бий болгох шаардлагатайг тодруулж байна. Энэхүү тайланд хувийн цэцэрлэгүүд чанарын хувьд ерөнхийдөө улсын цэцэрлэгүүдтэй адилхан байгаа боловч Улаанбаатар хотын гэр хорооллоос бусад газрын чинээлэг өрхүүдэд үйлчилж байгаа хувийн цэцэрлэгүүд гэр хорооллын ядуу өрхүүдэд үйлчилж байгаа цэцэрлэгүүдээс чанарын хувьд илүү байгааг харуулсан. Гэр хорооллын хувийн цэцэрлэгийн хүүхдүүд гэр хорооллын бус хүүхдүүдээс харьцангуй хоцорч байгаа нь судалгааны дүн шинжилгээгээр илэрсэн. Тиймээс хувийн цэцэрлэгүүдийн үүрэг оролцоог нэмэгдүүлэхийн хамт үйлчилгээний чанар сайн байх, чанарын ялгааг арилгах зэрэг асуудалд онцгойлон анхаарч зарим зохистой урамшууллын системийг боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байна. Мөн хувийн цэцэрлэгүүдийн үйлчилгээний чанарыг

⁴⁶Энэ тайланг бичих үед аймаг ба нийслэлийн түвшинд нарийвчилсан задаргаа бүхий төсвийн зарцуулалтын мэдээлэл байхгүй байсан учир үнэ өртгийг тооцоолох боломжгүй байв.

сайжруулахад бэрхшээл учруулж буй хүчин зүйлсийг тодруулах судалгааг өргөн хүрээнд хийх хэрэгтэй байна.

Гол арга хэмжээ 3: Хөдөө орон нутаг руу чиглэсэн хөрөнгө оруулалтаар дамжуулан төрийн өмчийн ердийн цэцэрлэгийн чанарыг сайжруулах

Чанарын стандартын хэрэгжилтийг хянах, төрийн өмчийн болон хувийн хэвшлийн цэцэрлэгүүдийн чанарыг үнэлэх, чанар баталгаажуулалтын механизм хэрэгтэй байна. Монгол улсад чанарын бүтцийн болон үйл явцын талуудыг удирдан чиглүүлэх норм, стандартууд аль хэдийн боловсруулагдсан байна. Гэвч эдгээр норм, стандартыг мөрдөх, хэрэгжүүлэх болон чанарын үнэлгээг тогтмол хийхгүйгээр цаашид хөрөнгө оруулалтыг оновчтой хийхэд шаардлагатай чиглэлүүдийг тодорхойлох боломжгүй юм. Энэхүү тайланд тодруулсан чанарын ялгаанууд цаашид улам нэмэгдэж, даамжрахаас сэргийлэх, мөн нэн чухал хэрэгцээнүүд рүүгээ хөрөнгийн эх үүсвэрээ чиглүүлэхийн тулд БСШУСЯ нь нутаг дэвсгэрийнхээ янз бүрийн хэсэгт байрлаж байгаа төрийн өмчийн болон хувийн цэцэрлэгүүдийн чанарыг тогтмол хянах механизмыг бий болгох хэрэгтэй байна. Тухайлбал, цэцэрлэгийн түвшинд ашиглаж болох чанарын онооны картыг боловсруулж болох юм. Онооны картаар дамжуулан цуглуулсан мэдээллийг аймгийн эсвэл тухайн орон нутгийн боловсролын газар, хэлтэст нэгтгэж, БСШУСЯ-д хүргэж болох юм. Ингэхдээ жил бүрийн боловсролын салбарын статистикийн мэдээллийн эмхэтгэлийг гаргахад ашигладаг мэдээлэл солилцооны журмыг баримталж болно.

Төрийн хөрөнгийн хуваарилалтын тэгш байдал, үр нөлөөг нэмэгдүүлэхийн тулд чанарыг сайжруулах аливаа үйл ажиллагааг хөдөө орон нутаг руу чиглүүлэх нь зүйтэй. Уг тайланд Монгол улсад хүүхдийн хөгжлийн үр дүнд цэцэрлэгийн чанар чухал нөлөө үзүүлж байгааг харуулсан боловч цэцэрлэгүүдийн наад зах нь гуравны нэг ба түүнээс дээш хувийнх нь чанар муу байна (хүснэгт 2.6). Чанар тааруу цэцэрлэгүүдийн олонхи нь хөдөө орон нутагт байна. Сүүлийн жилүүдэд хэрэгжүүлж буй СӨБ-ын чанарын шинэчлэл хөтөлбөр нь зөв чиглэл рүү явж буй оновчтой алхам боловч, цэцэрлэгүүдийг хэт нийтлэг байдлаар харж, чанарын шинэчлэл хийх хамгийн шаардлагатай хэсэг болох хөдөө орон нутгийн цэцэрлэгүүд рүү чиглэсэн анхаарал зарим талаар сарниж байна. Хөдөө орон нутгийн цэцэрлэгүүдийг хамруулсан аливаа арга хэмжээ, хөтөлбөрүүд нь хүүхдийн хөгжлийн үр дүнд ажиглагдаж буй хот, хөдөөгийн ялгааг арилгахад тус дэм үзүүлэх юм.

Үйлчилгээний чанарыг сайжруулах арга хэмжээ нь цэцэрлэгүүдийн математик, тооны орчинд анхаарах ёстой. Тус улсын цэцэрлэгүүд математик, тооны айн хөгжлийн үзүүлэлтүүдэд хамгийн бага үнэлгээ авсан. Яамнаас хэрэгжүүлж байгаа чанарын шинэчлэлийн ажил нь багш нарыг хүүхдийн нийгэм-сэтгэлзүйн хөдөлгөөн, хэл ярианы хөгжлийг дэмжихийг илүүтэй анхаарч байна. Тухайлбал, саявтархан цэцэрлэгүүдийг шинэ ном, гадаад хэлний сургалтын хэрэглэгдэхүүн материалаар хангасан байна. Харин танин мэдэхүйн хөгжлийг дэмжих талын асуудлыг хойш тавьж, гүйцэтгэх чадварыг бүр орхигдуулсан байна. Гэвч яг асуудалд нийгэм-эдийн засгийн байдал болон өрхийн бусад хүчин зүйлс нь СӨБ-ын хамрагдалт, цэцэрлэгийн чанараас илүү ихээр нөлөөлдөг болохыг бидний судалгааны түүвэр харуулсан. Хөдөө орон нутаг руу чиглэсэн хөтөлбөр, түүний дотор математикийн айн хөгжлийг дэмжих нь хүүхдийн хөгжлийн хот, хөдөөгийн ялгааг арилгахад тусална.

Танин мэдэхүй ба хэл ярианы айн хөгжлийн нийгэм-эдийн засгийн түвшнээс хамаарах ялгааг бага насанд нь арилгахгүй бол цаашид улам нэмэгдэнэ гэдгийг анхаарч, одоогоор ашиглаж байгаа тоо тоолол болон уншиж, бичихэд бэлтгэх, таниулах аргуудыг эргэн харах хэрэгтэй. Математик ба хэл ярианы айд ажиглагдаж байгаа нийгэм-эдийн засгийн байдлаас хамааралтай томоохон ялгаа нь улсын цэцэрлэгүүдийн хүүхдүүд янз бүрийн түвшинд байна гэдгийг харуулж байна. Дэлхий дахины туршлагаас харахад эдгээр зөрүү нь арилахгүй байсаар, сургуульд орох үед ч хэвээр байдаг байна. Монгол улсын СӨБ-ын албан ёсны сургалтын хөтөлбөрт тоо, үсэг таниулах зорилго, үйл ажиллагаа багтаагүй боловч амьжиргаа сайтай айлын хүүхдүүд эдгээрийн талаар боломжийн мэдлэгтэй байна. Суралцах чадварын ялгаа нь тун бага наснаас эхэлж, нийгэм-эдийн засгийн байдлаас ихээхэн хамаардаг бөгөөд СӨБ-д удаан хугацаанд хамрагдсан ч энэ зөрүү хэвээр байдгийг энэхүү тайлан нотолж байна⁴⁷. Ядуу өрхүүдийн хүүхдүүд хожим өсөж том болоод бусад хүүхдийг гүйцэх магадлалаар бага байдаг бол одоогийн цэцэрлэгийн орчин эдгээр ялгааг арилгахад төдийлөн тус нэмэр болохгүй байна. Эдгээр зөрүүг арилгахын тулд хөгжүүлэх үйл ажиллагааны арга зүй, ялангуяа математик, гүйцэтгэх чадвар, хэл яриаг хөгжүүлэх үйл ажиллагааны аргуудыг эргэн харах шаардлагатай байна. Гэхдээ энэ нь хүүхдүүдийг "залхтал" тоо цээжлүүлэх, хэт шахах орчныг бий болгоно гэсэн үг биш юм. Монгол улсын цэцэрлэгүүд хүүхэд төвтэй арга зүйг ашиглаж байгаа бөгөөд энэ чиг хандлага нь цаашид хэвээр үргэлжлэх, сайжрах ёстой.

Төрийн өмчийн цэцэрлэгийн нэг бүлэгт байх хүүхдийн тоог бууруулах нь СӨБ-ын үр нөлөөг сайжруулах боловч төрийн өмчийн ердийн цэцэрлэгийн үйлчилгээг өргөжүүлэхийг шаардана. Манай судалгааны төрийн өмчийн ердийн цэцэрлэгийн түүвэрт хамрагдсан бүлгүүдийн хэмжээ нь үнэлгээний оноонд чухал нөлөө үзүүлсэнгүй. Энэ нь ихэнх цэцэрлэгийн бүлгүүд хэтэрхий олон хүүхэдтэй, хамгийн багадаа нэг бүлэгт 21 хүүхэдтэй байсан. Тийм учраас бидэнд 20 буюу түүнээс доош тооны хүүхэдтэй бүлэгт хүүхдүүд илүүтэй хөгждөг эсэх талаар мэдээлэл цуглуулах боломж байсангүй. Гэвч үүнээс гадна, өмнө дурьдсанчлан ЕСЕMI үнэлгээний Үйл ажиллагаа, Орон зай ба Харилцааны дэд хэмжүүрүүд нь анги дүүргэлт хэтэрсэнтэй холбоотой саад бэрхшээлийг харуулж байсан учир эдгээр чанарын оноог регресс т оруулахад тус үр нөлөө нь харагдаж байсан. Эцэст нь хэлэхэд Монгол улсын цэцэрлэгүүд дэндүү олон хүүхэдтэй ажиллаж, тавьж болох хязгаарыг аль хэдийн давсан учир цэцэрлэгийн бүлгийн тоо хөгжлийн үр дүнд хамаагүй болсон байж болох юм. Ямартай ч, нэг бүлэгт хэт олон хүүхэд байх нь багш хүүхэд нэг бүртай ганцаарчлан ажиллах, анхаарах боломжийг хязгаарлах учир орон зайн багтаамжийг нэмэгдүүлэх, бүлгийн хүүхдүүдийг олон жижиг хэсэгт хуваах нь үйлчилгээний чанар, үр нөлөөг сайжруулахад чухал алхам байж болох юм.

Чанарыг сайжруулах санхүүжилтийн эх үүсвэрийг босгохдоо эцэг эхийн оролцоог нэмэгдүүлж болох боловч эцэг эхийн халааснаас гарах мөнгө амьжиргааны түвшинд хэрхэн нөлөөлөхийг бодож үзэх ёстой. Эцэг эхээс гарч байгаа мөнгө нь одоогоор сургалтын материал, хэрэглэгдхүүнийг худалдан авч байгаа бол удахгүй хоолны зардалд хувь нэмэр оруулах болно. Эцэг эхийн зүгээс оруулах хувь нэмэр өөр ямар ч хэлбэртэй байж болох талаар улам гүнзгийрүүлэн судалж, эдгээр хувь нэмэр, оролцоог үйлчилгээний чанарыг сайжруулахын төлөө ашиглах ёстой. Одоогоор нэг бүлэгт байх

⁴⁷Төрийн өмчийн ердийн цэцэрлэгийн түүврийн ихэнх хүүхдүүд нь цэцэрлэгт наад зах нь хоёр жил орчим хамрагдсан хүүхдүүд байв (бүлэг 2).

хүүхдийн тоо нормоос хэтэрсэн, цэцэрлэгийн гадна олон хүүхэд үлдэж байна гэх зэрэг мэдээллээс үүдэн СӨБ-ын үйлчилгээний хэрэгцээ ханган нийлүүлэлтээсээ давах үед, эцэг эхчүүд өөрсдөөсөө илүү их хувь нэмрийг оруулах хүсэлтэй болох нь гарцаагүй юм. Гэвч тэдний оруулж байгаа хувь нэмрийг ил тод байдлаар, нэн чухал хэрэгцээндээ ашиглахад анхаарах ёстой. Мөн үүний хажуугаар эцэг эхийн халааснаас гарч буй хувь нэмэр нь амьжиргааны түвшинд хэрхэн нөлөөлөхийг сайтар судалж үзэх ёстой. Одоогоор СӨБ-д хамрагдаж чадахгүй байгаа хүүхдүүд хамгийн эмзэг өрхүүдийнх байгаа учир эцэг эхээс гарах мөнгийг тухайн айлын хүүхдүүдийг цэцэрлэгт элсэн ороход саад болох хэмжээний өндөр байлгахгүй байх тал дээр хяналт тавих нь зүйтэй. Мөн эцэг эхээс гарах хувь нэмрийг нийгэм-эдийн засгийн байдалтай нь уялдуулж, амьжиргааны түвшин доогуур өрхүүдээс бага хэмжээний татаасыг авч болох юм (гол арга хэмжээ 4-ийг харна уу). Төрийн үйлчилгээнд оруулах хувь хүмүүсийн хандив нэмрийг зохицуулах улсын тодорхой журам байх ёстой.

Гол арга хэмжээ 4: БНХБ-ын санхүүжилтийн нормуудыг эргэн харж, хүүхдийн хөгжлийн үр дүнд нөлөөлж буй жэндэрийн болон бусад төрлийн ялгааг арилгахын тулд судалгааны ажлыг үргэлжлүүлэх

БНХБ-ын санхүүжилтийн норм, эцэг эхийн оруулах хувь нэмрийг тооцохдоо боловсролын салбарын нийт санхүүжилтэд хэрхэн нөлөөлөх талаар бодолцож, тэгш байдлыг сайжруулах тал дээр анхаарах ёстой. 1, 2 дугаар бүлэгт улс даяар цэцэрлэгийн чанар ба хүүхдийн хөгжлийн үр дүнгийн ялгаа маш их байгаа тухай өгүүлсэн нь байршлаас болон цэцэрлэгийн төрлөөс хамаарч олгодог өнөөгийн норм, нормативууд нь тэгш бус байдлыг арилгахад тус нэмэр болохгүй гэдгийг тодруулж байна. Мөн эдгээр нь алслагдсан орон нутгийн малчин өрхүүд болон амьжиргааны түвшин доогуур бусад өрхүүдэд очиж байгаа санхүүгийн дарамтын асуудлыг шийдвэрлэж чадахгүй байна. Тиймээс энэ байдал нь одоогийн санхүүжилтийн механизм, түүний хуваарилалтын тэгш байдлыг шинжлэн дүгнэх хэрэгтэйг харуулж байна. Тэгш бус байдлыг арилгахын тулд олон төрлийн арга, стратегийг ашигладаг дэлхийн улс орнуудын жишээнээс Монгол улс суралцах боломжтой. Австрали, Унгар, АНУ ба Их Британи зэрэг улсууд бүгд үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд (төрийн болон хувийн) болон эцэг эхчүүдэд үйлчилгээнд хамрагдахад нь дэмжлэг үзүүлдэг ба үүнийг хэрэгжүүлэхдээ зорилтот бүлэг тус бүрийн хэрэгцээнд нийцүүлдэг байна. Хөтөлбөрүүд нь ерөнхийдөө амьжиргааны түвшин доогуур байгаа өрхүүд рүү чиглэсэн, тэдний эрх ашгийг хамгаалсан байдаг. Авч болох арга хэмжээнүүдэд төрийн өмчийн БНХБ-ын үйлчилгээнд хамрагдахад орлогын түвшнийг харгалздаг дүрэм журамтай байх, мөн хамтран санхүүжүүлэх хэмжээг тогтоох зэрэг орно (тодорхой заасан хэмжээ эсвэл тухайн хөтөлбөрийн үнэ өртгөөс хамаарах уян хатан нөхцөлтэй). Австрали улсад Австралийн уугуул иргэдийн боловсролыг сайжруулахын тулд шаардлагатай тохиолдолд боловсролын байгууллагууд нь нэг хүнд ногдох зардлаар тооцсон нэмэлт санхүүжилтийг авдаг. Харин Бразил улсад нэг хүүхдэд ногдох жилийн доод хэмжээний зардлыг төлөх чадваргүй орон нутгуудад нэмэлт санхүүжилтийг олгодог байна.

Бага насны хүүхдийн хөгжлийн зарим талууд дээр хөвгүүд охидоос хоцорч байгаа шалтгааныг ойлгохын тулд нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай. Хэл яриа, гүйцэтгэх чадвар, жижиг булчингийн хөгжлөөр хөвгүүд хоцорч байгааг судлах хэрэгтэй. Учир нь эрчүүдийн хоцрогдол насанд хүрсэн хүн амын боловсролын түвшинд ч бас ажиглагдаж байна: 2013 оны ОУБТС-д 15-49 насны эмэгтэйчүүдийн 34 хувь нь их, дээд

сургууль төгссөн байсан бол эрэгтэйчүүдийн зөвхөн 21 хувь нь төгссөн байжээ (НҮБ-ын Хүүхдийн сан, 2013). Яамны Боловсролын чанарын шинэчлэлийн хөтөлбөрийн хүрээнд 2016-2017 онд хийх бага ангиудын үнэлгээ нь бага ангийн охид хөвгүүдээс илүү чадвартай байна уу үгүй юу гэдэг талаарх мэдээллийг тодруулна. Жэндэрийн ялгааг нарийвчлан ойлгохын тулд гэр бүлийн болон сургуулийн орчинд байгаа нийгэм соёлын хүчин зүйлсийг судлах чанарын судалгаа хийх нь ашиг тустай байж болох юм.

Үндэсний цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй байх зэрэг боловсролын тусгай хэрэгцээтэй холбоотой асуудлуудыг шийдвэрлэхийн тулд зорилтот бүлэгт чиглэсэн оновчтой хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Казах хүүхдүүд хэл яриа, нийгэм-сэтгэлийн хөдөлгөөний айд бусад хүүхдүүдээс ихээхэн хоцорч байсан ч гэсэн ханган нийлүүлэлтийн хүчин зүйлсийг хянаж үзсэний дараа дээрх зөрүү арилж байсан юм. Тэгэхээр оновчтой зорилтот арга хэмжээ авснаар цөөнхийн хоцрогдлыг арилгах боломжтой байгаа нь үнэхээр баярламаар үр дүн юм. Үүнээс гадна хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай хэрэгцээнд нийцсэн зорилтот арга хэмжээ байх хэрэгтэй.

Номзүй

Aboud, F. E. 2006. "Evaluation of an Early Childhood Preschool Program in Rural Bangladesh." *Early Childhood Research Quarterly* 21 (1): 46-60.

Aboud, F.E. 2007. "Evaluation of an Early Childhood Parenting Programme in Rural Bangladesh." *Journal of Health Population and Nutrition* 25: 3-13.

Almond, Douglas, and Janet Currie. 2011. "Human Capital Development before Age Five." In Orley Ashenfelter and David Card, eds., *Handbook of Labor Economics*. North Holland: Amsterdam, pp. 1315-486.

Behrman, Jere, Lia Fernald, and Patrice Engle. 2013. "Preschool Programs in Developing Countries." P. Glewwe, *Education Policy in Developing Countries*. Chicago: University of Chicago Press.

Berlinski, Samuel, and Norbert Schady, eds. *The Early Years: Child Well-being and the Role of Public Policy*. Palgrave Macmillan, 2015.

Bernal, Raquel. "The effect of maternal employment and child care on children's cognitive development." *International Economic Review* 49.4 (2008): 1173-1209.

Bernal, Raquel. "The impact of a technical training program for childcare providers on children's wellbeing." *Documentos CEDE*. Bogotá: Universidad de los Andes (2010).

Bouguen, A., D. Filmer, K. Macours, S. Naudeau. 2013. *Impact Evaluation of Three Types of Early Childhood Development Interventions in Cambodia*. Washington, DC: World Bank Policy Research Working Paper Series 6540.

Brooks-Gunn, Jeann, Flavio Cunha, Greg Duncan, James Heckman, and Aaron Sojourner. 2006. "A Reanalysis of the IHDP Program." Unpublished manuscript, Infant Health and Development Program, Northwestern University, 2006.

Carneiro, P.M., and J.J. Heckman. 2003. "Human Capital Policy" in J. Heckman and A. Krueger (eds) *Inequality in America: What Role for Human Capital Policy?* MIT Press, Cambridge.

Case, Anne, and Christina Paxson. 2008. "Stature and Status: Height, Ability, and Labor Market Outcomes." *Journal of Political Economy* 116(3): 499-532.

Cunha, Flavio, James Heckman and Lance Lochner. 2006. "Interpreting the Evidence on Life Cycle Skill Formation." In Eric Hanushek and Finis Welch, eds., *Handbook of the Economics of Education*. North Holland: Amsterdam, pp. 697-812.

Cunha, Flavio, and James Heckman. 2007. "The Technology of Skill Formation." *American Economic Review* 97(2): 31-47.

Currie, J. and D. Thomas. 1999. "Early Test Scores, Socioeconomic Status and Future Outcomes." NBER Working Paper 6943. National Bureau of Economic Research, Cambridge, MA.

Duncan, Greg J., and Katherine Magnuson. 2013. "Investing in Preschool Programs." *Journal of Economic Perspectives* 27(2): 109-32.

Engle, Patrice, Maureen Black, Jere Behrman, Meena Cabral de Mello, Paul Gertler, Lydia Kapiriri, Reynaldo Martorell, and Mary Eming Young. 2007. "Strategies to Avoid the Loss of Developmental Potential in More Than 200 Million Children in the Developing World." *The Lancet* 369(9557): 229-42.

Engle, Patrice, Lia Fernald, Harold Alderman, Jere Behrman, Chloe O'Gara, Aisha Yousafzai, Meena Cabral de Mello, Melissa Hidrobo, Nurper Ulkuer, Ilgi Ertem, S, Iltus, and the Global Child Development Steering Group. 2011. "Strategies for Reducing Inequalities and Improving Developmental Outcomes for Young Children in Low and Middle Income Countries." *The Lancet* 378(9799): 1339-53.

Feinstein, L. 2003. "Inequality in the Early Cognitive Development of British Children in the 1970 Cohort." *Economica* 70 (1): 73-97

Fernald, L., P. Kariger, P. Engle, and A. Raikes. 2009. "Examining Early Child Development in Low-Income Countries: A Toolkit for the Assessment of Children in the First Five Years of Life." Washington, DC: World Bank.

Fernald, Lia, Ann Weber, Emmanuela Galasso, and Lisy Ratsifandrihamanana. 2011. "Socioeconomic Gradients and Child Development in a Very Low Income Population: Evidence from Madagascar." *Developmental Science* 14(4): 832-47.

Ghuman, S., Behrman, J. R., Borja, J. B., Gultiano, S., & King, E. M. (2005). Family Background, Service Providers, and Early Childhood Development in the Philippines: Proxies and Interactions. *Economic Development and Cultural Change*, 54 (1), 129-164.

Grantham-McGregor, Cheung, B., Cueto, Glewwe, Richer, & Trupp.(2007). Developmental potential in the first five years for children in developing countries. *The Lancet*, 369 (9555), 60-70.

Halpern, R., Barros, F. C., Horta, B. L., & Victoria, C. (1996). "Desenvolvimento neuropsicomotor aos 12 meses de idade em uma coorte de base populacional no Sul do Brasil: diferenciais conforme peso ao nascer e renda familiar. *Saúde Pública*, 12 (1), S73-S78.

Heckman, J. 2006. "Skill Formation and the Economics of Investing in Disadvantaged Children." *Science* 312 (5782): 1900–02.

Heckman, James J. 2007. "The Technology, and Neuroscience of Human Capital Formation." *Proceedings of the National Academy of Sciences*, 104(33): 13250-13255.

Heckman, James. 2008. "Schools, Skills, and Synapses." Institute for the Study of Labor (IZA) Discussion Paper 3515.

Heckman, J. J., and D. V. Masterov. 2007. "The Productivity Argument for Investing in Young Children." *Applied Economic Perspectives and Policy* 29(3): 446–493.

Jaramillo, A., and K. Tietjen. 2001. *Early Childhood Development in Africa: Can We Do More and Better for Less? A Look at the Impact and Implications of Preschools in Cape Verde and Guinea.* World Bank Africa Region Human Development Series. Washington, DC: World Bank.

Jung, Haeil; Hasan, Amer. 2014. *The Impact of Early Childhood Education on Early Achievement Gaps : Evidence from the Indonesia Early Childhood Education and Development*

Project. World Bank, Washington, DC. © World Bank.

<https://openknowledge.worldbank.org/handle/10986/18340> License: CC BY 3.0 IGO.

Liddell C, and Rae G. (2001). Predicting early grade retention: a longitudinal investigation of primary school progress in a sample of rural South African children. *British Journal of Educational Psychology*, 71 (3), 413-28.

Lynch, R.G. 2005. "Early Childhood Investments Yield Big Payoff." *Policy Perspectives*. San Francisco, CA: WestEd.

Боловсрол, шинжлэх ухааны яам (БШУЯ). 2014 он. 2013-2014 оны хичээлийн жилийн Боловсрол, Шинжлэх ухааны Статистикийн Эмхтгэл: 2013 оны санхүүгийн жил. Улаанбаатар хот, Монгол улс.

Naudeau, Sophie, Sebastian Martinez, Patrick Premand, and Deon Filmer. 2011. "Cognitive Development among Young Children in Low-Income Countries. In *No Small Matter: The Impact of Poverty, Shocks, and Human Capital Investments in Early Childhood Development*, Harold Alderman, ed., The World Bank, Washington, DC.

Paxson, C., and N. Schady. 2007. "Cognitive Development among young Children in Ecuador: The Role of Wealth, Health, and Parenting." *Journal of Human Resources* 42 (1): 49-84.

Pianta, R.C. and S.J. Mcoy. 1997. "The First Day of School: The Predictive Validity of Early School Screening." *Journal of Applied Developmental Psychology* 18 (1): 1-22.

Reynolds, A.J., J. A. Temple, D. L. Robertson, and E. A. Mann. 2001. "Long Term Effects of an Early Childhood Intervention on Educational Achievement and Juvenile Arrest- a 15- Year Follow-Up of Low-Income Children in Public Schools," *Journal of the American Medical Association* 285 (18): 2339-46.

Save the Children (2006) Education of Kazakh children: A situation analysis. United Kingdom.

Schady, Norbert. 2011. "Parental Education, Vocabulary, and Cognitive Development in Early Childhood: Longitudinal Evidence from Ecuador." *American Journal of Public Health* 101(12): 2299-307.

Schady, N., Behrman, J. R., Araujo, M. C., Azuero, R., Bernal, R., Bravo, D., ...& Vakis, R. (2014). Wealth gradients in early childhood cognitive development in five Latin American countries.

Schochet, P. Z. (2005). *Statistical power for random assignment evaluations of education programs*. Princeton, NJ: Mathematica Policy Research.

Schweinhart, L. J., J. Montie, Z. Xiang, W. S. Barnett, C. R. Belfield, and M. Nores. 2005. "Lifetime Effects: The High/Scope Perry Pre-school Study through Age 40." High/Scope Educational Research Foundation, Ypsilanti, Michigan.

Stith, A., Gorman, K., & Choudhury, N. (2003). The Effects of Psychosocial Risk and Gender on school attainment in Guatemala. *Applied Psychology*, 52 (4), 614-629.

Walker, Chang, Powell, & Grantham-McGregor. (2005). "Effects of Early Childhood Psychosocial Stimulation and Nutritional Supplementation on Cognition and Education in Growth-Stunted Jamaican Children: Prospective Cohort Study. *The Lancet*, 369 (9556).

World Bank. 2013. What matters most for early childhood development? A framework paper. Systems Approach for Better Education Results (SABER) Working Paper Series. Washington DC.

World Development Indicators. 2014. The World Bank. Washington DC.

World Bank. 2015. "IMPLEMENTATION COMPLETION AND RESULTS REPORT (TF-11836) ON A GLOBAL PARTNERSHIP FOR EDUCATION FUND GRANT To MONGOLIA FOR AN EARLY CHILDHOOD EDUCATION PROJECT". Washington, DC.

UNESCO Beijing. UNESCO National Education Support Strategy (UNESS): Mongolia. Beijing, January 2008.

UNESCO/IBE. 2011. World Data on Education. VII Ed. 2010/11. Mongolia.


UNICEF. 2016. UNICEF Annual Report 2015: Mongolia. Downloaded from http://www.unicef.org/about/annualreport/index_90469.html.

Хавсралтууд

Хавсралт 1. Монгол улсын СӨБ болон хувилбарт сургалтын түүх

Монгол улсын бага насны хүүхдийн боловсрол 1990-ээд оны эхэн үеэр ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжиж байх үед ихээхэн хүндрэлтэй тулгарсан юм. Социалист нийгмийн үед СӨБ-ын хүртээмж бараг асуудалгүй байсан гэж хэлж болно. Сум бүрд наад зах нь 0-2 настай хүүхдийн төрийн мэдлийн ясли, 3-6 настай хүүхдийн цэцэрлэг байдаг байв. Гэвч шилжилтийн үе дөнгөж дуусаад улсын эдийн засгийн хүчин чадал ихээхэн буурсан тул орон нутгийн төсвүүд, ялангуяа хөдөө орон нутгийн алслагдсан орон нутагт СӨБ-ын үйлчилгээгээр хангах боломжгүй болсон юм. Орон нутгийн засаг захиргаад санхүүгийн гачигдалтай тулгарсан учир олон ясли, цэцэрлэг үүд хаалгаа барьж, 2000 орчим багш нар ажилгүй болсон билээ (НҮБ-ын БСШУБ). Энэ үед СӨБ-ын элсэгчдийн тоо огцом буурсан юм (зураг А1). Энэхүү өөрчлөлт нь хөдөө орон нутаг, алслагдсан газар нутгийн малчин болон ядуу өрхүүдийн хүүхдүүдэд хамгийн хүндээр туссан юм.

Зураг А1. Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт, 1989-2012 он



(Эх сурвалж: НҮБ-ын БСШУБ-ийн Статистикийн Институт)

Монгол улсын алслагдсан орон нутгийн БНХБ-ын хөгжилд тулгамддаг гол асуудлууд бол алслагдмал байдал болон цаг уурын хүнд нөхцөл юм. Монгол улс нь дэлхийн хамгийн бага хүн амын нягтаршилтай улсад тооцогддог. Сүүлийн жилүүдэд хүн амын өсөлт хурдацтай байгаа ч гэлээ нэг кв километрт ногдох хүний тоо хоёроос доош хэвээр байна (WDI/Дэлхийн хөгжлийн үзүүлэлтийн баримтаас). Улсын нийт зургаагаас доош настай хүүхдүүдийн 54.6% нь хөдөө орон нутагт амьдардаг (НҮБ-ын Хүүхдийн сан). Байгаль, цаг ууртай холбоотой эдгээр асуудлын зэрэгцээ санхүүгийн асуудлууд байгаа учраас хөдөө орон нутгийн хүүхдүүдийн СӨБ-ын хэрэгцээг хангахад хэцүү болсон байна.

Харин эдгээр саад бэрхшээлийг даван туулахын тулд нүүдлийн гэр цэцэрлэгийн тухай ойлголт гарч иржээ. 1994 оноос НҮБ-ын Хүүхдийн сан, Хүүхдийн ивээх сан зэрэг олон улсын байгууллага нь хүрч үйлчлэхэд хүндрэлтэй малчдын хүүхдүүдэд хүрэхийн тулд анх энэхүү сургалтын хувилбарыг туршиж, хэрэгжүүлж эхэлсэн. Нүүдлийн гэр цэцэрлэгт хамрагдсан хүүхдүүд нь ихэвчлэн нутгийн баруун болон зүүн хэсгээр амьдардаг, орлого нь тогтворгүй, эмзэг бүлгийн өрхийн хүүхдүүд байв. Ийнхүү хүүхдүүдийг анх сургуульд орохоос нь өмнө бэлтгэлд сургаж, хичээл заахын зэрэгцээ хоол ундаар хангаж байсан

байна. Энэ туршилт маш эерэг үр дүнтэй байсан учир нүүдлийн гэр цэцэрлэгийг бусад байршлуудад туршиж, удалгүй улс даяар хэрэгжүүлэх болсон ба үүнийг СӨБ-ыг олгох "хувилбарт" арга гэж нэрлэжээ (Хүүхдийг ивээх сан, 2009).

СӨБ, ялангуяа хувилбарт сургалтын хөтөлбөрийг боловсруулахад таатай бодлогын орчин 1990-ээд оны дундаас эхлэн хөгжиж эхэлжээ. 1995 онд засгийн газар СӨБ-ыг бэхжүүлэх үндэсний хөтөлбөрийг баталсан байна. Тус хөтөлбөрийн гол зорилгуудын нэг бол нүүдлийн болон суурин хүн амын хэрэгцээнд нийцсэн СӨБ-ын таатай орчныг бүрдүүлэх байв. Гэвч төсвийн байдал хүнд байсан 1995-2000 оны хувьд энэ нь хэтэрхий өндөр зорилт байсан юм. 2005 онд "Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих цогц бодлогыг" бүх оролцогч талуудын уялдаа холбоог сайжруулахын үүднээс эрүүл мэнд, боловсрол болон нийгмийн хамгааллын яамд хамтран баталсан юм.

Харин хамгийн томоохон өөрчлөлт нь 2008 онд батлагдсан Монгол улсын СӨБ-ын тухай хууль байсан ба үүнд төрийн өмчийн цэцэрлэгт хамрагдаж байгаа хүүхдийн хоол, ном, гарын авлага, тоглоом болон нормативт суурилсан хувьсах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ гэж заасан. Хууль хэрэгжихээс өмнө эцэг эхчүүд хоол болон бусад зардлын 50 хувийг төлж байсан нь зарим эцэг эхчүүдийн хувьд хүүхдээ цэцэрлэгт өгөхөд учирч байсан том саад бэрхшээл байв. Үүнээс гадна засгийн газар өмнө нь зөвхөн гадны байгууллагуудын дэмжиж байсан (НҮБ-ын БСШУБ, НҮБ-ын Хүүхдийн сан, гм) бага насны хүүхдийн боловсролын албан бус хөтөлбөрүүдийг боловсруулахад санхүүгийн болон техникийн туслалцаа үзүүлэхээр болсон байна.

Хавсралт 2. Монгол улсын СӨБ-ын хамрагдалтад нөлөөлөх хүчин зүйлс: Регрессын үр дүнгийн хүснэгт

Монгол улсын 36-59 сартай хүүхдүүдийн өрхийн болон хувийн шинж чанарууд СӨБ-ын хамрагдалтанд нөлөөлж буй нөлөө, ОУБТС, 2010


ХУВЬСАГЧ		(1) Хамрагдалт	(2) Хамрагдалт	(3) Хамрагдалт
Эхийн боловсрол	<i>Бага</i>	0.0169 (0.0633)		0.0713 (0.0873)
	<i>Үндсэн (бага дунд)</i>	0.191*** (0.0550)		0.148* (0.0754)
	<i>Ахлах дунд</i>	0.287*** (0.0541)		0.123 (0.0757)
	<i>Техник мэргэжлийн</i>	0.342*** (0.0700)		0.130 (0.0889)
	<i>Их, дээд</i>	0.491*** (0.0535)		0.175** (0.0800)
Аж байдлын индекс	<i>Хоёрдахь</i>		0.314*** (0.0337)	0.200*** (0.0511)
	<i>Дундах</i>		0.490*** (0.0360)	0.406*** (0.0673)
	<i>Дөрөвдэх</i>		0.500*** (0.0372)	0.434*** (0.0811)
	<i>Хамгийн баян</i>		0.564*** (0.0391)	0.413*** (0.137)
Хүйс	<i>Эмэгтэй</i>			0.0255 (0.0280)
Бүс нутаг	<i>Хангай</i>			-0.0718 (0.0504)
	<i>Төв</i>			-0.0254 (0.0489)
	<i>Зүүн</i>			-0.0311 (0.0484)
	<i>Улаанбаатар</i>			-0.242*** (0.0517)
Яс үндэс	<i>Казах</i>			-0.137 (0.0857)
	<i>Тогтмол</i>	0.309*** (0.0479)	0.280*** (0.0215)	0.497** (0.216)
	Өрхийн болон хувийн шинж чанаруудын цогц хяналт	Үгүй	Үгүй	Тийм
	Ажиглалтууд	1,320	1,320	1,008
	R-squared (детерминацын коэффициент)	0.112	0.208	0.144

Стандарт алдаанууд хаалтанд орсон байгаа. Өрхийн болон хувийн шинж чанаруудын энд тусгагдаагүй хяналтуудад насны ангилал, байршил, "бусад" үндэстэн, шашин шүтлэг, гэрийн хийц материал, сууцын төрөл, сууцын болон газар өмчлөл, банкны данс, ариун цэврийн өрөөтэй байх, өрхийн хүүхдийн тоо зэрэг илрүүлэх үзүүлэлтүүд орж байгаа юм.

